



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Шударга ёс, хөгжил дэвшилд

СУДАЛГААНЫ ТАЙЛАН ЭМХЭТГЭЛ 2016-2019 он

III БОТЬ

ННА 72
ДАА 001.4
Х-855

Хянасан:

Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар
З.Баасанням

Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны дарга, ахлах
комиссар Ц.Шинэбаяр

Боловсруулсан:

Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны ажилтан,
комиссар Ц.Бадам

Цаасны хэмжээ: А4
Хэвлэсэн тоо: 300

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

ISBN 978-9919-22-716-6

ӨМНӨХ ҮГ



Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан судалгааны тайлангуудыг эмхэтгэн Та бүхэнд толилуулж байна.

Тус газар нь 2007 онд байгуулагдсан цагаасаа эхлэн авлигын шалтгаан нөхцөл, цар хүрээ, үр дагавар, хэлбэр болон эдгээртэй холбоотой олон тооны үзүүлэлтийг тооцоолох, хэмжих зорилготой судалгааны ажлыг жил бүр зохион байгуулж ирсэн. Эдгээр судалгааны ажлын зорилго нь авлигын нөхцөл байдлыг тодорхойлж, хэмжсэний үндсэн дээр авлигатай тэмцэх бодлогыг боловсруулахад ашиглах, авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох явдал юм.

Энэхүү эмхэтгэл нь тус газраас зохион байгуулсан давтамжит судалгааны үр дүнгийн тайлангуудаас бүрдэж байгаа бөгөөд эдгээрийг гурван боть болгон эмхэтгэлээ. Тухайлбал 2008 оноос 2018 онд зохион байгуулсан Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа, 2009, 2011, 2013 онуудад зохион байгуулсан Авлигын индексийн судалгаа, 2010, 2012, 2014 онуудад зохион байгуулсан Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ, 2015, 2016, 2018 онд зохион байгуулсан Шударга байдлын үнэлгээ, 2010 оноос 2019 онд зохион байгуулсан Хүүхдийн шударга

байдлын судалгаа, 2018 онд зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт хандлагыг тодорхойлох судалгаа зэрэг судалгааны тайлангуудыг эмхэтгэлд багтаан нийтийн хүртээл болгож байна.

Бид судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулахдаа олон улсын аргачлал, арга зүй, туршлагыг судлан үзэж, мөн манай улсад энэ чиглэлээр хийгдсэн судалгаа, бусад холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийж, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачидтай хамтран ажилладаг. Өөрөөр хэлбэл судалгаа шинжилгээний ажлыг Авлигатай тэмцэх газар дангаараа бус харин олон тооны байгууллага, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор гүйцэтгэдэг юм.

Судалгааны ажлын үр дүнгийн тайлангууд нь өргөн хүрээтэй, чухал ач холбогдолтой олон тооны мэдээ, мэдээлэл агуулсан бөгөөд бодлого боловсруулагчид, төрийн байгууллагын албан хаагчид, олон улсын байгууллагын ажилтнуудад авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр үйл ажиллагааг боловсруулах, төлөвлөх, үнэлж дүгнэхэд шаардлагатай мэдээллийг хүргэх, эрдэмтэд, судлаачдад судалгаа, мэдээллийн эх сурвалж болгох зорилгоор эмхэтгэлийг боловсрууллаа.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас Монгол Улс дахь авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээний 2019 оны тайланд судалгааны чиглэлээр хийгдэж байгаа ул суурьтай, хэвшиж тогтсон үйл ажиллагааг сайшаахын зэрэгцээ судалгааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд өнгөрсөн хугацаанд бий болсон их хэмжээний судалгааны мэдээллийг бүрэн хэмжээгээр ашиглах, судалгаагаар тогтоогдсон илэрхий дүгнэлт, нотолгоонд дүн шинжилгээ

хийж, стратегийн төлөвлөлт болон үнэлгээний үйл ажиллагаанд хамтатган ашиглахыг уриалсан байдаг. Энэхүү зөвлөмж нь бидний санаа бодолтой бүрэн дүүрэн нийцэж байгааг илэрхийлэх нь зүйтэй.

Тус газраас зохион байгуулсан давтамжит судалгааны ажлыг анх удаагаа эмхэтгэн хүргэж байгаа юм. Иймд энэхүү эмхэтгэлийг та бүхэн өөрсдийн үйл ажиллагаандаа

ашиглахын зэрэгцээ бидэнд хандан санал, зөвлөмжөө ирүүлбэл хүлээн авч хамтран ажиллахад бэлэн байна.

Судалгааны ажлуудыг зохион байгуулахад хамтран ажиллаж үнэтэй санал, дэмжлэг, туслалцаа үзүүлсэн эрдэмтэн судлаачид, төрийн болон төрийн бус байгууллага, судалгааны мэргэжлийн байгууллагууд, судалгаанд хамтран оролцож байсан бүх хүмүүст талархлаа илэрхийлье.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР З.ДАШДАВАА

ГАРЧИГ

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2016	7-22
УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2016	23-50
ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2016	51-70
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2017	71-86
УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2017	87-112
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2018	113-122
ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2018	123-146
УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2018	147-172
ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2018	173-196
АВЛИГЫН ТАЛААРХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА-2018	197-216
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2019	217-232
ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2019	233-260
УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2019	261-288
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АВЛИГЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА-2019	289-324
ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2019	325-370
ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАР, ОРЧИН ДАХЬ ЁС ЗҮЙН ТАНДАЛТ СУДАЛГАА-2019	371-414

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2016

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2016 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааг “Транспэрэнси Интернэшнл Солонгос” байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, Солонгос, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулж байсан билээ. Үүнээс хойш уг арга зүйн дагуу Хүүхдийн шударга байдлын судалгааг 7 дахь удаагаа зохион байгуулаад байна.

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн шударга байдал, ёс зүй, ёс суртахуун, төлөвшилтийг хүүхдэд ойлгомжтой, хялбар байдлаар тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтооход энэхүү судалгааны зорилго оршиж байна.

1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааны зорилгын нэг нь хүүхдийн шударга байдлын түвшнийг тодорхойлох бөгөөд судалгааны мэдээлэлд үндэслэн жил бүр хүүхдийн шударга байдлын түвшинг хэмжин гаргаж байгаа юм.

Хүүхдийн шударга байдлын түвшинг тогтоохдоо доорх 12 асуултад тухайн хүүхэд санал нийлж байгаа эсэхийг нь асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үнэлгээний арифметик дунджаар гаргав. Хүүхдийн шударга байдлын түвшин нь хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих үзэл гэсэн дэд үзүүлэлтээс бүрддэг. Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлэхэд ашигласан асуулт

Асуултын дугаар	Асуулт
1.	Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.
2.	Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.
3.	Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
4.	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.
5.	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.
6.	Баян байх нь шударга байхаас илүү чухал.
7.	Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.
8.	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.
9.	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондoo хурдан орохыг хичээнэ.
10.	Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.
11.	Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.
12.	Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.

Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахиx болон авлигыг үл тэвчих байдлын үзүүлэлтийг тооцохдоо дээр дурдсан асуултуудын дагуу дэд үзүүлэлтийн дунджийг тооцсон болно. Дэд үзүүлэлт тооцоход ашигласан асуултыг дараахь хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтийг тооцсон асуулт, асуултын дугаараар

	Ёс зүй, ёс суртахуун	Зөв төлөвшилт	Хууль сахиx	Авлигыг үл
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

2. СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан, 21 аймаг, нийслэлийн 7-12 дугаар ангийн сурагчдыг санамсаргүй байдлаар сонгон, бэлтгэгдсэн асуулгыг бөглүүлж, судалгааг зохион байгуулав.


Судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах ажлыг 21 аймаг, нийслэлд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн байгууллагатай хамтран 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

БҮЛЭГ II. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН БҮТЭЦ


“Хүүхдийн шударга байдал-2016” судалгаанд хамрагдсан сурагчдын 45.6 хувь нь эрэгтэй, 54.4 хувь нь эмэгтэй байгаа бол сурагчдыг насны хувьд авч үзвэл 15 настай сурагчид хамгийн их буюу 22.3 хувийг эзэлж байгаа бол 19 настай сурагчид хамгийн бага буюу судалгаанд хамрагдсан сурагчдын 0.7 хувь нь байна (Зураг 1).

Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, нас



Судалгаанд хамрагдсан сурагчдыг суралцаж буй ангиар нь авч үзвэл 11 дүгээр ангийн сурагч 22.2 хувь, 8 дугаар ангийн сурагч 21.5 хувь, 7 дугаар ангийн сурагч 20.8 хувь, 9 дүгээр ангийн сурагч 19.1 хувь, 10 дугаар ангийн сурагч 10.9 хувь байгаа бол 12 дугаар ангийн сурагч 5.4 хувийг эзэлж байна (Зураг 2).

Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, анги, дүнд эзлэх хувиар



Судалгаанд хамрагдсан сурагчдыг байршлаар нь авч үзвэл 62.4 хувь нь аймгуудаас, 37.6 хувь нь нийслэлээс хамрагдсан байна.

2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН

Хүүхдийн шударга байдлын судалгааны мэдээлэлд үндэслэн Хүүхдийн шударга байдлын түвшинг 4 дэд үзүүлэлт (ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих)-ийн хамт тооцдог. Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

Хүүхдийн шударга байдлын түвшин 2016 оны судалгаагаар 4.00 гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 0.01-ээр өссөн байна (Зураг 3).

Зураг 3. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор



Судалгааны үр дүнг ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт, зөв төлөвшилтийн дэд үзүүлэлт, хууль сахих байдлын дэд үзүүлэлт, авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтүүдээр дэлгэрэнгүйгээр доорх хүснэгтээр гаргав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Хүүхдийн шударга байдал 2015 судалгааны түвшин, дэд үзүүлэлтээр

Д/д			Үзүүлэлт		Үнэлгээ					
					2010	2012	2013	2014	2015	2016
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН					3.29	2.93	3.71	4.03	3.99	4.00
А. Ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт					3.03	2.73	3.80	4.07	4.08	4.10
	Танин мэдэхүйн	Хүүхдүүд гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусдын бүтээлийг өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.			3.20	2.72	3.66	3.94	3.94	3.98
	Нөлөөллийн	Баян байх нь шударга байхаас илүү чухал.			2.70	2.49	3.91	4.28	4.26	4.23
	Зан үйлийн	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.			3.20	2.99	3.82	3.99	4.03	4.10
Б. Зөв төлөвшилтийн дэд үзүүлэлт					2.51	2.29	3.88	4.32	4.21	4.16
	Танин мэдэхүй	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.			2.20	1.85	3.99	4.45	4.37	4.30
	Нөлөөллийн	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.			2.20	1.94	4.08	4.48	4.38	4.37
	Зан үйлийн	Хууль зөрчсөн, гэмт хэрэг хийсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.			3.10	3.10	3.57	4.02	3.87	3.81
В. Хууль сахих байдлын дэд үзүүлэлт					3.54	2.85	3.83	4.04	4.02	4.06
	Танин мэдэхүй	Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.			4.42	3.61	3.63	3.63	3.73	3.84
	Нөлөөллийн	Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.			3.40	2.96	4.02	4.10	4.09	4.05
	Зан үйлийн	Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.			2.80	1.98	3.83	4.38	4.24	4.28
Г. Авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлт					2.98	2.81	3.35	3.68	3.65	3.68
	Танин мэдэхүйн	Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.			2.70	2.34	3.69	4.15	4.17	4.14
	Нөлөөллийн	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/ эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.			3.35	3.11	2.73	3.29	2.67	2.72
	Зан үйлийн	Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.			2.90	2.97	3.65	4.19	4.10	4.18


2016 оны судалгааны үр дүнгээр Дорнод, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшин 0.51-0.7 пунктээр дээшилсэн байна. Харин Булган, Дундговь, Сүхбаатар, Баян-Өлгий аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшин 0.44-0.59 пунктээр буурчээ (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хүүхдийн шударга байдал 2016 судалгааны түвшин, аймаг, нийслэл

д/д	Аймаг, нийслэл	Шударга байдлын түвшин		Зөрүү
		2015	2016	
1	Архангай	4.01	3.89	-0.12
2	Баян-Өлгий	4.18	3.74	-0.44
3	Баянхонгор	4.03	4.17	0.14
4	Булган	4.26	3.67	-0.59
5	Говь-Алтай	3.36	4.03	0.67
6	Говьсүмбэр	3.71	3.92	0.21
7	Дархан-Уул	3.56	4.04	0.48
8	Дорноговь	3.99	4.22	0.23
9	Дорнод	3.38	4.08	0.70
10	Дундговь	4.26	3.79	-0.47
11	Завхан	3.96	4.03	0.07
12	Орхон	4.07	4.04	-0.03
13	Өвөрхангай	3.65	4.16	0.51
14	Өмнөговь	3.66	4.21	0.55
15	Сүхбаатар	4.13	3.69	-0.44
16	Сэлэнгэ	3.57	4.04	0.47
17	Төв	3.87	3.98	0.11
18	Увс	4.29	4.06	-0.23
19	Ховд	4.08	4.10	0.02
20	Хөвсгөл	4.36	4.09	-0.27
21	Хэнтий	4.00	4.17	0.17
22	Улаанбаатар	4.05	3.98	-0.07


Хүүхдүүдийн шударга байдал нас нэмэгдэх тутам буурч байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. 12 настай хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.13, 13 настай хүүхдүүдийнх 4.08 гарсан байгаа нь өндөр үзүүлэлт болж байна. Харин 19 настай хүүхдүүдийн шударга байдлын түвшин 3.48 гарсан нь хамгийн доогуур үзүүлэлт болж байна (Зураг 4).

Зураг 4. Хүүхдийн шударга байдлын түвшин болон хүүхдийн нас



Хүүхдийн шударга байдлын түвшин мөн хүйсийн хувьд зөрүүтэй байдал жил бүрийн судалгааны дүнгээс харагддаг. Энэ удаагийн судалгааны дүнгээс харахад эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин 4.06, эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин 3.93 болж зөрүү нь 0.12 пункт байна (Зураг 5).

Зураг 5. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр



3. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР

Хүүхдийн шударга байдлын түвшинг ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахиx, авлигыг үл тэвчих гэсэн 4 дэд үзүүлэлтээр үнэлсэн.

Хүснэгт 5. Хүүхдийн шударга байдлын түвшин, дэд үзүүлэлтээр

	2010	2012	2013	2014	2015	2016
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН	3.29	2.93	3.71	4.03	3.99	4.00
Ёс зүй, ёс суртахуун	3.03	2.73	3.80	4.07	4.08	4.10
Зөв төлөвшилт	2.51	2.29	3.88	4.32	4.21	4.16
Хууль сахиx	3.54	2.85	3.83	4.04	4.02	4.06
Авлигыг үл тэвчих	2.98	2.81	3.35	3.68	3.65	3.68

4. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль, дүрэм сахин дээдлэх болон авлигыг үл тэвчих байдал нь тэдний эцэг, эх, найз нөхөд, сургууль болон мэдээллийг хүлээн авч байгаа сувгаас шууд хамааралтай байдаг. Тиймээс судалгааны үр дүнд хүүхдийн шударга байдлын түвшин эцэг, эх, найз, нөхөд, сургууль, мэдээлэл хүлээн авч бус сувгаас хэрхэн хамаарч байгаа талаар доорх байдлаар шинжилгээ хийлээ.

Эцэг, эх:

Хүүхдийн шударга байдлын судалгаагаар хүүхэд шударга байж, зөв зүйл хийхэд ямар шалтгаан, хүчин зүйл нөлөөлж байгааг тодорхойлохыг зорилго болгодог. Хүүхдийн шударга байдалд нөлөөлөх нэг чухал хүчин зүйл бол эцэг, эхийн нөлөөлөл юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “Танд шударга бус асуудал тохиолдвол Та яах вэ?” гэсэн асуултад нийт хүүхдүүдийн 63.9 хувь нь “эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүнд хэлнэ” гэж хариулсан бол 26.3 хувь нь “арилгахын тулд ямар нэг зүйл хийнэ”, 9.9 хувь нь “юу ч хийхгүй” гэж хариулсан байна (Зураг 6).

Зураг 6. Шударга бус асуудал тохиолдоход хэнд ханддаг вэ?



Дээрхээс үзэхэд хүүхдүүд хүндрэлтэй асуудал тулгарахад хамгийн ихээр эцэг, эх, дотны хүмүүстээ ханддаг байна. Иймд эцэг, эх, гэр бүлийн нөлөөллийг судалгааны явцад тодруулав. Эцэг, эхчүүд хүүхдүүдтэй шударга байх талаар байнга ярилцдаг гэсэн хариулт 29.3 хувь болж 2.2 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 7.)

Зураг 7. Эцэг, эхчүүд шударга байдлын талаар ярилцдаг эсэх, 2015-2016 он




Эндээс харахад судалгаанд оролцсон сурагчдын дийлэнх хувь нь “байнга”, “заримдаа” ярилцдаг гэж хариулсан байгаа нь эерэг үзүүлэлт болж байна. Харин шударга бус зүйл хийсэн тохиолдолд эцэг, эх нь хэрхэн нөлөөлдөг талаар судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс тодруулахад “болохгүй зүйл хийснийг минь хэлж ойлгуулдаг” гэж нийт хүүхдүүдийн 65.8 хувь нь хариулсан бол 25.8 хувь нь “зэмлэл хүлээлгэж шийтгэдэг”, 5.1 хувь нь “тэд энэ талаар сонирхдоггүй”, 3.4 хувь нь “ямар ч үйлдэл хийдэггүй” гэж тус тус хариулсан байна (Зураг 8).

Зураг 8. Эцэг, эхийн хүүхдэд нөлөөлж буй байдал



Хүүхдээ шударга бус зүйл хийхэд эцэг, эх ямар хариу үйлдэл үзүүлж байгаагаас шалтгаалан тэдний зөв төлөвшил хамаарна. Үүнийг судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс тодруулахад “Болохгүй зүйл хийснийг минь хэлж ойлгуулдаг” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.03 байгаа нь “ямар ч үйлдэл хийдэггүй” гэж хариулсан хүүхдийнхээс 0.49 пунктээр илүү байна (Зураг 9).


Зураг 9. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга бус зүйлийн эсрэг эцэг, эхийн гаргаж буй үйлдлээр



Найз, нөхөд бусад хүмүүс:


Хүүхдүүдийн хувьд шударга байх, эсхүл зөв төлөвшилт олж авахад эцэг, эхээс гадна найз, нөхдийн хүрээ чухал нөлөөтэй юм. Иймд хүүхдүүдээс “Таны найз танаас шударга бус үйлдэл хийхийг хүсдэг үү?” гэж асуухад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 4.3 хувь нь “байнга”, 16.3 хувь нь “заримдаа”, 26.5 хувь нь “хаяа”, 53.0 хувь нь “хэзээ ч үгүй” гэж хариулсан байна. Дээрхээс харахад хүүхдүүдэд найз нөхдийн зүгээс шударга бус үйлдэл хийхийг хүсдэг тохиолдол бага бус байгааг харж болохоор байна (Зураг 10).

Зураг 10. Хүүхдэд найз нь шударга бус үйлдэл хийхийг хүсдэг эсэх



Найз нөхдийн нөлөөллийг хүүхдийн шударга байхтай ямар хамааралтай байгааг доорх үзүүлэлтээр харуулав (Зураг 11).

Зураг 11. Хүүхдийн шударга байдлын түвшин, найз нь шударга бус үйлдэл хийхийг хүсдэг эсэх




Дээрх үзүүлэлтээс харахад найз нөхөд нь ямар нэгэн байдлаар шударга бус зүйл хийхийг шаарддаг тохиолдол байгаа ч тэдний хүссэнээр “шударга бус үйлдэл” хийхийг хүсдэггүй хүүхдүүдийн шударга байдлын түвшин хүсдэг буюу “байнга”, “заримдаа”, “хааяа” гэж хариулсан хүүхдүүдийнхээс өндөр байна.

Шударга үйлсийн төлөө сайшаах


Хүүхдийн шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлөх нэг чухал үзүүлэлт бол тухайн хүүхдийг шударга зүйл хийснийх нь төлөө эцэг, эх, багш, найз нөхөд, ойр дотны хүмүүс нь магтаж, сайшааж, урамшуулж, хөхүүлэн дэмжиж байх явдал юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 67.4 хувь нь шударга хандсанаа төлөө сайшаагдаж байсан гэж хариулсан бол, 17.7 хувь нь “зарим нь муулдаг”, 14.9 хувь нь “үгүй” гэж хариулжээ (Зураг 12).

Зураг 12. Хүүхдийг шударга хандсаных нь төлөө сайшааж байсан эсэх



Шударга хандсанаа төлөө сайшаагдах нь хүүхдийн шударга байдлын түвшинтэй ямар хамааралтай болохыг доорх зургаар харуулав (Зураг 13).

Зураг 13. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга хандсаных нь төлөө сайшааж байсан эсэх




Эндээс харахад хүүхдүүд шударга хандсанаа төлөө сайшаагдаж байсан буюу “тийм” гэж хариулсан хүүхдүүдэд хамаарах шударга байдлын түвшин 4.05 буюу хамгийн өндөр байгаа бол “зарим нь муулдаг” гэж хариулсан хүүхдийнх 3.92, “сайшаагдаж байгаагүй буюу үгүй” гэж хариулсан хүүхдүүдийн 3.89 болж буурч байна.

Сургууль:

Бидний ирээдүй, хойч үе болсон хүүхдүүдэд бага наснаас нь эхлэн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилтийн болон авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд эцэг, эх, найз нөхдийн нөлөөллөөс гадна цэцэрлэг болон сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд энэ талаар тодорхой тусгах шаардлагатай байгаа нь жил бүрийн судалгааны үр дүнгээс харагдаж байдаг.


Судалгаагаар хүүхдүүдээс шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог эсэх талаар тодруулахад хүүхдүүдийн 73.7 хувь нь “тийм”, 26.3 хувь нь “үгүй” гэж хариулсан байна (Зураг 14).

Зураг 14. Шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиогддог эсэх



Хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох, эсхүл шударга ёсны талаар ямар нэгэн үйл ажиллагаа зохиогдож байх нь тэдний шударга байдлын түвшинд хэрхэн нөлөөлж байгааг доорх үзүүлэлтээс харж болно (Зураг 15).


Зураг 15. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиогддог эсэх



Дээрх үзүүлэлтээс харахад шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин “үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс 0.13 пунктээр илүү байгаа нь хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох нь тэдний шударга байдлын түвшинг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандах талаар тодруулсныг доорх үзүүлэлтээс харж болно (Зураг 16).

Зураг 16. Багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандах вэ?



Мэдээллийн орчин:


Хүүхдүүдийн шударга байдлын түвшинд эцэг, эх, найз, нөхөд болон сургуулийн орчин нөлөөлөхөөс гадна шударга ёсны талаарх мэдээллийг хаанаас авч байгаа нь чухал нөлөө үзүүлнэ. Шударга ёсны талаарх мэдээллийг сургуулиас авдаг гэж судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 34.7 хувь нь, гэр бүлээсээ гэж 24.8 хувь нь, интернэтээс гэж 15.9 хувь нь, телевиз, радиогоос гэж 9.9 хувь нь хариулсан бол 3.8-5.5 хувь нь найз нөхөд, сонин болон бусад эх үүсвэрээс мэдээлэл хүлээн авч байна (Зураг 17).

Зураг 17. Шударга ёсны талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?




Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг ямар эх үүсвэрээс авч байгаагаас нь хамааран шударга ёсны үзүүлэлтийг доорх зургаар харуулав (Зураг 18).

Зураг 18. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүүхдүүдийн мэдээлэл хүлээн авч буй эх үүсвэрээс хамаарч буй байдал



Аливаа шударга бус үйлдлийг үл тэвчих байдлыг тодорхойлох зорилгоор хүүхдүүдээс шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлж байх нь зөв эсэхийг асуусан юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 75.3 хувь нь шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв гэж үзэж байгаа бол 24.7 хувь нь буруу гэж үзсэн байна (Зураг 19).

Зураг 19. Шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв үү?



ДҮГНЭЛТ

Хүүхдийн шударга байдлын түвшин болон түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, шударга бус хандлагаас нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилгоор 7 дахь удаагийн “Хүүхдийн шударга байдал-2016” судалгаа¹-г Авлигатай тэмцэх газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгууллаа. Энэ удаагийн судалгааг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан, 21 аймаг, нийслэлийн 7-12 дугаар ангийн сурагчдыг хамруулан явуулсан юм. Энэ удаагийн судалгааны дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

- ✓ Хүүхдийн шударга байдлын түвшин 2016 оны судалгаагаар 4.00¹ гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 0.01 пунктийн зөрүүтэй байна.
- ✓ Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.10 болж 0.02 пунктээр, хууль сахих байдлын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.06 болж 0.04 пунктээр, авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлт 3.68 болж 0.03 пунктээр өссөн бол зан төлөвшлийн дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.10 болж 0.05 пунктээр буурсан байна.
- ✓ Дундговь (-0.47), Сүхбаатар (-0.44), Баян-Өлгий (-0.44), Хөвсгөл (-0.27), Увс (-0.23), Архангай (-0.12), Улаанбаатар (0.07), Орхон (-0.03) аймгийн хүүхдийн шударга байдал өмнөх оныхоос буурсан байна.
- ✓ Судалгааны дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин нас ахих тутам буурч байгаагаас гадна эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эмэгтэй хүүхдийнхээс доогуур байна.
- ✓ Хүүхдүүд хүндрэлтэй асуудал тулгарахад хамгийн ихээр эцэг, эх, дотны хүмүүстээ (63.9 хувь нь) ханддаг байна. Эцэг, эх хүүхэдтэйгээ шударга байх талаар байнга ярилцаж байх нь тэднийг шударга хандлага гаргахад эерэгээр нөлөөлж байна.
- ✓ Хүүхдээ буруу зүйл хийснийг мэдсэн эцэг, эх хүүхэддээ болохгүй зүйл хийснийг нь ойлгуулах, тайлбарласнаар тэднийг ирээдүйд зөв төлөвшилтэй, шударга иргэн болоход эерэг нөлөө үзүүлж байна. Эцэг, эх нь хүүхдээ шударга бус зүйл хийснийх нь төлөө хэлж ойлгуулдаг эсхүл зэмлэл хүлээдэг хүүхдүүдийн шударга байдлын түвшин эцэг, эхийн зүгээс хүүхдийнхээ асуудлыг сонирхдоггүй, эсхүл яамар ч арга хэмжээ авдаггүй хүүхдүүдийн шударга байдлын түвшингөөс өндөр байна.
- ✓ Найз нөхдийн хүрээ тухайн хүүхдийн зөв төлөвшилтөд чухал нөлөө үзүүлж байна.
- ✓ Хүүхдийн шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлөх нэг зүйл бол шударга үйлдлийнх нь төлөө “магтах, сайшаах, урамшуулах” явдал болох нь судалгааны дүнгээс харагдаж байна. Магтаал, сайшаал хүртдэг хүүхдүүдийн шударга байдлын түвшин огт сайшагддаггүй хүүхдийнхээс 0.16 пунктээр өндөр байна.
- ✓ Хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиох нь тэдний шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлж

¹ Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

байна. “Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог уу?” гэсэн асуултад “тийм” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин “үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс 0.13 пунктээр өндөр байв.

- ✓ Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг гэр бүлээс авах нь илүү үр дүнтэй байна. Шударга ёсны талаарх мэдээллийг “гэр бүл” -ээс авдаг хүүхдүүд бусад эх үүсвэрээс мэдээлэл авдаг хүүхдүүдээс илүү шударга байна.

ЗӨВЛӨМЖ

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Бүх шатны сургуулиудад шударга ёс (ёс зүй), авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх талаар хичээл оруулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах;
- Хүүхдүүдийн ил тод, шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шударга үйлдэл хийсэн хүүхдүүдийг шалгаруулан урамшуулах, шагнах зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулж, олон нийтэд мэдээлж байх.

ЭЦЭГ, ЭХ БОЛОН БУСАД НАСАНД ХҮРЭГСДИЙН ХУВЬД:

- Эцэг, эх болон бусад хүмүүсийн хувьд шударга байдлаараа гэр бүл, үр хүүхдүүддээ үлгэр жишээч байх;
- Хүүхдүүдэд буруу зүйл хийснийг нь ойлгуулж, тайлбарлах. Хэрэв шударга үйл хийсэн бол тэднийг урамшуулж, сайшааж байх;
- Хүүхдүүдийн найз, нөхдийн хүрээ, хүсэл сонирхлыг нь анхааран мэдэрч байх;
- Хүүхдүүдээ цаг гаргаж шударга ёсны талаар байнга ярилцаж байх.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг телевиз, радио болон интернетээс авч байгаа бөгөөд ялангуяа, телевиз, радиогоор хүүхдийн шударга ёсыг дэмжсэн, сонирхол татахуйц хөтөлбөр, нэвтрүүлгийг бэлтгэн хүргэж байх;
- Хүүхдийн ёс зүй, шударга байдлыг нэмэгдүүлэх талаар санал, санаачилга гаргах, энэ талаар холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх;
- Шударга бус явдлыг дэмжсэн, сайшаасан хөтөлбөр, нэвтрүүлгийг гаргахгүй байх.

**УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН
ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ
ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2016**



УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2016 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл: Авлигатай тэмцэх газар 2008 оноос хойш жил тутам “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулж судалгааны үр дүнг Мянганы хөгжлийн 9 дэх зорилтын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгох, хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх нэг шалгуур болгож ирсэн.

Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхэд мэдээллийн чухал их сурвалж болох учиртай.


Судалгааны хүрээнд дараах зорилтыг тавьж зохион байгуулав.

- Авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, авлигын хэлбэрийг авч үзэх;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын шалтгаан, нөхцөл түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын хэмжээ, түүний хор уршиг, үр дагаврыг гаргах;
- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зэрэг болно.

Судалгааны арга зүй: “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” –ны хүрээнд нийтийн алба (шүүх, хууль сахиулах салбараас бусад), шүүх, хууль сахиулах салбар, хэвлэл мэдээллийн салбар, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, бодлогын судалгаа, олон нийтийн санал бодлын судалгаа, бизнесийн салбар, иргэдийн төлөөллийг оролцуулан нийт 65 шинжээчийг хамруулсан. Судалгааны мэдээллийг цуглуулахдаа асуулгын аргыг ашигласан ба шинжээчдээр асуулт бүрийг “1-ээс 5” гэсэн баллаар үнэлүүлэн тооцоолсон. Баллын үнэлгээ буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол баллын үнэлгээ өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.

Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2015 оны судалгаа”-ны тоо баримттай харьцуулан шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тогтоосон болно.


Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үнэлгээ, үзүүлэлтийн схем



1. 2016 ОНЫ УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШИН

Монгол Улс дахь улс төрийн авлигын түвшин 2011 оноос тогтмол буурч ирсэн боловч 2015 онд 0.07 пунктээр өссөн. Харин 2016 онд 3.65 пункт болсон нь өнгөрсөн онтой адил түвшинд байна.


Зураг 2. Улс төрийн авлигын түвшин, 2008-2016 онд



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улс төрийн авлигын түвшинг тогтоохдоо үндсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашигладаг. 2016 оны судалгаагаар улс төрийн авлигын цар хүрээ нь өмнөх оноос 0.10 пунктээр буурсан бол авлигын хэлбэр өөрчлөгдөөгүй байна. Харин авлигын шалтгаан нөхцөл 0.09 пункт, хор уршиг, үр дагавар 0.05 пунктээр өссөн дүнтэй гарлаа. Судалгааны мэдээллээс дүгнэвэл улс төрийн авлигын цар хүрээ буурсан эерэг үзүүлэлттэй байгаа ч авлигын шалтгаан болон түүнээс үүдэн гарч буй хор уршиг нэмэгдсэн нь авлигын үнэлгээнд сөрөг талаас нөлөөлж буй хэрэг юм. Цаашид улс төрийн авлигын шалтгаан болон нийгэмд үзүүлж байгаа хор хөнөөлийн талаар илүү нарийвчилсан шинжилгээ хийж учир шалтгааныг тодруулах нь улс төрийн авлигын түвшинг бууруулах хүчин зүйлсийн нэг гэж үзэж байна.

Зураг 3. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үнэлгээ 3.53 гарч өмнөх оноос 0.10 пунктээр буурсан байна.

Улс төрийн авлигын цар хүрээг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлсон бөгөөд үүнээс улс төрийн авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.05 пункт буюу хамгийн өндөр гарсан байна. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан үзвэл улс төрийн авлигын түвшний өөрчлөлт 0.32 пункт, улс төрийн авлигын түгээмэл байдал 0.03 пунктээр тус тус өссөн байна.

Зураг 4. Улс төрийн авлигын цар хүрээний үнэлгээ




Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Улс төрийн авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.05 гарч өмнөх оныхоос 0.03 пунктээр өссөн байна.

Шинжээчид улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига их байгаа гэж 55.7 хувь нь үзэж байгаа бол 24.6 хувь нь маш их гэж үнэлжээ. Судалгааны мэдээллээс үзвэл арван шинжээч тутмын найм нь Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлига түгээмэл байсан гэж үнэлж байна.

Зураг 5. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин




Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин өөрчлөгдсөн байдалд өгсөн үнэлгээ 3.58 гарч өмнөх оноос 0.32 пунктээр өссөн дүнтэй байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига өмнөх жилээс нэмэгдсэн гэж шинжээчдийн 45.0 хувь нь үзэж байгаа бол 38.3 хувь нь өөрчлөгдөөгүй, 10.0 хувь нь маш их нэмэгдсэн гэж үнэлжээ. Судалгааны мэдээллээс үзвэл арван шинжээч тутмын зургаа нь Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига өнгөрсөн оноос нэмэгдсэн гэж үзэж байна.

Зураг 6. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт



Дэд үзүүлэлт 3. ТӨРИЙН ИНСТИТУЦ ДЭХ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд хамаарах 16 институцийн авлигын түвшний тархалтын цар хүрээний үнэлгээ нь 3.39 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.13 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт 16 институцийн 10-д нь авлига тархаасан байдлын үнэлгээ буурсан буюу эерэг үзүүлэлттэй байгаа ч улс төрийн намууд 4.36 пункт, засгийн газар /яам, агентлаг/ 4.03 пункттай гарч хамгийн их авлига тархсан институт болсон байна. Харьцуулсан хүснэгтээс үзвэл улс төрийн намууд 0.45 пунктээр, нутгийн өөрөө удирдах байгууллага /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/ 0.14 пунктээр, засгийн газар /яам, агентлаг/ болон аймаг нийслэл, сум дүүргийн Засаг дарга, ЗДТГ 0.06 пунктээр өссөн сөрөг үнэлгээтэй гарчээ.

Хүснэгт 1. Салбар, хүрээнд авлига тархсан цар хүрээ

		2015 он	2016 он	Өөрчлөлт
1.	Тахарын алба ¹	2.82	2.47	-0.35
2.	Хил хамгаалах байгууллага	3.06	2.56	-0.50
3.	Тагнуулын байгууллага	3.21	2.59	-0.62
4.	Авлигатай тэмцэх байгууллага	3.26	2.88	-0.37
5.	Шүүхийн шинжилгээний байгууллага	3.41	2.98	-0.43
6.	Гадаадын иргэн, харьяатын газар	3.24	3.19	-0.05
7.	Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ	3.45	3.35	-0.11
8.	Прокурор	3.72	3.43	-0.29
9.	Шүүх	3.60	3.44	-0.16

1 УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор Тахарын ерөнхий газрыг татан буулгахаар шийдвэрлэсэн.


10.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3.57	3.44	-0.13
11.	Цагдаагийн байгууллага	3.61	3.46	-0.15
12.	Нутгийн өөрөө удирдах байгууллага /Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/	3.41	3.55	0.14
13.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ	3.64	3.70	0.06
14.	Монгол Улсын Их Хурал	3.80	3.71	-0.09
15.	Засгийн газар /яам, агентлаг/	3.96	4.03	0.07
16.	Улс төрийн намууд	3.91	4.36	0.45

Дэд үзүүлэлт 4. ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Төрийн үйл ажиллагааны хүрээний 15 тодорхой чиглэлд авлигын тархалтын үнэлгээ 3.47 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.17 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт 15 тодорхой чиглэлээс 13 чиглэлд авлига тархсан байдлын үнэлгээ буурсан буюу эерэг үзүүлэлттэй байна. Тухайлбал хил хамгаалах 0.67 пункт, шүүхийн шинжилгээ 0.47 пункт, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа нь 0.40 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин албан тушаалын томилгоо хамгийн өндөр буюу 4.30 пункттэй гарсан нь өмнөх оноос 0.17 пунктээр өссөн байна. Мөн тусгай сангийн үйл ажиллагаа 0.10 пунктээр, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах 0.10 пунктээр өссөн нь төрийн үйл ажиллагааны хүрээний авлигын тархалтын үнэлгээ сөрөг гарахад нөлөөлсөн гэж шинжээчид үзжээ.

Зураг 7. Нийтийн алба /төрийн байгууллага/-ын үйл ажиллагаан дахь авлигын түвшин




Дэд үзүүлэлт 5. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН НӨЛӨӨЛӨЛ

Тодорхой салбар хүрээний үйл ажиллагаанд улс төрийн авлигын нөлөөллийн үнэлгээний үзүүлэлт 3.72 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.02 пунктээр буурсан байна.

Нийт 11 салбар, үйл ажиллагааны хүрээний 7 салбар, үйл ажиллагааны хүрээнд авлига чиглэгдэх байдал буурсан эерэг үзүүлэлттэй байна. Тухайлбал шүүх 0.23 пункт, хууль сахиулах 0.13 пункт, хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаа 0.12 пункт, төрийн алба 0.10 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин дэд бүтэц 4.19 пунктээр хамгийн өндөр гарсан бөгөөд өнгөрсөн оноос 0.27 пунктээр өссөн бол барилга 0.15 пункт, гадаадын хөрөнгө оруулалт 0.09 пунктээр өссөн сөрөг үнэлгээтэй гарчээ.

Зураг 8. Улс төрийн хүрээний авлигын нөхцөл байдал, /салбар, үйл ажиллагааны чиглэл/




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ 3.58 гарч өмнөх оны үнэлгээтэй ижил түвшинтэй байна.

Улс төрийн авлигын хэлбэрийг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлсон бөгөөд өнгөрсөн оноос нөлөөллийн хэлбэрийн үнэлгээ 0.02 пункт, улс төрийн нам, бизнесийн бүлэглэлийн хамаарал 0.04 пункт, улс төрийн авлигын хэлбэр 0.02 пунктээр нэмэгдсэн сөрөг үнэлгээтэй гарсан байна.

Зураг 9. Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ




Дэд үзүүлэлт 1. ХЭЭЛ ХАХУУЛИЙН ХЭЛБЭР

Улс төрийн авлигын хүрээн дэх хээл хахуулийн үнэлгээ 3.49 гарч өмнөх оноос 0.06 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Улс төрийн авлигын олон хэлбэр байгаагаас хамгийн түгээмэл гэж үзсэн дараахь хэлбэрийг сонгон үнэлүүлсэн. Улс төрийн авлигын хүрээн дэх хээл хахуулийн 13 хэлбэрээс 8 хэлбэрийн хээл хахуулийн үнэлгээ буурсан эерэг дүнтэй гарсан бол 5 хэлбэр өссөн сөрөг үзүүлэлттэй гарчээ. Тухайлбал хувьцаа өгөх хэлбэр 0.13 пункт, гадаадын банканд данс нээж өгөх хэлбэр 0.24 пункт, ашиг орлогоо хуваалцах хэлбэр 0.09 пункт, ажил, албан тушаалд томилох, оруулах хэлбэр 0.31 пункт, шагнал, цол, тэмдгээр шагнах хэлбэр 0.29 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин эмчилгээ, сувилгааны зардал төлөх хэлбэр 0.49 пунктээр, сургалтын зардлыг төлөх хэлбэр 0.39 пунктээр тус бүр буурсныг шинжээчид тодорхойлж байна.

Зураг 10. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ




Дэд үзүүлэлт 2. ХУУЛЬ БУС НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР

Улс төрчид, өндөр албан тушаалтнууд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ нь 3.64 гарч өмнөх оноос 0.02 пунктээр өссөн байна.

Хууль бус нөлөөллийг тогтоох 9 дэд үзүүлэлтээс 4 дэд үзүүлэлтийн үнэлгээ өссөн бөгөөд үүнд намын хэлхээ холбоог ашиглах хэлбэр 0.34 пункт, нутаг орны хэлхээ холбоог ашиглах хэлбэр 0.27 пункт, найз, танил талын хэлхээ холбоог ашиглах хэлбэр 0.26 пункт, садан төрлийн хэлхээ холбоог ашиглах хэлбэр 0.17 пунктээр өссөн нь хууль бус нөлөөллийн үнэлгээ сөрөг талдаа өөрчлөгдөхөд нөлөөлсөн байна.

Зураг 11. Хууль бус нөлөөллийн үнэлгээ



Дэд үзүүлэлт 3. УЛС ТӨРИЙН НАМ, БҮЛЭГЛЭЛ, УЛС ТӨР, БИЗНЕС, ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮДИЙН ХАРИЛЦАА ХАМААРАЛ

Төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчид болон улс төрийн нам, бүлэглэл, гадаад дотоод бизнесийн бүлэглэл, гэмт бүлэглэлийн харилцаа хамаарлын үнэлгээ 3.44 гарч өнгөрсөн оноос 0.04 пунктээр өссөн байна.

Нийт 11 нөхцөл байдлын үзүүлэлтээс 5 үзүүлэлтийн үнэлгээ өссөн нь үнэлгээний түвшинд сөргөөр нөлөөлсөн байна. Тухалбал гаднын улс бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ийг эрхшээлдээ оруулсан байдал 0.22 пункт, улс төрчид шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн байдал 0.22 пункт, гаднын улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тэй нэгдсэн байдал 0.18 пункт, улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан байдал 0.12 пунктээр өссөн байна. Судалгааны мэдээллээс үзвэл гаднын улс, бизнесийн бүлэглэлийн нөлөөлөл үйл ажиллагаанд хамгийн ихээр нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт 2. Нөхцөл байдлын үнэлгээ

№		2015 он	2016 он	Өөрчлөлт
1.	Улс төрчид бизнесийн бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3.39	3.61	0.22
2.	Бизнесийн бүлэглэл улс төрчдийг эрхшээлдээ оруулсан	3.87	4.05	0.18
3.	Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	3.93	4.23	0.30


4.	Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3.00	2.88	-0.12
5.	Гэмт бүлэглэл улс төрийн нам /бүлэглэл/-ийг эрхшээлдээ оруулсан	2.61	2.96	0.35
6.	Гадны улс төрийн бүлэглэл Монголын Улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	2.90	2.88	-0.02
7.	Гадны улс бизнесийн бүлэглэл Монголын Улс төрийн нам /бүлэглэл/-ийг эрхшээлдээ оруулсан	3.15	2.93	-0.22
8.	Гадны улс төрийн бүлэглэл Монголын Улс төрийн нам /бүлэглэл/-тэй нэгдсэн	2.81	2.64	-0.18
9.	Гадны бизнесийн бүлэглэл Монголын Улс төрийн нам /бүлэглэл/-тэй нэгдсэн	3.13	3.00	-0.13
10.	Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.00	4.13	0.13
11.	Улс төрчид шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	3.88	3.67	-0.22

Дэд үзүүлэлт 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ 3.84 гарч өнгөрсөн оноос 0.02 пунктээр өссөн үнэлгээтэй байна.

Нийт 15 дэд үзүүлэлтийн 9 дэд үзүүлэлтэд дунджаар 0.01 пунктээр өссөн нь үнэлгээний түвшинд сөргөөр нөлөөлсөн байна. Үүнд улс төрийн зорилгоор хандив өгөх, авах байдал 0.30 пункт, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох байдал 0.28 пункт, бизнесийн бүлэглэлийн захиалгаар хууль тогтоомж санаачлан батлуулах, дэмжих үйл ажиллагаа 0.21 пунктээр өссөн нь нөлөөлөх гол хүчин зүйл болжээ. Харин хууль бусаар дампууруулах хэлбэр 0.45 пунктээр буурсан нь хамгийн эерэг үзүүлэлт болжээ.

Зураг 12. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэр



Дэд үзүүлэлт 5. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ АРГА

Улс төрийн хүрээний хээл хахууль өгөх авах аргуудыг хэрэглэсэн байдлын үнэлгээ 3.37 гарч өмнөх оноос 0.01 пунктээр буурсан байна.

Нийт 11 түгээмэл үзүүлэлтийн 6 дэд үзүүлэлтийн үнэлгээ буурсан эерэг үзүүлэлттэй байгаа бол 5 дэд үзүүлэлтийн үнэлгээ өссөн сөрөг үнэлгээтэй гарчээ. 2016 онд эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах байдал 0.25 пунктээр буурсан нь хамгийн эерэг үзүүлэлт байгаа бол ойр дотнын хүмүүсээр дамжуулах хэлбэр 0.22 пункт, мөрийтэй тоглож санаатай алдах хэлбэр 0.20 пунктээр өссөн хамгийн сөрөг үзүүлэлт болжээ.

Зураг 13. Улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээ




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 3. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Улс төрийн авлигын түвшний шалгуураас шалтгаан нөхцөлийн үзүүлэлт 2016 онд 3.89 гарч өнгөрсөн оноос 0.09 пунктээр нэмэгдсэн байна. Шалтгаан, нөхцөлийн үзүүлэлтийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зорилгоор 3 дэд үзүүлэлтийн хүрээнд шинжилгээ хийж тодорхойлов.

Улс төрийн авлигын шалтгаан, нөхцөлийн үзүүлэлтээс бүлэглэлүүдийн нөхцөл байдал болон улс төрийн авлигын түвшинд нөлөөлсөн дутагдал доголдол, улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үзүүлэлт өссөн нь улс төрийн авлигын шалтгаан, нөхцөл сөрөг гарахад нөлөөлсөн байна.

Зураг 14. Шалтгаан, нөхцөл



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГАД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ 3.81 гарч өнгөрсөн оноос 0.06 пунктээр буурсан байна.

Улс төрийн авлигын нөлөөллийг 11 дэд хүчин зүйлсээр хэмжсэн бөгөөд үүний 4 дэд хүчин зүйлсийн үнэлгээ буурсан эерэг үнэлгээтэй байгаа бол 7 дэд хүчин зүйлсийн үнэлгээ өссөн сөрөг дүн гарсан байна. 2016 оны байдлаар УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчлийн үнэлгээ 1.01 пунктээр буурсан нь нийт үнэлгээнд хамгийн их нөлөөлсөн байна. Харин сонгуулийн санхүүжилтийн механизм 0.27 пункт, улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил 0.25 пункт, намын санхүүжилтийн механизм 0.20 пунктээр тус тус өссөн сөрөг үнэлгээтэй гарсан байна.

Хүснэгт 3. Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ

№		2015 он	2016 он	Өөрчлөлт
1.	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	3.68	3.72	0.04
2.	Сонгуулийн санхүүжилтийн механизм	3.90	4.17	0.27
3.	Намын санхүүжилтийн механизм	4.11	4.31	0.20
4.	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.33	4.48	0.15
5.	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.89	2.88	-1.01
6.	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.95	4.02	0.07
7.	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.66	3.71	0.05
8.	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	3.85	4.10	0.25
9.	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.81	3.49	-0.32
10.	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	3.76	3.45	-0.32
11.	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	3.50	3.45	-0.05

Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ДУТАГДАЛ, ДОГОЛДОЛ

Улс төрийн авлигад төрийн үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ 3.94 гарч өнгөрсөн оноос 0.13 пунктээр өссөн үнэлгээтэй гарсан байна.

Төрийн үйл ажиллагааны дутагдал, доголдлыг 12 дэд үзүүлэлтэд хамааруулж хэмжсэн бөгөөд үүний 11 дэд үзүүлэлтийн үнэлгээ өсөлттэй буюу сөрөг гарчээ. Шинжээчдийн онцолж байгаагаар хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул, албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж, төрийн албан хаагчийн ур чадвар дутмаг гэх зэрэг үзүүлэлтийг нэрлэсэн нь дунджаар 0.17 пунктээр өссөн байна.

Хүснэгт 4. Улс төрийн авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол


№		2015 он	2016 он	Өөрчлөлт
1.	Хүнд суртал	3.98	4.02	0.04
2.	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	4.02	4.09	0.07
3.	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	3.75	3.69	-0.06
4.	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	3.75	3.83	0.08
5.	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	3.88	3.94	0.06
6.	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	3.83	4.02	0.19
7.	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	3.80	4.17	0.37
8.	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	3.78	4.08	0.28
9.	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	3.75	4.03	0.29
10.	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.73	3.84	0.11
11.	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	3.89	3.89	0.00
12.	Төрийн албан хаагчийн ур чадвар дутмаг	3.62	3.74	0.12

Дэд үзүүлэлт 3. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХҮРЭЭЛЛҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улс төрийн хүрээн дэх тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн хүрээллийн нөхцөл байдлын үнэлгээ 3.78 гарч өнгөрсөн оноос 0.08 пунктээр өссөн байна.

Нийт 7 дэд үзүүлэлтээс 6 дэд үзүүлэлтийн үнэлгээ өссөн дүнтэй гарчээ. Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нэг хүнийг тойрсон хүрээлэл, хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нэг нутаг /аймаг/ тойрсон хүрээллийн нөлөөллийг их байсан гэж үзэж байгаа бол нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээллийн үзүүлэлт буурсан үнэлгээтэй байна.

Зураг 15. Улс төрийн хүрээн дэх хүрээллүүдийн нөхцөл байдал




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Улс төрийн авлигын түвшний шалгуураас авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 2016 онд 3.69 гарч өнгөрсөн оноос 0.05 пунктээр нэмэгдсэн байна.

Хор уршиг, үр дагаврын үзүүлэлтийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зорилгоор 2 дэд үзүүлэлтийн хүрээнд шинжилгээ хийж тодорхойлов. Улс төрийн авлигын хор уршиг, үр дагавар болон улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үзүүлэлт өссөн нь улс төрийн авлигын хор уршиг, үр дагаврын нөхцөл сөрөг гарахад нөлөөлсөн байна.

Зураг 16. Улс төрийн авлигын хор уршиг, үр дагавар



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ

Улс төрийн авлигын хор уршгийн үзүүлэлтийн үнэлгээ 4.02 болж өнгөрсөн оноос 0.13 пунктээр нэмэгдсэн байна.

Нийт 16 дэд үзүүлэлтээс 12 дэд үзүүлэлтийн үнэлгээ дунджаар 0.04 пунктээр нэмэгдсэн нь улс төрийн авлигын хор уршгийн үзүүлэлтийн үнэлгээ сөрөг дүнтэй гарахад нөлөөлсөн байна. Тухайлбал инфляц нэмэгдэхэд нөлөөлсөн байдал 0.41 пункт, гадаадын хөрөнгө оруулалт буурахад нөлөөлсөн байдал 0.40 пункт, улс орны эдийн засгийн хүч чадал сулрахад нөлөөлсөн байдал 0.36 пункт, төрийн албаны чадавх сулрахад нөлөөлсөн байдал 0.30 пунктээр тус тус өссөнийг шинжээчид онцолж байна.

Зураг 17. Улс төрийн хүрээний авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин




Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГААР ОЛСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээ 3.38 гарсан нь өнгөрсөн оноос 0.02 пунктээр өссөн байна.

Уг үзүүлэлтэд хамаарах 19 дэд үзүүлэлтийн 10 дэд үзүүлэлтийн үнэлгээ өссөн байна. Үүнээс гадаадын банканд хадгалах болон гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах байдлыг гэж шинжээчид хамгийн их гэж үзжээ. Тухайлбал гадаадын банканд хадгалах байдал 0.32 пункт, гадаадын оффшор бүсэд компани байгуулах байдал 0.20 пункт, гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах байдал 0.13 пункт, хувьцаа худалдан авах байдал 0.15 пункт, дотоодод орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдан авах байдал 0.10 пунктээр өссөн нь улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээ сөрөг дүнтэй гарахад хамгийн ихээр нөлөөлсөн гэж шинжээчид үзсэн байна.

Зураг 18. Улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт




2. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

Дэд бүлгийн энэхүү хүрээнд улс төрийн авлигын үндсэн үнэлгээнээс гаднах бусад үзүүлэлтүүдийн байдлаар авлигын ерөнхий ойлголт, төсөөллийг гаргаж ирэхийг зорьсон юм.

АВЛИГЫН ТҮВШИН

Судалгаанд оролцсон нийт шинжээчдийн 47.7 хувь нь Монгол Улсад авлига их байна гэж үнэлсэн бол 26.2 хувь нь маш их гэж үзжээ. Судалгааны мэдээллээс дүгнэвэл арван шинжээч тутмын долоо нь Монгол Улсад авлига сүүлийн нэг жилийн хугацаанд түгээмэл байсан гэж үнэлсэн байна.


Зураг 19. Монгол Улс дахь авлигын түвшин



УЛС ТӨРИЙН НАМУУДЫН АВЛИГАД АВТСАН БАЙДАЛ

Судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлгээгээр 2016 онд улс төрийн намуудын авлигад автсан байдлыг тус бүрд нь тооцож үзвэл АН 35.4 хувь, МАН 31.1 хувь, МАХН 18.3 хувь, ИЗНН 6.1 хувьтай эхний дөрвөн байрт жагсаж байна. Судалгааны мэдээллээс дүгнэвэл хамгийн их авлигад автсан намаар АН болон МАН-ыг тус тус нэрлэсэн байна.

Зураг 20. Монгол Улс дахь улс төрийн намуудын авлигад автсан байдал



АВЛИГЫН ХҮРЭЭНИЙ ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Монгол Улсын авлигын ерөнхий хандлагын зэрэгцээ цар хүрээгээр нь тодорхойлохыг зорьсон юм. Улс орны авлига ямар түвшинд байгаа нь цар хүрээний тархацтай шууд холбоотой юм. Нийт 11 дэд хүрээнээс улс төрийн нам 4.33 пункт, засгийн газар 4.05 пунктаар авлигын тархалтын үзүүлэлт хамгийн өндөр байгаа бол төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хүрээнд харьцангуй бага пункттэй гарчээ. Шинжээчдийн үнэлгээнээс үзвэл төрийн дээд шатны байгууллага болон улс төрийн намын хүрээнд авлига илүү түгээмэл байсан гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт 5. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдал

		Огт үгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Их	Маш их
1.	Төрийн бус байгууллага	25.9	53.7	11.1	7.4	1.9
2.	Хувийн хэвшил	7.1	42.9	30.4	12.5	7.1
3.	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	1.9	13.2	45.3	32.1	7.5
4.	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	1.8	22.8	22.8	33.3	19.3
5.	Шүүх	3.4	13.8	27.6	36.2	19.0
6.	Улс төрийн нам	1.7	1.7	8.3	38.3	50.0
7.	Улсын их хурал	3.3	5.0	30.0	40.0	21.7
8.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж	-	7.7	28.8	44.2	19.2
9.	Засгийн газар		4.8	17.5	46.0	31.7
10.	Прокурор	1.9	9.3	29.6	48.1	11.1
11.	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	1.7	10.3	25.9	48.3	13.8

АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛСӨН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС

Шинжээчид Монгол Улсын авлигын түвшинд нөлөөлж байгаа олон хүчин зүйлсийг нэрлэж байгаа ч үүнээс сонгууль, улс төрийн тогтворгүй байдал, албан тушаалын наймаа, төрийн алдаатай бодлого зэргийг тус тус онцолж байна.

Хүснэгт 6. Монгол Улсын авлигын ерөнхий түвшинд нөлөөлсөн гол нөхцөл байдал

№		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1.	Танил тал харж албан тушаалд томилдог.	1.1	1.6
2.	Үлгэр дууриалал үзүүлэх улс төрчид, спортынхон, бөхчүүд шударга бус байснаас олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлсөн.	1.1	1.6
3.	Авлигын хэргүүдээс болж улам доошилсон.	1.1	1.6
4.	АТГ-ын соён гэгээрүүлэх үйл ажиллагаа сайжирсан, ил тод явуулж байна.	1.1	1.6
5.	Мөнгөтэй болох үл хөдлөх хөрөнгөтэй болох	1.1	1.6
6.	Танил талын хүмүүсээр буюу итгэлтэй хүмүүсээр хүрээлүүлэл бүрдүүлдэг болсон.	1.1	1.6
7.	Хэвлэлийн эрх чөлөө, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хаалттай гэрээ хийж санхүүжүүлэн дуугүй болгосон байдал хамгийн их нөлөөлсөн.	1.1	1.6
8.	Цалин тэтгэмжийн хангалтгүй байдал болон гарааны тэгш бус байдлыг бий болгож буй хууль, дүрмүүд.	1.1	1.6
9.	Эрдэнэтийн хувьчлалын асуудал.	1.1	1.6
10.	Хууль журмын талаарх мэдлэг дутмаг.	1.1	1.6
11.	Ажлын хариуцлага ёс зүй, шударга бус байдал газар авсантай холбоотой.	2.2	3.2
12.	Төсөв бондын мөнгийг хууль бусаар ашиглах, завших явдал улаан цайм болсон. Үүнд тавих хяналт хангалтгүй байсантай холбоотой.	2.2	3.2

13.	Албан тушаалтны цалин бага, авч байгаа цалин нь хүрэлцээгүйд байгаа.	2.2	3.2
14.	Тусгай зөвшөөрөл олгох, цуцлах үйл ажиллагаа авлигын түвшинд ихээхэн нөлөөлсөн.	2.2	3.2
15.	Шилэн данс, мэдээллийн ил тодын тухай хууль хэрэгжиж буй байдал. Цахим орчин дахь иргэдийн хяналт эрс нэмэгдсэн.	2.2	3.2
16.	Хувийн хэвшилд төр их хутгалдсанаас, хувийн эрх ашиг давамгайлснаас.	2.2	3.2
17.	Хуулийн хэрэгжилт сул байдал зохих хэмжээгээр нөлөөлж байна.	3.4	4.8
18.	Авлига өгсөн авсан хүмүүс, байгууллагад тодорхой шийтгэл оноодоггүй. Авилгад өршөөгдөж байгаа нь нийгэм дэх шударга ёсны үнэ цэнэ байхгүй болоход нөлөөлж байна.	3.4	4.8
19.	Хувь хүний ухамсаргүй үйлдэл. Ёс зүйн доголдол, хангалттай шийтгэх тогтолцоогүй байдал.	3.4	4.8
20.	Ашиг сонирхлын зөрчил, ил тод бус байдал, хууль хэрэгждэггүй байдал, төрийн албаны хүнд суртал.	6.7	9.5
21.	Улс төрийн нам, бизнесийн олигарх бүлэглэлүүдийн ашиг сонирхол төрд гарсан. Өндөр түвшний авилга газар авсан байдал.	6.7	9.5
22.	Төрийн алдаатай бодлого нь нийгэм эдийн засгийн байдалд сөргөөр нөлөөлж байгаагаас ажилгүйдэл, томоохон хөрөнгө оруулалт зогссон.	11.2	15.9
23.	Албан тушаалын наймаа нэлээдгүй байгаа. Албан тушаалд томилох УИХ-ын гишүүдийн оролцоо маш их байна. Төрийн ямар ч албанд цэвэр өрсөлдөөний зарчмаар орох боломж байхгүй	15.7	22.2
24.	Сонгууль, Улс төрийн тогтворгүй байдал,	24.7	34.9
Нийт		100.0	141.3

БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЗАРЦУУЛЖ БУЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны явцад өгч буй авлигын үнэлгээг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл тендерт шалгаруулалтад ялахад, тусгай зөвшөөрөл авахад үйл явцад, төсөл хөтөлбөрт хамрагдахад илүү өндөр авлига өгдөг гэжээ.

Хүснэгт 7. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ

	5 хүртэлх хувь	6-10 хувь	11-15 хувь	16-20 хувь	21 дээш хувь
1. Төсөл хөтөлбөрт хамрагдах	25.0	29.2	15.6	16.7	14.6
2. Тендерт шалгаруулалтад ялахад	11.1	24.1	25.9	16.7	22.2
3. Зээл авахад	21.6	41.2	21.6	11.8	3.9
4. Өр төлбөр барагдуулах, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэхэд	28.6	38.1	16.7	11.9	4.8
5. Татвараас чөлөөлүүлэх, буруулахад	25.6	32.6	23.3	9.3	9.3
6. Хяналт шалгалтаар зөрчил дутагдалгүй гарахад	21.7	32.6	21.7	17.4	6.5
7. Тусгай зөвшөөрөл авахад	17.6	19.6	25.5	25.5	11.8

8.	Бараа ажил, үйлчилгээ хүлээлгэн өгөхөд	21.4	33.3	21.4	19.0	4.8
9.	Гадаадаас ажиллах хүч авахад	34.3	20.0	20.0	20.0	5.7

Хээл хахуульд өгч буй мөнгөн дүнг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход, тусгай зөвшөөрөл авахад зэрэгт хамгийн их өгдөг гэж шинжээчид хариулжээ.

ХЭЭЛ ХАХУУЛЬД ЗАРЦУУЛСАН МӨНГӨНИЙ ХЭМЖЭЭ

Хүснэгт 8. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ /зорилгоор/, сая төгрөгөөр

		1 сая хүртэл	1-5 сая	5-10 сая	10-20 сая	20-50 сая	50 саяас их
1.	Ажил, албан тушаалд ороход	4.3	37.0	21.7	15.2	4.3	17.4
2.	Тусгай зөвшөөрөл авахад	2.0	18.4	26.5	22.4	6.1	24.5
3.	Ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад	10.0	-	2.5	17.5	22.5	47.5
4.	Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход	2.9	8.8	20.6	20.6	32.4	14.7
5.	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход	2.4	29.3	22.0	19.5	14.6	12.2
6.	Эрүүгийн хэрэг үүсгэхэд	17.1	17.1	25.7	22.9	5.7	11.4
7.	Гэмт хэрэг зөрчлийг нуун дарагдуулахад	17.2	17.1	17.2	17.1	14.3	17.1
8.	Хуурамч бичиг баримт үйлдэхэд	18.8	28.1	28.1	9.4	6.3	9.4

ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шинжээчид улс төрийн хүрээн дэх авлигыг бууруулахад олон төрлийн арга хэмжээ шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнээс ур чадварт үндэслэн томилгоо хийх тогтолцоог бүрдүүлэх, улс төрийн намын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл зоригийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа зэргийг илүүтэй онцолж байна.


Зураг 21. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ




3. ШИНЖЭЭЧДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд оролцсон шинжээчдийг хүн ам зүйн байдлаар авч үзвэл 67.7 хувь нь эрэгтэй, 32.3 хувь нь эмэгтэй байна. Харин насны бүтцийн хувьд 35-44 насныхан 44.6 хувийг эзэлж байгаа бол 45-54 насныхан 23.1 хувьтай хамрагдсан байна.

Зураг 22. Шинжээчдийн хүйс




Зураг 23. Шинжээчдийн нас



Төрийн байгууллагад ажиллагсад 44.6 хувь, төрийн бус байгууллагад ажиллагсад 23.1 хувь, хувийн хэвшилд ажиллагсад 18.5 хувьтай, олон улсын байгууллагад ажиллагсад 9.2 хувь, судлаачид 4.6 хувьтай байна.

Зураг 24. Шинжээчдийн ажиллаж буй салбар



ДҮГНЭЛТ

Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 2016 онд өнгөрсөн оны буюу 2015 оны үзүүлэлттэй адил дүнтэй гарлаа. Улс төрийн авлигын түвшин буураагүй байгаа нь Монгол Улсад авлига түгээмэл тархалттай хэвээр байгааг илтгэж байна.

Авлигын цар хүрээ буурч, авлигын илрэн гарч буй хэлбэр өөрчлөгдөөгүй байгаа ч авлигад нөлөөлж буй шалтгаан, нөхцөл болон учруулж буй хор уршиг зэрэг үр дагавар нэмэгдсэн байна.

Намын болон сонгуулийн санхүүжилтийн механизм, улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил зэрэг нь улс төрийн авлигад нөлөөлсөн гол шалтгаан нөхцөл болсон байна. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль болж өнгөрсөнтэй холбоотойгоор сонгуулийн үйл явцад гарч буй хууль бус үйлдэл, эрх мэдлийн төлөөх тэмцэл нь улс төрийн авлигад нөлөөлөх гол хүчин зүйлс болсныг шинжээчид онцолжээ. Түүнчлэн хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал, олон шат дамжлага, давхардал, хийдэл, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул зэрэг нь төрийн албаны үйл ажиллагааны дутагдал бөгөөд авлигыг нөхцөлдүүлэгч бас нэгэн шалтгаан юм.

Улс төрийн хүрээний авлигын хор уршиг нь улс орныг бүхэлд нь хамарсан нийгэм, эдийн засгийн олон сөрөг үзэгдлийг үүсгэх шалтгаан болж байгаа юм. Тухайлбал улс орны эдийн засгийн хүч чадал суларсан, гадаадын хөрөнгө оруулалт буурсан, өмч хөрөнгийн тэгш биш байдал нэмэгдсэн, шударга ёс алдагдсан зэрэгт авлигын хор уршиг, үр дагавар ихээхэн нөлөөлжээ.

Улс төрчид төрийн өндөр албан тушаалтнууд авлигын замаар олсон хөрөнгөө гадаадын банканд хадгалах, гадаадын оффшор бүсэд компани байгуулах, гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах зэрэг олон замаар зарцуулдаг гэж шинжээчид үзэж байгаа нь улс төрийн хүрээний авлига улам нарийн зохион байгуулалттай далд хэлбэр үүсгэх нөхцөл нь болсон гэж дүгнэж болохоор байна.

Улс төрийн хүрээн дэх авлигыг бууруулахад олон төрлийн арга хэмжээ шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнээс ур чадварт үндэслэн томилгоо хийх тогтолцоог бүрдүүлэх, улс төрийн намын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл зоригийг нэмэгдүүлэх зэргийг шинжээчид тус тус онцолж байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА БАЙДЛЫН
ҮНЭЛГЭЭ-2016

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2016

ХУРААНГУЙ

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Авлигын индекс тооцох аргачлал”-ыг Авлигатай тэмцэх газрын дарга болон Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 76/(06/69) тоот хамтарсан тушаалаар, “Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлал”-ыг Авлигатай тэмцэх газрын даргын 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 59 дугаар тушаалаар тус тус батлан эдгээр аргачлалын дагуу Авлигын индексийг 2009, 2011, 2013 онд, Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг 2010, 2012, 2014 онуудад тооцож, олон нийтэд мэдээлж байсан билээ.

Авлигын индексийг тооцох, төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх явцад арга зүйгээ улам бүр боловсронгуй болгох, энэ чиглэлээр олон улсын түвшинд гарсан шинэлэг арга зүй, ололт амжилтыг тусгах шаардлага зүй ёсоор тавигдсан юм. Энэхүү шаардлагын дагуу дээрх хоёр судалгааг нэгтгэн бусад улс орны тэргүүн туршлагад үндэслэн “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны А/129 дугаар тушаалаар батлуулсан билээ. Уг аргачлалын дагуу 2015, 2016 онд шударга байдлын үнэлгээг тооцон гаргаад байна. Авлигын индекс, төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг нэг удаагийн судалгаагаар хамт тооцох нөхцөл бүрдсэн, нөгөө талаас цаг хугацаа, хөрөнгө хэмнэх ихээхэн ач холбогдолтой болсон.

Мөн Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д зааснаар Авлигатай тэмцэх газраас гаргасан “Байгууллагын шударга байдлын түвшингийн үнэлгээ” нь төрийн захиргааны байгууллагын үнэлгээний шалгуур үзүүлэлт болдог байсан. Дээрх журмыг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болгон шинэчлэн баталсан бөгөөд уг журмын 9.9-д “Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын түвшингийн үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно” гэж заасан байдаг.

Шударга байдлын үнэлгээ (ШБҮ) нь тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ (үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн үнэлгээ), дотоод шударга байдлын үнэлгээ (төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчдын үнэлгээ), бодлогод оролцогчдын үнэлгээ (шинжээчдийн үнэлгээ) гэсэн гурван дэд үнэлгээнээс бүрдсэн үнэлгээ юм.

Үнэлгээг 0-100 хүртэл оноогоор тооцох бөгөөд утга нь 100-тай тэнцүү бол шударга байдлын дээд түвшинг илэрхийлнэ. ШБҮ-нд 2015 онд 62, 2016 онд 60 байгууллага (яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ)-ыг хамруулаад байна.

ШБҮ-ний 2016 оны судалгаанд нийтдээ 4900 нэгж (Гадаад шударга байдлын үнэлгээнд 2890 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, Дотоод шударга байдлын үнэлгээнд 1410 төрийн албан хаагч, Бодлогод оролцогчдын үнэлгээнд 620

шинжээч)-ийг хамруулсан болно.

Төрийн байгууллагууд ШБҮ-ээр 100 онооноос 2016 онд дунджаар 69.7 оноо авсан нь өмнөх оныхоос 4.2 пунктээр буурсан байна. ШБҮ-ний дундаж оноо өмнөх оныхоос буурсан нь тухайн төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өгсөн үнэлгээ 6.5 пунктээр, шинжээчдийн үнэлгээ 5.0 пунктээр, тухайн төрийн албан хаагчдын өгсөн үнэлгээ 1.0 пунктээр тус тус буурсантай холбоотой юм.

Цаашид төрийн байгууллагууд удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн бодлогын ил тод, шударга байдлыг хангах, авлигын эсрэг үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд сурталчлах, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг “шүгэл үлээх” механизмыг дэмжих зэрэг үйл ажиллагаанд анхаарал хандуулж, тодорхой үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна.

ШБҮ-НИЙ АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ

Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/129 тушаалын нэгдүгээр хавсралтаар “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Шударга байдлын үнэлгээний судалгааг зохион байгуулах удирдамж”-ийг, гуравдугаар хавсралтаар “Судалгааны асуулгын маягт”-ыг тус тус баталсан билээ (дэлгэрэнгүй байдлаар Авлигатай тэмцэх газрын <http://www.iaac.mn/category/23?menu=181> цахим хуудаснаас үзнэ үү).

ШБҮ-ний зорилго

ШБҮ-г дараахь зорилгын хүрээнд зохион байгуулж байна.


- Шударга ёсыг бэхжүүлэх, авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, авлигыг таслан зогсоох болон төрийн байгууллагаас авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг суурь мэдээллээр хангах;
- Тухайн байгууллагын үнэлгээг нэмэгдүүлэхэд зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох;
- Үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх замаар төрийн байгууллагын зүгээс үнэлгээний үр дүнг сайжруулах хүсэл зоригийг нэмэгдүүлэх, авлигыг бууруулах санал, санаачилга өрнүүлэх, эрмэлзлэлийг бий болгох.

ШБҮ-ний бүтэц


ШБҮ гэж тухайн байгууллагын ГШБҮ, ДШБҮ, БОҮ-ний 62 дэд үзүүлэлтэд тулгуурласан үнэлгээ юм. Үүнд:

- Гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ) гэж тухайн байгууллагын шударга байдалд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн өгч буй үнэлгээг;
- Дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ) гэж тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын зүгээс байгууллагынхаа талаар өгч буй үнэлгээг;
- Бодлогод оролцогчдын үнэлгээ (БОҮ) гэж тухайн байгууллагын шударга байдлын талаарх бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын өгсөн үнэлгээг хэлдэг.

ШБҮ-ний үзүүлэлтийн систем



ШБҮ-ний загвар, 2016 он



Түүвэрлэлт, түүврийн хэмжээ

1. Үнэлгээнд хамруулсан байгууллага

ШБҮ-нд зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний байгууллага буюу яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг хамруулдаг бөгөөд тухайн жилд үнэлгээнд хамруулах байгууллагын нэрсийг Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар баталдаг. ШБҮ-ний 2016 оны судалгаанд нийтдээ 60 байгууллага (яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ)-ыг хамруулсан болно. Судалгаанд хамруулсан байгууллагын нэрсийг хавсралтаас харна уу.

2. Түүврийн хэмжээ


ШБҮ-нд хамрагдсан 60 байгууллага (13 яам, 25 агентлаг, 21 аймаг, нийслэлийн ЗДТГ)-ыг үнэлэх түүврийн хэмжээ нь нийтдээ 4900 нэгж (ГШБҮ-нд 2890 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, ДШБҮ-нд 1410 төрийн албан хаагч, БОҮ-нд 620 шинжээч) байв.

Мэдээлэл цуглуулалт

ШБҮ-ний судалгааны мэдээлэл цуглуулах ажлын АТГ-аас нэгдсэн удирдамжаар хангаж ажилласан бөгөөд мэдээлэл цуглуулалтыг судалгаа, дүн шинжилгээний компанийг сонгон шалгаруулж улсын хэмжээнд гүйцэтгүүлсэн болно. Мэдээлэл цуглуулах ажлыг улсын хэмжээнд 2016 оны 10 дугаар сарын 1-ээс 11 дүгээр сарын 15-ны хооронд зохион байгуулсан юм.

ШБҮ-НИЙ ҮР ДҮН


ШБҮ-ний дундаж оноо 2016 онд 69.7¹ гарсан нь өмнөх оныхоос 4.2 пунктээр буурсан байна. Ийнхүү буурахад тухайн төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өгсөн үнэлгээ 6.5 пунктээр, шинжээчдийн үнэлгээ 5.0 пунктээр, тухайн төрийн албан хаагчдын өгсөн үнэлгээ 1.0 пунктээр тус тус буурсан нь нөлөөлөв.



ШБҮ-нд хамрагдсан байгууллагуудыг 0-100 оноогоор үнэлэхэд 61.4-77.7 оноо авсан байна. Үнэлгээг байгууллагаар авч үзвэл Биеийн тамир, спортын газар, Цагдаагийн ерөнхий газар, Дорноговь аймгийн ЗДТГ, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Баян-Өлгий аймгийн ЗДТГ, Зам, тээврийн хөгжлийн яам, Говьсүмбэр аймгийн ЗДТГ, Ашигт малтмал, газрын тосны газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Гаалийн ерөнхий газар харьцангуй бага оноо авсан байна.

ШБҮ-г байгууллагын төрлөөр нь авч үзвэл 2016 онд яамдын үнэлгээ 69.2 болж өмнөх оныхоос 3.2 пунктээр, ЗГ-ын агентлагийн үнэлгээ 70.5 болж өмнөх оныхоос 5.9 пунктээр, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 69.0 болж өмнөх оныхоос 3.9 пунктээр тус тус буурчээ.

¹ Шударга бол 100 оноо, шударга бус бол 0 оноо авна



ШБҮ-ний дүнгээр 2016 онд 13 яамны 11-нийх нь үнэлгээ өмнөх оныхоос буурсан байгаагийн дотор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны үнэлгээ 13.1 пунктээр, Эрчим хүчний яамны үнэлгээ 6.3 пунктээр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 6.0 пунктээр, Хууль зүй, дотоод хэргийн яам 5.6 пунктээр буурсан нь хамгийн өндөр дүнтэй байна.

Засгийн газрын 25 агентлагаас Цагдаагийн ерөнхий газрын үнэлгээ 15.1 пунктээр, Цаг уур, орчны шинжилгээний газрын үнэлгээ 7.7 пунктээр, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын үнэлгээ 7.3 пунктээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үнэлгээ 6.6 пунктээр буурсан байна.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ-г авч үзэхэд 22 байгууллагын 18-ынх нь үнэлгээ өмнөх оныхоос буурсан байгаагийн дотор Дорноговь аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 17.3 пунктээр, Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 14.0 пунктээр, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 10.4 пунктээр, Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 7.8 пунктээр буурсан нь хамгийн өндөр дүнтэй байна.

Гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ)

Төрийн байгууллагаас сүүлийн 12 сарын хугацаанд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийн үнэлгээгээр ГШБҮ-г гаргасан бөгөөд уг үнэлгээ нь ил тод, хариуцлагатай байдлын болон авлигын индекс гэсэн хоёр дэд индексийн дунджаар дүгнэгдэж байгаа болно. ГШБҮ 2016 онд 63.3 болж өмнөх оныхоос 6.5 пунктээр буурсан байна.

1. Ил тод, хариуцлагатай байдлын индекс

Тухайн байгууллагаас үйлчилгээ авахад ил тод, хариуцлагатай байсан эсэхийг үнэлүүлж ил тод, хариуцлагатай байдлын индексийг тооцоход төрийн байгууллагуудын дундаж үнэлгээ 57.5 гарсан. Яамдаас Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Барилга, хот байгуулалтын яам, агентлагуудаас Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Цагдаагийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд Говьсүмбэр, Өмнөговь, Дорнод зэрэг аймгийн ЗДТГ-ын ил тод, хариуцлагатай байдлын индекс харьцангуй доогуур гарлаа.

2. Авлигын индекс

Авлигын индексийг авлигын талаарх төсөөлөл болон тохиолдол (авлигын шууд болон шууд бус тохиолдол)-ын үнэлгээгээр үнэлсэн болно. Авлигын индексээр 100 онооноос 2016 онд 69.1 оноо авч өмнөх оныхоос 9.4 пунктээр буурсан байна. Авлигын индексээр яамдаас Барилга, хот байгуулалтын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, агентлагаас Ашигт малтмал, газрын тосны газар, Цагдаагийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар аймаг, нийслэлээс Дархан- Уул, Орхон, Хөвсгөл аймгийн ЗДТГ харьцангуй бага оноотой байна (хавсралтаас харна уу).

Сүүлийн 12 сарын хугацаанд төрийн үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын 3.8 хувь нь төрийн үйлчилгээг авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус байдлаар бэлэг, хандив, бусад санхүүгийн тусламж зэргийг тухайн байгууллага/албан тушаалтанд өгсөн нь өмнөх оныхоос 0.9 пунктээр нэмэгдсэн байна. Мөн судалгаанд оролцогчоос “Таны найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотны хэн нэгэн тухайн байгууллагаас үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэргийг сүүлийн 12 сарын хугацаанд өгч байсныг мэдэх үү?” гэж асуухад судалгаанд оролцогчдийн 15.8 хувь нь “тийм” гэж хариулсан байгаа нь өмнөх оныхоос 8.0 пунктээр нэмэгджээ.

Дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ)

Байгууллагын ДШБҮ-г тухайн байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдын үнэлгээнд үндэслэн гаргав. Дотоод шударга байдлыг тухайн байгууллага дахь албан бус хэм хэмжээ, авлигын эсрэг тогтолцоо, хүний нөөцийн асуудал, төсвийн зарцуулалт, удирдлагын үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх асуудал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэг үзүүлэлтээр үнэлсэн болно. ДШБҮ 2016 онд 80.9 гарч өмнөх оныхоос 1.0 пунктээр буурчээ.

Яамдаас Байгаль орчин, аялал жуулчлалын яам (75.0), Эрүүл мэндийн яам (75.8), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (77.4), агентлагуудаас Биеийн тамир, спортын газар (60.9), Мал эмнэлэг, үржлийн газар (69.5), Иргэний нисэхийн ерөнхий газар (76.9), аймаг, нийслэлийн хувьд Баян-Өлгий (67.3), Ховд(73.6), Завхан (74.5) аймгийн ЗДТГ-ын ДШБҮ харьцангуй бага оноо авсан байна.

1. Соёлын индекс

ДШБҮ нь тухайн байгууллага дахь соёлын индекс болон үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексээс бүрдэж байгаа билээ. Соёлын индекс нь тухайн байгууллага дахь албан бус хэм хэмжээ, авлигын эсрэг тогтолцоо гэсэн хоёр үзүүлэлтээс бүрдэж байгаа юм. Үүнээс авлигын эсрэг тогтолцооны үзүүлэлтийн дундаж 2016 онд 64.8 гарсан нь харьцангуй бага байгаа бөгөөд авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалах, мөн зөрчил гаргасан алба хаагчдад хариуцлага хүлээлгэх, авлигыг хянах дотоод хяналтын механизмыг бүрдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

2. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс

Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс нь хүний нөөцийн асуудал, төсвийн зарцуулалт, удирдлагын үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх асуудал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлийн үзүүлэлтээс бүрдэж байгаа бөгөөд 2016 оны хувьд удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлийн үзүүлэлт 68.9 гарсан байна.

Бодлогод оролцогчдын (шинжээчдийн) үнэлгээ (БОУ)

БОУ буюу шинжээчдийн үнэлгээнд тухайн байгууллагын харьяа дээд байгууллагын төлөөлөл, бодлого боловсруулагчид болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, аудитор, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, эрдэмтэн, судлаачдын төлөөллийг шинжээчээр оролцуулсан юм.

БОУ-ээр төрийн байгууллагууд 2016 онд 64.8 оноо авсан нь өмнөх оныхоос 5.0 пунктээр буурсан байна. Уг үнэлгээг байгууллагаар авч үзвэл яамдаас Зам, тээврийн хөгжлийн яам (50.1), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (53.1), Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (56.4), Эрүүл мэндийн яам (58.0), агентлагаас Цагдаагийн ерөнхий газар (51.3), Гаалийн ерөнхий газар (54.8), Соёл, урлагийн газар (56.0), Биеийн тамир, спортын газар (56.9), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (57.6), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (58.9) оноо авсан байгаа нь харьцангуй бага оноо болж байна. Харин аймаг, нийслэлийн хувьд Архангай, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын үнэлгээ харьцангуй бага байна.

БОУ-ээс харахад тухайн байгууллагад авлигыг хянах механизм (байгууллага дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцох, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажиллаж байгаа эсэх)-ын үзүүлэлт харьцангуй бага үнэлгээтэй гарсан байна.

Мөн үнэлгээнээс харахад удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Авлигын эсрэг хуульд заасны дагуу Авлигатай тэмцэх газраас Шударга байдлын үнэлгээг хоёр дахь удаагаа зохион байгуулаад байна. Шударга байдлын үнэлгээгээр 2016 онд нийтдээ 60 байгууллагыг үнэлсэн бөгөөд үнэлгээний судалгаанд нийтдээ 4900 нэгжээс мэдээлэл цуглуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллав.


Шударга байдлын үнэлгээний 2016 оны дүнгээс харахад үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын дундаж үнэлгээ 69.7 оноотой гарсан нь өмнөх оныхоос 4.2 пунктээр буурчээ. Ийнхүү буурахад тухайн төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өгсөн үнэлгээ 6.5 пунктээр, шинжээчдийн үнэлгээ 5.0 пунктээр, тухайн төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчдийн өгсөн үнэлгээ 1.0 пунктээр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Үнэлгээг байгууллагаар авч үзвэл 2016 онд Биеийн тамир, спортын газар, Цагдаагийн ерөнхий газар, Дорноговь аймгийн ЗДТГ, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Баян-Өлгий аймгийн ЗДТГ, Зам, тээврийн хөгжлийн яам, Говьсүмбэр аймгийн ЗДТГ, Ашигт малтмал, газрын тосны газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Гаалийн ерөнхий газар зэрэг байгууллага харьцангуй бага оноо авчээ.

Үнэлгээнд хамрагдсан 62 байгууллагын авсан үнэлгээ нь 61.4-77.7 онооны хооронд байгаа нь цаашид үнэлгээг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарал хандуулах шаардлагатай байгааг харуулж байна. Үнэлгээнд яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ гэсэн байгууллагыг хамруулсан бөгөөд аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дундаж үнэлгээ 69.0 гарсан нь хамгийн бага дүн болж байна.

Төрийн байгууллагууд шударга байдлын үнэлгээгээ нэмэгдүүлэхийн тулд авлигатай тэмцэх удирдлагын хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн бодлогын ил тод, шударга байдлыг хангах, авлигын эсрэг үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд сурталчлах, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг шүгэл үлээх механизмыг дэмжих зэрэгт анхаарал хандуулж тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хавсралт-1. ШБҮ, 2016 онд



Хавсралт-2. ШБҮ, 2015, 2016 онд

Д/д	Байгууллагын нэр	2016	Байгууллагын нэр	2015
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	65.5	Байгаль, орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	69.3
2	Батлан хамгаалах яам	77.7	Батлан хамгаалах яам	78.9
3	Гадаад харилцааны яам	73.5	Гадаад хэргийн яам	77.2
4	Сангийн яам	75.5	Сангийн яам	75.6
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	66.6	Хууль зүйн яам	72.2
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	71.9	Хөдөлмөрийн яам	73.5
	-	-	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	70.0
7	Барилга, хот байгуулалтын яам	65.7	Барилга, хот байгуулалтын яам	65.8
8	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	64.0	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	77.2
9	Зам, тээврийн хөгжлийн яам	64.5	Зам тээврийн яам	69.0
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	65.3	Уул уурхайн яам	71.3
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	73.3	Хүнс, хөдөө аж ахуйн яам	71.4
12	Эрчим хүчний яам	69.0	Эрчим хүчний яам	75.4
13	Эрүүл мэндийн яам	66.7	Эрүүл мэнд, спортын яам	66.1
	-	-	Аж үйлдвэрийн яам	72.6
14	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	74.1	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	79.0
15	Үндэсний хөгжлийн газар	75.2	-	-
16	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	71.2	-	-
	-	-	Худалдан авах ажиллагааны газар	77.3
	-	-	Хөрөнгө оруулалтын газар	76.4
17	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	70.5	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	67.3
18	Онцгой байдлын ерөнхий газар	73.4	Онцгой байдлын ерөнхий газар	77.8
19	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	69.6	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	73.9
20	Стандарт, хэмжил зүйн газар	74.1	Стандартчилал, хэмжил зүйн газар	79.2
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	73.8	Цаг уур, орчны шинжилгээний газар	81.4
22	Зэвсэгт хүчний жанжин штаб	63.2	-	-
23	Гаалийн ерөнхий газар	65.9	Гаалийн ерөнхий газар	68.9
24	Татварын ерөнхий газар	70.7	Татварын ерөнхий газар	69.2
25	Цагдаагийн ерөнхий газар	62.0	Цагдаагийн ерөнхий газар	77.1
26	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	73.5	Улсын бүртгэлийн ерөнхий газар	73.7
	-	-	Оюуны өмчийн газар	79.4
27	Архивын ерөнхий газар	77.3	Архивын ерөнхий газар	75.3
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	71.4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	78.1
29	Гадаадын иргэн, харьяатын газар	74.1	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	77.5

30	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	72.4	Нийгмийн даатгалын ерөнхий газар	79.7
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	72.1	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар	76.9
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	73.8	Хүүхдийн төлөө үндэсний газар	75.7
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	67.0	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	73.1
34	Биеийн тамир, спортын газар	61.4	-	-
35	Соёл, урлагийн газар	62.9	-	-
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	71.5	Иргэний нисэхийн ерөнхий газар	72.3
37	Ашигт малтмал, газрын тосны газар	64.9	Ашигт малтмалын газар	68.2
	-	-	Газрын тосны газар	77.6
38	Мал эмнэлэг, үржлийн газар	69.9	Мал эмнэлэг, үржлийн газар	73.4
	-	-	Тахарын ерөнхий газар	79.3
39	Архангай аймгийн ЗДТГ	67.5	Архангай аймгийн ЗДТГ	72.2
40	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	64.2	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	65.5
41	Баянхонгор аймгийн ЗДТГ	67.8	Баянхонгор аймгийн ЗДТГ	73.0
42	Булган аймгийн ЗДТГ	68.2	Булган аймгийн ЗДТГ	75.3
43	Говь-Алтай аймгийн ЗДТГ	68.5	Говь-Алтай аймгийн ЗДТГ	76.3
44	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	64.5	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	78.5
45	Дархан-Уул аймгийн ЗДТГ	69.8	Дархан-Уул аймгийн ЗДТГ	70.9
46	Дорноговь аймгийн ЗДТГ	64.0	Дорноговь аймгийн ЗДТГ	81.3
47	Дорнод аймгийн ЗДТГ	70.5	Дорнод аймгийн ЗДТГ	71.3
48	Дундговь аймгийн ЗДТГ	66.3	Дундговь аймгийн ЗДТГ	66.6
49	Завхан аймгийн ЗДТГ	67.4	Завхан аймгийн ЗДТГ	66.2
50	Орхон аймгийн ЗДТГ	68.7	Орхон аймгийн ЗДТГ	72.2
51	Өвөрхангай аймгийн ЗДТГ	75.2	Өвөрхангай аймгийн ЗДТГ	72.6
52	Өмнөговь аймгийн ЗДТГ	66.1	Өмнөговь аймгийн ЗДТГ	67.6
53	Сүхбаатар аймгийн ЗДТГ	74.9	Сүхбаатар аймгийн ЗДТГ	77.1
54	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	77.7	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	73.6
55	Төв аймгийн ЗДТГ	67.0	Төв аймгийн ЗДТГ	71.3
56	Увс аймгийн ЗДТГ	71.9	Увс аймгийн ЗДТГ	79.4
57	Ховд аймгийн ЗДТГ	67.1	Ховд аймгийн ЗДТГ	71.3
58	Хөвсгөл аймгийн ЗДТГ	68.6	Хөвсгөл аймгийн ЗДТГ	79.0
59	Хэнтий аймгийн ЗДТГ	71.5	Хэнтий аймгийн ЗДТГ	70.8
60	Нийслэлийн ЗДТГ	71.3	Нийслэлийн ЗДТГ	72.8

Хавсралт-3. ГШБҮ, 2016 онд

Д/д	Төрийн байгууллагын нэр	ГШБҮ	Ил тод, хариуцлагатай байдлын индекс	Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	59.6	56.4	54.5	64.0	62.8	50.7	92.8	45.0
2	Батлан хамгаалах яам	73.8	63.5	64.0	62.2	84.2	64.2	99.7	88.6
3	Гадаад харилцааны яам	63.3	56.6	48.9	61.4	70.0	59.5	81.9	68.6
4	Сангийн яам	72.6	64.6	59.1	64.6	80.7	70.2	86.1	85.7
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	50.7	47.1	41.7	47.5	54.4	52.1	71.1	40.0
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	69.4	59.4	56.2	60.9	79.5	61.0	97.5	80.0
7	Барилга, хот байгуулалтын яам	52.6	50.9	46.9	55.9	54.3	49.9	64.5	48.6
8	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	53.0	50.5	45.6	58.2	55.5	47.7	78.8	40.0
9	Зам, тээврийн хөгжлийн яам	60.4	51.7	51.5	56.7	69.0	46.9	97.4	62.9
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	65.4	57.6	52.5	62.4	73.2	57.9	89.2	72.5
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	78.5	72.7	70.2	75.7	84.3	72.4	97.9	82.5
12	Эрчим хүчний яам	61.9	64.8	60.3	71.2	59.0	63.0	99.7	14.3
13	Эрүүл мэндийн яам	66.5	58.8	56.3	63.3	74.1	56.7	93.2	72.5
14	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	68.3	72.3	66.1	78.2	64.3	72.5	85.5	35.0
15	Үндэсний хөгжлийн газар	-	-	-	-	-	-	-	-
16	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	76.4	70.6	64.3	75.9	82.2	71.6	100.0	75.0
17	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	61.7	52.9	46.6	58.9	70.6	53.2	90.0	68.6
18	Онцгой байдлын ерөнхий газар	63.7	57.4	43.3	65.8	69.9	63.1	86.7	60.0
19	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	60.1	54.8	49.7	59.3	65.5	55.4	86.0	55.0
20	Стандарт, хэмжил зүйн газар	69.9	62.5	57.9	64.9	77.4	64.7	92.5	75.0
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	60.4	58.8	58.0	62.0	61.9	56.6	65.9	63.3
22	Зэвсэгт хүчний жанжин штаб	-	-	-	-	-	-	-	-
23	Гаалийн ерөнхий газар	61.9	54.8	45.5	60.7	69.0	58.3	63.0	85.7
24	Татварын ерөнхий газар	68.8	59.0	51.8	65.1	78.7	60.0	86.0	90.0
25	Цагдаагийн ерөнхий газар	52.8	46.3	41.4	51.0	59.3	46.7	87.1	44.3
26	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	62.6	61.3	60.5	64.1	63.8	59.2	98.0	34.3
27	Архивын ерөнхий газар	81.8	75.6	63.1	79.8	88.0	83.9	100.0	80.0
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	71.0	65.3	64.3	70.4	76.7	61.3	96.8	72.0
29	Гадаадын иргэн, харьяатын газар	73.5	61.4	56.7	65.3	85.5	62.3	98.2	96.0

30	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	63.7	57.5	52.3	61.1	69.9	58.9	79.4	71.4
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	58.6	56.7	51.2	62.7	60.6	56.1	94.1	31.7
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	71.4	58.8	45.8	66.5	84.1	64.0	98.2	90.0
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	52.4	44.6	42.9	48.8	60.2	42.1	88.5	50.0
34	Биеийн тамир, спортын газар	66.5	62.7	55.3	70.8	70.2	61.9	80.8	68.0
35	Соёл, урлагийн газар	69.9	62.4	58.9	64.0	77.3	64.5	99.6	68.0
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	-	-	-	-	-	-	-	-
37	Ашигт малтмал, газрын тосны газар	53.8	48.7	33.2	57.0	58.9	56.0	37.5	83.3
38	Мал эмнэлэг, үржлийн газар	69.9	61.6	54.7	66.8	78.3	63.3	99.5	72.0
39	Архангай аймгийн ЗДТГ	66.9	58.4	57.7	61.1	75.4	56.6	99.8	70.0
40	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	63.9	54.2	52.1	52.1	73.6	58.6	88.2	74.0
41	Баянхонгор аймгийн ЗДТГ	55.3	49.6	44.9	58.1	60.9	45.9	91.0	46.0
42	Булган аймгийн ЗДТГ	58.5	58.8	57.3	63.4	58.3	55.6	99.3	20.0
43	Говь-Алтай аймгийн ЗДТГ	54.3	46.2	43.0	49.8	62.4	45.9	97.2	44.0
44	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	51.3	39.7	32.9	44.7	62.9	41.5	97.2	50.0
45	Дархан-Уул аймгийн ЗДТГ	51.3	51.2	53.7	53.9	51.5	46.1	92.3	16.0
46	Дорноговь аймгийн ЗДТГ	59.3	48.9	47.1	51.6	69.7	48.0	99.0	62.0
47	Дорнод аймгийн ЗДТГ	58.4	45.7	43.6	49.6	71.1	43.8	93.5	76.0
48	Дундговь аймгийн ЗДТГ	60.5	55.9	57.5	59.8	65.1	50.5	92.9	52.0
49	Завхан аймгийн ЗДТГ	62.2	53.2	51.6	58.4	71.3	49.5	92.4	72.0
50	Орхон аймгийн ЗДТГ	57.5	60.5	59.5	67.1	54.5	54.9	96.7	12.0
51	Өвөрхангай аймгийн ЗДТГ	70.0	70.7	72.1	73.3	69.3	66.8	83.1	58.0
52	Өмнөговь аймгийн ЗДТГ	53.7	45.6	45.2	50.9	61.7	40.8	96.5	48.0
53	Сүхбаатар аймгийн ЗДТГ	66.2	56.2	50.4	64.0	76.2	54.3	86.4	88.0
54	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	65.6	70.5	70.8	71.7	60.6	69.1	98.7	14.0
55	Төв аймгийн ЗДТГ	60.6	53.2	51.5	60.2	67.9	47.9	93.7	62.0
56	Увс аймгийн ЗДТГ	69.1	60.8	57.3	65.5	77.3	59.7	96.3	76.0
57	Ховд аймгийн ЗДТГ	57.3	47.9	46.1	54.2	66.7	43.3	88.7	68.0
58	Хөвсгөл аймгийн ЗДТГ	60.8	64.0	63.5	67.9	57.5	60.7	95.8	16.0
59	Хэнтий аймгийн ЗДТГ	76.5	66.0	65.6	66.4	86.9	66.0	98.7	96.0
60	Нийслэлийн ЗДТГ	61.1	57.3	56.7	60.0	64.8	55.3	84.1	55.0
	ДУНДАЖ	63.3	57.5	53.5	61.9	69.1	57.0	89.9	60.4

Хавсралт-4. ДШБҮ, 2016 онд

Д/д	Төрийн байгууллагын нэр	ДШБҮ	Соёлын индекс	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Ажлын байран дахь шударга байдлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	75.0	65.6	74.3	57.0	84.4	95.2	90.8	78.1	100.0	57.7
2	Батлан хамгаалах яам	81.4	72.5	78.6	66.4	90.3	97.9	95.6	86.3	100.0	71.9
3	Гадаад харилцааны яам	86.6	80.1	83.9	76.3	93.2	97.3	98.4	93.0	100.0	77.4
4	Сангийн яам	86.3	79.1	83.5	74.7	93.5	99.8	99.8	96.4	100.0	71.7
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	83.2	75.0	80.4	69.5	91.5	98.7	97.1	90.5	100.0	71.3
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	80.4	71.4	82.1	60.7	89.5	96.6	94.3	90.0	96.7	69.9
7	Барилга, хот байгуулалтын яам	82.0	72.0	79.2	64.8	92.0	99.0	96.9	94.8	100.0	69.1
8	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	82.7	74.1	80.9	67.3	91.3	98.7	96.7	86.9	100.0	74.0
9	Зам, тээврийн хөгжлийн яам	82.9	74.5	80.0	69.0	91.3	98.1	97.4	94.2	100.0	66.8
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	77.4	66.8	78.0	55.7	87.9	95.0	93.1	87.9	98.3	65.3
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	79.8	70.9	75.2	66.7	88.7	97.6	93.2	82.3	100.0	70.5
12	Эрчим хүчний яам	82.8	74.7	81.4	67.9	90.9	99.8	97.3	92.0	98.3	67.2
13	Эрүүл мэндийн яам	75.8	66.1	76.9	55.3	85.5	96.8	87.6	83.4	100.0	59.7
14	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	83.6	75.8	78.9	72.6	91.4	100.0	97.3	92.4	100.0	67.4
15	Үндэсний хөгжлийн газар	86.0	78.9	86.1	71.8	93.0	98.8	94.6	92.9	100.0	78.7
16	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	78.4	65.2	75.8	54.7	91.6	97.0	98.4	88.1	100.0	74.3
17	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	84.8	75.6	81.0	70.2	93.9	100.0	100.0	96.1	100.0	73.4
18	Онцгой байдлын ерөнхий газар	80.2	69.4	80.4	58.5	91.0	97.9	95.0	90.4	100.0	71.5
19	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	82.0	72.7	83.9	61.5	91.2	98.3	91.7	90.8	100.0	75.1
20	Стандарт, хэмжил зүйн газар	80.6	70.6	78.7	62.5	90.5	97.5	97.1	90.6	100.0	67.2
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	83.9	75.5	82.7	68.4	92.2	99.7	96.8	99.3	100.0	65.4
22	Зэвсэгт хүчний жанжин штаб	-	-	-	-	-	-	-	-	-	-

23	Гаалийн ерөнхий газар	81.0	71.4	81.7	61.2	90.6	94.8	98.8	93.5	98.3	67.4
24	Татварын ерөнхий газар	82.8	72.9	80.7	65.0	92.7	97.8	99.7	95.4	98.3	72.3
25	Цагдаагийн ерөнхий газар	81.8	72.7	75.9	69.5	90.9	97.5	98.6	92.2	100.0	66.4
26	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	84.1	75.9	81.5	70.2	92.2	99.1	98.4	93.9	100.0	69.8
27	Архивын ерөнхий газар	81.6	72.8	82.8	62.8	90.4	98.5	97.5	92.1	100.0	64.0
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	85.7	79.2	84.2	74.3	92.1	99.1	97.5	90.9	100.0	73.0
29	Гадаадын иргэн, харьяатын газар	84.6	78.2	80.3	76.0	91.0	99.7	96.6	88.0	100.0	70.5
30	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	85.6	77.4	80.2	74.6	93.8	99.7	100.0	94.3	100.0	75.0
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	85.6	77.4	84.9	70.0	93.7	100.0	98.6	96.4	100.0	73.6
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	84.3	77.0	82.1	71.9	91.6	98.6	94.6	89.1	97.5	78.3
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	85.2	77.3	83.2	71.3	93.2	99.7	99.3	95.9	100.0	70.8
34	Биеийн тамир, спортын газар	60.9	55.9	70.5	41.3	65.9	94.8	23.2	68.7	90.0	52.9
35	Соёл, урлагийн газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	76.9	66.9	74.7	59.0	87.0	94.6	92.5	85.5	100.0	62.5
37	Ашигт малтмал, газрын тосны газар	77.4	67.8	78.7	56.9	87.0	96.8	93.5	77.7	95.0	71.9
38	Мал эмнэлэг, үржлийн газар	69.5	56.4	68.9	43.9	82.6	96.0	93.2	74.7	100.0	49.2
39	Архангай аймгийн ЗДТГ	82.3	72.8	81.3	64.2	91.9	100.0	94.7	93.0	100.0	71.6
40	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	67.3	67.1	77.7	56.5	67.5	51.7	85.6	52.0	95.0	53.3
41	Баянхонгор аймгийн ЗДТГ	77.3	66.6	76.9	56.4	87.9	99.0	87.8	84.9	100.0	67.8
42	Булган аймгийн ЗДТГ	77.9	68.2	77.4	59.0	87.6	99.0	94.7	80.1	100.0	64.3
43	Говь-Алтай аймгийн ЗДТГ	83.5	74.9	83.1	66.7	92.0	99.7	96.0	94.9	100.0	69.6
44	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	81.7	72.6	78.7	66.6	90.8	99.7	93.3	91.2	100.0	69.7
45	Дархан-Уул аймгийн ЗДТГ	80.2	71.8	78.4	65.2	88.6	99.2	93.7	78.1	97.5	74.3
46	Дорноговь аймгийн ЗДТГ	78.5	67.9	73.6	62.1	89.1	98.5	93.9	83.2	100.0	69.8
47	Дорнод аймгийн ЗДТГ	84.0	76.7	80.9	72.6	91.2	98.3	97.2	91.6	97.5	71.6
48	Дундговь аймгийн ЗДТГ	78.1	64.9	73.7	56.2	91.3	97.1	94.5	93.8	100.0	70.9
49	Завхан аймгийн ЗДТГ	74.5	64.9	72.2	57.6	84.0	96.3	89.2	75.1	100.0	59.5
50	Орхон аймгийн ЗДТГ	82.8	73.3	79.7	66.8	92.3	98.8	96.5	91.0	100.0	74.9
51	Өвөрхангай аймгийн ЗДТГ	86.8	80.2	88.2	72.1	93.4	99.7	99.6	96.4	100.0	71.0
52	Өмнөговь аймгийн ЗДТГ	81.4	71.6	81.8	61.3	91.2	99.7	98.3	93.4	100.0	64.7
53	Сүхбаатар аймгийн ЗДТГ	87.1	80.8	83.9	77.6	93.5	99.7	96.9	96.5	100.0	74.4

54	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	85.2	77.0	80.6	73.3	93.5	98.5	98.6	93.5	100.0	76.8
55	Төв аймгийн ЗДТГ	78.7	69.7	75.3	64.0	87.8	98.4	89.4	87.6	100.0	63.8
56	Увс аймгийн ЗДТГ	83.6	75.2	81.3	69.0	92.1	98.7	94.6	93.6	100.0	73.6
57	Ховд аймгийн ЗДТГ	73.6	66.6	73.4	59.9	80.6	95.8	71.7	76.5	97.5	61.4
58	Хөвсгөл аймгийн ЗДТГ	83.6	74.5	80.4	68.6	92.7	97.8	96.5	94.5	100.0	74.4
59	Хэнтий аймгийн ЗДТГ	79.4	68.3	75.8	60.8	90.4	98.1	96.6	88.7	100.0	68.6
60	Нийслэлийн ЗДТГ	81.2	72.1	80.6	63.7	90.3	98.0	95.7	89.9	98.9	68.9
	ДУНДАЖ	80.9	72.1	79.4	64.8	89.6	97.4	93.9	88.7	99.3	68.9

Хавсралт-5. БОУ, 2016 онд

Д/д	Төрийн байгууллагын нэр	БОУ	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	61.9	60.1	44.0	85.0	58.3
2	Батлан хамгаалах яам	77.9	78.5	62.3	100.0	70.8
3	Гадаад харилцааны яам	70.7	67.5	61.0	100.0	54.2
4	Сангийн яам	67.6	65.5	50.0	93.8	61.3
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	65.9	59.9	46.9	95.0	61.8
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	66.0	63.8	42.6	100.0	57.5
7	Барилга, хот байгуулалтын яам	62.6	63.7	36.7	100.0	50.0
8	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	56.4	64.0	43.0	69.4	49.2
9	Зам, тээврийн хөгжлийн яам	50.1	49.1	41.4	62.8	47.4
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	53.1	43.8	32.6	93.8	42.3
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	61.7	59.5	42.7	91.7	52.8
12	Эрчим хүчний яам	62.4	51.2	44.4	100.0	54.1
13	Эрүүл мэндийн яам	58.0	58.9	37.1	83.3	52.5
14	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	70.5	67.6	49.1	100.0	65.3
15	Үндэсний хөгжлийн газар	64.5	58.5	48.3	100.0	51.3
16	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	58.9	49.4	45.0	88.9	52.5
17	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	64.9	61.7	47.2	95.0	55.6
18	Онцгой байдлын ерөнхий газар	76.3	77.8	58.0	100.0	69.4
19	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	66.6	65.1	43.1	100.0	58.1
20	Стандарт, хэмжил зүйн газар	71.8	68.6	55.0	95.0	68.8
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	77.0	83.0	58.7	100.0	66.3
22	Зэвсэгт хүчний жанжин штаб	63.2	68.9	42.1	87.5	54.2
23	Гаалийн ерөнхий газар	54.8	51.5	47.7	70.1	50.0
24	Татварын ерөнхий газар	60.6	61.0	46.6	80.0	54.7
25	Цагдаагийн ерөнхий газар	51.3	49.7	48.1	57.8	49.7
26	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	74.0	71.1	58.7	100.0	66.3
27	Архивын ерөнхий газар	68.5	70.9	49.0	100.0	54.0
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	57.6	51.3	42.8	80.6	55.9
29	Гадаадын иргэн, харьяатын газар	64.4	64.4	45.3	95.0	52.8
30	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	67.8	68.5	48.5	95.0	59.3

31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	72.2	73.1	55.7	100.0	60.1
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	65.7	66.6	44.8	95.0	56.5
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	63.3	68.1	46.3	85.0	53.8
34	Биеийн тамир, спортын газар	56.9	50.6	45.0	84.4	47.4
35	Соёл, урлагийн газар	56.0	56.7	36.9	78.6	51.8
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	66.2	63.7	53.1	95.0	52.8
37	Ашигт малтмал, газрын тосны газар	63.4	59.2	50.8	88.8	54.7
38	Мал эмнэлэг, үржлийн газар	70.1	71.0	47.9	92.9	68.8
39	Архангай аймгийн ЗДТГ	53.3	56.7	40.2	80.0	36.1
40	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	61.4	74.1	39.0	83.8	48.6
41	Баянхонгор аймгийн ЗДТГ	70.9	70.0	54.6	95.0	63.8
42	Булган аймгийн ЗДТГ	68.1	70.2	46.9	100.0	55.4
43	Говь-Алтай аймгийн ЗДТГ	67.7	78.2	39.7	100.0	52.8
44	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	60.6	65.7	29.5	94.4	52.8
45	Дархан-Уул аймгийн ЗДТГ	78.0	77.0	66.7	100.0	68.3
46	Дорноговь аймгийн ЗДТГ	54.3	48.7	35.7	92.9	40.0
47	Дорнод аймгийн ЗДТГ	69.2	73.0	48.3	100.0	55.6
48	Дундговь аймгийн ЗДТГ	60.3	59.5	39.1	100.0	42.7
49	Завхан аймгийн ЗДТГ	65.4	68.8	42.6	93.8	56.7
50	Орхон аймгийн ЗДТГ	65.8	65.4	50.7	91.7	55.6
51	Өвөрхангай аймгийн ЗДТГ	69.0	76.4	48.4	93.8	57.3
52	Өмнөговь аймгийн ЗДТГ	63.4	70.9	37.2	86.7	58.7
53	Сүхбаатар аймгийн ЗДТГ	71.2	75.4	46.9	100.0	62.5
54	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	82.3	81.9	73.5	100.0	73.8
55	Төв аймгийн ЗДТГ	61.6	60.5	42.0	90.0	53.8
56	Увс аймгийн ЗДТГ	62.9	65.9	36.0	95.0	54.7
57	Ховд аймгийн ЗДТГ	70.5	68.1	50.8	100.0	63.1
58	Хөвсгөл аймгийн ЗДТГ	61.5	64.3	48.8	80.0	52.8
59	Хэнтий аймгийн ЗДТГ	58.8	59.6	45.3	76.3	54.2
60	Нийслэлийн ЗДТГ	71.5	71.0	56.3	95.0	63.8
	Дундаж	64.8	64.7	46.9	91.5	56.1

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2017

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2017 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааг “Транспэрэнси Интернэшнл Солонгос” байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, Солонгос, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулж байсан билээ. Үүнээс хойш уг арга зүйн дагуу Хүүхдийн шударга байдлын судалгааг 7 дахь удаагаа зохион байгуулаад байна.

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн шударга байдал, ёс зүй, ёс суртахуун, төлөвшилтийг хүүхдэд ойлгомжтой, хялбар байдлаар тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтооход энэхүү судалгааны зорилго оршиж байна.

1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааны зорилгын нэг нь хүүхдийн шударга байдлын түвшнийг тодорхойлох бөгөөд судалгааны мэдээлэлд үндэслэн жил бүр хүүхдийн шударга байдлын түвшинг хэмжин гаргаж байгаа юм.

Хүүхдийн шударга байдлын түвшинг тогтоохдоо доорх 12 асуултад тухайн хүүхэд санал нийлж байгаа эсэхийг нь асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үнэлгээний арифметик дунджаар гаргав. Хүүхдийн шударга байдлын түвшин нь хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих үзэл гэсэн дэд үзүүлэлтээс бүрддэг. Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлэхэд ашигласан асуулт

Асуултын дугаар	Асуулт
1.	Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.
2.	Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.
3.	Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
4.	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.
5.	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.
6.	Баян байх нь шударга байхаас илүү чухал.
7.	Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.
8.	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.
9.	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондoo хурдан орохыг хичээнэ.
10.	Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.
11.	Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.
12.	Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.

Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдлын үзүүлэлтийг тооцохдоо дээр дурдсан асуултуудын дагуу дэд үзүүлэлтийн дунджийг тооцсон болно. Дэд үзүүлэлт тооцоход ашигласан асуултыг дараахь хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтийг тооцсон асуулт, асуултын дугаараар

	Ёс зүй, ёс суртахуун	Зөв төлөвшилт	Хууль сахих	Авлигыг үл тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

2. СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан, 21 аймаг, нийслэлийн 7-12 дугаар ангийн сурагчдыг санамсаргүй байдлаар сонгон, бэлтгэгдсэн асуулгыг бөглүүлж, судалгааг зохион байгуулав.


Судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах ажлыг 21 аймаг, нийслэлд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн байгууллагатай хамтран 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд зохион байгууллаа.

БҮЛЭГ II. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН БҮТЭЦ


“Хүүхдийн шударга байдал-2017” судалгаанд хамрагдсан сурагчдын 43.8 хувь нь эрэгтэй, 56.2 хувь нь эмэгтэй байгаа бол насны хувьд 15 настай сурагчид хамгийн их буюу 21.7 хувь, 19 настай сурагчид хамгийн бага буюу 0.7 хувь нь байна (Зураг 1).

Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, нас



Судалгаанд хамрагдсан сурагчдыг суралцаж буй ангиар нь авч үзвэл 12 дугаар ангийн сурагч 19.7 хувь, 11 дүгээр ангийн сурагч 8.2 хувь, 10 дугаар ангийн сурагч дугаар ангийн сурагч 21.9 хувь, 9 дугаар ангийн сурагч 14.8 хувь, 7 ба 8 дугаар ангийн сурагч 17.7 хувийг эзэлж байна (Зураг 2).

Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, анги, дүнд эзлэх хувиар



Судалгаанд хамрагдсан сурагчдыг байршлаар нь авч үзвэл 79.4 хувь нь аймгуудаас, 20.6 хувь нь нийслэлээс хамрагдсан байна.

2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН

Хүүхдийн шударга байдлын судалгааны мэдээлэлд үндэслэн Хүүхдийн шударга байдлын түвшинг 4 дэд үзүүлэлт (ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахиу, авлигыг үл тэвчих)-ийн хамт тооцдог. Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

Хүүхдийн шударга байдлын түвшин 2017 оны судалгаагаар 3.97 гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 0.03-аар буурсан байна (Зураг 3).

Зураг 3. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор



Судалгааны үр дүнг ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт, зөв төлөвшилтийн дэд үзүүлэлт, хууль сахих байдлын дэд үзүүлэлт, авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтүүдээр дэлгэрэнгүйгээр доорх хүснэгтээр гаргав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Хүүхдийн шударга байдал 2017 судалгааны түвшин, дэд үзүүлэлтээр

Д/д Үзүүлэлт			Үнэлгээ						
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН			2010	2012	2013	2014	2015	2016	2017
А. Ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт			3.29	2.93	3.71	4.03	3.99	4.00	3.97
	Танин мэдэхүйн	Хүүхдүүд гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусдын бүтээлийг өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.	3.20	2.72	3.66	3.94	3.94	3.98	3.87
	Нөлөөллийн	Баян байх нь шударга байхаас илүү чухал.	2.70	2.49	3.91	4.28	4.26	4.23	4.2
	Зан үйлийн	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.	3.20	2.99	3.82	3.99	4.03	4.10	4.2
Б. Зөв төлөвшилтийн дэд үзүүлэлт			2.51	2.29	3.88	4.32	4.21	4.16	4.18
	Танин мэдэхүйн	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.	2.20	1.85	3.99	4.45	4.37	4.30	4.36
	Нөлөөллийн	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.	2.20	1.94	4.08	4.48	4.38	4.37	4.4
	Зан үйлийн	Хууль зөрчсөн, гэмт хэрэг хийсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.	3.10	3.10	3.57	4.02	3.87	3.81	3.8
В. Хууль сахих байдлын дэд үзүүлэлт			3.54	2.85	3.83	4.04	4.02	4.06	3.94
	Танин мэдэхүйн	Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.	4.42	3.61	3.63	3.63	3.73	3.84	3.64
	Нөлөөллийн	Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.	3.40	2.96	4.02	4.10	4.09	4.05	4.0
	Зан үйлийн	Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.	2.80	1.98	3.83	4.38	4.24	4.28	4.2
Г. Авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлт			2.98	2.81	3.35	3.68	3.65	3.68	3.63
	Танин мэдэхүйн	Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.	2.70	2.34	3.69	4.15	4.17	4.14	4.10
	Нөлөөллийн	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.	3.35	3.11	2.73	3.29	2.67	2.72	2.6
	Зан үйлийн	Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.	2.90	2.97	3.65	4.19	4.10	4.18	4.20

2017 оны судалгааны үр дүнгээр Дундговь, Булган, Сүхбаатар, Баян-Өлгий аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшин 0.47-0.24 пунктээр дээшилсэн байна. Харин Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Баянхонгор аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшин 0.52-0.13 пунктээр буурчээ (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хүүхдийн шударга байдал 2017 судалгааны түвшин, аймаг, нийслэл

д/д	Аймаг, нийслэл	Шударга байдлын түвшин			
		2015	2016	2017	Зөрүү
1	Архангай	4.01	3.89	3.95	0.06
2	Баян-Өлгий	4.18	3.74	3.98	0.24
3	Баянхонгор	4.03	4.17	4.04	-0.13
4	Булган	4.26	3.67	3.95	0.28
5	Говь-Алтай	3.36	4.03	4.03	-
6	Говьсүмбэр	3.71	3.92	4.09	0.17
7	Дархан-Уул	3.56	4.04	4.02	-0.02
8	Дорноговь	3.99	4.22	3.70	-0.52
9	Дорнод	3.38	4.08	4.11	0.03
10	Дундговь	4.26	3.79	4.26	0.47
11	Завхан	3.96	4.03	4.04	0.01
12	Орхон	4.07	4.04	3.99	-0.05
13	Өвөрхангай	3.65	4.16	3.72	-0.44
14	Өмнөговь	3.66	4.21	3.97	-0.24
15	Сүхбаатар	4.13	3.69	3.96	0.27
16	Сэлэнгэ	3.57	4.04	4.10	0.06
17	Төв	3.87	3.98	3.81	-0.17
18	Увс	4.29	4.06	4.03	-0.03
19	Ховд	4.08	4.10	4.00	-0.10
20	Хөвсгөл	4.36	4.09	4.28	0.19
21	Хэнтий	4.00	4.17	4.24	0.07
22	Улаанбаатар	4.05	3.98	3.95	-0.03


Нийслэлийн Налайх, Багануур, Баянзүрх болон Баганхангай дүүргүүдийн хүүхдийн шударга байдлын түвшин 0.37-0.01 пунктээр дээшилсэн байна. Харин Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгино-Хайрхан, Хан-Уул дүүргүүдийн хүүхдийн шударга байдлын түвшин 0.53-0.20 пунктээр буурчээ (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Хүүхдийн шударга байдлын 2017 оны судалгааны түвшин, дүүргээр

д/д	Дүүргүүд	2015	2017	Зөрүү
1	Багануур	3.77	4.04	0.27
2	Багахангай	3.90	3.91	0.01
3	Баянгол	4.37	3.84	-0.53
4	Баянзүрх	3.58	3.77	0.19
5	Налайх	3.66	4.03	0.37
6	Сонгинохайрхан	4.19	3.93	-0.26
7	Сүхбаатар	4.53	4.09	-0.44
8	Хан-Уул	4.06	3.86	-0.20
9	Чингэлтэй	4.42	4.09	-0.33


Хүүхдүүдийн шударга байдлыг мөн суралцаж буй ангиар нь авч үзвэл 7 дугаар ангийн сурагчдын шударга байдлын түвшин 4.02, 8 дугаар ангийн сурагчдынх 4.10 гарсан байгаа нь өндөр үзүүлэлт болж байна. Харин 9 дүгээр ангийн сурагчдын шударга байдлын түвшин 3.98, 10 ангийн сурагчдынх 3.97, 11 ба 12 дугаар ангийн сурагчдынх 3.84-3.86 гарсан байгаа нь ойролцоо үзүүлэлт байлаа (Зураг 4).

Зураг 4. Хүүхдийн шударга байдлын түвшин болон хүүхдийн нас



Хүүхдийн шударга байдлын түвшин мөн хүйсийн хувьд зөрүүтэй байдал жил бүрийн судалгааны дүнгээс харагддаг. Энэ удаагийн судалгааны дүнгээс харахад эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин 4.07, эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин 3.85 болж зөрүү нь 0.22 пункт байна (Зураг 5).

Зураг 5. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр



3. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР

Хүүхдийн шударга байдлын түвшинг ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахиx, авлигыг үл тэвчих гэсэн 4 дэд үзүүлэлтээр үнэлсэн.

Хүснэгт 6. Хүүхдийн шударга байдлын түвшин, дэд үзүүлэлтээр

	2010	2012	2013	2014	2015	2016	2017
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН	3.29	2.93	3.71	4.03	3.99	4.00	3.97
Ёс зүй, ёс суртахуун	3.03	2.73	3.80	4.07	4.08	4.10	4.10
Зөв төлөвшилт	2.51	2.29	3.88	4.32	4.21	4.16	4.19
Хууль сахиx	3.54	2.85	3.83	4.04	4.02	4.06	3.96
Авлигыг үл тэвчих	2.98	2.81	3.35	3.68	3.65	3.68	3.64


4. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль, дүрэм сахин дээдлэх болон авлигыг үл тэвчих байдал нь тэдний эцэг, эх, найз нөхөд, сургууль болон мэдээллийг хүлээн авч байгаа сувгаас шууд хамааралтай байдаг. Тиймээс судалгааны үр дүнд хүүхдийн шударга байдлын түвшин эцэг, эх, найз, нөхөд, сургууль, мэдээлэл хүлээн авч бус сувгаас хэрхэн хамаарч байгаа талаар доорх байдлаар шинжилгээ хийлээ.

Эцэг, эх:

Хүүхдийн шударга байдлын судалгаагаар хүүхэд шударга байж, зөв зүйл хийхэд ямар шалтгаан, хүчин зүйл нөлөөлж байгааг тодорхойлохыг зорилго болгодог. Хүүхдийн шударга байдалд нөлөөлөх нэг чухал хүчин зүйл бол эцэг, эхийн нөлөөлөл юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “Танд шударга бус асуудал тохиолдвол Та яах вэ?” гэсэн асуултад нийт хүүхдүүдийн 62.5 хувь нь “эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүнд хэлнэ” гэж хариулсан бол 26.7 хувь нь “арилгахын тулд ямар нэг зүйл хийнэ”, 10.9 хувь нь “юу ч хийхгүй” гэж хариулсан байна (Зураг 6).

Зураг 6. Шударга бус асуудал тохиолдоход хэнд ханддаг вэ?



Дээрхээс үзэхэд хүүхдүүд хүндрэлтэй асуудал тулгарахад хамгийн ихээр эцэг, эх, дотны хүмүүстээ ханддаг байна. Иймд эцэг, эх, гэр бүлийн нөлөөллийг судалгааны явцад тодруулав. Эцэг, эхчүүд хүүхдүүтэй шударга байх талаар байнга ярилцдаг гэсэн хариулт 27.2 хувь, заримдаа ярилцдаг гэсэн хариулт 40.4 хувь, хаяа ярилцдаг гэсэн хариулт 24.5 хувь байгаа бол хэзээ ч үгүй гэсэн хариулт 7.9 хувийг эзэлж байна (Зураг 7.)

Зураг 7. Эцэг, эхчүүд шударга байдлын талаар ярилцдаг эсэх, 2015-2016 он



Эндээс харахад судалгаанд оролцсон сурагчдын дийлэнх хувь нь “байнга”, “заримдаа” ярилцдаг гэж хариулсан байгаа нь эерэг үзүүлэлт болж байгаа бөгөөд шударга байх талаар хүүхдүүдтэйгээ байнга ярилцдаг хүүхдийн шударга байдал (4.09) эцэг, эхчүүд нь хэзээ ч ярилцдаггүй (3.69) хүүхдийнхээс өндөр байна (Зураг 8.).

Зураг 8. Хүүхдийн шударга байдалд эцэг, эхийн нөлөөлөл



Харин шударга бус зүйл хийсэн тохиолдолд эцэг, эх нь хэрхэн нөлөөлдөг талаар судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс тодруулахад “болохгүй зүйл хийснийг минь хэлж ойлгуулдаг” гэж нийт хүүхдүүдийн 66.6 хувь нь хариулсан бол 26.0 хувь нь “зэмлэл хүлээлгэж шийтгэдэг”, 4.5 хувь нь “тэд энэ талаар сонирхдоггүй”, 2.9 хувь нь “ямар ч үйлдэл хийдэггүй” гэж тус тус хариулсан байна (Зураг 9).

Зураг 9. Эцэг, эхийн хүүхдэд нөлөөлж буй байдал



Хүүхдээ шударга бус зүйл хийхэд эцэг, эх ямар хариу үйлдэл үзүүлж байгаагаас шалтгаалан тэдний зөв төлөвшил хамаарна. Үүнийг судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс тодруулахад “Болохгүй зүйл хийснийг минь хэлж ойлгуулдаг” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.02 байгаа нь “ямар ч үйлдэл хийдэггүй, яадаг ч үгүй” (3.71) гэж хариулсан хүүхдийнхээс 0.31 пунктээр илүү байна (Зураг 10).


Зураг 10. Хүүхдийн шударга байдалд эцэг, эхийн нөлөөлөл



Найз, нөхөд бусад хүмүүс:

Хүүхдүүдийн хувьд шударга байх, эсхүл зөв төлөвшилт олж авахад эцэг, эхээс гадна найз, нөхдийн хүрээ чухал нөлөөтэй юм. Иймд хүүхдүүдээс “Таны найз танаас шударга бус үйлдэл хийхийг хүсдэг үү?” гэж асуухад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 5.4 хувь нь “байнга”, 17.4 хувь нь “заримдаа”, 29.4 хувь нь “хаяа”, 47.8 хувь нь “хэзээ ч үгүй” гэж хариулсан байна. Дээрхээс харахад хүүхдүүдэд найз нөхдийн зүгээс шударга бус үйлдэл хийхийг хүсдэг тохиолдол бага бус байгааг харж болохоор байна (Зураг 11).

Зураг 11. Хүүхдэд найз нь шударга бус үйлдэл хийхийг хүсдэг эсэх



Найз нөхдийн нөлөөллийг хүүхдийн шударга байхтай ямар хамааралтай байгааг доорх үзүүлэлтээр харуулав (Зураг 12).

Зураг 12. Хүүхдийн шударга байдлын түвшин, найз нь шударга бус үйлдэл хийхийг хүсдэг эсэх




Дээрх үзүүлэлтээс харахад найз нөхөд нь ямар нэгэн байдлаар шударга бус зүйл хийхийг шаарддаг тохиолдол байгаа ч тэдний хүссэнээр “шударга бус үйлдэл” хийхийг хүсдэггүй хүүхдүүдийн шударга байдлын түвшин хүсдэг буюу “байнга”, “заримдаа”, “хааяа” гэж хариулсан хүүхдүүдийнхээс өндөр байна.

Шударга үйлсийн төлөө сайшаах

Хүүхдийн шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлөх нэг чухал үзүүлэлт бол тухайн хүүхдийг шударга зүйл хийснийх нь төлөө эцэг,эх, багш, найз нөхөд, ойр дотны хүмүүс нь магтаж, сайшааж, урамшуулж, хөхүүлэн дэмжиж байх явдал юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 63.7 хувь нь шударга хандсанахаа төлөө сайшаагдаж байсан гэж хариулсан бол, 21.3 хувь нь “зарим нь муулдаг”, 15.0 хувь нь “үгүй” гэж хариулжээ (Зураг 12).

Зураг 13. Хүүхдийг шударга хандсаных нь төлөө сайшааж байсан эсэх



Шударга хандсанахаа төлөө сайшаагдах нь хүүхдийн шударга байдлын түвшинтэй ямар хамааралтай болохыг доорх зургаар харуулав (Зураг 13).

Зураг 14. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга хандсанах нь төлөө сайшааж байсан эсэх




Эндээс харахад хүүхдүүд шударга хандсанахаа төлөө сайшаагдаж байсан буюу “тийм” гэж хариулсан хүүхдүүдэд хамаарах шударга байдлын түвшин 4.00 буюу хамгийн өндөр байгаа бол “зарим нь муулдаг” гэж хариулсан хүүхдийнх 3.81, “сайшаагдаж байгаагүй буюу үгүй” гэж хариулсан хүүхдүүдийн 3.79 болж буурч байна.

Сургууль:

Бидний ирээдүй, хойч үе болсон хүүхдүүдэд бага наснаас нь эхлэн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилтийн болон авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд эцэг, эх, найз нөхдийн нөлөөллөөс гадна цэцэрлэг болон сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд энэ талаар тодорхой тусгах шаардлагатай байгаа нь жил бүрийн судалгааны үр дүнгээс харагдаж байдаг.


Судалгаагаар хүүхдүүдээс шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог эсэх талаар тодруулахад хүүхдүүдийн 65.5 хувь нь “тийм”, 34.5 хувь нь “үгүй” гэж хариулсан байна (Зураг 15).

Зураг 15. Шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиогддог эсэх



Хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох, эсхүл шударга ёсны талаар ямар нэгэн үйл ажиллагаа зохиогдож байх нь тэдний шударга байдлын түвшинд хэрхэн нөлөөлж байгааг доорх үзүүлэлтээс харж болно (Зураг 16).


Зураг 16. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиогддог эсэх



Дээрх үзүүлэлтээс харахад шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин “үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс 0.08 пунктээр илүү байгаа нь хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох нь тэдний шударга байдлын түвшинг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандах талаар тодруулсныг доорх үзүүлэлтээс харж болно (Зураг 17).

Зураг 17. Багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандах вэ?



Мэдээллийн орчин:

Хүүхдүүдийн шударга байдлын түвшинд эцэг, эх, найз, нөхөд болон сургуулийн орчин нөлөөлөхөөс гадна шударга ёсны талаарх мэдээллийг хаанаас авч байгаа нь чухал нөлөө үзүүлнэ. Шударга ёсны талаарх мэдээллийг сургуулиас авдаг гэж судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 31.0 хувь нь, гэр бүлээсээ гэж 27.0 хувь нь, интернэтээс гэж 17.0 хувь нь, телевиз, радиогоос гэж 11.0 хувь нь хариулсан бол 2.0-8.0 хувь нь найз нөхөд, сонин болон бусад эх үүсвэрээс мэдээлэл хүлээн авч байна (Зураг 18).

Зураг 18. Шударга ёсны талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?



Аливаа шударга бус үйлдлийг үл тэвчих байдлыг тодорхойлох зорилгоор хүүхдүүдээс шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлж байх нь зөв эсэхийг асуусан юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 75.3 хувь нь шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв гэж үзэж байгаа бол 24.7 хувь нь буруу гэж үзсэн байна (Зураг 19).

Зураг 19. Шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв үү?



ДҮГНЭЛТ

Хүүхдийн шударга байдлын түвшин болон түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, шударга бус хандлагаас нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилгоор 8 дахь удаагийн “Хүүхдийн шударга байдал-2017” судалгаа”-г Авлигатай тэмцэх газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгууллаа. Судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан, 21 аймаг, нийслэлийн 7-12 дугаар ангийн сурагчдыг хамруулан явуулав. Энэ удаагийн судалгааны дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.


- ✓ Хүүхдийн шударга байдлын түвшин 2017 оны судалгаагаар 3.97¹ гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 0.03 пунктийн зөрүүтэй байна.
- ✓ Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох зан төлөвшилтийн дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 0.02 пунктээр өссөн бол ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт, хууль сахих байдлын дэд үзүүлэлт, авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 0.03-0.32 пунктээр буурсан байна.
- ✓ Аймаг, нийслэлийн хүүхдийн шударга байдлын түвшин хэлбэлздэг ч Говьсүмбэр (2015 он - 3.71, 2016 он - 3.92, 2017 он – 4.09), Дорнод (2015 он – 3.38, 2016 он – 4.08, 2017 он – 4.11), Сэлэнгэ (2015 он – 3.57, 2016 он – 4.04, 2017 он – 4.10), Хэнтий (2015 он – 4.00, 2016 он – 4.17, 2017 он – 4.24) аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшин өсөж байгаа эерэг чиг хандлага ажиглагдаж байна.
- ✓ Судалгааны дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин нас ахин анги дэвших тутам буурч байгаагаас гадна эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эмэгтэй хүүхдийнхээс доогуур байна. Мөн нийслэлийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин орон нутгийн хүүхдүүдийнхээс доогуур байна.
- ✓ Хүүхдүүд хүндрэлтэй асуудал тулгарахад хамгийн ихээр эцэг, эх, дотны хүмүүстээ (62.5 хувь нь) ханддаг байна. Эцэг, эх хүүхэдтэйгээ шударга байх

1 Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

талаар байнга ярилцаж байх (4.09) нь тэднийг шударга хандлага гаргахад эерэгээр нөлөөлж байна.

- ✓ Хүүхдээ буруу зүйл хийснийг мэдсэн эцэг, эх хүүхэддээ болохгүй зүйл хийснийг нь ойлгуулах, тайлбарласнаар тэднийг ирээдүйд зөв төлөвшилтэй, шударга иргэн болоход эерэг нөлөө үзүүлж байна. Эцэг, эх нь хүүхдээ шударга бус зүйл хийснийх нь төлөө хэлж ойлгуулах (4.02) нь зэмлэл хүлээлгэх (3.92), хүүхдийнхээ асуудлыг сонирхохгүй (3.83) байх эсхүл ямарч үйлдэл хийдэггүй (3.71) хүүхдүүдийн шударга байдлын түвшнөөс өндөр байна.
- ✓ Хүүхдийн шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлөх нэг зүйл бол шударга үйлдлийнх нь төлөө “магтах, сайшаах, урамшуулах” явдал болох нь судалгааны дүнгээс харагдаж байна. Магтаал, сайшаал хүртдэг хүүхдүүдийн шударга байдлын түвшин огт сайшагддаггүй хүүхдийнхээс 0.21 пунктээр өндөр байна.
- ✓ Хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиох нь тэдний шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлж байна. “Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог уу?” гэсэн асуултад “тийм” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин “үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс 0.08 пунктээр өндөр байв.
- ✓ Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг сургууль, гэр бүл, интернэтээс авдаг ба шударга бус үйлдлийг олон нийтэд мэдээлэх нь зөв гэж хүүхдүүд үзэж байна.

**УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
СУДАЛГАА-2017**



УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2017 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УДИРТГАЛ

Авлигатай тэмцэх газраас “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г 10 дахь удаагаа зохион байгуулав. Олон нийтэд танилцуулж буй энэхүү судалгааны тайлан Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал, ялангуяа “том авлига” гэж онцлон нэрлэдэг улс төрийн хүрээний авлигын талаар тодорхой төсөөлөл өгөх юм.

Судалгааны хүрээнд дараах зорилтыг тавьж зохион байгуулав.


- Авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, авлигын хэлбэрийг авч үзэх;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын хэмжээ, түүний хор уршиг, үр дагаврыг гаргах;
- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зэрэг болно.

Судалгааны арга зүй: “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” –ны хүрээнд нийтийн алба (шүүх, хууль сахиулах салбараас бусад), шүүх, хууль сахиулах салбар, хэвлэл мэдээллийн салбар, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, бодлогын судалгаа, олон нийтийн санал бодлын судалгаа, бизнесийн салбар, иргэдийн төлөөллийг оролцуулан нийт 65 шинжээчийг хамруулсан. Судалгааны мэдээллийг цуглуулахдаа асуулгын аргыг ашигласан ба шинжээчдээр асуулт бүрийг “1-ээс 5” гэсэн баллаар үнэлүүлэн тооцоолсон. Баллын үнэлгээ буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол баллын үнэлгээ өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.

Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхэд мэдээллийн чухал их сурвалж болох учиртай.

Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2016 оны судалгаа”-ны тоо баримттай харьцуулан шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тогтоосон болно.


Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үнэлгээ, үзүүлэлтийн схем



1. 2017 ОНЫ УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШИН

Монгол Улс дахь улс төрийн авлигын түвшин 2011 оноос тогтмол буурч ирсэн боловч 2015-2016 онд 0.07 пунктээр өссөн. Харин 2017 онд 3,97 болж өнгөрсөн оноос 0.32 пунктээр өссөн байна.


Зураг 2. Улс төрийн авлигын түвшин, 2008-2017 онд



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улс төрийн авлигын түвшинг тогтоохдоо үндсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашигладаг. 2017 оны судалгаагаар улс төрийн авлигын цар хүрээний үнэлгээ өмнөх оноос 0.42 пунктээр өссөн бол авлигын хэлбэрийн үнэлгээ 0.34 пунктээр өсчээ. Харин авлигын шалтгаан нөхцлийн үнэлгээ 0.26 пункт, хор уршиг, үр дагаврын үнэлгээ 0.22 пунктээр өссөн дүнтэй гарлаа.

Зураг 3. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээний үзүүлэлт 3.94 гарч өмнөх оноос 0.42 пунктээр өссөн байна.

Улс төрийн авлигын цар хүрээг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлсон бөгөөд үүнээс улс төрийн авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.18 пункт буюу хамгийн өндөр гарсан байна. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал салбар хүрээн дэх улс төрийн авлигын тархалтын цар хүрээний үнэлгээ 0.59 пункт, төрийн байгууллагын тодорхой үйл ажиллагаан дахь авлигын түвшний үнэлгээ 0.46 пункт, салбар болон үйл ажиллагаанд улс төрийн авлига чиглэгдсэн байдлын үнэлгээ 0.20 пункт, улс төрийн авлигын түвшний өөрчлөлтийн үнэлгээ 0.01 пункт, улс төрийн авлигын түгээмэл байдлын үнэлгээ 0.13 пунктээр тус тус өссөн байна.

Зураг 4. Улс төрийн авлигын цар хүрээний үнэлгээ




ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1.1 УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Улс төрийн авлигын түгээмэл байдлын үзүүлэлт 4.18 гарч өмнөх оныхоос 0.13 пунктээр өссөн байна.

Шинжээчид улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлига их байгаа гэж 43.5 хувь нь үзэж байгаа бол 32.3 хувь нь маш их гэж үнэлжээ. Судалгааны мэдээллээс үзвэл арван шинжээч тутмын долоо нь Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлига түгээмэл байсан гэж үнэлж байна.

Зураг 5. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын түвшин




ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1.2 УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын түвшний өөрчлөлтийн байдалд өгсөн үзүүлэлт 3.59 гарч өмнөх оноос 0.01 пунктээр өссөн дүнтэй байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлига өмнөх жилээс нэмэгдсэн гэж шинжээчдийн 45.0 хувь нь үзэж байгаа бол 38.3 хувь нь өөрчлөгдөөгүй, 10.0 хувь нь маш их нэмэгдсэн гэж үнэлжээ. Судалгааны мэдээллээс үзвэл арван шинжээч тутмын тав нь Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлига өнгөрсөн оноос нэмэгдсэн гэж үзэж байна.

Зураг 6. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын түвшний өөрчлөлт

**ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1.3 ТӨРИЙН ИНСТИТУЦ ДЭХ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ**

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд хамаарах 15 институцийн авлигын тархалтын үзүүлэлт 3.99 гарч өмнөх оноос 0.59 пунктээр өссөн байна.

Салбар, хүрээний 15 институцийн авлига тархсан байдлын үзүүлэлт өссөн буюу сөрөг үнэлгээтэй гарчээ. Улс төрийн намуудад авлига тархсан байдлын үнэлгээ 4.48 пункт, засгийн газар /яам, агентлаг/-т авлига тархсан байдлын үнэлгээ 4.27 пункттэй гарсан нь авлига хамгийн их тархсан институц болжээ. Харьцуулсан хүснэгтээс үзвэл улс төрийн намуудын авлигын тархалтын үнэлгээ 0.13 пунктээр, засгийн газар /Яам, агентлаг/-т 0.23 пунктээр болон Монгол Улсын Их Хуралд авлига тархсан байдлын үнэлгээ 0.54 пунктээр өссөн сөрөг дүнтэй гарчээ.

Хүснэгт 1. Салбар, хүрээнд авлига тархсан цар хүрээ

		2016 он	2017 он	Өөрчлөлт
1	Улс төрийн намууд	4.36	4.48	0.13
2	Засгийн газар /Яам, агентлаг/	4.03	4.27	0.23
3	Монгол Улсын Их Хурал	3.71	4.25	0.54
4	Тагнуулын байгууллага	2.59	4.08	1.49
5	Прокурор	3.43	4.04	0.61
6	Шүүх	3.44	4.02	0.58
7	Цагдаагийн байгууллага	3.46	3.96	0.50
8	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ	3.70	3.93	0.23
9	Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ	3.35	3.90	0.56

10	Нутгийн өөрөө удирдах байгууллага /Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/	3.55	3.89	0.34
11	Шүүхийн шинжилгээний байгууллага	2.98	3.86	0.88
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3.44	3.81	0.37
13	Гадаадын иргэн, харьяатын газар	3.19	3.73	0.54
14	Авлигатай тэмцэх байгууллага	2.88	3.71	0.83
15	Хил хамгаалах байгууллага	2.56	3.54	0.97

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1.4 ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Төрийн үйл ажиллагааны хүрээний 16 тодорхой чиглэлд авлигын тархалтын үзүүлэлт 3.94 гарч өмнөх оноос 46 пунктээр өссөн дүнтэй байна.

Тодорхой 16 чиглэлийн авлига тархсан байдлын үзүүлэлт өссөн буюу сөрөг үнэлгээтэй байна. Тухайлбал албан тушаалын томилгоод авлигын тархалтын үнэлгээ хамгийн өндөр буюу 4.43 пункттэй гарч өмнөх оноос 1.13 пунктээр өсчээ. Хил хамгаалах үйл ажиллагааны чиглэлд авлигын тархалтын үнэлгээ 1.20 пунктээр, гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаанд 0.99 пунктээр, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд 0.74 пунктээр тус тус өссөн нь төрийн үйл ажиллагааны хүрээний авлигын тархалтын үзүүлэлтийг сөрөг гарахад ихээхэн нөлөөлсөн байна.

Зураг 7. Нийтийн алба /төрийн байгууллага/-ын үйл ажиллагаан дахь авлигын түвшин




ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1.5 УЛС ТӨРИЙН АВЛИГЫН НӨЛӨӨЛӨЛ

Тодорхой салбар хүрээний үйл ажиллагаанд улс төрийн авлигын нөлөөллийн үзүүлэлт 3.92 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.20 пунктээр өссөн байна.

Нийт 11 салбар болон үйл ажиллагааны 8 чиглэлд нь авлига нөлөөлсөн байдлын үзүүлэлт өссөн сөрөг дүнтэй гарлаа. Тухалбал уул уурхай, ашигт малтмалын хүрээний үйл ажиллагаанд авлига нөлөөлсөн байдлын үнэлгээ 4.31 пункт, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаанд авлига нөлөөлсөн байдлын үнэлгээ 4.07 пункт, төрийн албаны үйл ажиллагаанд авлига нөлөөлсөн байдлын үнэлгээ 4.05 пункт гарчээ. Харин шүүхийн салбарт авлига нөлөөлсөн байдлын үнэлгээ 0.53 пунктээр, хууль сахиулах салбарт 0.47 пунктээр, хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд 0.38 пунктээр өссөн нь улс төрийн авлигын нөлөөллийн үзүүлэлт сөрөг гарахад хамгийн их нөлөөлжээ.

Зураг 8. Улс төрийн хүрээний авлигын нөхцөл байдал, /салбар, үйл ажиллагааны чиглэл/




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үзүүлэлт 3.92 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.34 пунктээр өссөн байна.

Улс төрийн авлигын хэлбэрийг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлсон бөгөөд өнгөрсөн оноос улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ 0.34 пунктээр, нөлөөллийн хэлбэрийн үнэлгээ 0.29 пунктээр, улс төрийн нам, бизнесийн бүлэглэлийн

хамааралын үнэлгээ 0.43 пунктээр, хээл хахууль өгөх, авах арга хэлбэрийн үнэлгээ 0.44 пунктээр, хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ 0.20 пунктээр нэмэгдэж сөрөг дүнтэй гарчээ.

Зураг 9. Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ




ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2.1 ХЭЭЛ ХАХУУЛИЙН ХЭЛБЭР

Улс төрийн авлигын хүрээн дэх хээл хахуулийн хэлбэрийн үзүүлэлт 3.69 гарч өмнөх оноос 0.20 пунктээр өссөн байна.

Улс төрийн авлигын олон хэлбэр байгаагаас хамгийн түгээмэл гэж үзсэн дараах 13 хэлбэрийг сонгон үнэлүүлсэн. Улс төрийн авлигын хүрээн дэх хээл хахуулийн 3 хэлбэрийн үнэлгээ буурсан эерэг дүнтэй гарсан бол 10 хэлбэрийн үнэлгээ өссөн сөрөг дүнтэй гарчээ. Тухайлбал бэлэн мөнгө өгөх хэлбэрийн үнэлгээ 0.41 пункт, эмчилгээ, сувилгааны зардал төлөх хэлбэрийн үнэлгээ 0.47 пункт, сургалтын зардлыг төлөх хэлбэрийн үнэлгээ 0.38 пункт, ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх хэлбэрийн үнэлгээ 0.33 пунктээр тус тус өссөн байна. Харин ажил, албан тушаалд томилох, оруулах хэлбэрийн үнэлгээ 0.11 пунктээр, хувьцаа өгөх хэлбэрийн үнэлгээ 0.10 пунктээр, шагнал, цол, тэмдгээр шагнах хэлбэрийн үнэлгээ 0.10 пунктээр тус бүр буурчээ.

Зураг 10. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ




ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2.2 ХУУЛЬ БУС НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР

Улс төрчид, өндөр албан тушаалтнууд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийн үзүүлэлт 3.94 гарч өмнөх оноос 0.30 пунктээр өссөн байна.

Хууль бус нөлөөллийг тогтоох 9 дэд үзүүлэлт өмнөх оноос өссөн бөгөөд айлган сүрдүүлэх, заналхийлэх хэлбэрийн үнэлгээ 0.57 пункт, албадах хэлбэрийн үнэлгээ 0.53 пункт, дарамт шахалт үзүүлэх хэлбэрийн үнэлгээ 0.34 пункт, нутаг орны хэлхээ холбоог ашиглах хэлбэрийн үнэлгээ 0.27 пунктээр тус тус өссөн нь хууль бус нөлөөллийн үзүүлэлт сөрөг гарахад хамгийн их нөлөөлсөн байна.

Зураг 11. Хууль бус нөлөөллийн үнэлгээ



ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2.3 УЛС ТӨРИЙН НАМ, БҮЛЭГЛЭЛ, УЛС ТӨР, БИЗНЕС, ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮДИЙН ХАРИЛЦАА ХАМААРАЛ

Төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчид болон улс төрийн нам, бүлэглэл, гадаад дотоод бизнесийн бүлэглэл, гэмт бүлэглэлийн харилцаа хамаарлын үзүүлэлт 3.88 гарч өнгөрсөн оноос 0.44 пунктээр өссөн байна.

Нийт 11 нөхцөл байдлын үнэлгээ бүгд өсч сөрөг дүнтэй гарсан байна. Тухалбал гаднын бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ийг эрхшээлдээ оруулсан байдлын үнэлгээ 0.74 пункт, гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн байдлын үнэлгээ 0.67 пункт, гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан байдлын үнэлгээ 0.64 пункт, улс төрчид шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн байдлын үнэлгээ 0.62 пункт, гаднын улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тэй нэгдсэн байдлын үнэлгээ 0.47 пунктээр өссөн байна.

Хүснэгт 2. Нөхцөл байдлын үнэлгээ

№		2016 он	2017 он	Өөрчлөлт
1	Бизнесийн бүлэглэл улс төрчдийг эрхшээлдээ оруулсан	4.05	4.31	0.26
2	Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.13	4.29	0.16
3	Улс төрчид шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	3.67	4.29	0.62
4	Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4.23	4.27	0.04
5	Улс төрчид бизнесийн бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3.61	3.79	0.18
6	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	2.93	3.68	0.74
7	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	2.88	3.53	0.64
8	Гэмт бүлэглэл улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	2.96	3.50	0.54
9	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	3.00	3.47	0.47
10	Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	2.88	3.40	0.52
11	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	2.64	3.31	0.67

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2.4 УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төрийн авлигын хэлбэрийн үзүүлэлт 4.18 гарч өнгөрсөн оноос 0.34 пунктээр өссөн үнэлгээтэй байна.

Нийт 15 үзүүлэлтийн 14 үзүүлэлт нь өссөн сөрөг дүнтэй гарсан бол 1 үзүүлэлт буурсан эерэг дүнтэй байна. Үүнд хууль бусаар дампууруулах хэлбэрийн үнэлгээ 0.85 пункт, мөнгө угаах хэлбэрийн үнэлгээ 0.66 пункт, сонгогчдын саналыг худалдан авах хэлбэрийн үнэлгээ 0.53 пунктээр тус бүр өссөн нь нийт үнэлгээнд нөлөөлөх гол хүчин зүйл болжээ. Харин төрийн өмчийг хувьдаа завших хэлбэрийн үнэлгээ 0.02 пунктээр буурсан байна.

Зураг 12. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэр



ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2.5 УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ АРГА

Улс төрийн хүрээний хээл хахууль өгөх, авах аргуудыг хэрэглэсэн байдлын үзүүлэлт 3.87 гарч өмнөх оноос 0.44 пунктээр өссөн байна.

Нийт 11 хэлбэрийн үзүүлэлт бүгд өсч сөрөг дүнтэй гарчээ. 2017 онд зуучлагчаар дамжуулах аргын үнэлгээ 4.08 пункт, ойр дотны хүмүүсээр дамжуулах аргын үнэлгээ 4.06 пункт гарсан нь хамгийн сөрөг үзүүлэлтүүд болжээ. Мөн биечлэн уулзаж өгч, авах аргын үнэлгээ 0.65 пунктээр, өмгөөлөгчөөр дамжуулах аргын үнэлгээ 0.58 пунктээр, мөрийтэй тоглож санаатай алдах хэлбэрийн үнэлгээ 0.55 пунктээр тус тус өсчээ.

Зураг 13. Улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээ




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 3. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Улс төрийн авлигын түвшний шалгуураас шалтгаан нөхцөлийн үзүүлэлт 2017 онд 4.15 гарч өнгөрсөн оноос 0.26 пунктээр нэмэгдсэн байна.

Улс төрийн авлигын шалтгаан, нөхцөлөөс бүлэглэлүүдийн нөхцөл байдлын үзүүлэлт 4.08 пункт гарч өмнөх оноос 0.36 пунктээр нэмэгджээ. Мөн улс төрийн авлигын түвшинд нөлөөлсөн дутагдал доголдолын үзүүлэлт 4.10 пункт, улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үзүүлэлт 4.25 пункт гарч өмнөх оны үзүүлэлтээс өссөн сөрөг дүнтэй байна.

Зураг 14. Шалтгаан, нөхцөл



ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 3.1 УЛС ТӨРИЙН АВЛИГАД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үзүүлэлт 4.25 гарч өнгөрсөн оноос 0.44 пунктээр өссөн байна.

2017 оны байдлаар УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчлийн үзүүлэлт 4.23 пункт гарч өмнөх оны үнэлгээнээс 1.35 пунктээр өссөн нь нийт үзүүлэлтэд хамгийн их нөлөөлсөн байна. Мөн сонгуулийн санхүүжилтийн механизмийн үнэлгээ 0.24 пункт, улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчлийн үнэлгээ 0.39 пункт, намын санхүүжилтийн механизмын үнэлгээ 0.25 пунктээр тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ

№		2016 он	2017 он	Өөрчлөлт
1	Намын санхүүжилтийн механизм	4.31	4.56	0.25
2	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.48	4.55	0.07
3	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	4.10	4.49	0.39
4	Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.17	4.42	0.24
5	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4.02	4.26	0.24
6	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.49	4.25	0.76
7	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	2.88	4.23	1.35
8	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.71	4.07	0.37
9	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	3.72	4.02	0.30
10	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	3.45	3.96	0.52
11	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	3.45	3.93	0.48

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 3.2 УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ДУТАГДАЛ, ДОГОЛДОЛ

Улс төрийн авлигад төрийн үйл ажиллагааны нөлөөллийн үзүүлэлт 4.10 гарч өнгөрсөн оноос 0.16 пунктээр өссөн байна.

Төрийн үйл ажиллагааны дутагдал, доголдлыг 12 үзүүлэлтэд хамааруулж хэмжсэн бөгөөд үүнээс 11 үзүүлэлт өсөлттэй буюу сөрөг гарчээ. Шинжээчдийн үзэж байгаагаар хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул, албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж, төрийн албан хаагчийн ур чадвар дутмаг гэх зэрэг үзүүлэлтийг илүү сөргөөр үнэлсэн байна.

Хүснэгт 4. Улс төрийн авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол


№		2016 он	2017 он	Өөрчлөлт
1	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.17	4.35	0.18
2	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	4.08	4.33	0.26
3	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	4.03	4.21	0.18
4	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	3.89	4.14	0.25
5	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	4.02	4.13	0.11
6	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	3.94	4.11	0.18
7	Хүнд суртал	4.02	4.10	0.08
8	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	4.09	4.03	-0.06
9	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	3.83	4.00	0.17
10	ТАХ-ийн ур чадвар дутмаг	3.74	3.94	0.20
11	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.84	3.89	0.05
12	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	3.69	3.85	0.16

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 3.3 УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХҮРЭЭЛЛҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улс төрийн хүрээн дэх тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн хүрээллийн нөхцөл байдлын үзүүлэлт 4.08 гарч өнгөрсөн оноос 0.31 пунктээр өссөн байна.

Нийт 7 дэд үзүүлэлтээс 6 дэд үзүүлэлтийн үнэлгээ өссөн дүнтэй гарчээ. Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нам тойрсон хүрээлэл, бизнесийн хүрээлэл, нам дамнасан хүрээлэл, нэг нутаг /аймаг/ тойрсон хүрээллийн нөлөөлөл их байсан гэж үзэж байгаа бол хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нэг хүнийг тойрсон хүрээллийн нөхцөл байдлын үнэлгээ буурсан дүнтэй байна.

Зураг 15. Улс төрийн хүрээн дэх хүрээллүүдийн нөхцөл байдал




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Улс төрийн авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 2017 онд 3.91 гарч өнгөрсөн оноос 0.22 пунктээр нэмэгдсэн байна.

Улс төрийн авлигын хор уршиг, үр дагаврын үнэлгээ 0.31 пунктээр, улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээ 0.09 пунктээр өссөн нь авлигын хор уршиг, үр дагаврын үндсэн шалгуур үзүүлэлтэд сөргөөр нөлөөлжээ.

Зураг 16. Улс төрийн авлигын хор уршиг, үр дагавар



ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 4.1 УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ

Улс төрийн авлигын хор уршгийн үзүүлэлтийн үзүүлэлт 4.34 болж өнгөрсөн оноос 0.32 пунктээр нэмэгдсэн байна.

Нийт 16 үзүүлэлтээс 15 үзүүлэлтийн үнэлгээ дунджаар 0.37 пунктээр нэмэгдсэн нь улс төрийн авлигын хор уршгийн үзүүлэлт сөрөг дүнтэй гарахад нөлөөлсөн байна. Тухайлбал нийгмийн дэг журам алдагдсан байдлын үнэлгээ 0.80 пунктээр, гэмт хэрэг нэмэгдсэн байдлын үнэлгээ 0.58 пунктээр, хүний эрхийн зөрчил нэмэгдсэн байдлын үнэлгээ 0.55 пунктээр тус тус өсчээ.

Зураг 17. Улс төрийн хүрээний авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин



ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 4.2 УЛС ТӨРИЙН АВЛИГААР ОЛСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үзүүлэлт 3.47 гарсан нь өнгөрсөн оноос 0.09 пунктээр өссөн байна.

Нийт 19 үзүүлэлтээс 14 үзүүлэлтийн үнэлгээ өссөн сөрөг дүнтэй байна. Үүнээс гадаадын банканд хадгалах болон гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах хэлбэрийг түгээмэл гэж шинжээчид үзсэн байна. Гэвч гадаадын банканд хадгалах хэлбэрийн үнэлгээ 0.35 пункт, гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах хэлбэрийн үнэлгээ 0.21 пунктээр өмнө оноос буурсан эерэг дүнтэй гарчээ. Харин урлагийн бүтээл худалдан авах хэлбэрийн үнэлгээ 0.60 пункт, гэр бүлийн гишүүний сургалтын төлбөрт зарцуулах хэлбэрийн үнэлгээ 0.35 пункт, эмчилгээнд зарцуулах хэлбэрийн үнэлгээ 0.35 пунктээр тус тус өссөн нь улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үзүүлэлт сөрөг дүнтэй гарахад хамгийн ихээр нөлөөлсөн байна.

Зураг 18. Улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт




2. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

Дэд бүлгийн энэхүү хүрээнд улс төрийн авлигын үндсэн үзүүлэлтээс гаднах бусад үзүүлэлтийн үнэлгээгээр авлигын ерөнхий ойлголт, төсөөллийг гаргаж ирэхийг зорьсон юм.

АВЛИГЫН ТҮВШИН

Судалгаанд оролцсон нийт шинжээчдийн 43.5 хувь нь Монгол Улсад авлига их байна гэж үнэлсэн бол 32.3 хувь нь маш их гэж үзжээ. Судалгааны мэдээллээс дүгнэвэл арван шинжээч тутмын долоо нь Монгол Улсад авлига сүүлийн нэг жилийн хугацаанд түгээмэл байсан гэж үзэж байна.


Зураг 19. Монгол Улс дахь авлигын түвшин



УЛС ТӨРИЙН НАМУУДЫН АВЛИГАД АВТСАН БАЙДАЛ

Судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлгээгээр 2017 онд улс төрийн намуудын авлигад автсан байдлыг тус бүрд нь тооцож үзвэл МАН 35.8 хувь, АН 35.1 хувь, МАХН 19.2 хувьтай эхний гурваг байрт жагсаж байна. Судалгааны мэдээллээс дүгнэвэл хамгийн их авлигад автсан намаар МАН болон АН-ыг тус тус нэрлэсэн байна.

Зураг 20. Монгол Улс дахь улс төрийн намуудын авлигад автсан байдал



АВЛИГЫН ХҮРЭЭНИЙ ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Монгол Улсын авлигыг ерөнхий хандлагын зэрэгцээ цар хүрээгээр нь тодорхойлохыг зорьсон юм. Улс орны авлига ямар түвшинд байгаа нь цар хүрээний тархацтай шууд холбоотой юм. Нийт 11 дэд хүрээнээс улс төрийн намыг 90.7 хувь, засгийн газрыг 79 хувь, Улсын Их Хурлыг 65.6 хувь нь авлигын тархалтын үзүүлэлтээр хамгийн өндөр гэж үзжээ. Харин төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хүрээнд харьцангуй бага гэж үнэлж байна. Шинжээчдийн үнэлгээнээс үзвэл төрийн дээд шатны байгууллага болон улс төрийн намын хүрээнд авлига илүү түгээмэл байсан гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт 5. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдал

		Мэдэхгүй	Огт үгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Их	Маш их
1	Улс төрийн нам	4.7	-	1.6	3.1	26.6	64.1
2	Засгийн газар	8.1	-	1.6	11.3	35.5	43.5
3	Прокурор	28.3	-	2.2	8.7	26.1	34.8
4	Улсын их хурал	29.5	-	-	8.2	29.5	32.8
5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж	11.5	-	6.6	16.4	32.8	32.8
6	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	16.1	-	6.5	19.4	27.4	30.6
7	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	16.7	-	2.4	16.7	38.1	26.2
8	Шүүх	24.6	-	1.6	19.7	27.9	26.2
9	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	12.5	-	10.9	21.9	29.7	25
10	Хувийн хэвшил	16.1	6.5	29	19.4	16.1	12.9
11	Төрийн бус байгууллага	24.2	8.1	22.6	21	12.9	11.3

БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЗАРЦУУЛЖ БУЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны явцад өгч буй авлигын үнэлгээг тооцож үзвэл тендерт шалгаруулалтад ялахад, тусгай зөвшөөрөл авахад үйл явцад, төсөл хөтөлбөрт хамрагдахад илүү өндөр авлига өгдөг гэжээ.

Хүснэгт 6. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ /хувь/

		Мэдэхгүй	5 хүртэлх хувь	6-10 хувь	11-15 хувь	16-20 хувь	21 дээш хувь
1	Төсөл хөтөлбөрт хамрагдах	19.0	3.2	36.5	19.0	11.1	11.1
2	Тендерт шалгаруулалтад ялахад	18.8	4.7	17.2	25.0	17.2	17.2
3	Зээл авахад	22.2	22.2	19.0	19.0	11.1	6.3
4	Өр төлбөр барагдуулах, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэхэд	30.8	15.9	19.0	17.5	9.5	6.3
5	Татвараас чөлөөлүүлэх, буруулахад	30.2	14.3	19.0	20.6	4.8	11.1
6	Хяналт шалгалтаар зөрчил дутагдалгүй гарахад	18.8	15.6	12.5	28.1	9.4	15.6
7	Тусгай зөвшөөрөл авахад	20.6	9.5	14.3	15.9	14.3	25.4
8	Бараа ажил, үйлчилгээ хүлээлгэн өгөхөд	20.6	12.7	22.2	20.6	12.7	11.1
9	Гадаадаас ажиллах хүч авахад	40.0	7.9	19.0	12.7	12.7	6.3

ХЭЭЛ ХАХУУЛЬД ЗАРЦУУЛСАН МӨНГӨНИЙ ХЭМЖЭЭ

Хээл хахуульд өгч буй мөнгөн дүнг тооцож үзвэл тусгай зөвшөөрөл авахад, ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгох зэрэгт хамгийн их хэмжээний мөнгө авлигад зарцуулдаг гэж шинжээчид хариулжээ.

Хүснэгт 7. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ /зорилгоор, сая төгрөгөөр

		Мэдэхгүй	1 сая хүртэл	1-5 сая	5-10 сая	10-20 сая	20-50 сая	50 саяас их
1	Ажил, албан тушаалд ороход	25.0	1.6	23.4	15.6	14.1	7.8	12.5
2	Тусгай зөвшөөрөл авахад	33.9	8.1	21.0	9.7	8.1	19.4	33.9
3	Ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад	38.7	1.6	3.2	4.8	6.5	1.6	43.5
4	Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход	50.0	-	6.5	4.8	4.8	11.3	22.6
5	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход	45.2	1.6	11.3	6.5	6.5	12.9	16.1
6	Эрүүгийн хэрэг үүсгэхэд	54.1	3.3	6.6	9.8	4.9	8.2	13.1
7	Гэмт хэрэг зөрчлийг нуун дарагдуулахад	49.2	1.6	9.8	3.3	4.9	8.2	23.0
8	Хуурамч бичиг баримт үйлдэхэд	50.0	1.9	17.3	11.5	1.9	7.7	9.6

ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шинжээчид улс төрийн хүрээн дэх авлигыг бууруулахад олон төрлийн арга хэмжээ шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнээс ур чадварт үндэслэн томилгоо хийх тогтолцоог бүрдүүлэх, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, Хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулах, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зэргийг илүү үр дүнтэй гэж үзэж байна.


Зураг 21. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ




3. ШИНЖЭЭЧДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд оролцсон шинжээчдийг хүн ам зүйн байдлаар авч үзвэл 55.4 хувь нь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэй байна. Харин насны бүтцийн хувьд 35-44 насныхан 45.3 хувийг эзэлж байгаа бол 45-54 насныхан 25.0 хувьтай хамрагдсан байна.

Зураг 22. Шинжээчдийн хүйс




Зураг 23. Шинжээчдийн нас



Төрийн байгууллагад ажиллагсад 43.1 хувь, төрийн бус байгууллагад ажиллагсад 16.9 хувь, хувийн хэвшилд ажиллагсад 20.0 хувьтай, олон улсын байгууллагад ажиллагсад 9.2 хувь, судлаачид 10.7 хувьтай оролцжээ.

Зураг 24. Шинжээчдийн ажиллаж буй салбар



ДҮГНЭЛТ

Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин өнгөрсөн буюу 2016 оны үзүүлэлтээс 0.32 пунктээр өндөр гарлаа.

Улс төрийн авлигын түвшинд нөлөөлж буй шалтгаан нөхцөл, илрэн гарч буй хэлбэр, хамарч буй цар хүрээ, учруулж буй хор уршиг гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтүүд бүгд өссөн нь Монгол Улсад дээд түвшний авлига улам бүр хүрээгээ тэлж, улс оронд учруулж буй сөрөг үр дагавар нэмэгдсэнийг илтгэж байна.

Монгол Улсын Их Хурал, засгийн газар /яам, агентлаг/, улс төрийн нам, шүүх, хуулийн байгууллага зэрэг дээд шатны салбар хүрээнд улс төрийн авлигын түвшин бусад төрийн институтээс харьцангуй өндөр байгаа нь улс орны нийгэм, эдийн засгийг удирдан чиглүүлэх үйл ажиллагааны хүрээнд улс төрийн авлигын нөлөөлөл хамгийн их байна гэж дүгнэж болохоор байна.

Монгол Улсад албан ёсны бүртгэлтэй улс төрийн намуудаас парламентад суудалтай, түүнчлэн засгийн эрх барьж байгаа Монгол Ардын Нам, мөн парламентад суудалтай Ардчилсан нам, Монгол Ардын Хувьсгалт Нам авлигад хамгийн ихээр автсан байгаа нь Монголын улс төрийн хүрээний үйл ажиллагаа хувийн эрх ашгаа улс төрийн намын ашиг сонирхлын дор далдалсан нэг нам, эсхүл намууд дамнасан бүлэглэл, хүрээллүүдийн үйл ажиллагаа болж хувирсантай холбоотой гэж үзэж байна.

Улс төрийн авлигын хор уршиг нь улс орны эдийн засгийн хүч чадлыг сулруулж, төрийн албаны чадавхийг бууруулаад зогсохгүй Монгол Улсын нэр хүнийг олон улсын түвшинд унасан ноцтой хор уршиг сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Шинжээчид улс төрийн авлигыг бууруулахад олон төрлийн арга хэмжээ шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнээс ур чадварт үндэслэн томилгоо хийх тогтолцоог бүрдүүлэх, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг чангатгах зэрэг асуудлыг илүү анхаарах шаардлагатай гэж онцолж байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2018



ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2018 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БҮЛЭГ I. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Хүүхдийн шударга байдлын түвшинг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

Хүүхдийн шударга байдлын түвшин 2018 оны судалгаагаар 3.91 гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 0.06-аар буурсан байна (Зураг 1).


Зураг 1. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор



Зураг 2. Хүүхдийн шударга байдлын 2018 оны судалгааны түвшин аймаг, нийслэлээр




Зураг 3. Баруун бүсийн аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшин 2015- 2018 оны байдлаар




Зураг 4. Хангайн бүсийн аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшин 2015-2018 оны байдлаар



Зураг 5. Төвийн бүсийн аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшин 2015-2018 оны байдлаар



Зураг 6. Зүүн бүсийн аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшин 2015-2018 оны байдлаар




Зураг 7. Нийслэлийн дүүргүүдийн хүүхдийн шударга байдлын 2018 оны түвшин



Зураг 8. Хүүхдийн шударга байдал хүйсээр



Зураг 9. Хүүхдийн шударга байдал суралцаж буй ангиар



Зураг 10. Хүүхдийн шударга байдал сургуулийн өмчийн хэлбэрээр



ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Зураг 11. Шударга байх талаар ярилцдаг нь хүүхдийн шударга байдалд нөлөөлөх эсэх




Зураг 12. Хүүхдийг шударга хандсаныг нь төлөө магтах явдал шударга байдалд нөлөөлөх эсэх




Зураг 13. Шударга ёсны талаар хичээл орох нь шударга байдалд нөлөөлөх эсэх



Зураг 14. Шударга бус асуудал тохиолдоход хүүхдийн үйлдэл




Зураг 15. Хүүхдүүд шударга бус зүйл хийхэд эцэг, эхийн үйлдэл




Зураг 16. Хүүхдүүд шударга бус үйлдлийн талаар ярилцах ба хүүхдийн шударга байдал



Зураг 17. Хүүхдүүдийн шударга ёсны талаарх мэдээлэл авах суваг ба хүүхдийн шударга байдлын түвшин



Зураг 18. Шударга бус үйлдлийг олон нийтэд мэдээлэх эсэх



БҮЛЭГ II. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүүхдийн шударга байдлын судалгааг “Транспэрэнси Интернэшнл Солонгос” байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, Солонгос, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулсан. Үүнээс хойш уг арга зүйн дагуу Хүүхдийн шударга байдлын судалгааг 8 дахь удаагаа зохион байгуулаад байна.

1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын түвшинг тогтоохдоо доорх 12 асуултад тухайн хүүхэд санал нийлж байгаа эсэхийг нь асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үнэлгээний арифметик дунджаар гаргав. Хүүхдийн шударга байдлын түвшин нь хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих үзэл гэсэн дэд үзүүлэлтээс бүрддэг. Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлэхэд ашигласан асуулт

Асуултын дугаар	Асуулт
1.	Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.
2.	Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.
3.	Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
4.	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.
5.	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.
6.	Баян байх нь шударга байхаас илүү чухал.
7.	Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.
8.	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.
9.	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.
10.	Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.
11.	Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.
12.	Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.

Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдлын үзүүлэлтийг тооцохдоо дээр дурдсан асуултуудын дагуу дэд үзүүлэлтийн дунджийг тооцсон болно. Дэд үзүүлэлт тооцоход ашигласан асуултыг дараахь хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтийг тооцсон асуулт, асуултын дугаараар

Ёс зүй, ёс суртахуун		Зөв төлөвшилт	Хууль сахих	Авлигыг үл тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

2. СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ


Хүүхдийн шударга байдлын судалгааг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан, 21 аймаг, нийслэлийн 7-12 дугаар ангийн сурагчдыг санамсаргүй байдлаар сонгон, бэлтгэгдсэн асуулгыг бөглүүлж, судалгааг зохион байгуулав.

Судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах ажлыг 21 аймаг, нийслэлд Монголын Сурагчдын холбоо төрийн бус байгууллагатай хамтран 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд зохион байгууллаа.


3. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН БҮТЭЦ

“Хүүхдийн шударга байдал-2018” судалгаанд хамрагдсан нийт 4071 сурагчдийн 45.8 хувь нь эрэгтэй, 54.2 хувь нь эмэгтэй байгаа бол 16 настай сургагчид хамгийн их буюу 16.8 хувь, 19 настай сурагчид хамгийн бага буюу 2.3 хувь байна. Судалгаанд хамрагдсан сурагчдыг байршлаар нь авч үзвэл 59.2 хувь нь аймгуудаас, 40.8 хувь нь нийслэлээс хамрагдсан байна (Зураг 19-20).

Зураг 19. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, нас



Зураг 20. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, анги



ДҮГНЭЛТ

Авлигатай тэмцэх газар нь “Хүүхдийн шударга байдлын түвшин 2018 он” судалгааг Монголын Сурагчдын холбоо төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулав. Судалгааны үр дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

- ✓ Хүүхдийн шударга байдлын түвшин 2018 оны судалгаагаар 3.91¹ гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 0.06 пунктийн зөрүүтэй байна.
- ✓ Хүүхдийн шударга байдлын түвшинг аймаг, нийслэлээр тооцдог ба 2018 оны судалгааны үр дүнгээр 13 аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин буурсан байна. Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин 2015 оноос хойш эерэг хандлагатай байгаа бол Орхон, Ховд, Улаанбаатарын хүүхдийн шударга байдлын түвшин сүүлийн 4 удаагийн судалгааны үр дүнгээр буурч байна.
- ✓ Судалгааны дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин нас ахин анги дэвших тутам буурч байгаагаас гадна эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эмэгтэй хүүхдийнхээс доогуур байна. Мөн нийслэлийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин орон нутгийн хүүхдүүдийнхээс доогуур байдаг хандлага мөн энэ удаагийн судалгаанд илрэв.
- ✓ Энэ удаагийн судалгаагаар сургуулийн өмчийн хэлбэрээр хүүхдийн шударга байдлын түвшинг тооцов. Төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин хувийн өмчийн хэлбэрийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшинөөс 0.15 пунктээр их байна.
- ✓ Шударга байх талаар ярилцах, шударга хандсаны төлөө сайшаан урамшуулах, шударга ёсны талаар зааж сургах, хүүхэддээ анхаарал, халамжтай байх нь хүүхдийн шударга байдалд эерэгээр нөлөөлдөг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

¹ Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2018



ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2018


СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Шударга байдлын үнэлгээ (ШБҮ) нь тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ (үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн үнэлгээ), дотоод шударга байдлын үнэлгээ (төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчдын үнэлгээ), бодлогод оролцогчдын үнэлгээ (шинжээчдийн үнэлгээ) гэсэн гурван дэд үнэлгээнээс бүрдсэн үнэлгээ юм.

Үнэлгээг 0-100 хүртэл оноогоор тооцох бөгөөд утга нь 100-тай тэнцүү бол шударга байдлын дээд түвшинг илэрхийлнэ. ШБҮ-нд 2015 онд 62, 2016 онд 60, 2018 онд 62 байгууллага (яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ)-ыг хамруулаад байна.


ШБҮ-ний 2018 оны судалгаанд нийтдээ 9411 нэгж (Гадаад шударга байдлын үнэлгээнд 7260 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, Дотоод шударга байдлын үнэлгээнд 1360 төрийн албан хаагч, Шинжээчдийн үнэлгээнд 795 шинжээч)-ийг хамруулсан болно.

Зураг 1. Шударга байдлын үнэлгээ, оноор, хувиар



Төрийн байгууллагууд ШБҮ-ээр 100 онооноос 2018 онд дунджаар 68.7 оноо авсан нь өмнөх оны үзүүлэлтээс 1.0 пунктээр буурсан байна. Харин 2015 оны үзүүлэлтээс 5.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 2. Шударга байдлын үнэлгээ, 2018 оноор, байгууллагаар, хувиар



Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын ШБҮ-ний нийт дунджийг авч үзэхэд ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр дундаж үнэлгээтэй буюу 71.7 гэсэн үзүүлэлттэй гарсан. Яамдын ШБҮ-ний нийт дундаж 69.0 гэсэн үзүүлэлт гарсан. Харин аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын дундаж үнэлгээ 66.1 гарсан нь хамгийн бага дүн болж байна.

Шударга байдлын үнэлгээгээр 2018 онд хамгийн өндөр үнэлгээ авсан

байгууллагуудыг дурдвал Соёл, урлагийн газар хамгийн өндөр буюу 83.6, Завхан аймгийн ЗДТГ 83.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 83.1, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 80.4, Гадаад харилцааны яам 80.2 гэсэн үнэлгээг тус тус авч эхний байруудад эрэмбэлэгдсэн байна.

Харин Ховд аймгийн ЗДТГ 61.2, Говь-Алтай аймгийн ЗДТГ 59.3, Орхон аймгийн ЗДТГ 57.8, Баян-Өлгий аймгийн ЗДТГ 55.6, Дундговь аймгийн ЗДТГ 55.5 гэсэн үнэлгээг тус тус авч бусад байгууллагатай харьцуулахад бага үнэлгээтэй байна.

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1 Үндэслэл

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Авлигын индекс тооцох аргачлал”-ыг Авлигатай тэмцэх газрын дарга болон Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 76/(06/69) тоот хамтарсан тушаалаар, “Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлал”-ыг Авлигатай тэмцэх газрын даргын 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 59 дугаар тушаалаар тус тус батлан эдгээр аргачлалын дагуу Авлигын индексийг 2009, 2011, 2013 онд, Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг 2010, 2012, 2014, 2015 онуудад тооцож, олон нийтэд мэдээлж байсан билээ.

Авлигын индексийг тооцох, төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх явцад арга зүйгээ улам бүр боловсронгуй болгох, энэ чиглэлээр олон улсын түвшинд гарсан шинэлэг арга зүй, ололт амжилтыг тусгах шаардлага зүй ёсоор тавигдсан юм. Энэхүү шаардлагын дагуу дээрх хоёр судалгааг нэгтгэн бусад улс орны тэргүүн туршлагад үндэслэн “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны А/129 дугаар тушаалаар батлуулсан билээ.

Мөн Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д зааснаар Авлигатай тэмцэх газраас гаргасан “Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ” нь төрийн захиргааны байгууллагын үнэлгээний шалгуур үзүүлэлт болдог байсан. Дээрх журмыг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болгон шинэчлэн баталсан бөгөөд уг журмын 9.9-д “Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын түвшний үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно” гэж заасан байдаг.

Дээрх үндэслэлийн дагуу Шударга байдлын үнэлгээ 2018 судалгааг хийж гүйцэтгэлээ.

1.2 Шударга байдлын үнэлгээний зорилго, зорилт

Шударга байдлын үнэлгээг дараах зорилго, зорилтын хүрээнд явуулсан.

- Шударга ёсыг бэхжүүлэх, авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, авлигыг таслан зогсоох болон төрийн байгууллагаас авлигатай тэмцэх чиглэлээр

авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг суурь мэдээллээр хангах;

- Тухайн байгууллагын үнэлгээг нэмэгдүүлэхэд зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох;
- Үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх замаар төрийн байгууллагын зүгээс үнэлгээний үр дүнг сайжруулах хүсэл зоригийг нэмэгдүүлэх, авлигыг бууруулах санал, санаачилга өрнүүлэх, эрмэлзлийг бий болгох.

1.3 Шударга байдлын үнэлгээний систем, хамрах хүрээ

ШБҮ гэж тухайн байгууллагын ГШБҮ, ДШБҮ, ШҮ-ний 62 дэд үзүүлэлтэд тулгуурласан үнэлгээ юм. Үүнд:

- Гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ) гэж тухайн байгууллагын шударга байдалд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн өгч буй үнэлгээг;
- Дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ) гэж тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын зүгээс байгууллагынхаа талаар өгч буй үнэлгээг;
- Шинжээчийн үнэлгээ (ШҮ) гэж тухайн байгууллагын шударга байдлын талаарх бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын өгсөн үнэлгээг хэлнэ.

1.4 Шударга байдлын үнэлгээний загвар 2018

Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээг гаргахдаа дотоод ШБҮ, гадаад ШБҮ, шинжээчдийн үнэлгээ гэсэн 3 үндсэн үзүүлэлтээр үнэлгээг гаргадаг.

- Дотоод шударга байдлын үнэлгээнд авлигын индекс болон ил тод хариуцлагатай байдлын индексийн нийт 20 үнэлгээний үзүүлэлтүүд багтана.
- Харин гадаад шударга байдлын үнэлгээнд соёлын индекс болон ажлын байран дахь шударга байдлын индексийн нийт 26 үнэлгээний үзүүлэлт багтана.
- Шинжээчийн үнэлгээнд авлигын талаарх төсөөлөл, бодит тохиолдол болон авлигыг хянах механизм, удирдлагын хүсэл эрмэлзлийн нийт 16 үнэлгээний үзүүлэлт багтана.

Шударга байдлын үнэлгээний загварыг дараах зурагт дэлгэрэнгүй үзүүлсэн болно.

Зураг 1. Шударга байдлын үнэлгээний загвар



1.5 Хамрах хүрээ, түүврийн хэмжээ

Хамрах хүрээ

ШБҮ-нд зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний байгууллага буюу яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг хамруулдаг бөгөөд тухайн жилд үнэлгээнд хамруулах байгууллагын нэрсийг Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар баталдаг. ШБҮ-ний 2018 оны судалгаанд нийтдээ 62 байгууллага (яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ)-ыг хамруулсан болно.

Зураг 2. Шударга байдлын үнэлгээний систем, хамрах хүрээ



Түүврийн хэмжээ

Энэхүү судалгаанд 13 яам, 22 аймаг, нийслэлийн ЗДТГ, 27 агентлаг хамрагдсан. Үүнийг нэгжийн хувьд задлан авч үзвэл ГШБҮ-нд нийт 7260 иргэн, ДШБҮ-нд 1356 төрийн албан хаагч, ШҮ-нд 795 шинжээч буюу нийт 9411 оролцогчийг хамруулсан.

1.6 Мэдээлэл цуглуулалт

ШБҮ-ний судалгааг АТГ-аас нэгдсэн удирдамжаар хангаж ажилласан бөгөөд үнэлгээг судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК гүйцэтгэсэн.

“Эс ай Си Эй” ХХК нь 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн №177 тоот гэрээний хүрээнд хүлээсэн үүргийн дагуу зөвлөх үйлчилгээний ажлыг улсын хэмжээнд 2018 оны 9 дүгээр сарын 10- аас 11 дүгээр сарын 30-ны хооронд амжилттай зохион байгууллаа. Үнэлгээний мэдээлэл цуглуулалтын ажилд хот, хөдөөд нийт 48 судлаач 84 хонгийн хугацаанд ажиллаж судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэлээ.

БҮЛЭГ II. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН


Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээний үр дүнг дараах 4 дэд сэдвийн хүрээнд хүргэж байна. Үүнд:

1. Шударга байдлын үнэлгээний үр дүн
2. Гадаад шударга байдлын үнэлгээний үр дүн
3. Дотоод шударга байдлын үнэлгээний үр дүн
4. Шинжээчийн үнэлгээний үр дүн

2.1 Шударга байдлын үнэлгээний үр дүн


Шударга байдлын үнэлгээний үр дүнг гаргахдаа өмнөх 2 судалгааны үр дүн буюу 2015, 2016 оны судалгааны үр дүнгүүдтэй харьцуулан, яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээг гаргасан байгаа болно.

Зураг 3. Шударга байдлын үнэлгээ, оноор, хувиар



Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын үнэлгээгээр 2018 оны шударга байдлын үнэлгээ 68.7 хувь гарч энэ нь өнгөрсөн судалгааны буюу 2016 оны үзүүлэлтээс 1.0 пунктээр буурсан байна. Харин 2015 оны судалгааны үзүүлэлтээс 5.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 4. Байгууллагуудын шударга байдлын үнэлгээ, оноор, хувиар




Яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын шударга байдлын үнэлгээг авч үзвэл өнгөрсөн судалгааны буюу 2016 оны үзүүлэлтэй харьцуулахад ЗГ-ын агентлагийн шударга байдлын үнэлгээнд ахиц гарсан бол аймгуудын ЗДТГ-ын хувьд 2.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Харин яамдын шударга байдлын үнэлгээ 0.3 пунктээр буурсан байгаа нь ажиглагдаж байна.

2.2 Гадаад шударга байдлын үнэлгээний үр дүн

Гадаад шударга байдлын үнэлгээ мөн дээрхтэй адил өмнөх 2 судалгааны үр дүн буюу 2015, 2016 оны судалгааны үр дүнгүүдтэй харьцуулан гаргасан. Мөн ГШБҮ-ний гол үзүүлэлтүүд болох авлигын эрсдэлийн индекс, ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын индекс, авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол зэрэг үзүүлэлтүүдээр үнэлгээг гаргасан.


Зураг 5. Гадаад шударга байдлын үнэлгээ, оноор, хувиар



Гадаад шударга байдлын үнэлгээний хувьд /үйлчлүүлэгчдийн үнэлгээ/ 63.3 хувьтай гарсан ба шударга байдлын үнэлгээнээс 5.4 пунктээр бага гарсан байгаа нь үйлчлүүлэгч, иргэдийн хувьд төрийн байгууллагуудын шударга байдалд тааруу үнэлгээ өгч байгааг илтгэж байна. Гадаад шударга байдлын үнэлгээ нь өмнөх судалгааны үр дүнтэй мөн адил 63.3 хувьтай гарсан байгаа бол яамдын үнэлгээ 1.4 пунктээр нэмэгдсэн, ЗГ-ын агентлагуудын үнэлгээ 0.8 пунктээр буурсан, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 0.3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Дээрх

графикаас харахад судалгаанд оролцогчид яамдын шударга байдлыг өндрөөр үнэлсэн нь харагдаж байна.

Зураг 6. Гадаад шударга байдлын үнэлгээ, 2018 он, дэд үзүүлэлтээр, хувиар




Гадаад шударга байдлын 2018 оны үнэлгээг дэд үзүүлэлт тус бүрээр нь авч үзэхэд дээрхтэй мөн адил яамд хамгийн өндөр үнэлгээг авсан байна. Харин дэд үзүүлэлтүүд дотроос авлигын талаарх төсөөллийн үнэлгээгээр ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр буюу 57.5, авлигын шууд бус тохиолдлын үнэлгээгээр аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд хамгийн өндөр буюу 75.7 гэсэн үнэлгээг авсан байна.

2.3 Дотоод шударга байдлын үнэлгээний үр дүн


Дотоод шударга байдлын үнэлгээг өмнөх 2 судалгааны үр дүн буюу 2015, 2016 оны судалгааны үр дүнгүүдтэй харьцуулан гаргасан. Мөн ДШБҮ-ний гол үзүүлэлтүүд болох албан бус хэм хэмжээ, авлигын эсрэг тогтолцоо, хүний нөөц, төсвийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх, удирдлагын хүсэл эрмэлзэл зэрэг үзүүлэлтүүдээр үнэлгээг гаргасан.

Зураг 7. Дотоод шударга байдлын үнэлгээ, оноор, хувиар



Дотоод шударга байдлын үнэлгээ буюу байгууллагын ажилтан, албан хаагчдын үнэлгээ 76.8 хувь буюу ерөнхий үнэлгээнээс 8.1 пунктээр өндөр гарсан байгаа нь төрийн албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг өндрөөр үнэлдэг болох нь харагдаж байна. Гэвч энэ нь өмнөх оны судалгаанаас 4.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг яам, ЗГ-ын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ДШБҮ мөн адил бүгд буурсан байгаа нь бататган харуулж байна.

Зураг 8. Дотоод шударга байдлын үнэлгээ, 2018 он, дэд үзүүлэлтээр, хувиар




Дотоод шударга байдлын 2018 оны үнэлгээг дэд үзүүлэлт тус бүрээр нь авч үзэхэд албан бус хэм хэмжээний үнэлгээгээр ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр буюу 78.8, авлигын эсрэг тогтолцооны үнэлгээгээр ЗГ-ын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд хамгийн өндөр буюу 62.2, хүний нөөцийн үнэлгээгээр яам, ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр буюу 94.6, төсвийн зарцуулалтын үнэлгээгээр ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр буюу 94.0, Үүрэг даалгаврын шударга байдлын үнэлгээгээр аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд хамгийн өндөр буюу 81.6, гадаад орчин дахь авлигатай тэмцэх үнэлгээгээр яамд хамгийн өндөр буюу 99.2, удирдлагын хүсэл эрмэлзлийн үнэлгээгээр аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд хамгийн өндөр буюу 54.7 гэсэн үнэлгээг тус тус авсан байна. Дээрх 7 дэд үзүүлэлтийн 4-т нь ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр үнэлгээ авсан байгаагаас үзэхэд ДШБҮ нь яамд болон аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээнээс өндөр байгаа нь харагдаж байна.

2.4 Шинжээчдийн шударга байдлын үнэлгээний үр дүн

Шинжээчдийн шударга байдлын үнэлгээг өмнөх 2 судалгааны үр дүн буюу 2015, 2016 оны судалгааны үр дүнгүүдтэй харьцуулан гаргасан. Мөн ШШБҮ-ний гол үзүүлэлтүүд болох авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зэрэг үзүүлэлтүүдээр үнэлгээг гаргасан.


Зураг 9. Шинжээчдийн шударга байдлын үнэлгээ, оноор, хувиар



Шинжээчдийн шударга байдлын үнэлгээ буюу эксперт, шинжээчдийн үнэлгээ 66.0 хувьтай гарсан байна. Энэ үзүүлэлт ерөнхий үнэлгээнээс 2.7 пунктээр бага гарсан ба эксперт, шинжээчид байгууллагын шударга байдалд тааруу үнэлгээ өгч байгааг илтгэж байна.

ШШБҮ-г байгууллага бүрээр ангилан авч үзвэл яамдын үнэлгээ 2.5 пунктээр, ЗГ-ын агентлагуудын үнэлгээ 4.6 пунктээр өссөн үзүүлэлттэй байгаа бол аймгийн, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 4.0 пунктээр буурсан үзүүлэлттэй байна

Зураг 10. Шинжээчдийн шударга байдлын үнэлгээ, 2018 он, дэд үзүүлэлтээр, хувиар



Шинжээчдийн шударга байдлын 2018 оны үнэлгээг дэд үзүүлэлт тус бүрээр нь авч үзэхэд авлигын талаарх төсөөллийн үнэлгээгээр ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр буюу 74.0, авлигыг хянах механизмын үнэлгээгээр мөн ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр буюу 50.8, авлигын бодит тохиолдлын үнэлгээгээр яамд хамгийн өндөр буюу 96.3, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийн үнэлгээгээр ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр буюу 59.5 гэсэн үнэлгээг тус тус авсан байна. Дээрх 4 дэд үзүүлэлтийн 3-т нь ЗГ-ын агентлагууд хамгийн өндөр үнэлгээ авсан байгаагаас үзэхэд ШШБҮ нь яамд болон аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээнээс өндөр байгаа нь харагдаж байна.

БҮЛЭГ III. БАЙГУУЛЛАГУУДЫН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Байгууллагуудын шударга байдлын үнэлгээг гаргахдаа байгууллагын төрлөөр нь ангилан яамдын ШБҮ, засгийн газрын агентлагуудын ШБҮ, аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ШБҮ гэсэн 3 түвшинд хуваан авч үзсэн.


Нийт 62 байгууллага ШБҮ-нд хамрагдсанаас Соёл, урлагийн газар хамгийн өндөр үнэлгээг авсан. Нийт 62 байгууллагаас Соёл, урлагийн газар, Завхан аймгийн ЗДТГ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Батлан хамгаалахын яам зэрэг 5 байгууллага 80 хувиас дээш үнэлгээ авсан.

Зураг 11. Хамгийн өндөр үнэлгээ авсан 10 байгууллага, хувиар



Шударга байдлын үнэлгээгээр 2018 онд хамгийн өндөр үнэлгээ авсан байгууллагуудыг дурдвал Соёл, урлагийн газар хамгийн өндөр буюу 83.6, Завхан аймгийн ЗДТГ 83.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 83.1, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 80.4, Гадаад харилцааны яам 80.2, Батлан хамгаалахын яам 76.8, Гадаадын иргэн, харьяатын газар 76.6, Үндэсний хөгжлийн газар 76.4, Оюуны өмчийн газар 76.1, Цаг уур, орчны шинжилгээний газар 76.0 гэсэн үнэлгээг тус тус авч эхний 10-т эрэмбэлэгдсэн байна.

Зураг 12. Хамгийн бага үнэлгээ авсан 10 байгууллага, хувиар




Шударга байдлын үнэлгээгээр 2018 онд хамгийн бага үнэлгээ авсан байгууллагуудыг дурдвал Төв аймгийн ЗДТГ 63.9, Татварын ерөнхий газар 63.4, Биеийн тамир, спортын газар 62.7, Архангай аймгийн ЗДТГ 62.5, Өвөрхангай аймгийн ЗДТГ 61.4, Ховд аймгийн ЗДТГ 61.2, Говь-Алтай аймгийн ЗДТГ 59.3, Орхон аймгийн ЗДТГ 57.8, Баян-Өлгий аймгийн ЗДТГ 55.6, Дундговь аймгийн ЗДТГ 55.5 гэсэн үнэлгээг тус тус авч сүүлийн 10-т эрэмбэлэгдсэн байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1- ээс үзнэ үү.

3.1 Яамдын шударга байдлын үнэлгээ

Яамдын шударга байдлын үнэлгээнд 13 яам хамрагдсан ба нийт дундаж үнэлгээ нь 69.0 хувьтай гарсан. Доорх зурагт яамдын 2015, 2016, 2018 оны шударга байдлын үнэлгээг харьцуулан гаргасан.

Зураг 13. Яамдын шударга байдлын үнэлгээ, оноор, хувиар




Яамдын хувьд 2018 оны шударга байдлын үнэлгээгээр Гадаад харилцааны яам хамгийн өндөр үнэлгээ буюу 80.2 оноог авсан бол үүний дараа 2-рт Батлан хамгаалахын яам 76.8, 3-рт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 73.2 гэсэн үнэлгээг тус тус авч, эхний 3 байрыг эзэлсэн. Харин хамгийн бага үнэлгээг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам авсан байна.

3.2 ЗГ-ын агентлагуудын үнэлгээ

ЗГ-ын агентлагуудын үнэлгээнд 27 агентлаг хамрагдсан ба нийт дундаж үнэлгээ нь 71.7 хувьтай гарсан.

Доорх зурагт тус агентлагуудын 2015, 2016, 2018 оны шударга байдлын үнэлгээг харьцуулан гаргасан.

Зураг 14. ЗГ-ын агентлагуудын шударга байдлын үнэлгээ, оноор, хувиар




Засгийн газрын агентлагуудын 2018 оны шударга байдлын үнэлгээгээр Соёл, урлагийн газар хамгийн өндөр үнэлгээ буюу 83.6, үүний дараа 2-рт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 83.1, 3-рт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 80.4 гэсэн үнэлгээг тус тус авч, эхний 3 байрыг эзэлсэн байна. Харин бага үнэлгээг Биеийн тамир, спортын газар авсан байна.

3.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үнэлгээ

Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үнэлгээнд 22 ЗДТГ хамрагдсан ба нийт дундаж үнэлгээ нь 66.1 хувьтай гарсан.

Доорх зурагт тус ЗДТГ-уудын 2015, 2016, 2018 оны шударга байдлын үнэлгээг харьцуулан гаргасан.

Зураг 15. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын шударга байдлын үнэлгээ, оноор, хувиар



Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээгээр Завхан аймгийн ЗДТГ хамгийн өндөр үнэлгээ буюу 83.2, үүний дараа 2-рт Увс аймгийн ЗДТГ 74.0, 3-рт Дархан-Уул аймгийн ЗДТГ 72.0 гэсэн үнэлгээг тус тус авч, эхний 3 байрыг эзэлсэн байна. Харин хамгийн бага үнэлгээг Дундговь аймгийн ЗДТГ авсан байна.

БҮЛЭГ IV. МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГЫН ТӨСӨӨЛӨЛ

Энэхүү бүлэг нь шударга байдлыг түвшнийг тогтоохтой холбоогүй бөгөөд зөвхөн Монгол улс дахь авлигыг үнэлэх зорилготойгоор шударга байдлын үнэлгээний судалгаанд нэмэгдэж орж ирсэн бүлэг юм.

Монгол улс дахь авлигын төсөөлөл бүлгийн хүрээнд Монгол улсын авлигын өнөөгийн байдал болон авлига хамгийн их тархсан институц, ирэх 2 жилийн авлигын нөхцөл байдлын талаар судалгаанд оролцогчдоос санаа бодлыг авч судалгааны үр дүнд нэгтгэснээ хүргэж байна.

4.1 Монгол Улсын авлигын өнөөгийн байдал

Монгол Улсын авлигын өнөөгийн байдлыг тодорхойлохдоо судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хэр түгээмэл байна вэ? гэсэн асуултаар тодруулсан ба хариултуудын хувьд ихээхэн түгээмэл, түгээмэл, дунд зэрэг, бага, огт байхгүй, мэдэхгүй гэсэн хариултуудын үр дүнг авч дараах байдлаар нэгтгэсэн. Энэхүү үр дүнгээ 2016 оны судалгааны үр дүнтэй харьцуулан үзүүлэв.

Зураг 16. Монгол Улсад авлига хэр түгээмэл байна вэ?



Судалгаанд оролцогчдын 28.3 хувь нь Монгол Улсад авлига ихээхэн түгээмэл байна гэж хариулсан бол энэ нь өмнөх судалгаа буюу 2016 оны үр дүнгээс 8.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн 50.6 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байна гэж хариулжээ. Үүнээс харахад нийт судалгаанд оролцогчдын 78.7 хувь нь Монгол улсад авлига түгээмэл байна гэж үзсэн байна.

4.2 Монгол Улсын ирэх 2 жилийн авлигын нөхцөл байдал

Монгол улсын ирэх 2 жилийн авлигын нөхцөл байдлыг тодорхойлохдоо судалгаанд оролцогчдоос Ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэр өөрчлөгдөх вэ? гэсэн асуултаар тодруулсан ба хариултуудын хувьд их өснө, өснө, өөрчлөгдөхгүй, буурна, их буурна, мэдэхгүй гэсэн хариултуудын үр дүнг авч дараах байдлаар нэгтгэсэн. Энэхүү үр дүнгээ 2016 оны судалгааны үр дүнтэй харьцуулан үзүүлэв.

Зураг 17. Ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэр өөрчлөгдөх вэ?




Судалгаанд оролцогчдын 29.0 хувь нь ирэх 2 жилд Монгол Улсын авлигын түвшин өөрчлөгдөхгүй гэж хамгийн өндөр хувьтай хариулсан байгаа бол 21.9 хувь нь авлига өснө гэж хариулсан байна. Харин 22.2 хувь нь дээрх асуултад мэдэхгүй гэж хариулсан буюу хариулахаас татгалзсан байна. Ирэх 2 жилд авлигын түвшин буурна гэж 16.6 хувь нь хариулсан байгаа бол энэ нь өмнөх судалгаа буюу 2016 оны үр дүнгээс 13.2 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь ирэх жилүүдэд Монгол Улс дахь авлигын түвшин буурна гэдэгт олон нийт итгэлгүй байгааг илтгэж байна.


4.3 Монгол Улсад авлига их тархсан институт

Энэ хэсэгт 2018 онд Монгол Улсад авлига хамгийн их тархсан институтыг 2016 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харууллаа.

Зураг 18. Монгол Улсад авлига их тархсан институт, 2018 он, хувиар



Зураг 19. Монгол Улсад авлига их тархсан институт, 2016 он, хувиар



Монгол Улсад авлига их тархсан институтээр 2016 онд Шүүхийн байгууллага 3-рт эрэмбэлэгдэж байсан бол 2018 онд 1-рт эрэмбэлэгдэж 2 байраар урагшилж авлига их тархсан институт гэж 49.2 хувьтай нэрлэгдсэн байна.

Газрын алба 2016 онд 1-рт эрэмбэлэгдэж байсан бол 2018 онд 2-рт эрэмбэлэгдэж 1 байраар ухран авлига их тархсан институт гэж 47.0 хувьтай нэрлэгдсэн байна.

Эрүүл мэндийн байгууллага 2016 онд 2-рт эрэмбэлэгдэж байсан бол 2018 онд

3-рт эрэмбэлэгдэж 1 байраар ухран авлига их тархсан институт гэж 46.4 хувьтай нэрлэгдсэн байна.

Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг 2016 онд 5-рт эрэмбэлэгдэж байсан бол 2018 онд 4-рт эрэмбэлэгдэж 1 байраар урагшилж авлига их тархсан институт гэж 43.9 хувьтай нэрлэгдсэн байна.

Боловсролын байгууллага 2016 онд 9-рт эрэмбэлэгдэж байсан бол 2018 онд 5-рт эрэмбэлэгдэж 4 байраар урагшлан авлига их тархсан институт гэж 41.0 хувьтай нэрлэгдсэн байна.

Дээрхээс харахад Шүүх, Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага, Төрийн захиргааны байгууллага яам, агентлагууд 2016 онд ч эхний 5-д эрэмбэлэгдэж байсан бол 2018 онд ч мөн ялгаагүй эхний 5-д эрэмбэлэгдсэн байна. Үүн дээр нэмэгдээд 9-р байраас урагшилж Боловсролын байгууллага 5-д эрэмбэлэгдсэн байна.

БҮЛЭГ V. ДҮГНЭЛТ

Авлигын эсрэг хуульд заасны дагуу Авлигатай тэмцэх газраас Шударга байдлын үнэлгээг гурав дахь удаагаа зохион байгуулаад байна. Шударга байдлын үнэлгээгээр 2018 онд нийтдээ 62 байгууллагыг үнэлсэн бөгөөд үнэлгээний судалгаанд нийтдээ 9411 нэгжээс мэдээлэл цуглуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллав.

Төрийн байгууллагыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр нь шударга байдлын үнэлгээний судалгаа юм. Судалгааны үр дүнд үндэслэн авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тэдгээрийг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын үнэлгээгээр шударга байдлын үнэлгээ 68.8 хувь гарч өнгөрсөн оны үзүүлэлтээс 1.0 пунктээр буурсан байна. Анх судалгаа хийгдсэн 2015 оны үнэлгээтэй харьцуулахад 5.0 пунктээр бага үзүүлэлттэй гарсан байна. Үнэлгээ буурахад гол нөлөөлж буй үзүүлэлт бол гадаад шударга байдлын үнэлгээ буюу тухайн байгууллагаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгч иргэдийн үнэлгээ байсан.

Үйлчлүүлэгч, иргэдийн үнэлгээнээс харахад байгууллагын үйл ажиллагааны ил тод байдалд хамгийн их анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дотоод шударга байдлын үнэлгээний хувьд үнэлгээ бага гарахад нөлөөлж байгаа гол үзүүлэлт нь авлигын эсрэг тогтолцоо болон байгууллагын удирдлагын авлигаас ангид байх хүсэл эрмэлзэл байсан.

Бодлогод оролцогчийн үнэлгээнд авлигыг хянах механизм болон байгууллагын удирдлагын авлигаас ангид байх хүсэл эрмэлзэл хамгийн их нөлөөг үзүүлж байлаа.

Үнэлгээг байгууллагаар авч үзвэл 2018 онд Соёл, урлагийн газар, Завхан аймгийн ЗДТГ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Батлан хамгаалахын яам зэрэг байгууллагууд хамгийн өндөр үнэлгээг авсан байна.

Харин яамдаас Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ЗГ-ын агентлагуудаас Татварын ерөнхий газар, Биеийн тамир спортын газар, аймаг, нийслэлийн ЗДТГ-аас Баян-Өлгий, Дундговь аймгийн ЗДТГ-ууд харьцангуй бага оноо авчээ.

Үнэлгээнд хамрагдсан 62 байгууллагын авсан үнэлгээ нь 55.3-83.6 онооны хооронд байгаа нь цаашид үнэлгээг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарал хандуулах шаардлагатай байгааг харуулж байна.


Үнэлгээнд яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ гэсэн байгууллагыг хамруулсан

бөгөөд аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дундаж үнэлгээ 66.1 гарсан нь хамгийн бага дүн болж байна.

Шударга байдлын үнэлгээг сайжруулах хүрээнд төрийн байгууллагуудын хувьд ил тод байдал, авлигын эсрэг тэмцэх хүсэл эрмэлзэл, авлигыг хянах механизмыг сайжруулах талд илүү анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөн түүнчлэн байгууллагын дотоод хяналт, аудитын үйл ажиллагаанд анхаарах нь зүйтэй юм.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

Хавсралт 1. Шударга байдлын үнэлгээ, 2018 он, хувиар



Хавсралт 2. Гадаад шударга байдлын үнэлгээ, 2018 он, хувиар

Д/д	Байгууллаганы нэр	ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	Авлигын эрсдлийн индекс	Ил тод байдал	Хариуцлагат ай байдал	Авлигын индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	59.8	52.9	52.5	55.9	66.6	50.3	87	62.7
2	Батлан хамгаалахын яам	85.9	80.9	79.9	82.8	90.9	80	95.8	97.1
3	Гадаад харилцааны яам	80.2	74	73.4	80.2	86.4	68.5	99.1	91.7
4	Сангийн яам	59.1	53.3	54.3	54.8	64.8	51	67.5	76
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	54.2	50.4	53.2	52.4	58	45.7	78.2	50
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	53.6	50.9	47.8	55.4	56.3	49.7	52.7	66.7
7	Барилга, хот байгуулалтын яам	58.6	49.7	46.9	53.6	67.5	48.6	87.6	66.2
8	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	59.7	52.1	49.1	56.4	67.3	50.9	84.7	66.2
9	Зам, тээврийн хөгжлийн яам	67.5	66.3	60.8	72.5	68.8	65.5	68.5	72.4
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	59.1	50.8	50	52.7	67.4	49.6	85.1	67.5
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	84.5	77.8	69.5	84.8	91.2	79	99.4	95.1
12	Эрчим хүчний яам	60.6	55.9	55.9	66.5	65.4	45.3	70.3	80.5
13	Эрүүл мэндийн яам	63.5	56.8	53.5	62.8	70.3	54	84.7	72.1
16	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	62.5	53.1	52.3	60	71.9	47	87.6	81
17	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	61.8	56.2	53.4	61.6	67.4	53.6	85	63.6
18	Онцгой байдлын ерөнхий газар	52.3	48.7	42.1	55.5	55.8	48.4	43.5	75.6
19	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	53.5	50.8	49.7	55.9	56.1	46.8	68.6	53.1
20	Стандарт, хэмжил зүйн газар	64.4	59.3	57.1	63.5	69.5	57.4	79.6	71.6
21	Цаг уур, орчны шинжилгээний газар								
22	Гаалийн ерөнхий газар	56.7	51.9	52.3	51.6	61.5	51.9	77.1	55.6
23	Татварын ерөнхий газар	53.8	55.2	57.1	59.3	52.4	49.2	61	47.1
24	Цагдаагийн ерөнхий газар	49.3	44.3	38	48.5	54.2	46.4	50	66.3
25	Улсын бүртгэлийн ерөнхий газар	60.2	51.7	46.6	53.9	68.8	54.5	81.3	70.5
26	Архивын ерөнхий газар	57.2	52	50.1	57	62.3	48.8	76.7	61.5
27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	84.6	80.4	81.5	83.1	88.8	76.7	93.7	95.9
28	Гадаадын иргэн, харьяатын газар	75.9	65.4	64.5	65.6	86.3	66.1	99.9	92.9
29	Нийгмийн даатгалын ерөнхий газар	69	57.7	48.4	63.1	80.3	61.5	99.5	80
30	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	77.2	70.4	66.2	76.4	84.1	68.4	94.4	89.4
31	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	73	65.4	62.6	66.3	80.6	67.2	89.8	84.9
33	Биеийн тамир, спортын газар	55.6	50.6	56.1	47.7	60.7	47.9	79.6	54.5
36	Ашигт малтмал, газрын тосны газар	63.6	59.8	59.2	61.3	67.4	58.9	73.2	70.1
37	Мал эмнэлэг, үржлийн газар	67.6	63.6	60.2	67.7	71.7	62.9	80.2	72
38	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	59.4	55.8	51.7	63.1	63	52.7	76.3	60
39	Оюуны өмчийн газар	81.6	73.9	67.8	79.8	89.2	74.2	96.4	97
40	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	78.4	71.7	65.3	77.8	85.1	71.8	99.4	84.2
41	Архангай аймгийн ЗДТГ	57.3	47.3	43.7	55.3	67.2	42.8	88.8	70.2
42	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	59	49.6	43.8	53.6	68.5	51.4	84.3	69.6

43	Баянхонгор аймгийн ЗДТГ	63.9	55	56.4	57.2	72.7	51.5	82.9	83.7
44	Булган аймгийн ЗДТГ	54.7	47	41.5	50.9	62.4	48.6	62.8	75.8
45	Говь-Алтай аймгийн ЗДТГ	47.7	46.7	46.2	50.9	48.8	43	48.9	54.6
46	Говь сүмбэр аймгийн ЗДТГ	54.1	43.3	38	47	65	44.8	80.7	69.4
47	Дархан-Уул аймгийн ЗДТГ	65.6	57.8	56.6	60.3	73.4	56.4	85.2	78.8
48	Дорноговь аймгийн ЗДТГ	61.7	50.3	44.2	56.7	73	50.2	93.4	75.5
49	Дорнод аймгийн ЗДТГ	65.3	56.5	55	62.3	74.1	52.2	97.4	72.6
50	Дундговь аймгийн ЗДТГ	51.2	38.4	32.8	43.9	63.9	38.6	80	73.2
51	Завхан аймгийн ЗДТГ	90	85.9	86.2	85.8	94	85.7	98.6	97.8
52	Орхон аймгийн ЗДТГ	44.9	41.9	40.6	45.2	47.9	40	46.4	57.4
53	Өвөрхангай аймгийн ЗДТГ	52.7	43.7	41.4	49.2	61.7	40.4	71.4	73.2
54	Өмнөговь аймгийн ЗДТГ	61.4	53.4	55	59.6	69.4	45.5	85.7	77
55	Сүхбаатар аймгийн ЗДТГ	72.6	63.4	57.3	68.2	81.8	64.9	93.7	86.8
56	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	66.5	58.9	55.1	62.3	74.2	59.3	84	79.2
57	Төв аймгийн ЗДТГ	59.6	51.7	48.3	57.6	67.5	49.3	84.4	68.9
58	Увс аймгийн ЗДТГ	78.1	66.9	60.5	71.3	89.4	68.9	99.2	100
59	Ховд аймгийн ЗДТГ	54.9	43.9	37.4	48.2	65.9	46	78.6	73
60	Хөвсгөл аймгийн ЗДТГ	62.6	53.2	50.6	56.8	72	52.2	83.4	80.5
61	Хэнтий аймгийн ЗДТГ	51.7	40.9	32.2	48.2	62.5	42.4	73.2	72
62	Нийслэлийн ЗДТГ	58.6	56.5	52.9	60.7	60.7	56	51.1	75.2

Хавсралт 3. Дотоод шударга байдлын үнэлгээ, 2018 он, хувиар

Д/д	Байгууллагын нэр	ДОТООД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	Соёлын индекс	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	73.9	68.8	73.6	64.1	78.9	94.5	79.9	67.9	100	52.4
2	Батлан хамгаалахын яам	76.5	68.6	77.8	59.3	84.4	93.8	96.9	76.8	100	54.5
3	Гадаад харилцааны яам	83	77.6	85.2	70	88.5	93.7	97.2	89.8	100	61.7
4	Сангийн яам	81.1	75.9	83.2	68.6	86.3	97.1	97.9	79.8	100	56.5
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	78.4	73	79.8	66.1	83.9	94.2	91	81	100	53.4
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	78	69.8	78.9	60.8	86.2	97.1	97.6	84.2	98.3	53.8
7	Барилга, хот байгуулалтын яам	83.1	78	83	73	88.1	98.6	100	84	100	58
8	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	77.9	71	75.7	66.4	84.8	98.5	98.6	76	96.7	54.1
9	Зам, тээврийн хөгжлийн яам	74.2	64.8	72	57.7	83.6	90.1	95.7	80.6	100	51.8
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	75.1	66.8	75.1	58.5	83.4	96.9	93.8	77.7	97.5	51.2
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	72.3	66	74.6	57.4	78.5	97.4	72	79.3	98.3	45.7
12	Эрчим хүчний яам	75.5	67.4	71.7	63.1	83.7	93.1	94.7	78.8	100	52
13	Эрүүл мэндийн яам	67.5	57.6	68.6	46.5	77.5	84.4	88.8	73.8	98.3	42.1
14	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	80.2	72.9	81.9	64	87.5	97.9	98.4	82.9	100	58.1
15	Үндэсний хөгжлийн газар	75.4	66.7	73.1	60.3	84.1	98.5	95.3	80.7	100	45.8
16	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	82.1	79.2	82.5	76	84.9	90.8	93.8	82.6	100	57.3
17	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	79.2	74.7	80	69.3	83.7	92.2	98.8	77.1	95	55.4

18	Онцгой байдлын ерөнхий газар	80.6	74.7	77.2	72.1	86.6	96.7	97.2	84	98.3	56.9
19	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	85.4	81.1	88.7	73.5	89.6	97.6	100	91.3	100	59.2
20	Стандарт, хэмжил зүйн газар	76.6	69.5	78.1	60.9	83.7	94.7	87.8	85.6	100	50.4
21	Цаг уур, орчны шинжилгээ ний газар	74.6	64.9	74.6	55.2	84.3	96.4	92.2	82.5	100	50.3
22	Гаалийн ерөнхий газар	78	71.8	78.1	65.5	84.2	93.8	89	85.5	100	52.7
23	Татварын ерөнхий газар	76.4	69.4	76.2	62.6	83.4	92.6	96.2	82.1	96.7	49.3
24	Цагдаагийн ерөнхий газар	79.8	73.9	75.6	72.2	85.7	87.2	98	87.1	98.3	57.7
25	Улсын бүртгэлийн ерөнхи й газар	75.8	70	79.9	60	81.6	91.6	87.6	77.8	98.6	52.4
26	Архивын ерөнхий газар	69.6	61.9	75.9	47.8	77.4	88.3	92.7	64	97.5	44.3
27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	82.4	76.4	82.6	70.1	88.4	97.1	97.1	87.2	100	60.6
28	Гадаадын иргэн, харьяатын газар	81.7	76	82.9	69.2	87.3	98.5	99.5	82.1	100	56.1
29	Нийгмийн даатгалын ерөнхий газар	79.9	73.1	77.3	68.9	86.8	96.1	97.1	87.5	100	53.3
30	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	75.1	68.6	79.1	58.1	81.5	86.3	96.9	76	95	53.3
31	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	82	76.7	84.1	69.3	87.3	98.1	99.4	87.5	96.7	54.9
32	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	82.6	78	87.2	68.7	87.2	98.1	98.4	84.7	100	54.9
33	Биеийн тамир, спортын газар	63.9	50.5	60.1	40.8	77.4	96.9	78.6	70.9	96.7	43.8
34	Соёл, урлагийн газар	84.8	80.8	89.4	72.2	88.9	100	99.2	92.5	100	52.8
35	Иргэний нисэхийн ерөнхий газар	66.3	58.1	71	45.1	74.5	93	60.5	77.1	100	41.7
36	Ашигт малтмал, газрын тосны газар	71.1	63.4	75.3	51.6	78.8	88.1	94.5	70.6	97.5	43.5
37	Мал эмнэлэг, үржлийн газар	73.5	67.2	75.3	59.2	79.7	96.6	95.1	58.4	100	48.4
38	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	78	70.2	76	64.3	85.8	93.7	97.2	87.1	100	51
39	Оюуны өмчийн газар	72.5	61.1	75.1	47.2	83.9	93.9	96.4	77.5	100	51.9
40	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	84.3	78.3	89.6	67.1	90.3	99.3	100	93.8	100	58.4
41	Архангай аймгийн ЗДТГ	80.9	74.6	80.9	68.2	87.2	97.4	96.9	85.3	100	56.2
42	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	60.9	54.9	60.5	49.2	67	62.8	69.3	70.9	90	42.1
43	Баянхонгор аймгийн ЗДТГ	74.2	64.9	74.4	55.3	83.5	94.6	89.9	76	100	56.9
44	Булган аймгийн ЗДТГ	83	77.7	83.2	72.2	88.4	97.2	98.8	88.1	100	57.9
45	Говь-Алтай аймгийн ЗДТГ	68.5	59.7	69.1	50.2	77.4	67.1	88.4	79.2	97.5	55.1
46	Говь сүмбэр аймгийн ЗДТГ	84.1	79.1	86.3	71.9	89.1	97.8	98.3	87.2	100	62.2
47	Дархан-Уул аймгийн ЗДТГ	76.3	74.4	82.7	66.1	78.1	67.1	94.6	72	100	56.9
48	Дорноговь аймгийн ЗДТГ	75.5	72.3	77.2	67.5	78.6	69	93.2	82.9	87.5	60.3
49	Дорнод аймгийн ЗДТГ	67.4	57.2	67.4	47	77.7	73	88.1	78.2	100	48.9
50	Дундговь аймгийн ЗДТГ	69.5	62.3	71.2	53.3	76.7	94	65.5	74.4	95	54.6
51	Завхан аймгийн ЗДТГ	80.3	79.8	84.7	74.9	80.8	98.9	71.5	74.3	100	59.1
52	Орхон аймгийн ЗДТГ	69.4	69.2	78.7	59.7	69.7	56.3	95.8	69.4	80	46.9
53	Өвөрхангай аймгийн ЗДТГ	78.7	73.9	80.9	66.8	83.6	79.9	94.9	85	100	57.9
54	Өмнөговь аймгийн ЗДТГ	81.2	73.5	80.6	66.5	88.8	97.1	97.9	90.9	100	58.1
55	Сүхбаатар аймгийн ЗДТГ	71.9	62.1	72.5	51.6	81.8	95.3	94.2	72.6	97.5	49.5
56	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	79.7	73.4	81.3	65.6	85.9	95.3	92.9	86.6	100	54.6
57	Төв аймгийн ЗДТГ	78.1	69	78.4	59.6	87.2	96.8	95.2	87.3	100	56.5
58	Увс аймгийн ЗДТГ	82.5	76.3	83	69.5	88.7	97.3	98.4	92.5	100	55.5
59	Ховд аймгийн ЗДТГ	67.7	61.1	69.9	52.4	74.3	83.6	60	78.8	95	54
60	Хөвсгөл аймгийн ЗДТГ	78.6	73.7	75.7	71.6	83.5	86.2	97.3	81.3	100	52.8
61	Хэнтий аймгийн ЗДТГ	82.5	76.6	84.4	68.8	88.4	99.3	97.7	92.2	100	53
62	Нийслэлийн ЗДТГ	81.1	76.4	83.8	69.1	85.8	93.9	91.8	89.5	98.9	54.9

Хавсралт 4. Бодлогод оролцогчийн шударга байдлын үнэлгээ, 2018 он, хувиар

Д/д	Байгууллагын нэр	БОДЛОГД ОРОЛЦОГЧДЫН ҮНЭЛГЭЭ	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	63.2	61.5	38.3	100	52.9
2	Батлан хамгаалахын яам	67.3	64.9	49.4	91.7	63.3
3	Гадаад харилцааны яам	76.6	78.9	66.7	100	60.7
4	Сангийн яам	60.8	62.6	41	90.9	48.8
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	64.5	62.6	50.9	91.6	52.9
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	67.8	71.1	42.1	95	62.9
7	Барилга, хот байгуулалтын яам	60.3	56.6	37.2	100	47.5
8	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	63.1	67.1	37.3	100	47.8
9	Зам, тээврийн хөгжлийн яам	68.4	68.4	50.2	100	55.1
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	59.8	51.8	39.8	96.4	51
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	63.7	60.2	41.5	100	53.1
12	Эрчим хүчний яам	61.7	62.7	47.9	90	46.1
13	Эрүүл мэндийн яам	68.9	69.7	48.9	95.8	61.2
14	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	62.9	69.9	39.9	93.8	47.9
15	Үндэсний хөгжлийн газар	75.7	89.3	49.2	100	64.3
16	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	75.8	65.3	69	100	68.8
17	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	56.6	59.8	39.8	71.4	55.4
18	Онцгой байдлын ерөнхий газар	79.4	77.8	67.2	100	72.5
19	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	74.8	84.6	44.2	100	70.3
20	Стандарт, хэмжил зүйн газар	62.5	80.7	39.3	100	30.2
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	75.5	89.4	51.9	100	60.8
22	Гаалийн ерөнхий газар	67.4	68.5	45.7	100	55.3
23	Татварын ерөнхий газар	59.5	57.4	48.8	81.9	50
24	Цагдаагийн ерөнхий газар	77.6	81	63.1	100	66.3
25	Улсын бүртгэлийн ерөнхий газар	67.4	57.9	53.7	100	57.8
26	Архивын ерөнхий газар	70.1	76.6	39.9	100	64
27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	74.2	82.2	63.3	100	51.3
28	Гадаадын иргэн, харьяатын газар	73.3	75.2	48.2	100	69.7
29	Нийгмийн даатгалын ерөнхий газар	72.3	72.4	48.1	100	68.8
30	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	59.4	57	51.8	76.4	52.5
31	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	70.3	78	49.7	100	53.4
32	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	63.4	72.1	43.7	94.4	43.4
33	Биеийн тамир, спортын газар	67.6	77.6	40.3	100	52.6
34	Соёл, урлагийн газар	80.3	91	57.8	100	72.5
35	Иргэний нисэхийн ерөнхий газар	70.2	75.2	52.4	92.9	60.4
36	Ашигт малтмал, газрын тосны газар	63.2	55.3	47.1	100	50.5
37	Мал эмнэлэг, үржлийн газар	68.5	57.5	51.5	100	65
38	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	62.9	71.5	47.1	76.7	56.3
39	Оюуны өмчийн газар	74	81.9	57.4	91.7	64.9
40	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	84.3	92	63	100	82.1
41	Архангай аймгийн ЗДТГ	49.9	45.9	39.5	75	39.3
42	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	47.2	46.8	32.1	67.6	42.2

43	Баянхонгор аймгийн ЗДТГ	63.5	72.9	47.1	77.2	56.7
44	Булган аймгийн ЗДТГ	66.8	66.4	45.4	92.9	62.5
45	Говь-Алтай аймгийн ЗДТГ	61	72.9	42.1	74.6	54.5
46	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	62	59	37.9	90.9	60.3
47	Дархан-Уул аймгийн ЗДТГ	73.7	78.8	54.3	96.2	65.6
48	Дорноговь аймгийн ЗДТГ	75.3	77.5	59.5	89.3	74.9
49	Дорнод аймгийн ЗДТГ	73.6	86.6	49.6	100	58.3
50	Дундговь аймгийн ЗДТГ	47	40.4	23.6	85.7	38.3
51	Завхан аймгийн ЗДТГ	78.2	79.3	55.7	100	77.9
52	Орхон аймгийн ЗДТГ	59	59.7	50.7	70.3	55.5
53	Өвөрхангай аймгийн ЗДТГ	53.8	52.9	33.9	87.9	40.5
54	Өмнөговь аймгийн ЗДТГ	61.9	68.8	60.2	67.9	50.8
55	Сүхбаатар аймгийн ЗДТГ	60.3	59.4	36.1	93.8	51.8
56	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	68.3	68.2	42.6	100	62.5
57	Төв аймгийн ЗДТГ	53.2	57.6	31.9	83	40.4
58	Увс аймгийн ЗДТГ	61.2	69.8	32.7	93.3	49.1
59	Ховд аймгийн ЗДТГ	61.4	61.6	42.2	76.7	65
60	Хөвсгөл аймгийн ЗДТГ	53	56.1	38.8	73.5	43.7
61	Хэнтий аймгийн ЗДТГ	65.4	68.5	46.1	82.6	64.2
62	Нийслэлийн ЗДТГ	63.7	68.8	52.1	76.9	57

Анхааруулга

1. Шударга байдлын үнэлгээний судалгааны мэдээллийг цуглуулах, боловсруулах, үр дүнг тооцох, тайлан бэлтгэх үйл ажиллагаанд Авлигатай тэмцэх газар оролцоогүй болно. Энэхүү үнэлгээ нь тухайн байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, тухайн байгууллагаас төрийн үйлчилгээг хүргэж буй төрийн албан хаагч болон шинжээчдийн өгсөн үнэлгээнд үндэслэсэн болно.
2. Судалгааны дүн нь яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг бүхэлд нь үнэлж өгсөн үнэлгээ бөгөөд харин тухайн байгууллагын хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ), эсхүл авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан албан тушаалтны үнэлгээ гэж ойлгож болохгүй.

**УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
СУДАЛГАА-2018**

УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2018 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл: Авлигатай тэмцэх газар 2008 оноос хойш жил тутам “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулж судалгааны үр дүнг Мянганы хөгжлийн 9 дэх зорилтын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгох, хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх нэг шалгуур болгож ирсэн.

Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхэд мэдээллийн чухал их сурвалж болох учиртай.

2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 онд тус хоёр хүрээг тусд нь авч үзэж, “Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” болон “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г хийхээр болсон юм. Уг хоёр судалгааг “Максима Консалтинг” ХХК хийж гүйцэтгэв.

Судалгааны хүрээнд дараах зорилтыг тавьж зохион байгуулав.

- Авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, авлигын хэлбэрийг авч үзэх;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын шалтгаан, нөхцөл түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын хэмжээ, түүний хор уршиг, үр дагаврыг гаргах;
- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зэрэг болно.


Судалгааны арга зүй: “Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г тоон болон чанарын судалгааны аргаар хийж явуулсан. Ингэхдээ нийтийн алба (шүүх, хууль сахиулах салбараас бусад), шүүх, хууль сахиулах салбар, хэвлэл мэдээллийн салбар, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, бодлогын судалгаа, олон нийтийн санал бодлын судалгаа, бизнесийн салбар, иргэдийн төлөөллийг оролцуулан нийт 66 шинжээчийг хамруулсан.

Тоон судалгааны мэдээллийг цуглуулахдаа нүүр тулсан ярилцлагын асуулгын аргыг ашигласан ба шинжээчдээр асуулт бүрийг “1-ээс 5” гэсэн баллаар үнэлүүлэн тооцоолсон. Баллын үнэлгээ буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол баллын үнэлгээ өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.

Чанарын судалгааг фокус бүлгийн хэлэлцүүлгийн аргаар хийж явуулсан бөгөөд 6 удаагийн хэлэлцүүлэгт нийт 48 шинжээчийг оролцуулан судалгааны асуултуудыг дэлгэрүүлж, гүнзгийрүүлж хэлэлцсэн.

Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2017 оны судалгаа”-ны тоо баримттай харьцуулан шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тогтоосон болно.


График 1. Улс төрийн хүрээн дэх авлигын үнэлгээ, үзүүлэлтийн схем.



1. 2018 ОНЫ УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШИН

Судалгааны үр дүнд 2018 онд улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 3.93 гарлаа. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 0.06 баллаар буурсан буюу ач холбогдол өгөх хэмжээнд өөрчлөлт гарсангүй. Тус судалгаа хийгдэж ирсэн өнгөрсөн 11 жилийн үзүүлэлтийг харьцуулан харахад авлигын төсөөллийн индексийн дундаж 3.87 байгаа ба 2008 оны анхдагч үзүүлэлтээс 0.5 хүртэл баллаар буурч байсан 2013-2016 онуудыг эс тооцвоос өндөр түвшинд 4 баллын орчимд тогтвортой хэлбэлзэх хандлага илэрч байна.

График 2. Улс төрийн авлигын түвшин, 2008-2018 онд.



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улс төрийн авлигын түвшинг тогтоохдоо дараах үндсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашигладаг: цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөл, хор уршиг/үр дагавар.

Үндсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн хувьд ч 2018 оны судалгаагаар ач холбогдол өгмөөр өөрчлөлт төдийлөн гарсангүй.

Улс төрийн авлигын цар хүрээ нь өмнөх оноос 0.01 пунктээр нэмэгдсэн бол авлигын хэлбэр 0.11 пунктээр, авлигын шалтгаан нөхцөл 0.06 пунктээр, хор уршиг, үр дагавар 0.10 пунктээр тус бүр буурсан байна.

График 3. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ.¹

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Улс төрийн хүрээний авлигын цар хүрээний үнэлгээ 3.99 гарч, өмнөх оны албан ёсны дүнгээс 0.05 пунктээр илүү гарсан хэдий ч бодитоор 0.01 пунктээр буурсан (2017 онд улс төр, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн албан ёсны дүн 3.94, зөвхөн улс төрийг хүрээг тусд нь тооцвол 4.00) буюу өөрчлөлтгүй байна.


Улс төрийн авлигын цар хүрээг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлох бөгөөд тус бүр дараах өөрчлөлт гарсан байна:

1. Улс төрийн авлигын түгээмэл байдал + 0.16;
2. Улс төрийн авлигын түвшний өөрчлөлт - 0.03;
3. Тодорхой салбар, хүрээн (төрийн институц) дэх улс төрийн авлигын тархалтын цар хүрээ + 0.06 (2017 оны улс төр, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн албан ёсны дүнтэй харьцулахад) буюу - 0.19 (2017 оны зөвхөн улс төрийн хүрээний тусд нь тооцсон дүнтэй харьцулахад);

¹ Авлигын цар хүрээний үзүүлэлт 2017 онд улс төр болон шүүх, хууль хяналтыг хүрээг нэгтгэсэн байдлаар 3.94 гарсан (нэг дүгээр багана). Хэрэв 2018 оны судалгааны аргачлалын дагуу шүүх, хууль хяналтын хүрээний үзүүлэлтүүдийг хасч, зөвхөн улс төрийн үзүүлэлтийг тооцвол 4.00 гэсэн индекс гарч байгаа юм (нэг дүгээр багана, ногоон өнгөөр тэмдэглэсэн үзүүлэлт).

4. Төрийн байгууллагын тодорхой үйл ажиллагаан дахь авилгын түвшин + 0.24 (2017 оны улс төр, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн албан ёсны дүнтэй харьцуулахад) буюу - 0.01 (2017 оны зөвхөн улс төрийн хүрээний тусд нь тооцсон дүнтэй харьцуулахад);
5. Тодорхой салбар, үйл ажиллагаанд улс төрийн авлига чиглэгдсэн байдал (буюу ямар салбар, үйл ажиллагаатай улс төрийн авлига хэр холбогдсон болох) + 0.05.

График 4. Улс төрийн авлигын цар хүрээний үнэлгээ.²



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ


Улс төрийн авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.34 гарч өмнөх оныхоос 0.16 пунктээр (2017 онд 4.18) өссөн байна.

Ингэхдээ шинжээчдийн 83.4% нь Монголын улс төрийн хүрээнд авлига их болон маш их түгээмэл гэж үнэлсэн. Харьцуулахад 2017 онд тус хоёр үзүүлэлтийн нийлбэр 75.8%-тай гарч байжээ.

2 2017 онд “салбар хүрээ дэх авлигын тархалтын цар хүрээ” дэд үзүүлэлтийн дүн улс төр болон шүүх, хууль хяналтыг хүрээг нэгтгэсэн байдлаар 3.99 гарсан (5-р багана). Хэрэв 2018 оны судалгааны аргачлалын дагуу шүүх, хууль хяналтын хүрээний үзүүлэлтүүдийг хасч, зөвхөн улс төрийн үзүүлэлтийг тооцвол 4.12 гэсэн индекс гарч байгаа юм (5-р багана, ногоон өнгөөр тэмдэглэсэн үзүүлэлт).

2017 онд “төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын түвшин” дэд үзүүлэлтийн дүн улс төр болон шүүх, хууль хяналтыг хүрээг нэгтгэсэн байдлаар 3.93 гарсан (7-р багана). Хэрэв 2018 оны судалгааны аргачлалын дагуу шүүх, хууль хяналтын хүрээний үзүүлэлтүүдийг хасч, зөвхөн улс төрийн үзүүлэлтийг тооцвол 4.18 гэсэн индекс гарч байгаа юм (7-р багана, ногоон өнгөөр тэмдэглэсэн үзүүлэлт).

График 5. Улс төрийн хүрээн дэх авлигын түгээмэл байдал.




Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Улс төрийн хүрээн дэх авлигын түвшин өөрчлөгдсөн байдалд өгсөн үнэлгээ 3.56 гарч өмнөх оноос 0.03 пунктээр (2017 онд 3.59) өссөн дүнтэй буюу өөрчлөлтгүй байна.

Ингэхдээ шинжээчдийн 48.5% нь улс төрийн хүрээнд авлига нэмэгдсэн болон маш их нэмэгдсэн гэж үнэлсэн. Харьцуулахад 2017 оны тус хоёр үзүүлэлтийн нийлбэр болох 47.6%-иас бараг өөрчлөгдсөнгүй.

График 6. Улс төрийн хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт.



Дэд үзүүлэлт 3. ТӨРИЙН ИНСТИТУЦ ДЭХ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Төрийн институт дэх улс төрийн авлигын тархалтын үзүүлэлт 3.93 пункттэй гарч өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад 0.06 буюу 0.19 пунктээр буурсан байна (2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн дүн 3.99; зөвхөн улс төрийн хүрээний үзүүлэлтийг салгаж тооцсон дүн 4.12).

Ингэхдээ ерөнхийлөгчийн засаглалын хүрээ, Улсын Их Хурал, улс төрийн намуудын үзүүлэлт 0.27-0.38 пунктээр буурсан бол бусад институцын хувьд өөрчлөлт бараг гарсангүй. Засгийн газар, түүний харъяа байгууллага болон улс төрийн намууд урьдын адил авлига хамгийн түгээмэл институцуудад тооцогдсон хэвээр байна.


Хүснэгт 1. Салбар хүрээн (төрийн институц) дэх авлига тархсан байдал.

		2017	2018	Өөрчлөлт
1	Засгийн газар /яам, агентлаг/	4.27	4.23	-0.04
2	Улс төрийн намууд	4.48	4.21	-0.27
3	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ	3.93	3.97	+0.04
4	Монгол Улсын Их Хурал	4.25	3.87	-0.38
5	Нутгийн өөрөө удирдах байгууллага /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/	3.89	3.75	-0.14
6	Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ	3.90	3.57	-0.34

**Дэд үзүүлэлт 4. ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН
ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ**

Төрийн үйл ажиллагаан дахь авлигын цар хүрээг (шүүх, хууль хяналтын үйл ажиллагаанс бусад) 6 тодорхой чиглэлээр авч үнэлүүлэхэд үзүүлэлт 4.17 гарч, өмнөх оны албан ёсны үзүүлэлттэй харьцуулахад 0.24 пунктээр өссөн буюу бодитоор өөрчлөлтгүй (+ 0.01) байна (2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн албан ёсны дүн 3.93; зөвхөн улс төрийн хүрээний үзүүлэлтийг салгаж тооцсон дүн 4.18).

График 7. Нийтийн алба/төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын тархалтын цар хүрээ.



Дэд үзүүлэлт 5. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН НӨЛӨӨЛӨЛ, ЧИГЛЭЛ

Улс төрийн авлига бусад салбар хүрээний үйл ажиллагаа руу хэр чиглэж байгаа буюу нөлөөллийн (авлигын чиглэл буюу аль салбар, үйл ажиллагаатай хэр холбогдсон байдал) үнэлгээний үзүүлэлт 3.97 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.05 пунктээр өссөн буюу бараг өөрчлөлтгүй байна (2017 оны үзүүлэлт 3.92).

Нийт 11 салбар, үйл ажиллагааны хүрээнд үнэлгээг гаргасан ба тэдгээр дотроо дараах өөрчлөлтүүд гарсан байна.

Ач холбогдол өгмөөр хэмжээнд өссөн салбарууд:

- аж үйлдвэр + 0.41,
- уул уурхай, ашигт малтмал + 0.26,
- гадаадын хөрөнгө оруулалт + 0.12.

Бага хэмжээний өөрчлөлт гарсан эсвэл өөрчлөлт гараагүй салбарууд:

- төрийн алба + 0.09
- бизнес, хувийн хэвшил + 0.07,
- шүүх + 0.05,
- дэд бүтэц + 0.03,
- барилга 0.00,
- хууль сахиулах - 0.04,
- хэвлэл, мэдээллийн хэрэгсэл - 0.08,
- хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаа - 0.09.

График 8. Улс төрийн хүрээний авлигын чиглэл.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ 3.81 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.11 пунктээр буурсан байна (2017 оны үзүүлэлт 3.92).

Улс төрийн авлигын хэлбэрийг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлох бөгөөд тус бүр дараах өөрчлөлт гарсан байна.

1. Хээл хахуулийн хэлбэр - 0.10;
2. Хээл хахууль өгөх, авах аргууд - 0.10;
3. Бүлэглэлүүдийн нөхцөл байдал - 0.22;
4. Авлигын хэлбэр - 0.12;
5. Хууль бус нөлөөллийн хэлбэр + 0.02.

График 9. Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ.



Дэд үзүүлэлт 1. ХЭЭЛ ХАХУУЛИЙН ХЭЛБЭР

Улс төрийн хүрээн дэх хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ 3.59 гарч өмнөх оноос 0.10 пунктээр буурсан бага зэргийн эерэг үзүүлэлттэй байна (2017 оны үзүүлэлт 3.69).


Хээл хахуулийн олон хэлбэр байгаагаас хамгийн түгээмэл гэж үзсэн дараах хэлбэрийг сонгон үнэлүүлсэн (зураг 10). Улс төрийн авлигын хүрээн дэх хээл хахуулийн 13 хэлбэрээс 3 хэлбэрийн үнэлгээ өссөн сөрөг дүнтэй гарсан бол бол 7 хэлбэрийн үзүүлэлт буурсан эерэг үзүүлэлт гарч, 3 хэлбэрийн хувьд (бараг) өөрчлөлт гарсангүй. Ингэхэд дараах хэлбэрүүдийн хувьд үзүүлэлт өссөн:

- ажил, албан тушаалын томилгоо + 0.14,
- шагнал, цол, тэмдгээр шагнах + 0.22,
- хувьцаа өгөх + 0.19.

Харин дараах хэлбэрүүдийн хувьд үзүүлэлт буурсан байна:

- ашиг, орлого хуввалцах - 0.13,
- бэлэн мөнгө өгөх - 0.33,
- ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт үзүүлэлх - 0.11,
- үнэтэй бэлэг өгөх - 0.37,
- эмчилгээ, сувилгааны зардлыг төлөх - 0.18,
- гадаадын банкинд данс нээж өгөх - 0.15,
- өрийг нь төлөх - 0.05.

График 10. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ.




Дэд үзүүлэлт 2. ХУУЛЬ БУС НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР

Улс төрчид, өндөр албан тушаалтнууд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ нь 3.66 гарч өмнөх оноос 0.02 пунктээр өссөн буюу өөрчлөлтгүй байна.

Хууль бус нөлөөллийг тогтоох 9 дэд үзүүлэлтээс 5 дэд үзүүлэлтийн үнэлгээ өссөн бөгөөд үүнд амлалт өгч нөлөөлөх хэлбэр 0.26 пункт, хүсэлт тавих хэлбэр 0.19 пункт, албадах хэлбэр 0.09 пункт, нутаг орны хэлхээ холбоог ашиглах хэлбэр 0.07 пункт, садан төрлийн хэлхээ холбоог ашиглах хэлбэр 0.08 пунктээр өссөн. Харин дарамт, шахалт үзүүлэх хэлбэр 0.16 пунктээр, айлган сүрдүүлэх хэлбэр 0.09 пунктээр буурсан байна.

График 11. Хууль бус нөлөөллийн үнэлгээ.



Дэд үзүүлэлт 3. УЛС ТӨРИЙН НАМ, БҮЛЭГЛЭЛ, УЛС ТӨР, БИЗНЕС, ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮДИЙН ХАРИЛЦАА ХАМААРАЛ

Төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчид болон улс төрийн нам, бүлэглэл, гадаад дотоод бизнесийн бүлэглэл, гэмт бүлэглэлийн харилцаа хамаарлын үнэлгээ 3.74 гарч өнгөрсөн оноос 0.14 пунктээр буурсан байна (2017 оны үзүүлэлт 3.88).

Нийт 11 нөхцөл байдлын үзүүлэлтээс 2 үзүүлэлтийн үнэлгээ бага зэрэг өсч, 5 үзүүлэлтийн үнэлгээ бага зэрэг, 1 үзүүлэлтийн үнэлгээ 0.21 пунктээр буурсан байна.

Индексийн үзүүлэлтээс гадна шинжээчдийн өгсөн хариултыг дурдвал 83.3% “улс төр, бизнесийн бүлэглэлүүд нэгдсэн”, 74.2% нь “бизнесийн бүлэглэлүүд улс төрчдийг эрхшээлдээ оруулсан”, 68.2% нь “улс төрчид бизнесийн бүлэглэлүүдийг эрхшээлдээ оруулсан” болон 74.2% нь “улс төрчид шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн” гэж үзэж байгаа нь (“их” болон “маш их” хэмжээнд) анхаарал татна. Түүнчлэн 75.8% нь улс төрийн хүрээний авлига илүү далд хэлбэр рүү шилжсэн гэж үзэж байна.

Хүснэгт 2. Бүлэглэлүүдийн харилцаа хамаарал, нөхцөл байдлын үнэлгээ.

#	Бүлэглэлүүдийн нөхцөл байдал	2017	2018	Өөрчлөлт
1	Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4,27	4,35	+0,09
2	Бизнесийн бүлэглэл улс төрчдийг эрхшээлдээ оруулсан	4,31	4,20	-0,11
3	Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4,29	4,19	-0,10
4	Улс төрчид шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4,29	4,15	-0,14
5	Улс төрчид бизнесийн бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3,79	3,80	+0,01
6	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам / бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3,68	3,75	+0,08
7	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам / бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3,53	3,42	-0,10

8	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам / бүлэглэл/-тай нэгдсэн	3,47	3,40	-0,07
9	Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3,40	3,36	-0,04
10	Гэмт бүлэглэл улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3,50	3,29	-0,21
11	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам / бүлэглэл/-тай нэгдсэн	3,31	3,27	-0,03

Дэд үзүүлэлт 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ 4.06 гарч өнгөрсөн оноос 0.12 пунктээр буурсан үзүүлэлттэй байна (2017 оны үзүүлэлт 4.18).


Нийт 15 дэд үзүүлэлтийн 2 дэд үзүүлэлтэд тодорхой хэмжээний өсөлт гарсан:

- албан тушаалаа урвуулан ашиглах + 0.08,
- төрийн өмчиг хувьдаа завших + 0.08.

Харин 9 үзүүлэлтүүдийн хувьд тодорхой хэмжээнд бууралт ажиглагдсан:

- төсвийг хувийн ашиг сонирхлын дагуу хуваарилах - 0.26,
- аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох - 0.23,
- мөнгө угаах - 0.19,
- ашиг сонирхолдоо нийцүүлэн шийдвэр гаргах, гаргуулах - 0.18,
- төсвийн хөрөнгийг зориултын бус зарцуулах - 0.18,
- төрийн өмчиг хууль бус арга замаар хувьчлах - 0.16,
- бизнес бүлэглэлийн захиалгаар хууль тогтоомж санаачлан батлуулах, дэмжих - 0.15,
- хээл хахууль өгөх, авах, зуучлах - 0.15,
- хууль бусаар дампууруулах - 0.13.

График 12. Улс төрийн хүрэн дэх авлигын хэлбэр.



Дэд үзүүлэлт 5. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ АРГА

Улс төрийн хүрээний хээл хахууль өгөх, авах аргуудыг хэрэглэсэн байдлын үнэлгээ 3.71 гарч өмнөх оноос 0.10 пунктээр буурсан байна (2017 оны үзүүлэлт 3.81).

Нийт 11 түгээмэл үзүүлэлтийн 6 үзүүлэлтийн үнэлгээ буурсан эерэг үзүүлэлттэй байгаа бол 4 үзүүлэлтийн үнэлгээ өссөн сөрөг үнэлгээтэй гарчээ.


Дараах үзүүлэлтийн үнэлгээ өссөн:

- мөнгө зээлдүүлж мартах + 0.25,
- эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах + 0.10,
- эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдаж авах + 0.09,
- өмгөөлөгчөөр дамжуулах + 0.05.

Харин дараах үзүүлэлтийн үнэлгээ буурсан:

- биечлэн уулзаж өгч авах – 0.33,
- ойр дотны хүмүүсээр дамжуулах – 0.28,
- зуучлагчаар дамжуулах – 0.18,
- үйл ажиллагааны зардал болгож өгөх – 0.09,
- мөрийтэй тоглож санаатай алдах – 0.04.

График 13. Улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээ.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 3. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Улс төрийн авлигын шалтгаан нөхцөлийн үзүүлэлт 2018 онд 4.09 гарч өнгөрсөн оноос 0.06 пунктээр буурсан байна (2017 оны үзүүлэлт 4.15). Шалтгаан, нөхцөлийн үзүүлэлтийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зорилгоор 3 дэд үзүүлэлтийн хүрээнд шинжилгээ хийж тодорхойлов.

Улс төрийн авлигын шалтгаан, нөхцөлийн үзүүлэлтээс бүлэглэл, хүрээллүүдийн нөхцөл байдлын үзүүлэлт 0.19 пунктээр буурч, харин авлигад нөлөөлөх хүчин зүйлс (- 0.01) болон авлигын түвшинд нөлөөлөх дутагдал, доголдолын үзүүлэлтэд (+ 0.03) бараг өөрчлөлт гарсангүй.

График 14. Авлигын шалтгаан, нөхцөл.



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГАД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ 4.24 гарч өнгөрсөн оноос 0.01 пунктээр буурсан буюу өөрчлөлтгүй байна.

Улс төрийн авлигын нөлөөллийг 11 дэд хүчин зүйлсээр хэмжсэн бөгөөд үүний 5 дэд хүчин зүйлсийн үнэлгээ буурсан эерэг үнэлгээтэй байгаа бол 3 дэд хүчин зүйлсийн үнэлгээ өссөн сөрөг дүн гарсан байна.

Албан тушаалын томилгоо болон сонгуулийн өнөөгийн тогтолцоо үзүүлэлт 0.20 болон 0.23 пунктээр тус бүр хамгийн их өссөн бол хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил (- 0.20), ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зорчил (- 0.18), хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц (- 0.15)-ад хамгийн их бууралт гарсан байна.

Хүснэгт 3. Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ.

	Авлигад нөлөөлөх хүчин зүйлс	2017	2018	Зөрүү
1	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4,55	4,74	+0,20
2	Намын санхүүжилтийн механизм	4,56	4,58	+0,02
3	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	4,49	4,52	+0,02
4	Сонгуулийн санхүүжилтийн механизм	4,42	4,43	+0,01
5	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	4,02	4,25	+0,23
6	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4,26	4,21	-0,05
7	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4,23	4,19	-0,04
8	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4,25	4,05	-0,20

9	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	3,93	4,02	+0,08
10	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4,07	3,90	-0,18
11	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	3,96	3,81	-0,15

Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ДУТАГДАЛ, ДОГОЛДОЛ

Улс төрийн авлигад нөлөөлөх төрийн үйл ажиллагааны дутагдал, доголдолын нөлөөллийн үнэлгээ 4.13 гарч өнгөрсөн оноос 0.03 пунктээр өссөн буюу бараг өөрчлөлтгүй байна (2018 оны үзүүлэлт 4.10).

Төрийн үйл ажиллагааны дутагдал, доголдлыг 12 дэд үзүүлэлтэд хамааруулж хэмжсэн бөгөөд үүний 7 дэд үзүүлэлтийн үнэлгээ өсөлттэй буюу сөрөг гарчээ. Ингэхдээ төрийн албан хаагчийн ур чадварын дутмаг байдал, олон давхар шатлага, хийдэл, мэдээллийн нээлттэй, ил тод бус байдал болон албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломжийн нөлөөлөл хамгийн их өссөн байна. Харин төрийн үйлчилгээний хүртээмж муу гэсэн үзүүлэлт 0.17 пунктээр хамгийн их буурсан байна.

Хүснэгт 4. Улс төрийн авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол.

	Хариулт	2017	2018	Зөрүү
1	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	4,33	4,27	- 0,06
2	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4,35	4,26	- 0,10
3	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	4,13	4,24	+ 0,11
4	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	4,03	4,21	+ 0,18
5	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	4,21	4,21	0,00
6	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4,11	4,19	+ 0,08
7	ТАХ-ийн ур чадвар дутмаг	3,94	4,19	+ 0,25
8	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	4,14	4,17	+ 0,04
9	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	4,00	4,11	+ 0,11
10	Хүнд суртал	4,10	4,08	- 0,02
11	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3,89	3,97	+ 0,08
12	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	3,85	3,68	- 0,17

Дэд үзүүлэлт 3. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХҮРЭЭЛЛҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улс төрийн хүрээн дэх тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн хүрээллийн нөхцөл байдал буюу ямар төрлийн хүрээллүүд түгээмэл байгаа талаарх үнэлгээ 3.89 гарч өнгөрсөн оноос 0.19 пунктээр буурсан байна (2017 оны үзүүлэлт 4.08).

Нийт 7 дэд үзүүлэлтээс 4 дэд үзүүлэлтийн үнэлгээ буурсан, 1 үзүүлэлтийн үнэлгээ өссөн дүнтэй гарчээ. Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нэг хүнийг тойрсон хүрээллийн үзүүлэлт 0.09 пунктээр өссөн бол хувийн эрх ашгийг илүүд үзсэн найз нөхдийн хүрээллийн үзүүлэлт 0.24 пунктээр, хувийн эрх ашгийг илүүд үзсэн бизнесийн хүрээллийн үзүүлэлт 0.09 пунктээр, хувийн эрх ашгийг илүүд үзсэн нэг нутаг, аймгийн хүрээллийн үзүүлэлт 0.07 пунктээр буурсан. Харин нийтийн эрх ашгийн төлөө хүрээллийн үнэлгээ 1.03 пунктээр буурсан нь анхаарал татаж байгаа ч 2015 болон 2016 оны үзүүлэлттэй ижил түвшинд байна.

График 15. Улс төрийн хүрээн дэх хүрээллүүдийн нөхцөл байдал.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Улс төрийн авлигын түвшний шалгуураас авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 2018 онд 3.81 гарч өнгөрсөн оноос 0.10 пунктээр буурсан байна.

Хор уршиг, үр дагаврын үзүүлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлийг хоёр дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлов. Ингэхэд улс төрийн авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 0.15 пунктээр буурч, харин авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үзүүлэлт 0.05 пунктээр нэмэгдсэн байна.

График 16. Улс төрийн авлигын хор үршиг, үр дагавар.



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ

Улс төрийн авлигын хор уршгийн үзүүлэлтийн үнэлгээ 4.09 болж өнгөрсөн оноос 0.25 пунктээр буурсан байна (2017 оны үзүүлэлт 4.34).


Нийт 16 дэд үзүүлэлтээс 14 үзүүлэлтийн үнэлгээ буурсан байна. Ингэхэд дараах үзүүлэлтийн үнэлгээ хамгийн их буурсан:

- гадаадын хөрөнгө оруулалт буурсан - 0.46,
- гэмт хэрэг нэмэгдэх - 0.42,
- хүний эрхийн зөрчил нэмэгдэх - 0.35,
- нийгмийн дэг журам алдагдах - 0.30,
- улс орны эдийн засгийн хүч сулрах - 0.29,
- ажилгүйдэл нэмэгдэх - 0.28,
- шударга ёс алдагдах - 0.27,
- ядуурал нэмэгдэх - 0.26,

- Монгол улсын нэр хүнд олон түвшинд унах - 0.25,
- Төрийн албаны чадвар сулрах - 0.23,
- Ёс суртахууны үнэт зүйлс алдагдах - 0.20.

Харин байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл 0.07 пунктээр, хуулийн хэрэгжилт суларсан 0.03 пунктээр нэмэгдсэн байна.

График 17. Улс төрийн хүрээний авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин.




Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГААР ОЛСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээ 3.52 гарсан нь өнгөрсөн оноос 0.05 пунктээр өссөн байна (2017 оны үзүүлэлт 3.47).

Уг үзүүлэлт хамаарах 19 дэд үзүүлэлтийн 10 үзүүлэлтийн үнэлгээ ямар нэг хэмжээнд өссөнөөс дотоодын банкинд хадгалах (+0.49), дотоодод орон сууц, барилга байгууламж бариулах (+0.44), бэлэн мөнгө хэлбэрээр хадгалах (+0.36), гэр бүлийн өмчлөлийн компанид хувь оруулах (+0.31), дотоодод орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах (0.023) хэлбэрүүдийн үнэлгөө хамгийн их өссөн.

Харин 9 үзүүлэлтийн үнэлгээ буурснаас гадаадын оффшор бүсэд компани байгуулах (-0.31), гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах (-0.19), эмчилгээнд зарцуулах (-0.16), өдөр тутмын хэрэгцээнд зарцуулах (-0.11) хэлбэрүүдийн үнэлгээ хамгийн их буурсан байна.

График 18. Улс төрийн (түүнчлэн шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний) авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт.




2. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлгийн хүрээнд улс төрийн авлигын үндсэн үнэлгээнээс гаднах бусад үзүүлэлтүүдийн байдлаар авлигын ерөнхий ойлголт, төсөөллийг дэлгэрүүлж гаргаж ирэхийг зорьсон болно.

АВЛИГЫН ТҮВШИН

Судалгааны хүрээнд улс төрийн хүрээгээр хязгаарлалгүй Монголын нийгэм дэх авлигын ерөнхий хандлага, түгээмэл байдлыг шинжээчдээр үнэлүүлэхэд 74.3 хувь нь их болон маш их гэж үнэлсэн байгаа юм.

График 19. Монголын нийгэм дэх авлигын түвшин.



УЛС ТӨРИЙН НАМУУДЫН АВЛИГАД АВТСАН БАЙДАЛ

Судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлгээгээр 2018 онд улс төрийн намуудын авлигад автсан байдлыг тус бүрд нь тооцож үзвэл Монгол Ардын Нам болон Ардчилсан нам хоёр ижил хэмжээнд тус бүр 36.4 хувьтайгаар авлигад хамгийн их автагдсанаар тооцогдож байна. Удаагаар Монгол Ардын Хувьсгалт Нам 18.2 хувьтай, Иргэний Зориг-Ногоон нам 6.1 хувьтай үнэлэгдэж байна.

График 20. Монгол Улс дахь улс төрийн намуудын авлигад автсан байдал.



АВЛИГЫН ХҮРЭЭНИЙ ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Монголын нийгэм дэх авлигын ерөнхий хандлагын зэрэгцээ цар хүрээгээр нь тодорхойлохыг зорьсон юм. Улс орны авлига ямар түвшинд байгаа нь цар хүрээний тархацтай шууд холбоотой юм. Нийт 11 дэд хүрээнээс засгийн газар болон улс төрийн намын хүрээн дэх авлигын тархалтын үзүүлэлт хамгийн өндөр гарч, удаагаар шүүх, прокурор, Улсын Их хурал байгаа бол төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хүрээнд харьцангуй бага пункттэй гарчээ. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн “их” болон “маш их” гэсэн үнэлгээний нийлбэр 57.6 хувьтай байгаа нь анхаарал татаж байна.

Хүснэгт 5. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдал (%).

		Огт үгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Их	Маш их	(“их, маш их”-ийн нийлбэр)
1	Засгийн газар (яам, агентлаг)	0,0	3,0	4,5	50,0	36,4	(86,4)
2	Улс төрийн нам	0,0	4,5	9,1	30,3	42,4	(72,7)
3	Шүүх	0,0	4,5	12,1	40,9	28,8	(69,7)
4	Прокурор	1,5	4,5	12,1	36,4	25,8	(62,1)

5	Улсын Их Хурал	0,0	6,1	12,1	33,3	25,8	(59,1)
6	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	1,5	7,6	16,7	28,8	28,8	(57,6)
7	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	0,0	6,1	25,8	30,3	24,2	(54,5)
8	Төрийн/орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой ААН	3,0	6,1	16,7	30,3	24,2	(54,5)
9	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	3,0	10,6	24,2	22,7	19,7	(42,4)
10	Хувийн хэвшил	15,2	21,2	10,6	18,2	7,6	(25,8)
11	Төрийн бус байгууллага	15,2	27,3	16,7	6,1	1,5	(7,6)

АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛСӨН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгааны хүрээнд Монгол Улс дахь авлигын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар шинжээчдээс нээлттэй хэлбэрээр асуухад нийт 115 хариулт өгөгдсөнийг нэгтгэн боловсруулахад 24 төрлийн хүчин зүйл дурдагдсан юм. Тэдгээрийн эрэмбэлэхэд дараах дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 6. Монгол Улсын авлигын ерөнхий түвшинд нөлөөлсөн гол нөхцөл байдал.

	-	Хувь	Тохиолдол
1	Улс төрийн намуудын гажуудсан байдал	7,83%	9
2	Хариуцлагын тогтолцооны хомсдол	7,83%	9
3	Албан тушаалын томилгоо/наймаа	7,83%	9
4	Засаглалын тогтворгүй/залгамжгүй байдал	6,96%	8
5	Шунал, ёс суртахууны доройтол	6,96%	8
6	Хүн амын-эдийн засгийн байдал	6,09%	7
7	Сонгуулийн тогтолцоо	6,09%	7
8	Төрийн албаны тогтворгүй байдал	6,09%	7
9	Хууль эрх зүйн алдаа дутагдал	6,09%	7
10	Төрийн албаны чадамж	4,35%	5
11	Төрийн худалдан авалт (тендер, концесс)	4,35%	5
12	Иргэд, иргэний нийгмийн сул байдал	3,48%	4
13	Мэдээллийн ил тод бус/замбараагүй байдал	3,48%	4
14	Төрийн үйл ажиллагааны ил тод байдал	2,61%	3
15	ОНМХ-ийн сул/хараат байдал	2,61%	3
16	Нийгмийн хүлээн зөвшөөрсөн/дөжирсөн хандлага	2,61%	3
17	Шүүх засаглалын сул тал, гажуудал	2,61%	3
18	Эдийн засгийн тогтворгүй байдал	2,61%	3
19	Авлигын эсрэг бүтцийн сул байдал/гажуудал	1,74%	2
20	Авлигын эсрэг боловсролын хомсдол	1,74%	2
21	Авлигын эсрэг үйл ажиллагааны сул байдал	1,74%	2
22	Гадны улс/байгууллагын нөлөө	1,74%	2
23	Гэмт бүлэглэлүүдийн нөлөө	1,74%	2
24	Авлига илүү далд хэлбэр рүү шилжсэн	0,87%	1
	Нийт	100%	115

БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЗАРЦУУЛЖ БУЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ

Бизнес эрхлэгчид үйл ажиллагааныхаа явцад өгч буй авлигын үнэлгээг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл тендерийн шалгаруулалтад ялахад, тусгай зөвшөөрөл авахад, төсөл хөтөлбөрт хамрагдахад илүү өндөр авлига өгдөг гэжээ.

Хүснэгт 7. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ (%)

		<5 хувь	6-10 хувь	11-15 хувь	16-20 хувь	21< хувь
1.	Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	6,1	25,8	16,7	19,7	13,6
2.	Тендерт шалгаруулалтад ялахад	4,5	21,2	18,2	21,2	21,2
3.	Зээл авахад	15,2	34,8	15,2	6,1	10,6
4.	Өр төлбөр барагдуулах, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэхэд	12,1	25,8	16,7	4,5	6,1
5.	Татвараас чөлөөлүүлэх, бууруулахад	9,1	21,2	18,2	9,1	13,6
6.	Хяналт шалгалтаар зөрчил дутагдалгүй гарахад	13,6	18,2	22,7	9,1	12,1
7.	Тусгай зөвшөөрөл авахад	4,5	15,2	19,7	16,7	25,8
8.	Бараа, ажил, үйлчилгээ хүлээлгэн өгөхөд	10,6	21,2	15,2	16,7	12,1
9.	Гадаадаас ажиллах хүч авахад	7,6	15,2	13,6	10,6	12,1

ХЭЭЛ ХАХУУЛЬД ЗАРЦУУЛСАН МӨНГӨНИЙ ХЭМЖЭЭ

Хээл хахуульд өгч буй мөнгөн дүнг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход, тусгай зөвшөөрөл авахад зэрэгт хамгийн их өгдөг гэж шинжээчид хариулжээ.

Хүснэгт 8. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ /зорилгоор/, сая төгрөгөөр.

		<1 сая	1-5 сая	5-10 сая	10-20 сая	20-50 сая	50 сая <
1	Ажил, албан тушаалд ороход	3,0	22,7	22,7	13,6	4,5	22,7
2	Тусгай зөвшөөрөл авахад	1,5	6,1	27,3	15,2	16,7	21,2
3	Ашиг сонирхолдоо нийцсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад	1,5	0,0	1,5	6,1	12,1	51,5
4	Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход	0,0	3,0	6,1	13,6	13,6	36,4
5	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход	0,0	15,2	12,1	13,6	16,7	16,7
6	Эрүүгийн хэрэг үүсгэхэд	0,0	9,1	12,1	18,2	9,1	12,1
7	Гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад	1,5	7,6	9,1	16,7	13,6	19,7
8	Хуурамч бичиг баримт үйлдэхэд	6,1%	21,2	13,6	15,2	7,6	6,1

ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улс төрийн (дээд түвшний) авлигатай тэмцэх үйл ажиллагааны сэдэвтэй холбогдуулан шинжээчдээс хаалттай хэлбэрээр нийт 21 арга хэмжээний ач холбогдлын талаар асууж үнэлүүлсэн юм. Өгсөн ач холбогдлоор нь эрэмбэлэхэд дараах дүр зураг харагдаж байна.

График 21. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ.



ГУРАВ. ШИНЖЭЭЧДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

График 22. Шинжээчдийн хүйс.



График 23. Шинжээчдийн нас.





График 24. Шинжээчдийн салбарын хаярьяалал.



ДҮГНЭЛТ

Монголын улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны дүн 2018 онд өнгөрсөн оны буюу 2017 оны үзүүлэлттэй ойролцоо, өндөр түвшинд гарлаа. 2017 оны индекс 3.97 пункттай гарсан бол 2018 оных 3.93 буюу (-) 0.04 пунктын зөрүүтэй гарлаа.

Авлигын түвшний төсөөллийн индексийг бүрэлдүүлэх үндсэн (4) шалгуур үзүүлэлтийн түвшинд ч өөрчлөлт бараг гарсангүй (0.11 пункт болон түүнээс доош), зөвхөн үндсэн шалгуурыг бүрэлдүүлэх дэд үзүүлэлтийн түвшинд тодорхой хэмжээний өсөлт, бууралт ажиглагдлаа.

Тайлангийн эхэнд дурдагдсанаар тус судалгаа хийгдэж ирсэн өнгөрсөн 11 жилийн үзүүлэлтийг харьцуулан харахад авлигын төсөөллийн индексийн дундаж 3.87 байгаа ба 2008 оны анхдагч үзүүлэлтээс 0.5 хүртэл баллаар буурч байсан 2013-2016 онуудыг эс тооцвоос өндөр түвшинд 4 баллын орчимд тогтвортой хэлбэлзэх хандлага илэрч байна.

Энэ оны судалгааны хүрээнд анх удаагаа чанарын судалгааны хэлбэрийг нэмэлтээр ашигласан. Тоон судалгааны дүнтэй харьцуулахад дэлгэрэнгүй ярилцлагын хүрээнд оролцогчид илүү сөрөг үнэлгээг илэрхийлэх хандлага ажиглагдсан ба энэ нь экспертын түвшний оролцогчид эргэлзээтэй зүйлийг бага түвшинд үнэлэх эсвэл мэдэхгүй гэж хариулах хандлагаар тайлбарлагдана.

Шинжээчдийн давамгайлсан байр суурийг илэрхийлэхэд Монголын нийгэмд авлига бүх түвшин, нийгмийн амьдралын бараг бүх хүрээнд нэвтэрч өдөр тутмын, хэвийн мэт үзэгдэл болсон. Авлига зөвхөн хэмжээ, хэлбэрээрээ ялгагдана. Авлигыг хүссэн хүсээгүй хүлээн зөвшөөрсөн, өөрөөр хэлбэл дөжирсөн, бүх нийтийн уур амьсгал нь улс төрийн авлига цэцэглэх ерөнхий фон болдог.

Улс төрийн хүрээ бол авлигад хамгийн их идэгдсэн нийгмийн хүрээ. Улс төрийн авлига бол нийгмийн баялгийг хууль бусаар дахин хуваарилах асар том процесс. Авлигын үндсэн сэдэл бол шунал. Улс төрд хамгийн их баялгийг хуваарилах боломж байхаас гадна өөрөө “зарлагагүй бизнес” юм. Шуналыг хангах буюу хөрөнгөжих боломжийг улс төрийн эрх мэдэл бүрэлдүүлнэ. Улс төрийн эрх мэдлийн дээд түвшин бол засгийн эрх. Улс төрийн эрх мэдэлд хүрэх нь улс төрийн намаар дамжин өөрөө авлигын замаар явагдана. Улс төрийн нам бол авлигыг хэрэгжүүлэх үндсэн субъект.

Ингэхэд улс төрийн нам доторх эрх мэдлийн төлөө тэмцэл → нам → сонгууль → төр → эрх мэдэл → томилгоо гэсэн бүдүүвч тодорч харагдана.

Төрийн эрх мэдлийг авснаар авлигын замаар улс төрийн, албан тушаалын томилгоог явуулж, үүгээрээ цаашдын авлигын нөхцөл боломжийг бүрэлдүүлнэ. Томилгоо бол улс төрийн авлигын үндсэн хэлбэр. Харин авлигыг хэрэгжүүлэх үндсэн арга нь хуйвалдаан болно.

Нам улс төр-бизнесийн бүлэглүүдэд үйлчилдэг эсвэл намын удирдлагууд өөрсдөө тэдгээр бүлэглэлүүдийн нэг хэсэг байна. Улс төр-бизнесийн бүлэглэлүүд нам дамнасан зохион байгуулалттай. Шүүх болон хууль хяналтын байгууллагын авлигын хүрээлүүд тэдгээрийн нэг хэсэг буюу тэдгээртэй харилцан хамаарал, нөлөөлөлтэй харилцаанд байдаг.

Улс төрийн авлига байх үндсэн нөхцөл боломж нь төрийн тогтолцооноос үүдэлтэй. Энэ нь засаглалын хуваарилалт зүй зохистой хийгдээгүйгээс эхэлнэ. Ингэхдээ засаглалууд нэг нэгнээ хянах бус, харин нэг нэгнийхээ эрх мэдэл, үйл ажиллагаанд оролцох, гацаах боломжоор хангагдсан. Ялангуяа гүйцэтгэх засаглалын эрх мэдэл хязгаарлагдмал байгаа нь түүний ажиллах, шийдвэрлэх чадварыг мохоож, эрх мэдлийн тодорхой бус орчинд авлига үүсэх, оршин тогтнох, цэцэглэх таатай орчныг

бүрэлдүүлж байдаг.

Авлига хөгжих боломжийг олгож байгаа үндсэн зүйл бол мэдээллийн ил тод бус байдал болон хяналтын тогтолцоо байхгүй явдал. Хяналтын тогтолцоо гэдэг нь тодорхой үүрэг бүхий төрийн ямар нэгэн бүтэц гэхээс илүүтэй олон нийтийн хяналтыг хэлнэ. Харин олон нийтийн хяналт байхгүй байгаа. Учир нь олон нийтийн хяналтанд үндсэн үүргийг гүйцэтгэх олон нийтийн мэдээллийн хэрэгсэл энэ үүргээ гүйцэтгэх чадваргүй, өөрөө авлигын тогтолцооны нэг хэсэг болсон. Шалтгаан нь ОНМХ-ийг зохицуулаагүй, зүй ёсоор хөгжин бүрэлдэх боломж олгоогүй, тиймд өнөөгийн замбараагүй, завхарсан салбар болж бүрэлдсэн. Иргэдийн хандлага, иргэний нийгмийн ухамсар, хөгжил, идэвхийн түвшин ч үүнтэй багагүй хэмжээнд холбоотой.

Улс төрийн хүчний үйл ажиллагаа, юун түрүүнд санхүүжилтийн зохицуулалт алдаа дутагдалтай байгаа нь авлигын түвшинд маш сөргөөр нөлөөлнө. Энэ нь намуудын засгийн эрхийн төлөө үйл ажиллагаа буюу сонгуулийн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг. Сонгуулийн ажиллагаа санхүүжилтээсээ эхлэн өндөр хэмжээнд авлигажсан. Үүнийг үргэлжлүүлэн тууштай бодоход авлигын замаар сонгуульд ялах нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авах явдал, тиймд төрийн эрх мэдлийг хууль бусаар авсан бол төр өөрөө хууль бус болно гэсэн гаргалгаа гарч ирнэ.

Цаашлан төрийн алба зүй зохистой ажиллах бүтцийн болон эрх зүйн орчин хангалтгүй. Төрийн ажлыг хийж гүйцэтгэх нөхцөл эрх зүйн хувьд хязгаарлагдмал. Энэ нь нэг талаас гүйцэтгэх засаглалд бүхэлдээ хангалттай эрх мэдэл өгөгдөөгүйтэй холбогдолтой ч нөгөө талаас доод, дунд түвшинд өдөр тутмын ажлыг шийдвэрлэхэд одоогийн эрх зүйн зохицуулалт их саад болдог. (Үүнтэй холбогдуулан “Захиргааны ерөнхий хууль”-ийг жишээ болгодог.)

Мөн хүчин төгөлдөр хууль, бусад эрх зүйн актын чанарын хангалтгүй байдал их хэмжээнд нөлөөлнө. Хууль өөрөө цоорхойтой, тодорхой бус, хоорондоо авцалдаагүй байдаг нь авлигын зорилгоор тайбарлах, ашиглах боломжийг бас бүрэлдүүлдэг.

Улс төрийн болон төрийн албаны хариуцлага тооцох үр дүнтэй тогтолцоо байхгүй явдал мөн улс төрийн авлигад таатай нөлөөлнө. Мөн авлигын томилгооны үр дүнд төрийн алба чадваргүйдсэн, ёс зүйн хувьд доройтсон нь өөрөө авлигыг цаашид дэлгэрүүлэх хүчин зүйл болсон.

Нийгмийн ерөнхий хандлага улс төрийн авлигыг өөгшүүлэхэд нөлөөлж байгаа гэж өмнө нь дурдсан. Хэрэв нийгмийн хэм хэмжээ уламжлал, ёс суртахуун, хууль гэсэн гурван зүйлийн хүрээнд тогтоогдож, тогтож байдаг бол эсрэгээр өнөөгийн нийгэмд авлигын үр дүнд аль аль нь зохих үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон.

Авлигатай тэмцэхтэй холбогдуулан хязгаарлагдмал шинжтэй саналууд илэрхийлэгдэх хэдий ч ихэнхи оролцогчдын хувьд “тогтолцоог нь нураахгүй бол” гэх гарцгүй, найдлагагүй хандлага давамгайлсан.

Тодорхой саналуудын хувьд засаглалын хуваарилалтыг сайн салгаж тодорхойлж өгөх, ингэхдээ гүйцэтгэх засаглалыг бэхжүүлэх, түүнчлэн хяналтын үүрэгтэй дээд танхим бүхий хоёр танхимтай парламенттай байх, үндсэн хуулийн шүүхтэй болох зэргийг хамгийн түгээмэл дурдсан. Орон нутгийн удирдлагын түвшинд ч гүйцэтгэх засаглалын эрх мэдлийн бэхжүүлэхийн зэрэгцээ ИТХ-ын эрх мэдлийг эрс хязгаарлах саналууд илэрхийлэгдсэн.

Цаашлан улс төрийн намын санхүүжилтийг өөрөөр зохицуулах, сонгуулийн тогтолцоог өөрчлөх, ингэхдээ сонгуулийн ажиллагааг аль болох ил тод болгох, сурталчилгааны хугацааг эрс сунгах саналууд илэрхийлэгдсэн.

Мөн томилгооны асуудлыг зохицуулах, улс төрийн албан тушаалтан төрийн жинхэнэ албан хаагчийг томилох боломжийг хаах, улс төрийн болон төрийн

албаны хариуцлагын үр дүнтэй тогтолцоотой болохын зэрэгцээ авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлыг дэлгэрүүлэх, үүнийг бага сургуулийн боловсролоос эхлүүлэхийг шинжээчид чухалд үзсэн болно.

**ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН
ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ
ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2018**



ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2018 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл: Авлигатай тэмцэх газар 2008 оноос хойш жил тутам “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулж судалгааны үр дүнг Мянганы хөгжлийн 9 дэх зорилтын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгох, хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх нэг шалгуур болгож ирсэн.

Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхэд мэдээллийн чухал их сурвалж болох учиртай.

2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 онд тус хоёр хүрээг тусд нь авч үзэж, “Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” болон “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г хийхээр болсон юм. Уг хоёр судалгааг “Максима Консалтинг” ХХК хийж гүйцэтгэв.

Судалгааны хүрээнд дараах зорилтыг тавьж зохион байгуулав.

- Авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, авлигын хэлбэрийг авч үзэх;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын шалтгаан, нөхцөл түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэмжээ, түүний хор уршиг, үр дагаврыг гаргах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх хүрээн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зэрэг болно.

Судалгааны арга зүй: “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г тоон болон чанарын судалгааны аргаар хийж явуулсан. Ингэхдээ нийтийн алба (шүүх, хууль сахиулах салбараас бусад), шүүх, хууль сахиулах салбар, хэвлэл мэдээллийн салбар, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, бодлогын судалгаа, олон нийтийн санал бодлын судалгаа, бизнесийн салбар, иргэдийн төлөөллийг оролцуулан нийт 66 шинжээчийг хамруулсан.


Тоон судалгааны мэдээллийг цуглуулахдаа нүүр тулсан ярилцлагын асуулгын аргыг ашигласан ба шинжээчдээр асуулт бүрийг “1-ээс 5” гэсэн баллаар үнэлүүлэн тооцоолсон. Баллын үнэлгээ буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол баллын үнэлгээ өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.

Чанарын судалгааг фокус бүлгийн хэлэлцүүлгийн аргаар хийж явуулсан бөгөөд 6 удаагийн хэлэлцүүлэгт нийт 48 шинжээчийг оролцуулан судалгааны асуултуудыг дэлгэрүүлж, гүнзгийрүүлж хэлэлцсэн.

Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ боломжтой тохиодолд “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2017 оны судалгаа”-наас шүүх, хууль хяналтын байгууллагатай холбогдолтой тоо баримтыг

салган шинээр тооцоолж 2018 оны үзүүлэлэлттэй харьцуулан шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тогтоосон болно. Бусад тохиодолд энэ оны үзүүлэлтийг 2018 оны улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын нэгтгэсэн дүнтэй зэрэгцүүлэн толилуулсан нь ямар нэгэн өөрчлөлтийг тогтоосон бус гагцхүү баримжаалах зориулттай болно. Үүнийг тухай бүрт нь тэмдэглэсэн байгаа.


График 1. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үнэлгээ, үзүүлэлтийн схем.



1. 2018 ОНЫ ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШИН

Судалгааны үр дүнд 2018 онд шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 3.68 гарлаа. Тус салбарын индексийг анх удаагаа гаргаж байгаа тул ямар нэгэн өөрчлөлтийг тогтоох боломжгүй. Баримжаалах зориултаар харьцуулахад ижил аргачлалаар хийгдсэн мөн энэ оны улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 3.93 гарсан. Харин өмнө жилүүдэд нэгтгэсэн байдлаар гаргаж байсан улс төр болон шүүх, хууль байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн индексийн 2008-2017 оны дундаж 3.86 байгаа юм.

График 2. Улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 2008-2017 онд, шүүх, хууль хяналтын хүрээний авлигын түвшин 2018 онд.



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг тогтоохдоо дараах үндсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашигласан: цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөл, хор уршиг/үр дагавар.

Ижил аргачлалаар нэгэн зэрэг хийж явуулсан улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа болон өмнөх жилийн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх судалгаанаас салгаж тооцоолж болох шүүх, хууль хяналтын байгууллагын үзүүлэлттэй харьцуулахад энэ салбарт улс төрийн хүрээнээс арай бага авлигын үнэлгээ өгдөг хандлага ажиглагдаж байгаа юм. Тухайлбал энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлтээс шүүх, хууль хяналтын байгууллагын үндсэн шалгууруудын үзүүлэлт 0.15-0.30 пунктээр бага гарсан.

График 3. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ.



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ


Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээний үнэлгээ 3.69 гарлаа. Харин энэ оны улс төрийн хүрээний авлигын цар хүрээний үнэлгээ 3.99 гарсан.

Цар хүрээний үнэлгээг 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлох бөгөөд дүнг доорх график 4-т харуулав. Индексээс гадна чанарын хувьд дэд үзүүлэлт бүрийн хувьд хэр өндөр үнэлгээ өгснийг “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрээр харуулахад:

1. Авлигын түгээмэл байдал 75.8%,
2. Авлигын түвшний өөрчлөлт 42.2%,

3. Авлигын цар хүрээ салбар, хүрээ/байгууллагаар 46.3% (дундаж),
4. Авлигын түвшин тодорхой үйл ажиллагааны төрлөөр 36.7%,
5. Авлигын чиглэглэгдсэн байдлаар 59.0% гарлаа.

График 4. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээний үнэлгээ.




Дэд үзүүлэлт 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.13 пунктэй гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.34 гарсан. Харин 2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын нэгтгэсэн үзүүлэлт 4.18 байсан.

Хувиар авч үзвэл шинжээчдийн 75.8% нь тус салбарт авлига их болон маш их хэмжээнд түгээмэл гэж үнэлсэн (улс төрийн хүрээний үзүүлэлт 83.8%).

График 5. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин.




Дэд үзүүлэлт 2. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлтийн үнэлгээ 3.59 пункттэй гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний авлигын түвшний өөрчлөлтийн үнэлгээ 3.56 гарсан. Харин 2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын нэгтгэсэн үзүүлэлт 3.59 байсан.

Хувиар авч үзвэл шинжээчдийн 42.4% нь тус салбарт авлига их, бага ямар нэг хэмжээнд нэмэгдсэн гэж үнэлсэн (улс төрийн хүрээний үзүүлэлт 48.5%).

График 6. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт.



Дэд үзүүлэлт 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА ДАХЬ АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Шүүх, хууль хяналтын байгууллага тус бүр дэх авлигын тархалтын цар хүрээний үнэлгээ 3.57 пункттай өмнөх оны үзүүлэлтээс 0.29 пунктээр буурсан үзүүлэлттэй гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний авлигын түгээмэл байдлын үнэлгээ 3.93 гарсан бол 2017 оны шүүх, хууль хяналтын байгууллагын үзүүлэлт 3.86 байв.

Хувиар авч үзвэл салбар, байгууллагуудын авлига “их” болон “маш их” тархмал гэсэн үнэлгээний дундаж 46.3% байгаа ч хоорондоо их зөрүүтэй үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Салбар, хүрээ/байгууллагад авлига тархсан цар хүрээ.

		2017	2018	Өөрчлөлт	Их, маш их тархсан
1	Прокурор	4.04	4.02	-0.03	66.7%
2	Шүүх	4.02	3.97	-0.05	68.2%
3	Цагдаагийн байгууллага	3.96	3.68	-0.28	53.0%
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3.81	3.54	-0.27	43.9%
5	Авлигатай тэмцэх байгууллага	3.71	3.53	-0.19	48.5%
6	Шүүхийн шинжилгээний байгууллага	3.86	3.50	-0.36	40.9%
7	Тагнуулын байгууллага	4.08	3.43	-0.65	33.3%
8	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар	3.73	3.42	-0.31	37.9%
9	Хил хамгаалах байгууллага	3.54	3.05	-0.49	24.2%
10	Дотоодын цэрэг ¹	-	-	-	-
	Нийт	3.86	3.57	-0.29	46.3%

Дэд үзүүлэлт 4. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Авлига тархсан байдлыг байгууллагуудаас гадна тэдгээрийн явуулдаг тодорхой үйл ажиллагааны хүрээгээр үнэлүүлэхэд 3.44 буюу өмнөх оны үзүүлэлтээс 0.27 пунктээр буурсан үзүүлэлттэй гарлаа. Харин энэ оны улс төрийн хүрээний энэ үзүүлэлт 4.17 гарсан байна. Үнэлгээг тухайн салбарын үндсэн 10 үйл ажиллагааны хүрээнд гаргасан.

¹ Дотоодын цэргийн хувьд үнэлгээнд мэдэхгүй хувь хэт өндөр байсан тул үнэлгээг нь гаргаагүй болно.


Хүснэгт 2. Шүүх, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын түвшин.

	Шүүх, хууль сахиулах үйл ажиллагаа	2017	2018	Өөрчлөлт
1	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа	3,94	3,85	-0,09
2	Прокурорын хяналт	4,02	3,82	-0,20
3	Эрүүгийн хэрэг шүүхэд таслан шийдвэрлэх ажиллагаа	3,81	3,71	-0,10
4	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа	3,70	3,62	-0,08
5	Шүүхийн шинжилгээний ажиллагаа	3,74	3,53	-0,21
6	Иргэний харьяалал, шилжилт, хөдөлгөөний бүртгэл	3,64	3,42	-0,22
7	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа	3,84	3,40	-0,44
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	3,72	3,30	-0,42
9	Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа	3,24	2,87	-0,37
10	Хил хамгаалах ажиллагаа	3,50	2,85	-0,65

Дэд үзүүлэлт 5. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН НӨЛӨӨЛӨЛ, ЧИГЛЭЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын авлига бусад салбар, хүрээний үйл ажиллагаа руу хэр чиглэж байгаа буюу нөлөөллийн (авлигын чиглэл буюу аль салбар, үйл ажиллагаатай хэр холбогдсон байдал) үнэлгээний үзүүлэлт 3.72 гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн авлигын тус шалгуурын үзүүлэлт 3.97 гарсан байна.

График 7. Шүүх, хууль сахиулах байгууллагын авлига бусад салбар, үйл ажиллагаа руу чиглэгдсэн байдал.



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ 3.52 гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний авлигын хэлбэрийн үнэлгээ 3.71 гарсан бол 2017 оны улс төрийн болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 3.81 гарч байсан байна.

Цар хүрээний үнэлгээг хээл хахуулийн хэлбэр, хээл хахууль өгөх, авах арга, бүлэглэлүүдийн харилцаа холбоо, авлигын хэлбэр болон хууль бус нөлөөллийн хэлбэр гэсэн 5 дэд үзүүлэлтийн хүрээнд үнэлүүлж гаргасан.

График 8. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ.




Дэд үзүүлэлт 1. ХЭЭЛ ХАХУУЛИЙН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ 3.57 гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний ижил шалгуурын үнэлгээ 3.59 гарсан байна. Харин 2017 оны улс төрийн болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 3.69 гарч байжээ.

Хээл хахуулийн олон хэлбэр байгаагаас хамгийн түгээмэл гэж үзсэн дараах 13 хэлбэрийг сонгон үнэлүүлсэн (зураг 10). Өндөр үзүүлэлттэй гарсан хэлбэрүүдийн үзүүлэлтийн тодруулах үүднээс тэдгээрийн “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрийг харуулбал,

- ажил албан тушаалд томилох, оруулах 65.2%,
- бэлэн мөнгө өгөх 54.5%,
- шагнал, цол, тэмдгээр шагнах 54.5%,
- ашиг, орлого хуваалцах 51.5%-тай байна.

График 9. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ.




Дэд үзүүлэлт 2. ХУУЛЬ БУС НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ нь 3.68 гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний ижил шалгуурын үнэлгээ 3.66 гарсан байна. Харин 2017 оны улс төрийн болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 3.94 гарч байжээ.

Хууль бус нөлөөллийн түгээмэл дараах 9 хэлбэрийг сонгон үнэлүүлсэн. Үзүүлэлтийн тодруулах үүднээс тэдгээрийн “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрийг харуулбал,

- Найз, танил талын хэлхээ холбоог ашиглах 68.2%,
- Нутаг орны хэлхээ холбоог ашиглах 68.2%,
- Намын хэлхээ холбоог ашиглах 63.6%,
- Садан төрлийн хэлхээ холбоог ашиглах 57.6%,
- Дарамт шахалт үзүүлэх 51.5%,
- Албадах 47.0%,
- Айлган сүрдүүлэх, заналхийлэх 42.4%,
- Хүсэлт тавих 42.4%,
- Амлалт өгөх 39.4%-тай байна.

График 10. Хууль бус нөлөөллийн үнэлгээ.



Дэд үзүүлэлт 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА, УЛС ТӨРИЙН НАМ/ БҮЛЭГЛЭЛ, УЛС ТӨР, БИЗНЕС, ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮДИЙН ХАРИЛЦАА, ХАМААРАЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд, улс төрчид болон улс төрийн нам/бүлэглэл, гадаад дотоод бизнесийн бүлэглэл, гэмт бүлэглэлийн харилцаа, хамаарлын үнэлгээ 3.38 гарлаа. Харин улс төрийн хүрээнийхний энэ үзүүлэлт 3.74, өнгөрсөн оны нэгтгэсэн үзүүлэлт 3.88 гарч байсан байна. Бүлэглэлүүдийн харилцаа, хамаарлын 13 төрлийн нөхцөл байдлыг үнэлүүлсэн.

Хүснэгт 3. Бүлэглэлүүдийн харилцаа, хамаарал, нөхцөл байдлын үнэлгээ.

	Бүлэглэлүүдийн нөхцөл байдал	Индекс
1	Хууль сахиулахын хүрээн дэх авлига илүү далд хэлбэрт шилжсэн	4,21
2	Улс төрчид шүүгч/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4,11
3	Улс төрчид шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	3,95
4	Бизнес бүлэглэл шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	3,66
5	Бизнес шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	3,65
6	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд бизнес бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3,57
7	Шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд улс төрчдийг эрхшээлдээ оруулсан	3,49
8	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд гэмт бүлэглэлийн эрхшээлд орсон	3,06
9	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон гэмт бүлэглэл нэгдсэн	3,06
10	Гадны бизнесийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	2,87
11	Гадны улс төрийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	2,85
12	Гадны бизнесийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудтай нэгдсэн	2,85
13	Гадны улс төрийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудтай нэгдсэн	2,55

Үзүүлэлтийн тодруулах үүднээс тэдгээрийн “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрийг харуулбал,

- Улс төрчид шүүгч, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн 69.7%,
- Улс төрчид шүүх, сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан 66.7%,
- Бизнес шүүх, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн 48.5%
- Бизнес бүлэглэл шүүх, сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан 47.0%
- Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд бизнес бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан 42.4%
- Шүүх, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд улс төрчдийг эрхшээлдээ оруулсан 40.9% байна.


Дэд үзүүлэлт 4. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ 3.59 гарсан. (Энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 4.06, 2017 оны нэгтгэсэн үзүүлэлт 4.18.)

Энэ шалгуурын үзүүлэлт судалгааны дундажтай ойролцоо хэдий ч онцлог нь бүрэлдүүлэгч үзүүлэлтүүд нь хоорондоо их зөрүүтэй буюу зарим нь их өндөр болоход

оршино. Үүнийг хувиар тодруулбал: “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрийн дундаж 49.8% байхад албан тушаал, эрх мэдлээ хэтрүүлэх 75,8%, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах 71,2%, түүнчлэн ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулах 66,7%, бизнесийн бүлэглэлийн захиалгаар шийдвэр гаргах 60,6% байна.


График 11. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэр.



**Дэд үзүүлэлт 5. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ ХЭЭЛ
ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ АРГА**

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудыг хэрэглэсэн байдлын үнэлгээ 3.38 гарлаа. (Энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 3.71, 2017 оны нэгтгэсэн үзүүлэлт 3.81.)

Нийт 11 аргыг үнэлүүлэхэд ойр дотны хүмүүсээр дамжуулах, зуучлагчаар дамжуулах, ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдний компанид давуу байдал олгох болон өмгөөлөгчөөр дамжуулах аргууд хамгийн түгээмэл хэрэглэгддэг гэсэн үнэлгээ гарсан (“их” болон “маш их” гэсэн үнэлгээний нийлбэрээр 57.6-39.4%).



Авлигын шалтгаан, нөхцөлийн үзүүлэлтийг авигад нөлөөлөх хүчин зүйлс, авлигын түвшинд нөлөөлөх (төрийн албаны) дутагдал, доголдол болон бүлэглэл, хүрээллүүдийн нөхцөл байдал гэсэн 3 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлдог.

Хүний нийгэм	2018 Зөвхөн шүүх, хууль хяналтын хүрээний дүн	2017 Улс төр, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн дүн
Бүлэглэл, хүрээлүүдийн нөхцөл байдал	3.68	4.08
Авлигад нөлөөлсөн хүчин зүйлс	3.82	4.25
Авлигын түвшинд нөлөөлсөн дутагдал, доголдол	4.02	4.10

Дэд үзүүлэлт 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГАД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ 3.82 гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний ижил үнэлгээ 4.24 гарч, 2017 оны улс төрийн болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 4.25 байлаа.

Авлигад нөлөөлөх 11 хүчин зүйлсийг үнэлүүлсэн бөгөөд өндөр үнэлгээний нийлбэрээр (“их” болон “маш их” гэсэн үнэлгээ) албан тушаалын томилгоо 75.8%-тай, (ИТХ-ийн үзүүлэлтийг эс тооцвол) бусад хүчин зүйлс жигд 50% гаруй байна.

Хүснэгт 4. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ.

	Авлигад нөлөөлөх хүчин зүйлс	Индекс	“их”, “маш их”-ийн нийлбэр
1	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4,31	75,8%
2	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3,93	56,1%
3	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	3,86	59,1%
4	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	3,86	57,6%
5	Намын санхүүжилтийн механизм	3,81	56,1%
6	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	3,80	54,5%
7	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	3,79	53,0%
8	Сонгуулийн санхүүжилтийн механизм	3,75	56,1%
9	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3,75	54,5%
10	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3,69	54,5%
11	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3,43	37,9%

Дэд үзүүлэлт 2. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ДУТАГДАЛ, ДОГОЛДОЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад төрийн албан дахь доголдол, дутагдал хэрхэн нөлөөлж буйн үнэлгээ 4.02 гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний ижил үнэлгээ 4.13 гарч, 2017 оны улс төрийн болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 4.10 байлаа.

Авлигад нөлөөлөх 12 доголдол, дутагдлыг үнэлүүлсэн бөгөөд өндөр үнэлгээний нийлбэрээр (“их” болон “маш их” гэсэн үнэлгээ) авч үзвэл албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж, шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг байдал, хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал, төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол, мэдээлэл нээлттэй, ил тод бус байдаг болон хүнд суртал 70%-иас илүү их өндөр нөлөөлөлтэй байна.

Хүснэгт 5. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол.

	Хариулт	Индекс	“их/маш их”-ийн нийлбэр
1	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	4,28	77,3%
2	ТАХ-ийн ур чадвар дутмаг	4,24	31,8%
3	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4,19	75,8%
4	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4,18	71,2%
5	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	4,17	71,2%
6	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	4,13	66,7%
7	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	4,10	71,2%
8	Хүнд суртал	4,10	71,2%
9	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	3,98	60,6%
10	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	3,71	48,5%
11	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	3,62	48,5%
12	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3,56	47,0%

Дэд үзүүлэлт 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ ХҮРЭЭЛЛҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн бүлэглэл, хүрээллийн нөхцөл байдал буюу ямар төрлийн хүрээллүүд түгээмэл, нөлөөлөлтэй байгаа талаарх үнэлгээ 3.68 гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний үнэлгээ 3.89 гарч, 2017 улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын үзүүлэлт 4.08 байлаа.

Ингэхэд өндөр үнэлгээний нийлбэрийн хувиар ч хувийн эрх ашгийг илүүд үзсэн нам тойрсон хүрээлэл (78.8%), нам дамнасан хүрээлэл (69.7%), бизнесийн хүрээллүүдийн (65.2%) нөлөөлөл өндөр байна.

График 14. Шүүх, хууль хяналтын хүрээн дэх хүрээллүүдийн нөхцөл байдал.



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор ур уршиг, үр дагаврын үзүүлэлт 3.66 гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 3.81 гарч, 2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 3.91 байлаа.

Авлигын төсөөллийн индексийг тогтоох 4 дэх үндсэн шалгуур болох энэ үзүүлэлтийг авлигын хор уршиг, үр дагавар болон авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт гэсэн хоёр дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлдог.

График 15. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагавар.



Дэд үзүүлэлт 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршгийн үзүүлэлт 3.79 гарсан бол энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 4.09 гарч, 2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 4.09 гарч байсан байна.

Хүснэгт 6. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин.

	Авлигын сөрөг үр дагавар	Индекс	“их/маш их”-ийн нийлбэр
1	Иргэдийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэл буурсан	4,28	74,2%
2	Хуулийн хэрэгжилт суларсан	4,17	74,2%
3	Төрийн албаны чадавхи суларсан	4,08	69,7%
4	Шударга ёс алдагдсан	4,05	69,7%
5	Ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан	4,02	68,2%
6	Өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдсэн	3,86	60,6%
7	Хүний эрхийн зөрчил нэмэгдсэн	3,82	62,1%
8	Нийгмийн дэг журам алдагдсан	3,75	57,6%
9	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэн	3,73	54,5%
10	Гэмт хэрэг нэмэгдсэн	3,69	54,5%
11	Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан	3,65	54,5%
12	Ядуурал нэмэгдсэн	3,61	47,0%
13	Гадаадын зээл тусламжийн үр ашиг буурсан	3,56	48,5%
14	Улс орны эдийн засгийн хүч чадал суларсан	3,48	43,9%
15	Ажилгүйдэл нэмэгдсэн	3,46	42,4%
16	Гадаадын хөрөнгө оруулалт буурсан	3,44	42,4%

Уг үзүүлэлт хамаарах 19 дэд үзүүлэлтийн 10 үзүүлэлтийн үнэлгээ ямар нэг хэмжээнд өссөнөөс дотоодын банкинд хадгалах (+0.49), дотоодод орон сууц, барилга байгууламж бариулах (+0.44), бэлэн мөнгө хэлбэрээр хадгалах (+0.36), гэр бүлийн өмчлөлийн компанид хувь оруулах (+0.31), дотоодод орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах (0.023) хэлбэрүүдийн үнэлгөө хамгийн их өссөн.

График 16. Улс төрийн (түүнчлэн шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний) авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт.




2. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлгийн хүрээнд шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлигын үндсэн үнэлгээнээс гаднах бусад үзүүлэлтүүдийн байдлаар авлигын ерөнхий ойлголт, төсөөллийг дэлгэрүүлж гаргаж ирэхийг зорьсон болно.

АВЛИГЫН ЕРӨНХИЙ ТҮВШИН

Судалгааны хүрээнд шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээгээр хязгаарлалгүй Монголын нийгэм дэх авлигын ерөнхий хандлага, түгээмэл байдлыг шинжээчдээр үнэлүүлэхэд 74.3 хувь нь их болон маш их гэж үнэлсэн байгаа юм.

График 17. Монголын нийгэм дэх авлигын түвшин.



АВЛИГЫН ХҮРЭЭНИЙ ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Монголын нийгэм дэх авлигын ерөнхий хандлагын зэрэгцээ хүрээгээр нь тодорхойлохыг зорьсон юм. Улс орны авлига ямар түвшинд байгаа нь цар хүрээний тархацтай шууд холбоотой юм. Нийт 11 дэд хүрээнээс засгийн газар болон улс төрийн намын хүрээн дэх авлигын тархалтын үзүүлэлт хамгийн өндөр гарч, удаагаар шүүх, прокурор, Улсын Их хурал байгаа бол төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хүрээнд харьцангуй бага пункттэй гарчээ. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн “их” болон “маш их” гэсэн үнэлгээний нийлбэр 57.6 хувьтай байгаа нь анхаарал татаж байна.

Хүснэгт 7. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдал (%).

		Огт үгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Их	Маш их	("их, маш их"-ийн нийлбэр)
1	Засгийн газар (яам, агентлаг)	0,0	3,0	4,5	50,0	36,4	(86,4)
2	Улс төрийн нам	0,0	4,5	9,1	30,3	42,4	(72,7)
3	Шүүх	0,0	4,5	12,1	40,9	28,8	(69,7)
4	Прокурор	1,5	4,5	12,1	36,4	25,8	(62,1)
5	Улсын Их Хурал	0,0	6,1	12,1	33,3	25,8	(59,1)
6	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	1,5	7,6	16,7	28,8	28,8	(57,6)
7	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	0,0	6,1	25,8	30,3	24,2	(54,5)
8	Төрийн/орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой ААН	3,0	6,1	16,7	30,3	24,2	(54,5)
9	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	3,0	10,6	24,2	22,7	19,7	(42,4)
10	Хувийн хэвшил	15,2	21,2	10,6	18,2	7,6	(25,8)
11	Төрийн бус байгууллага	15,2	27,3	16,7	6,1	1,5	(7,6)

АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛСӨН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгааны хүрээнд Монгол Улс дахь авлигын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар шинжээчдээс нээлтэй хэлбэрээр асуухад нийт 115 хариулт өгөгдсөнийг нэгтгэн боловсруулахад 24 төрлийн хүчин зүйл дурдагдсан юм. Тэдгээрийн эрэмбэлэхэд дараах дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 8. Монгол Улсын авлигын ерөнхий түвшинд нөлөөлсөн гол нөхцөл байдал.

	-	Хувь	Тохиолдол
1	Улс төрийн намуудын гажуудсан байдал	7,83%	9
2	Хариуцлагын тогтолцооны хомсдол	7,83%	9
3	Албан тушаалын томилгоо/наймаа	7,83%	9
4	Засаглалын тогтворгүй/залгамжгүй байдал	6,96%	8
5	Шунал, ёс суртахууны доройтол	6,96%	8
6	Хүн амын-эдийн засгийн байдал	6,09%	7
7	Сонгуулийн тогтолцоо	6,09%	7
8	Төрийн албаны тогтворгүй байдал	6,09%	7
9	Хууль эрх зүйн алдаа дутагдал	6,09%	7
10	Төрийн албаны чадамж	4,35%	5
11	Төрийн худалдан авалт (тендер, концесс)	4,35%	5
12	Иргэд, иргэний нийгмийн сул байдал	3,48%	4
13	Мэдээллийн ил тод бус/замбараагүй байдал	3,48%	4
14	Төрийн үйл ажиллагааны ил тод байдал	2,61%	3
15	ОНМХ-ийн сул/хараат байдал	2,61%	3
16	Нийгмийн хүлээн зөвшөөрсөн/дөжирсөн хандлага	2,61%	3
17	Шүүх засаглалын сул тал, гажуудал	2,61%	3
18	Эдийн засгийн тогтворгүй байдал	2,61%	3
19	Авлигын эсрэг бүтцийн сул байдал/гажуудал	1,74%	2
20	Авлигын эсрэг боловсролын хомсдол	1,74%	2
21	Авлигын эсрэг үйл ажиллагааны сул байдал	1,74%	2
22	Гадны улс/байгууллагын нөлөө	1,74%	2
23	Гэмт бүлэглэлүүдийн нөлөө	1,74%	2
24	Авлига илүү далд хэлбэр рүү шилжсэн	0,87%	1
	Нийт	100%	115

БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЗАРЦУУЛЖ БУЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ

Бизнес эрхлэгчид үйл ажиллагааныхаа явцад өгч буй авлигын үнэлгээг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл тендерийн шалгаруулалтад ялахад, тусгай зөвшөөрөл авахад, төсөл хөтөлбөрт хамрагдахад илүү өндөр авлига өгдөг гэжээ.

Хүснэгт 9. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ (%)

		<5 хувь	6-10 хувь	11-15 хувь	16-20 хувь	21< хувь
1.	Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	6,1	25,8	16,7	19,7	13,6
2.	Тендерт шалгаруулалтад ялахад	4,5	21,2	18,2	21,2	21,2
3.	Зээл авахад	15,2	34,8	15,2	6,1	10,6
4.	Өр төлбөр барагдуулах, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэхэд	12,1	25,8	16,7	4,5	6,1
5.	Татвараас чөлөөлүүлэх, бууруулахад	9,1	21,2	18,2	9,1	13,6
6.	Хяналт шалгалтаар зөрчил дутагдалгүй гарахад	13,6	18,2	22,7	9,1	12,1
7.	Тусгай зөвшөөрөл авахад	4,5	15,2	19,7	16,7	25,8
8.	Бараа, ажил, үйлчилгээ хүлээлгэн өгөхөд	10,6	21,2	15,2	16,7	12,1
9.	Гадаадаас ажиллах хүч авахад	7,6	15,2	13,6	10,6	12,1

ХЭЭЛ ХАХУУЛЬД ЗАРЦУУЛСАН МӨНГӨНИЙ ХЭМЖЭЭ

Хээл хахуульд өгч буй мөнгөн дүнг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход, тусгай зөвшөөрөл авахад зэрэгт хамгийн их өгдөг гэж шинжээчид хариулжээ.

Хүснэгт 10. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ / зорилгоор/, сая төгрөгөөр.

		<1 сая	1-5 сая	5-10 сая	10-20 сая	20-50 сая	50 сая <
1	Ажил, албан тушаалд ороход	3,0	22,7	22,7	13,6	4,5	22,7
2	Тусгай зөвшөөрөл авахад	1,5	6,1	27,3	15,2	16,7	21,2
3	Ашиг сонирхолдоо нийцсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад	1,5	0,0	1,5	6,1	12,1	51,5
4	Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход	0,0	3,0	6,1	13,6	13,6	36,4
5	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход	0,0	15,2	12,1	13,6	16,7	16,7
6	Эрүүгийн хэрэг үүсгэхэд	0,0	9,1	12,1	18,2	9,1	12,1
7	Гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад	1,5	7,6	9,1	16,7	13,6	19,7
8	Хуурамч бичиг баримт үйлдэхэд	6,1	21,2	13,6	15,2	7,6	6,1

ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Авлигатай тэмцэх үйл ажиллагааны сэдэвтэй холбогдуулан шинжээчдээс хаалттай хэлбэрээр нийт 21 арга хэмжээний ач холбогдлын талаар асууж үнэлүүлсэн юм. Өгсөн ач холбогдлоор нь эрэмбэлэхэд дараах дүр зураг харагдаж байна.

График 18. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ.



3. ШИНЖЭЭЧДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

График 19. Шинжээчдийн хүйс.



График 20. Шинжээчдийн нас.




График 21. Шинжээчдийн салбарын харьяалал.



ДҮГНЭЛТ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа 2018 онд анх удаагаа тусдаа хийгдэж, үр дүн нь 3.68 баллын үзүүлэлттэй гарлаа. Өмнөх авлигын төсөөллийн судалгаанууд улс төрийн болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээг хамруулсан нэгтгэсэн дүнг гаргадаг байсан тул ямар нэгэн өөрчлөлтийн талаарх дүгнэлтийг хийх боломжгүй юм. Гагцхүү баримжаалах зориулалтаар харьцуулбал 2017 оны улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын нэгтгэсэн үзүүлэлт 3.97 гарч байсан бол ижил аргачлалаар хийгдсэн 2018 оны улс төрийн хүрээний авлигын төсөөллийн судалгааны дүн 3.93 гарсан юм.

Тайлангийн эхэнд дурдагдсанаар тус судалгаа хийгдэж ирсэн өнгөрсөн 11 жилийн үзүүлэлтийг харьцуулан харахад авлигын төсөөллийн индексийн (улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын нэгтгэсэн) дундаж 3.87 байгаа ба 2008-2012 онуудад 4 орчим балл байж, 2013-2016 онуудад 3.58-3.68 хүртэл бууж, 2017 онд 3.97 хүртэл өссөн бол 2018 оны улс төрийн авлигын төсөөллийн индекс 3.93 гарсан. Тусгаарлан харгалзаж болох зарим үзүүлэлт дээр суурилан нэгтгэсэн дүнгийн хүрээнд шүүх, хууль хяналтын байгууллагын үзүүлэлт арай багаар үнэлэгдэж байсан гэж таамаглаж болно.

Энэ оны судалгааны хүрээнд анх удаагаа чанарын судалгааны хэлбэрийг нэмэлтээр ашигласан. Тоон судалгааны дүнтэй харьцуулахад дэлгэрэнгүй ярилцлагын хүрээнд оролцогчид илүү сөрөг үнэлгээг илэрхийлэх хандлага ажиглагдсан ба энэ нь экспертийн түвшний оролцогчид эргэлзээтэй зүйлийг бага түвшинд үнэлэх эсвэл мэдэхгүй гэж хариулах хандлагаар тайлбарлагдана.

Шинжээчдийн давамгайлсан байр суурийг илэрхийлэхэд Монголын нийгэмд авлига бүх түвшин, нийгмийн амьдралын бараг бүх хүрээнд нэвтэрч өдөр тутмын, хэвийн мэт үзэгдэл болсон. Авлига зөвхөн хэмжээ, хэлбэрээрээ ялгагдана. Авлигыг хүссэн хүсээгүй хүлээн зөвшөөрсөн, өөрөөр хэлбэл дөжирсөн, бүх нийтийн уур амьсгал нь шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд ч дэлгэрэх ерөнхий фон болдог.

Шинжээчдийн үзэж буйгаар улс төрийн хүрээ авлигад хамгийн их идэгдсэн нийгмийн хүрээ бол шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээ ч нэг их ялгаагүй хоёр дугаарт байрлаж байна. Ингэхдээ шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига улс төртэй нягт холбоотой, төрөл бүрийн ашиг сонирхлоор сүлбэлдсэн, харилцан хамаарал, нөлөөлөлтэй салшгүй нэг цогц болж байна.

Үндсэн сэдэл нь бусад тохиолдлын адил хөрөнгөжих гэсэн шунал ба энэ зорилго нь нийгмийн баялгийг хууль бусаар дахин хуваариласнаар хэрэгжинэ. Нийгмийн баялгийг дахин хуваарилахын тулд улс төрийн эрх мэдэл хэрэгтэй бол улс төрийн эрх мэдэлд шүүх, хууль хянах эрх мэдэл хэрэгтэй. Улс төрийн эрх мэдлийн дээд түвшин бол засгийн эрх. Улс төрийн эрх мэдэлд хүрэх нь улс төрийн намаар дамжин өөрөө авлигын замаар явагдана. Улс төрийн нам бол авлигыг хэрэгжүүлэх үндсэн субъект.

Ингэхэд улс төрийн нам доторх эрх мэдлийн төлөө тэмцэл → нам → сонгууль → төр → эрх мэдэл → томилгоо гэсэн бүдүүвч тодорч харагдана.

Төрийн эрх мэдлийг авснаар авлигын замаар улс төрийн, албан тушаалын томилгоог явуулж, үүгээрээ цаашдын авлигын нөхцөл боломжийг бүрэлдүүлнэ. Энэ бүх процессын шат бүрт шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига зохих үүргээ гүйцэтгэнэ.

Томилгоо бол улс төрийн авлигын үндсэн хэлбэр. Засгийн эрх мэдэлд хүрсэн хүчин шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнийн дээд түвшинд томилгоо хийж,

тэдгээр нь дараах шатандаа өөрсдийн томилгоог хийнэ.

Засаглалын хуваарилалт, төрийн зохион байгуулалт, олон нийтийн хяналтгүй байдал, мэдээллийн ил тод бус байдал болон хариуцлага тооцдоггүй байдал улс төрийн хүрээний адил шүүх, хууль хяналтын хүрээнд ч авлига бий болох боломжийг бүрэлдүүлж байгаа ба ингэхдээ улс төрийн нөлөөлөл гол үүрэг гүйцэтгэнэ.

Улс төрийн нөлөөллөөс гадна бүтцийн шалтгаан байгаа нь шүүх засаглалын жишээн дээр тод харагдана. Нэгдүгээрт, шүүх засаглалын дээд түвшний томилгоо улс төрийн нэг албан тушаалаас хэт хамааралтай болж, хоёрдугаарт, нэг байгууллага шүүгчдийг томилох, шүүхийн үйл ажиллагааг хариуцах, шүүгчидтэй хариуцлага тооцохыг хариуцаж байгаа нь авлига бараг зайлшгүй бий болох маш зохисгүй бүтэц болно. Түүнчлэн олон тохиолдолд хууль өөрөө тодорхой бус, хоёрдмол утгатай, цоорхойтой батлагддаг нь авлигын зорилгоор тайлбарлан шийдвэр гаргах боломжийг олгодог.

Цаашлан дэд салбар хоорондын зааг алдагдсан. Энэ нь цагдаагийн албан тушаалтнуудыг прокурор болон бусад дэд салбар руу томилох болсон нь тогтолцоо гажуудахад шууд нөлөөлсөн.

Улс төрийн нөлөөнөөс гадна ил тод бус байдал ялангуяа тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлдөг. Тус байгууллагын мөрдөх хэргүүдийг өргөнөөр нууцын зэрэглэлд оруулдаг нь улс төрийн хэрэг үүсгэх зэрэг авлигын боломжийг олгодог.

Энэ хоёр хүчин зүйл (улс төрийн нөлөө болон ил тод бус байдал) авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаан дээр мөн харагддаг. Үйл ажиллагаа, төсөв зэрэг нь тодорхой бусаас гадна тогтмол олон нийтэд чиглэсэн, шүүхээс өмнө ялласан шинж, агуулга бүхий мэдэгдэл хийдэг нь улс төрийн захиалга хэрэгжүүлэгч байгууллага гэсэн хардлагыг төрүүлдэг.

Энэ хүрээний авлигын үндсэн загвар нь *улс төр-шүүх*, *хууль хяналт* хэдий ч дотроо улс төрөөс үл хамаарсан, бие даасан авлигын хэлхээ холбоо, хэлбэрүүд бий.

Түүнчлэн энэ салбар танил талын цар хүрээ, хэлхээ холбоо их өндөр салбарт тооцогддог. Энэ салбарын мэргэжилтнүүд үндсэндээ хоёрхон сургууль дээр бэлтгэгддэг нь үүний гол шалтгаан бөгөөд нэг ангийн, нэг, дээд доод төгсөлтийн, нэг сургуулийн гэсэн зарчмаар хоорондын танил талын харилцаа үүсгэн ажил хэргийн, цаашлан авлигын нөхцөл боломжийг бий болгоход нөлөөлдөг. Энэ салбарт үндсэндээ мэргэжил нэгтний, нэг сургуулийнхны, багш-шавийн, намын, нэг нутгийн, мөнгөний гэсэн ашиг сонирхлын хэлхээ харилцаа, нөлөөлөл үйлчилдэг бололтой.

Эрх зүйн салбар дахь авлигын үзэгдэлд төрийн байгуулагаас гадна өмгөөлөгчийн институт чухал орон зайтай хийгээд голчлон зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг болно.

Шүүх, хууль хяналтын хүрээн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааны хувьд өмнө дурдагдсан хүчин зүйлсийг арилгах буюу юун түрүүнд улс төрийн нөлөнөөс ангижруулах, албан тушаалын томилгоог гагцхүү мэргэжлийн шалгуураар хийдэг болгох, үйл ажиллагааг ил тод болгох, хариуцлагын үр дүнтэй тогтолцоотой болоход оршино. Харин энэ бүхнийг бодит байдал хэрхэн хэрэгжүүлэх нь төдийлөн тодорхой бус байна.

**АВЛИГЫН ТАЛААРХ ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН
ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫГ
ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА-2018**



АВЛИГЫН ТАЛААРХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ 2018 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Үндэслэл

Монгол улс нь авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх зорилго бүхий Авлигын эсрэг бие даасан байгууллага, дагаж мөрдөх хуультай, олон улсын холбогдох тайлан, судалгаанууд хийгддэг, авлигын эсрэг тодорхой үйл ажиллагааг тогтмол явуулдаг орон юм. Авлигын төсөөллийн индекс, авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа, төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ гэх мэт авлигын нөлөөлөл, түвшинг тодорхойлох судалгаанууд тогтмол хийгддэг боловч олон нийт тэр дундаа нийгмийн эмзэг бүлгийн дунд авлигын асуудал, төрөл, шалтгаан, нөлөөлөл гэх мэтийг нарийвчлан авч үзсэн судалгааг хийж байгаагүй, энэ талаарх мэдээлэл хязгаарлагдмал байна. Олон улсын судалгаануудад дурдагсанаар нийгмийн эмзэг бүлэг болох хөгжлийн бэрхшээлтэй, хүүхэд, эмэгтэйчүүд, настай хүмүүс нь төрийн үйлчилгээг хамгийн их авдаг, шударга бус байдалтай нүүр тулдаг, хүний эрх хамгийн их зөрчигдөх эрсдэл бүхий бүлэг бөгөөд шударга бус байдалтай тулгарсан ч тэмцэх чадвар хамгийн бага байдаг байна. Авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх үйл ажиллагаанд нийгмийн эмзэг бүлгийн мэдээллийг тусгайлан авч үзэх, судалгаа хийх зайлшгүй шаардлагатай юм.

1.2. Зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, тэдний амьдралд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлоход оршино. Судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, тэдэн үзүүлж буй үр нөлөөг дараах чиглэлийн хүрээнд авч үзсэн. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлага
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг авлигын асуудал, шалтгаан, нөлөө

1.3. Судалгааны арга, аргачлал

Судалгааны мэдээллийг тоон болон чанарын аргаар дараах байдлаар цуглуулна. Үүнд: *Асуулга судалгаагаар* хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс авлигын талаарх ерөнхий мэдээллийг ярилцлагын аргаар авсан. Судалгааны мэдээллийг 2018 оны 5 сарын 8-аас 6 сарын 30-ны хооронд гүйцэтгэсэн ба мэдээлэл боловсруулалтыг SPSS 21.0 программ ашиглан гүйцэтгэсэн. *Чанарын судалгаагаар* хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнтэй ярилцаж нарийвчилсан мэдээлэл авсан.

1.4. Судалгааны хамрах хүрээ, түүвэр

Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик тоон мэдээгээр нийслэл хотод нийт 13104 хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьдарч байна. Уг судалгаанд 18 наснаас дээш иргэдийг хамруулсан бөгөөд судалгааны түүвэрлэлтийн алдааны хязгаар ± 5 бөгөөд 95%-ийн итгэх магадлалтайгаар түүврийн хэмжээг 373


гэж тооцоолсон. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ойролцоогоор 80% нь 18 наснаас дээш хүмүүс байдаг гэсэн тоон мэдээллийг үндэслэн судалгаанд 300 иргэн хамрагдсан ба оюуны бэрхшээлтэй иргэдээс бусад иргэдийг хамруулсан.

БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. Ерөнхий мэдээлэл


Энэхүү судалгаанд Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан. Оюуны бэрхшээлээс бусад төрлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан ба нийт оролцогчдын 35% нь сонсголын бэрхшээлтэй, 14% нь харааны бэрхшээлтэй, 17% нь хэл ярианы бэрхшээлтэй, 34% нь хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд байна.

График 1. Судалгаанд оролцогчдын хөгжлийн бэрхшээлийн төрөл




Судалгаанд оролцогчдын насны хувьд 18-аас дээш настай иргэдийг хамруулсан ба насны ангиллыг доорх хүснэгтэд харуулав.

График 2. Судалгаанд оролцогчдын насны бүлэг




Оролцогчдын боловсролын түвшний хувьд 12% нь боловсролгүй, 13% нь бага, 27% нь бүрэн бус дунд, 19% нь бүрэн дунд, 123% тусгай дунд буюу техник мэргэжлийн, 16% нь дээд боловсролтой иргэд байна.

График 3. Боловсролын түвшин



Ажил эрхлэлтийн хувьд ажилгүй, группт, тэтгэвэрт байгаа хүмүүс нийт судалгаанд оролцогчдын 70%-ийг эзэлж байгаа бол ажилтай хүмүүсийн дийлэнх нь хувиараа бизнес эрхлэгч болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагад ажилладаг хүмүүс байна. Хөдөлмөр эрхэлж буй иргэдийн хувьд гэртээ хувиараа бизнес эрхэлж байгаа иргэд болон бариа, массажны газар ажилладаг хүмүүс их байсан.


График 4. Ажил эрхлэлт



Судалгаанд оролцогчдын ам бүлийн байдлын хувьд 10.7% нь 1-2 ам бүлтэй, 47.7% нь 3-4 ам бүлтэй, 41.6% нь 5-аас дээш ам бүлтэй иргэд байв.

Судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн орлогын хувьд 17.9% нь 240,000₮ буюу түүнээс бага орлоготой, 51.1% нь 240,001-500,000₮, 23.3% нь 500,001-1,000,000₮, 7.6% нь 1,000,001-1,500,000₮-ийн орлогтой байгаа ба энэхүү судалгаанд оролцсон иргэдээс 1,500,000₮-с дээш өрхийн орлоготой иргэн байхгүй байна.

График 5. Өрхийн орлого



Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг харахад түүврийн хэмжээ болон бүтэц нь Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөхүйц хэмжээнд байна гэж үзэж байна.


2.2. Авлигын талаарх ойлголт, хандлага

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 77.5% нь авлига манай улсад нийтлэг үзэгдэл болсон гэж үзсэн ба 66.4% нь авлигыг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн байна.

График 6. Авлигын талаарх ойлголт




Авлигад хандах хандлага нь судалгаанд оролцогчдын эзэмшсэн боловсролтой хэрхэн хамаарч байгааг авч үзэн харьцуулахад боловсролын түвшингээс үл хамааран авлига байхыг эсэргүүцэж, дийлэнх нь санал нийлэхгүй гэж үзэж байна.



Авлигад хандах иргэдийн хандлагыг авч үзэхэд хүнд суртлыг шийдвэрлэх арга зам бол авлига өгөх явдал юм гэсэн үзэлтэй 21.4% нь санал нийлж байгаа бол 66.6% нь санал нийлэхгүй, 16% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Харин авлига шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг гэсэн үзэлтэй 28.6% нь санал нийлж, 48.1% нь санал нийлэхгүй гэсэн ба 23.3% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Үүнээс харахад судалгаанд оролцогчид авлигыг хүлээн зөвшөөрөхгүй, санал нийлэхгүй гэсэн боловч авлигад тустай тал байдаг гэж эргэлзэх, эерэг хандлага үзүүлэх хандлагатай иргэд багагүй байна. Хэдийгээр авлигын эсрэг үзэл бодолтой, ямар нэгэн хэмжээгээр байхыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа боловч авлигад ашигтай тал байгаа гэж үзсэн хүмүүс судалгаанд оролцогчдын тал орчим хувийг эзэлсэн байна.

График 7. Авлигын эсрэг байр суурь




Авлигаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хохирдог гэсэн байр суурьтай 40.8% нь санал нийлж, 30.6% нь нийлэхгүй, 28.6% нь мэдэхгүй гэж хариулсан байгаагаас судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд авлига, түүнийг тойрсон асуудалтай хамаарал багатай нь харагдаж байна.

График 8. Авлигаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хохирдог



Мөн авлигыг багасгахад иргэд өөрсдөө хариуцлагатай байх ёстой гэсэн байр суурийг 66.8% нь дэмжиж, 16.4% нь дэмжихгүй, 16.8% нь мэдэхгүй гэж хариулсан байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд авлигын эсрэг тэмцэх ойлголттой байгааг харуулж байна.

График 9. Авлигыг багасгахад иргэд өөрсдөө илүү хариуцлагатай байх ёстой.




Судалгаанд оролцогчдоор төрийн байгууллагуудын авлигын түвшинг үнэлүүлсэн бөгөөд гааль, шүүхийн байгууллагыг авилгад хамгийн их өртсөн гэж үзсэн байна. Судалгаанд оролцогчдын 5-6% нь цагдаа, татвар, халамж үйлчилгээний байгууллагуудыг мэдэхгүй гэж хариулсан байна.

График 10. Байгууллагуудын авлигад өртсөн байдалд өгсөн үнэлгээ




Авлигын чиг хандлагын талаарх асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 59% нь сүүлийн жилүүдэд авлигын түвшин өссөн гэж үзсэн байна.

График 11. Таны бодлоор сүүлийн жилүүдэд авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?



Авлигатай тэмцэхийн тулд авбал зохих арга хэмжээнүүдээс төрийн байгууллагын үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, шийтгэл арга хэмжээг хатуу болгох, шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй ил тод болгох гэсэн хариултууд хамгийн их хувийг эзэлсэн.

Диаграм 1. Авлигатай тэмцэхийн тулд юу хийх ёстой вэ?




Товч дүгнэхэд иргэд авлига манай улсад нийтлэг үзэгдэл болсон бөгөөд үүнийг багасгахад иргэд өөрсдөө хариуцлагатай хандах нь зүйтэй гэж үзэж байна. Авлига нь гааль, шүүх, боловсрол, татвар, бүх шатны засаг захиргааны байгууллагуудад хамгийн түгээмэл байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд энэ үзэгдлийн тохиолдол өссөн гэж үзжээ. Мөн судалгаанд оролцогч 5 хүн тутмын нэг нь авлига бол хууль дүрэм журмыг тойрч гарах арга хэрэгсэл, хүнд суртлыг шийдвэрлэх арга зам гэж үзсэн бөгөөд үүнээс болж хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хохирч байна гэж хариулсан байна. Энэ үзэгдлийг бууруулахын тулд төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, авлига авсан тохиолдолд авах арга хэмжээ, шийтгэл нь хатуу байх ёстой гэж үзэж байна.

2.3. Авлига хувь хүнд


Хувь хүний авлигатай холбоотой туршлага, авлига өгөх эсэх хандлагыг авч үзэхэд судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх нь авлигын эсрэг хандлагатай байна. Өөрт болон гэр бүлийн хэн нэгэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхийн тулд авлига өгөх эсэх хандлагыг харахад 15.3% нь авлига өгнө гэж хариулсан бол 84.7% нь авлига өгөхгүй гэж хариулсан.

График 12. Та өөрт болон гэр бүлд тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд авлига өгөх үү?



Харин сүүлийн 12 сарын хугацаанд судалгаанд оролцогч өөрөө болон гэр бүлийн гишүүн нь ямар нэгэн хэлбэрээр авлига, хээл хахууль өгсөн эсэхэд 15.6% нь өгсөн, 34.4% нь өгөөгүй, 27.1% нь мэдэхгүй гэж хариулсан бол 22.9% нь хариулахаас татгалзсан юм.

График 13. Сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд ямар нэгэн хэлбэрээр хээл хахууль өгсөн үү?



Сүүлийн 12 сарын хугацаанд авлига өгсөн гэж хариулсан оролцогчид бүгд 1 удаа өгсөн байна. Авлига өгсөн оролцогчдын хувьд нийгмийн халамж хүртэх, боловсрол эзэмших ба эзэмшүүлэх, төрийн албанд ажилд орох, хувийн хэвшилд ажилд орох, төсөл хөтөлбөрт хамрагдах гэсэн шалтгаанаар өгсөн байна. Хамгийн олон буюу боловсрол эзэмших ба эзэмшүүлэх зорилгоор 48% нь, төсөл хөтөлбөрт хамрагдах зорилгоор 41% нь өгсөн байна.

Диаграм 2. Авлига өгсөн зорилго



Ярилцлагын үеэр боловсролын салбар, улсын сургууль, цэцэрлэгийн байгууллагууд хамгийн их авлигад өртсөн гэв. Баян чинээлэг хүмүүс хувийн сургууль, цэцэрлэгт хүүхдээ явуулахаар тэр асуудлыг сайн мэдрэхгүй, улсын сургууль, цэцэрлэгт хүүхдээ өгдөг хүмүүс л үүнийг ойлгоно хэмээн тайлбарлав.

- Хүүхдээ харьяа дүүргийн цэцэрлэгт өгөхийн тулд 650,000₮ өгч оруулсан.
- Хүүхдээ таатай байлгах гэж багшид нь бэлэн, нэгж хэд хэдэн удаа өгсөн


Иргэн Д, хорт хавдрын улмаас ХБИ болсон

- Хотын төвийн 10 жилийн сургуульд хүүхэд оруулах гээд асуулгахад 1 сая төгрөг гэсэн. Боломжгүй тул харьяаллын гэр хорооллын сургуульд оруулсан.

Харааны бэрхшээлтэй иргэн

Яагаад авлига өгөх болсон шалтгааны хувьд авлига авахыг нэхэмжилсэн, дүрэм журмын шат дамжлагыг хурдасгахын тулд, хүртэх ёстой үйлчилгээ авахын тулд гэсэн тохиолдлоор өгсөн байна. Үүнээс авлига авахыг нэхэмжилсэн тохиолдолд орсон гэсэн хариулт талаас илүү хувийг эзэлж байна.

График 14. Авлига өгсөн шалтгаан



Сүүлийн 12 сарын хугацаанд авлига өгсөн хүмүүс бүгд авлига өгөхийг шаардсан учир өгсөн гэж хариулсан, асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд өөрийн хүсэлтээр өгсөн гэсэн хүн байхгүй байв. Үүнээс 61% нь авлига өгөхийг шууд шаардсан, 39% нь бага цалин, удаан хүлээх, олон шат дамжлага явахыг шийдвэрлэх боломжийн талаар

ярих буюу шууд бусаар ойлгуулсан байна. Эдгээр авлига өгсөн хүмүүсийн 54% нь багшид, 46% төрийн захиргааны албан хаагчид өгсөн байна. Албан тушаалын хувьд 92.7% нь дунд шатны буюу мэргэжилтэнд, 7.3% нь удирдах шатны албан тушаалтанд өгчээ.

Ярилцлагын үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн харилцаанд орох боломж нь хязгаарлагдмал байдагтай холбоотойгоор бусад байгууллагуудтай харилцах нь ховор, ихэвчлэн хороо, дүүргийн шатны байгууллагуудтай, мөн хүүхдээ сургууль, цэцэрлэгт оруулах зорилгоор боловсролын байгууллагуудтай түлхүү харилцдаг нь ажиглагдсан. Дээр дурдсан авлига өгсөн зорилго, шалтгаан болон өгсөн хүмүүсээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд гол харилцдаг байгууллагууд нь шууд болон шууд бус ямар нэг хэлбэрээр авлига өгөхийг шаарддаг тохиолдол цөөнгүй болох нь харагдаж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төрийн үйлчилгээг авахын тулд заавал авлига өгөх шаардлага байхгүй ч шат дамжлага, хүнд суртал ихтэй гэдгийг ярилцлагад хамрагдсан иргэн хэлж байлаа.

- *Хувийн байгууллагад ажиллаж байгаа тул группт хамрагдаагүй. Цалин авч байгаа тохиолдолд болохгүй гэсэн. ...Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлдэг үйлчилгээг авах боломжгүй. Хамрагдахын тулд бүрдүүлэх бичиг баримт, шаардлага нь тодорхой заасан тул авлига өгөх боломж байхгүй. Хөгжлийн бэрхшээлийг нотлох бичиг баримтгүй бол өөрөө харааны бэрхшээлтэй гэж мянга хэлээд нэмэргүй*
Харааны бэрхшээлтэй иргэн

Авлигад зарцуулсан мөнгөн дүнгийн хувьд бүгд 500,000₮ хүртэлх мөнгө зарцуулжээ. Үүний дийлэнх нь буюу 86% нь бэлэн мөнгөөр, үлдсэн хэсэг нь материаллаг зүйлээр өгсөн байна. Авилгыг гүйцэтгэх замын хувьд 51% нь танил талаараа дамжуулан өгсөн бол 49% нь өөрийн биеэр өгсөн гэжээ. Авлига өгсөн иргэдийг өрхийн орлогоор авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Авлига өгсөн зорилго өрхийн орлогоор


	240,000₮ хүртэл	240,000- 500,000	500,00-1- 1,000,000	1,000,001- 1,500,000
Боловсрол эзэмших ба эзэмшүүлэх	7%	41%		
Төсөл хөтөлбөрт хамрагдах	4%	17%	12%	7%
Төрийн албанд ажилд орох				7%
Хувшийн хэвшилд ажилд орох		10%		
Нийгмийн халамж хүртэх	7%			

Авлига өгч байсан иргэдийн дийлэнх нь 240,000-500,000₮-ийн өрхийн орлоготой байна. Эдгээр хүмүүсийн авлигад зарцуулсан мөнгө нь өрхийн төсөвт бага зэрэг нөлөөлсөн гэж 66%, дунд нөлөөлсөн гэж 34% нь хариулсан.

Судалгаанд оролцогчдоос хөгжлийн бэрхшээлтэй байдлаас шалтгаалан авлига өгч шийдвэрлэх асуудал тулгарч байсан эсэхийг асуухад 42% нь тийм гэж хариулсан. Харин эдгээр хүмүүст тулгарсан асуудлыг нээлттэй асуухад ялгаварлал их, хүнд суртал их, ажилд орох хэцүү, эмнэлэгт үйлчлүүлэхэд хэцүү байдаг гэх мэт дараах хариултуудыг өгсөн. Үүнээс зарим нь авлигатай холбоогүй боловч хөгжлийн

бэрхшээлтэй иргэд өөрсдийн тулгамддаг асуудлаа бичсэн байна. Ярилцлагын үед ажиглагдсан болон анкетийн хариултад олон дахин давтагдсан асуудал нь манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах тогтолцоо нь муу байдаг. Тиймээс иргэдэд гэрээсээ гараад нийгмийн харилцаанд орж, асуудал шийдвэрлэхэд учрах авилга хамгийн их тулгамдаж буй асуудал биш, гол бэрхшээл дөнгөж гэрээс гараад л эхэлдэг гэж байлаа. Зориулалтын зам талбай байхгүй, хараагүй хүмүүс замаар, гарцаар гарахад хүндрэлтэй, нийтийн тээвэр, автобусаар зорчих гэх мэт жирийн хүмүүсийн хувьд энгийн өдөр тутмын хэмнэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэцүү, тулгамдсан асуудал болдог. Түүнээс цаашлаад эмнэлэг, сургууль, төрийн захиргааны байгууллага хаа ч очсон үйлчилгээ авахад хүндрэлтэй байдаг гэв.

График 15. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч байсан асуудал



Сүүлийн 1 жилийн хугацаанд авлига өгсөн эсэх болон ирээдүйд өгөх эсэх хандлагыг харьцуулан харвал авлига өгч байсан иргэдийн 26.8% нь дахин авлига өгөх хандлагатай, авлига өгч байгаагүй иргэдийн 23.3% нь ирээдүйд авлига өгнө гэж хариулсан бол сүүлийн жил өгсөн эсэхийг мэдэхгүй болон хариулахаас татгалзсан иргэдийн 12.3% нь ирээдүйд авлига өгөх хандлагатай байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 57% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдсан, 43% нь хамрагдаагүй байна. Сүүлийн 12 сарын хугацаанд авлига өгсөн иргэдийн тоотой харьцуулж үзвэл нийт авлига өгсөн иргэдийн 71% нь халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдсан, 29% нь хамрагдаагүй байна.

Нийгмийн халамж, хамгааллын ямар үйлчилгээнд хамрагдахад авлига өгөх шаардлага тулгарч байсныг тодруулахад бүх үйлчилгээн дээр ямар нэг байдлаар авлига өгөх шаардлагатай болж байсан нь харагдлаа. Хамгийн олон буюу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдахад 35%, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахад гэж 32% нь хариулсан.

График 16. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд авлига өгч хамрагдаж байсан нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ



Судалгаанд оролцогчдын 74% нь авлигын эсрэг мэдээлэл өгдөггүй, 18% нь заримдаа мэдээллэдэг, 8% нь үргэлж мэдээллэдэг гэж хариулсан байгаагаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд авлигыг мэдээлэх эрмэлзэлгүй байна.


График 17. Авлигын эсрэг мэдээлэх эрмэлзэл



Үүний шалтгааныг харвал 32% нь мэдээлэл өгсөн ч үр дүнгүй байдаг, 30% нь хаана хандахаа мэддэггүй, 18% нь мэдээллийн нууцлал алдагдхаас эмээдэг гэж, үлдсэн 20% нь эдгээрээс бусад шалтгаанаар гэж хариулсан байна.

Авлигын талаарх мэдээллийн эх сурвалжийн хувьд хамгийн олон буюу 46% нь телевизээс, 20% нь ам дамжсан ярианаас авдаг байна.

График 18. Авлигын талаарх мэдээллийн эх сурвалж



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын тохиолдлын хувийн туршлага харьцангуй өндөр буюу авлига өгөөгүй гэж хариулсан 34.4% байна. Хэдийгээр авлига өгөхийг эсэргүүцэж байгаа ба иргэдийн идэвх оролцоо авлигыг бууруулахад чухал нөлөөтэй гэж үзэж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй иргэд ирээдүйд авлига өгөх, авлигад өртөх эрсдэлтэй байна. Хувийн тохиолдлын ихэнх хувийг төрөөс үзүүлж буй нийгмийн халамж хамгааллын үйлчилгээнд хамрагдах, боловсрол сургалтын байгууллагад элсэх болон суралцах тохиолдол эзэлж байна.

ДҮГНЭЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт төсөөллийг тодорхойлох, авлига тэдний амьдрал, үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг тодруулах зорилготойгоор Нийслэл хотын төвийн 6 дүүргийн 300 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд явуулсан судалгааны үр дүнг харуулж байна. Судалгааны үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд авлигын талаар тодорхой ойлголттой бөгөөд төрийн үйлчилгээ хүлээн авах, сургууль цэцэрлэгт үр хүүхдээ хамруулах зэрэг нийгмийн харилцааны явцад авлигад өртдөг, өртөх эрсдэлтэй тулгардаг байна. Тодруулбал,

- Иргэд авлига байхыг хүлээн зөвшөөрөхгүй гэж хариулж байгаа хэдий ч үүнийг хүнд суртал, шударга бус дүрэм журмыг тойрч гардаг нийтлэг үзэгдэл гэж ойлгож, авлигыг мэдээлэх эрмэлзэлгүй байгаа ба авлигыг өөрт тулаад ирэхэд эсэргүүцэх, татгалзах, үүний эсрэг арга хэмжээ авахгүйгээр өртөх эрсдэлтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд хамгийн их ордог газрууддаа буюу төрийн үйлчилгээнд хамрагдах, сургууль, цэцэрлэгт сурах, сургах зорилгоор авлигад өртөж байна.
- Авлигын тохиолдлын мөнгөн дүн 500,000₮ хүртэл байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд идэвхтэй ордоггүй, ихэвчлэн хороо, дүүргийн хэмжээнд харилцдаг тул авлига өгөх шаардлага гарвал төрийн захиргааны албан хаагчдад болон сургууль, цэцэрлэгт л өгдөг гэсэн ярилцлагын судалгаагаар гарсан үр дүн нь асуулга судалгаагаар батлагдсан. Үүний дээр эмнэлэг, нийгмийн халамж үйлчилгээний хэсэгт авлигын эрсдэл байгааг анхаарах нь зүйтэй байна.
- Сургууль, цэцэрлэг болон төрийн үйлчилгээнд хамрагдахад авлига, хээл хахууль өгөхийг нэхэмжилж байна. Судалгаанд оролцогчдын хувьд авлигын бүх тохиолдолд цаанаас нэхэмжилж, шаардсан байгаа ба энэ нь зөвхөн боловсролын байгууллага болон төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд байгаас харахад иргэд авах ёстой үйлчилгээгээ шууд авч чадахгүй авлига, хээл хахуульд өртөж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- ❖ *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох энэхүү суурь судалгааны хүрээнд гарсан дээрх дүгнэлтээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигад өртөж байгаа шалтгаан, тохиолдлуудыг нарийвчлан судлах.*

Суурь судалгаагаар иргэдийн хандлага, авлигад өртөх тохиолдлын талаар ерөнхий мэдээллүүдийг авсан ба үүнд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэрхшээлийн төрөл бүрээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх халамж, үйлчилгээний төрөл бүрээр гэх мэт кейс бүрээр дэлгэрэнгүй судалгаа хийх хэрэгцээ, шаардлага байна.

- ❖ *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн үйлчилгээ авдаг гол салбар, байгууллагуудад хяналт, шалгалтыг сайжруулах арга хэмжээ авч иргэдэд хүнд суртал байгаа эсэхийг илрүүлэх, багасгах*

Үүнд нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүний хүүхэд эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдах боломж нь хуульд заасны дагуу хөнгөлөлттэй байж чадаж байгаа эсэх, эмчилгээ, сувилгааны хөнгөлөлт үйлчилгээг хуулийн дагуу хүнд үзүүлж байгаа эсэх гэх мэт иргэдээс өөрсдөөс нь судалгаа авахаас гадна төрийн байгууллагууд дээр шалгалт, судалгаа хийж авлигад оролцогч тал бүрийг хамруулах

- ❖ *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд авлигын эсрэг мэдээлэл өгөх суваг, боломжийг таниулах, сурталчлах, тэдний авлигын эсрэг оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах*

Судалгаанд оролцогчдын хувьд хэрхэн мэдээлэхийг мэдэхгүй болон мэдээлсэн ч үр дүн гарахгүй гэсэн бодолтой байгаа нь тэдний авлигын эсрэг арга хэмжээний талаар ойлголт бага байгааг харуулж байгаа тул хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн ухуулан, сурталчлах, таниулах арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ. СУДАЛГААНЫ АСУУЛГА**АВЛИГЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ
СУДАЛГАА**

Улаанбаатар хотод амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох зорилгоор “Хэрэглээний боловсрол судлалын хүрээлэн” ТББ-аас энэхүү судалгааг явуулж байна. Бид иргэдийн амьдралд тохиолдож буй авлигын талаарх туршлага, санал бодлыг судлах болно.

Таны мэдээллийг зөвхөн судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах бөгөөд Монгол улсын “Хувь хүний нууцын тухай” хуулийн дагуу таны хариултыг мэдээллийн нууцыг чандлан хадгалах болно.

I. ТОДОРХОЙЛОХ ХЭСЭГ	
Асуулгын дугаар	
Судалгаа авсан огноо /YYYY/MM/DD/	
Судлаачийн код	
Респондентийн гар утас	

II. АВЛИГЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА						
1. Та дараах байр суурьтай санал нийлж байна уу?						
	Санал нийлж байна	Бага зэрэг нийлж байна	Төдийлөн нийлэхгүй байна	Огт санал нийлэхгүй байна	Мэдэхгүй	
1.1. Авлига манай улсад нийтлэг үзэгдэл болсон.	1	2	3	4	9	
1.2. Авлига тодорхой хэмжээнд байхыг хүлээн зөвшөөрнө.	1	2	3	4	9	
1.3. Хүнд суртлыг шийдвэрлэх арга зам нь авлига өгөх явдал юм.	1	2	3	4	9	
1.4. Авлига шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг.	1	2	3	4	9	
1.5. Авлигаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хохирдог.	1	2	3	4	9	
1.6. Авлигыг багасгахад иргэд өөрсдөө илүү хариуцлагатай байх ёстой.	1	2	3	4	9	
2. Таны бодлоор дараах салбаруудаас аль нь авлигад илүү өртсөн бэ?						
Авлигад өртсөн байдал Салбар	Огт үгүй	Бага зэрэг	Тодорхой хэмжээг эр	Нэлээд хэмжээг эр	Маш их	Мэдэхгүй
2.1. Боловсрол	1	2	3	4	5	9
2.2. Гааль	1	2	3	4	5	9
2.3. Засаг, захиргаа	1	2	3	4	5	9
2.4. Татвар	1	2	3	4	5	9
2.5. Халамж, үйлчилгээ	1	2	3	4	5	9

2.6. Цагдаа	1	2	3	4	5	9
2.7. Шүүх	1	2	3	4	5	9
2.8. Эрүүл мэнд	1	2	3	4	5	9
3. Таны бодлоор сүүлийн жилүүдэд авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?	Буурсан				1	
	Өөрчлөгдөөгүй				2	
	Өссөн				3	
4. Авлигатай тэмцэхийн тулд юу хийх ёстой вэ? /1 сонголттой/	Авах арга хэмжээ, шийтгэлийг хатуу болгох				1	
	Төрийн албан хаагчдын цалин нэмэгдүүлэх				2	
	Шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй ил тод байлгах				3	
	4.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах				4	
	5.Олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх				5	
	6.Бусад				6	

III. АВЛИГАТАЙ ХОЛБООТОЙ ХУВИЙН ТУРШЛАГА

5. Та өөрт болон гэр бүлд тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд авлига өгөх үү?	1.Тийм				
	2.Үгүй				
6. Сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд ямар нэгэн хэлбэрээр хээл хахууль өгсөн үү?	1.Тийм		→Асуулт 16 руу шилжих		
	2.Үгүй				
	3.Мэдэхгүй				
	4.Хариулахаас татгалзсан				
7. Хэрэв тийм бол хэдэн удаа өгсөн бэ?	1.1				
	2.2-3				
	3.3-с дээш				
8. Хэрэв тийм бол ямар шалтгаанаар хэдэн төгрөг зарцуулсан бэ?					
	500,000 хүртэл	500,001-1,000,000	1,000,001-2,500,000	2,500,001-5,000,000	5,000,001 ба түүнээс дээш
8.1. Эрүүл мэндийн үйлчилгээ авах	1	2	3	4	5
8.2. Нийгмийн халамж хүртэх	1	2	3	4	5
8.3. Боловсрол эзэмших ба эзэмшүүлэх	1	2	3	4	5
8.4. Газар ашиглах, өмчлөх, эзэмших	1	2	3	4	5
8.5. Төрийн албанд ажилд орох	1	2	3	4	5
8.6. Хувийн хэвшил ажилд орох	1	2	3	4	5
8.7. Хууль бус үйлдэл, гэмт хэргээс зайлсхийх, нуун дарагдуулах	1	2	3	4	5
8.8. Зээл авах	1	2	3	4	5
8.9. Төсөл хөтөлбөрт хамрагдах	1	2	3	4	5
8.10. Зөвшөөрөл, лиценз авах	1	2	3	4	5
8.11. Татвараас зайлсхийх	1	2	3	4	5
8.12. Бусад	1	2	3	4	5

9. Хэрэв тийм бол та хэнд хахууль өгсөн бэ?	Эмч	1
	Багш	2
	Нийгмийн ажилтан	3
	Төрийн захиргааны албан хаагч	4
	Цагдаагийн ажилтан	5
	Татварын байцаагч	6
	Гаалийн байцаагч	7
	Шүүгч	8
	Прокурор	9
	Бусад	10
10. Таны болон танай гэр бүлийн бусдад өгсөн авлигын тохиолдол доорх нөхцлүүдийн алинд хамаарах вэ? /Олон сонголттой/	Авлига авахыг нэхэмжилсэн	1
	Дүрэм журмын шат дамжлагыг хурдасгахын тулд	2
	Өөрт гарах зардлыг багасгахын тулд	3
	Хүртэх ёстой үйлчилгээг авахын тулд	4
	Бусад /тодорхой бичнэ үү/	5
11. Та авлига өгөх шаардлагатай гэдгийг хэрхэн мэдсэн бэ?	Авлига өгөхийг шууд шаардсан, нэхэмжилсэн	1
	Авлига өгөхийг шууд бусаар ойлгуулсан /бага цалингийн тухай, удаан хүлээх, олон дамжлага явахыг шийдвэрлэх боломжийн талаар ярих гэх мэт/	2
	Өөрийн хүслээр ажлаа бүтээхийн тулд өгсөн	3
12. Та ямар шатны албан тушаалтанд авлига өгсөн бэ?	Удирдах	1
	Дунд шатны буюу мэргэжилтэн	2
	Дундаас доод	3
13. Та авлигыг ямар замаар гүйцэтгүүлдэг вэ?	Өөрөө	1
	Танил талаараа	2
14. Та авлигыг ямар хэлбэрээр өгсөн бэ?	Бэлэн мөнгө	1
	Материаллаг зүйл	2
	Бусад.....	3
15. Авлигад зарцуулсан мөнгөн дүн танай өрхийн төсөвт хэрхэн нөлөөлсөн бэ?	Огт нөлөөлөөгүй	1
	Бага зэрэг	2
	Дунд	3
	Их хэмжээгээр	4
16. Таны амьдралд хөгжлийн бэрхшээлээс болж ялгаварлагдан авлига, хээл хахуулиар шийдвэрлэх асуудал тулгарч байсан уу? /Хөгжлийн бэрхшээлтэй биш байсан бол авлига өгөх шаардлагагүй/	Тийм	1
	Үгүй /→Асуулт 18 руу шилжих/	2
17. Хэрэв тийм бол танд ямар асуудал тулгарч байсан бэ?		
.....		
.....		
18. Та хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдсан уу?	Тийм	1
	Үгүй	2

19. Танд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж, хамгааллын дараах үйлчилгээнүүдэд хамрагдахад авлига өгөхөөс өөр аргагүй бэрхшээл тулгарч байсан уу? /Олон сонголттой/	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж авах	1
	Нийгмийн халамжийн тэтгэвэр авах	2
	Нөхцөлт мөнгөн тэтгэмж авах	3
	Тусламж, хөнгөлөлт эдлэх	4
	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах	5
	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн	6
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдах	7
	Эрүүл хамрагдах мэндийн үйлчилгээнд	8
	Боловсрол, соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдах	9
20. Танд авлигын эсрэг мэдээлэл өгөх эрмэлзэл байдаг уу?	Үргэлж мэдээллэдэг → Асуулт 22 луу	1
	Заримдаа мэдээллэдэг	2
	Мэдээллэдэггүй	3
21. Яагаад мэдээллэдэггүй вэ?	Хаана хандахаа мэддэггүй	1
	Мэдээллийн нууцлал алдагдахаас эмээдэг	2
	Мэдээлэл өгсөн ч үр дүн гарч байгаагүй	3
	Бусад	4
22. Авлигын талаарх мэдээллийг та хаанаас авдаг вэ? /Хамгийн гол гэсэн 1 хариултыг сонгоно уу/	Ам дамжсан яриа	1
	Гэр бүл, найз нөхөд	2
	Өөрт тохиолдсон туршлага	3
	ТВ	4
	Сонин, хэвлэл	5
	Интернет, сошиал медиа	6
	Бусад	7

IV. ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ		
23. Таны нас		
24. Ам бүл		
25. Боловсролын түвшин	Боловсролгүй	1
	Бага	2
	Бүрэн бус дунд	3
	Бүрэн дунд	4
	МСҮТ/ТМС	5
	Дээд	6
26. Ажил эрхлэлт	Төрийн байгууллага	1
	Төрийн бус байгууллага	2
	Олон улсын байгууллага	3
	Хувийн хэвшил	4
	Хувиараа бизнес эрхлэгч	5
	Тэтгэвэрт	6
	Оюутан	7
	Ажилгүй	8
	Группт	9
	Бусад	10
27. Өрхийн орлого	240,000 хүртэл	1
	240,000-500,000	2
	500,001-1,000,000	3
	1,000,001-1,500,000	4
	1,500,001-2,000,000	5
	2,000,001-с дээш	6
28. Тохирох төрлийг сонгоно уу?	Сонсголын бэрхшээлтэй	1
	Харааны бэрхшээлтэй	2
	Хэл ярианы бэрхшээлтэй	3
	Хөдөлгөөний бэрхшээлтэй	4


ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2019

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2019 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН


БҮЛЭГ I. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүүхдийн шударга байдлын түвшин 2019 оны судалгаагаар 3.91 гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны дүнтэй нэг түвшинд байна (Зураг 1).

Зураг 1. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор




Зураг 2. Хүүхдийн шударга байдлын түвшин, аймаг, нийслэлээр




Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлын түвшин, аймаг, нийслэлээр, оноор

д/д		2016 он	2017 он	2018 он	2019 он
1	Архангай	3.89	3.95	3.79	3.88
2	Баян-Өлгий	3.74	3.98	3.72	3.61
3	Баянхонгор	4.17	4.04	3.99	3.95
4	Булган	3.67	3.95	3.98	3.88
5	Говь-Алтай	4.03	4.03	4.39	4.04
6	Говьсүмбэр	3.92	4.09	3.90	3.88
7	Дархан-Уул	4.04	4.02	4.11	3.93
8	Дорноговь	4.22	3.70	4.14	3.95
9	Дорнод	4.08	4.11	3.96	3.93
10	Дундговь	3.79	4.26	4.19	3.93
11	Завхан	4.03	4.04	4.21	3.97
12	Орхон	4.04	3.99	3.40	3.83
13	Өвөрхангай	4.16	3.72	4.06	3.91
14	Өмнөговь	4.21	3.97	3.39	4.03
15	Сүхбаатар	3.69	3.96	3.92	3.90
16	Сэлэнгэ	4.04	4.10	4.13	3.91
17	Төв	3.98	3.81	4.11	3.97
18	Увс	4.06	4.03	4.11	3.98
19	Ховд	4.10	4.00	3.97	3.94
20	Хөвсгөл	4.09	4.28	4.01	3.99
21	Хэнтий	4.17	4.24	3.89	3.94
22	Улаанбаатар	3.98	3.95	3.78	3.88


Зураг 3. Хүүхдийн шударга байдлын түвшин, баруун бүс




Зураг 4. Хүүхдийн шударга байдлын түвшин, хангайн бүс




Зураг 5. Хүүхдийн шударга байдлын түвшин, төвийн бүс



Зураг 6. Хүүхдийн шударга байдлын түвшин, зүүн бүс




Зураг 7. Нийслэлийн дүүргүүдийн хүүхдийн шударга байдлын 2019 оны түвшин




Хүснэгт 3. Хүүхдийн шударга байдлын түвшин

Дүүрэг	2017 он	2018 он	2019 он	Зөрүү
Багануур	4.04	3.88	3.82	-0.06
Багахангай	3.91	4.00	3.69	-0.32
Баянгол	3.84	3.96	3.83	-0.13
Баянзүрх	3.77	4.04	3.88	-0.16
Налайх	4.03	3.04	3.86	0.82
Сонгинохайрхан	3.93	3.87	3.83	-0.04
Сүхбаатар	4.09	3.60	4.08	0.47
Хан-Уул	3.86	3.92	4.06	0.14
Чингэлтэй	4.09	3.67	3.85	0.18


Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр



Зураг 9. Хүүхдийн шударга байдлын түвшин, суралцаж буй ангиар



Зураг 10. Хүүхдийн шударга байдлын түвшин, сургуулийн өмчийн хэлбэрээр



ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Зураг 11. Шударга байх талаар гэртээ ярилцдаг нь хүүхдийн шударга байдалд нөлөөлөх эсэх



Зураг 12. Хүүхдийг шударга хандсаных нь төлөө магтах явдал шударга байдалд нөлөөлөх эсэх



Зураг 13. Шударга бус зүйл хийснийх нь төлөө хүүхдийг зэмлэх нь тэдний шударга байдалд нөлөөлөх эсэх




Зураг 14. Хүүхдүүд шударга бус зүйл хийхэд эцэг, эхийн гаргадаг үйлдэл тэдний шударга байдалд нөлөөлөх эсэх




Зураг 15. Хүүхдийн шударга байдалд найз нөхөд нь нөлөөлөх эсэх




Зураг 16. Хүүхдүүд шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлөх эсэх




Зураг 17. Шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнд хандах хандлага ба хүүхдийн шударга байдлын түвшин



Зураг 18. Шударга ёсны талаар хичээл орох нь шударга байдалд нөлөөлөх эсэх




Зураг 19. Шударга бус асуудал тохиолдоход хүүхдийн үйлдэл



Зураг 20. Хүүхдүүдийн шударга ёсны талаарх мэдээлэл авах суваг ба хүүхдийн шударга байдлын түвшин



Зураг 21. Багшийн зүгээс шударга бус, зохисгүй зан гаргахад хүүхдүүд хэнд ханддаг вэ?



Зураг 22. Шударга бус үйлдлийг олон нийтэд мэдээлэх эсэх



БҮЛЭГ II. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүүхдийн шударга байдлын судалгааг “Транспэрэнси Интернэшнл Солонгос” байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, Солонгос, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулсан. Үүнээс хойш уг арга зүйн дагуу Хүүхдийн шударга байдлын судалгааг 9 дахь удаагаа зохион байгуулаад байна.

1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын түвшинг тогтоохдоо доорх 12 асуултад тухайн хүүхэд санал нийлж байгаа эсэхийг нь асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үнэлгээний арифметик дунджаар гаргав. Хүүхдийн шударга байдлын түвшин нь хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих үзэл гэсэн дэд үзүүлэлтээс бүрддэг. Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хүснэгт 4. Хүүхдийн шударга байдлыг үнэлэхэд ашигласан асуулт

Асуултын дугаар	Асуулт
1.	Дотнын найз минь шалгалт өгч байхдаа бусдаас хуулж байвал би “найз минь юм чинь за яахав дээ” гэж бодно.
2.	Улс төрчид, дарга нарын үйлдэл хууль бус байсан ч тэр нь надад ашигтай байвал хүлээн зөвшөөрнө.
3.	Хүүхдүүд интернетэд байгаа бусдын бүтээлээс хуулбарлаж гэрийн даалгавараа хийхдээ эх сурвалжийг нь заавал дурдах албагүй.
4.	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь байж болох зүйл.
5.	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.
6.	Баян байх нь шударга байхаас илүү чухал.
7.	Төрийн албан хаагч төрийн үйлчилгээ үзүүлснийхээ төлөө шан харамж авч болно.
8.	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь миний сайн найз байсан ч би өөрийн итгэдэг багш, эцэг, эх, хэн нэгэнд мэдэгдэнэ
9.	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орно.
10.	Замын цагдаа, зохицуулагч байхгүй байвал би замын хөдөлгөөний дүрэм зөрчиж магадгүй.
11.	Гэмт хэрэг, авлига, хээл хахуульд холбогдсон хэн нэгэн хүнийг би зохих байгууллагад нь мэдэгдэнэ.
12.	Манай гэр бүл баяжиж л байвал аав, ээж эрх мэдлээ ашиглах, хууль зөрчих нь надад хамаагүй.

Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдлын үзүүлэлтийг тооцохдоо дээр дурдсан асуултуудын дагуу дэд үзүүлэлтийн дунджийг тооцсон болно. Дэд үзүүлэлт тооцоход ашигласан асуултыг дараахь хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтийг тооцсон асуулт

	Ёс зүй, ёс суртахуун	Зөв төлөвшилт	Хууль сахих	Авлигыг үл тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

2. СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан, 21 аймаг, нийслэлийн 7-12 дугаар ангийн сурагчдыг санамсаргүй байдлаар сонгон, бэлтгэгдсэн асуулгыг бөглүүлж, судалгааг зохион байгуулав.


Судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах ажлыг 21 аймаг, нийслэлийн Боловсролын газруудтай хамтран 2019 оны 4 дүгээр сарын 14-ны өдрөөс 2019 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

3. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

“Хүүхдийн шударга байдал-2019” судалгаанд хамрагдсан нийт 6576 сурагчдийн 43.6 хувь нь эрэгтэй, 56.4 хувь нь эмэгтэй байгаа бол 16 настай сурагчид хамгийн их буюу 20.6 хувь, 12 настай сурагчид хамгийн бага буюу 4.7 хувь байна. Судалгаанд

хамрагдсан сурагчдыг байршлаар нь авч үзвэл 57.5 хувь нь аймгуудаас, 42.5 хувь нь нийслэлээс хамрагдсан байна (Зураг 23).

Зураг 23. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, нас



ДҮГНЭЛТ

Авлигатай тэмцэх газар нь “Хүүхдийн шударга байдлын түвшин 2019 он” судалгааг аймаг, нийслэлийн Боловсролын газартай хамтран зохион байгуулав. Судалгааны үр дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

- ❖ Хүүхдийн шударга байдлын түвшин 2019 оны судалгаагаар 3.911 гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны түвшинд гарсан байна. Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн шударга байдал, ёс зүй, ёс суртахуун, төлөвшилтийг хүүхдэд ойлгомжтой, хялбар байдлаар тодорхойлох энэхүү судалгааны түвшин өнгөрсөн оны судалгааны түвшинд байгаа нь хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил зохих түвшинд хийгдээгүй байгааг илэрхийлж байна.
- ❖ Хүүхдийн шударга байдлын түвшинг аймаг, нийслэлээр тооцдог ба 2019 оны судалгааны үр дүнгээр 17 аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин буурсан байна. Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Орхон, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин сүүлийн гурван жилийн хугацаанд буурсан байна. Архангай, Орхон, Өмнөговь, Хэнтийн аймаг болон нийслэлийн хүүхдийн шударга байдлын түвшин эерэг өөрчлөлттэй гарчээ.

1 Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

- ❖ Судалгааны дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин нас ахин анги дэвших тутам буурч байгаагаас гадна эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эмэгтэй хүүхдийнхээс зөрүүтэй байна. Тус хандлага сүүлийн хэдэн жил хадгалагдаж байгаа нь анхаарал татаж байна. Иймд хүүхдүүдэд ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход боловсролын байгууллагаас гадна эцэг, эцэг, эх, ах, эгч зэрэг ойр дотны хүмүүс нь бүгд зөв үлгэр дууриал үзүүлэх шаардлагатай байна. Мөн нийслэлийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин орон нутгийн хүүхдүүдийнхээс доогуур байдаг хандлага мөн энэ удаагийн судалгаанд илрэв.
- ❖ Төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин хувийн өмчийн хэлбэрийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшинөөс 0.15 пунктээр их байна.
- ❖ Хүүхдийг шударга байх талаар ярилцах, шударга хандсаных нь төлөө магтаж сайшаах, шударга бус зүйл хийвэл зэмлэх явдал хүүхдийн шударга байдалд эерэгээр нөлөөлж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.
- ❖ Хүүхдийн шударга байдлын түвшинд найз нөхдийн хүрээлэл нөлөөтэй байна. Шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин найз нөхөдтэйгээ ярилцдаггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс өндөр байна. Иймд эцэг, эхчүүд хүүхдүүдээ ямар хүүхэдтэй нөхөрлөж байгаа, тэдний хүсэл, сонирхол, хүрээлэл зэргийг мэдэж байх асуудал чухал байна.
- ❖ Шударга ёсны талаар зааж сургах, хүүхэддээ анхаарал, халамжтай байх нь хүүхдийн шударга байдалд эерэгээр нөлөөлж байна. Шударга бус асуудал тохиолдвол эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүнд ханддаг хүүхдийн шударга байдлын түвшин шударга бус асуудал тохиолдвол ямар нэгэн үйлдэл хийдэггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс өндөр байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- ❖ Шударга ёсны тухай мэдээллийг гэр бүлийн хүрээнд авдаг хүүхдийн шударга байдлын түвшин нь сургуулийн орчин, зурагт радио, сонин, хэвлэл, интернет, найз, нөхдийн хүрээлэл зэрэг бусад хүрээнээс авдаг хүүхдийн шударга байдлын түвшинөөс өндөр байна.
- ❖ Шударга ёсны хэм хэмжээг, ёс суртахууны төлөвшил өндөртэй хүүхдүүд шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнийг зэмлэж сануулдаг ба шударга бус үйлдлийг олон нийтэд мэдээлэх нь зөв гэж үздэг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- ❖ Бидний ирээдүй, хойч үе болсон хүүхдүүдэд бага наснаас нь эхлэн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилтийн болон авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд эцэг, эх, найз нөхдийн нөлөөллөөс гадна цэцэрлэг болон сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд энэ талаар тодорхой тусгах шаардлагатай байгаа нь жил бүрийн судалгааны үр дүнгээс харагдаж байдаг.

ЗӨВЛӨМЖ

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Бүх шатны сургуулиудад шударга ёс (ёс зүй), ёс суртахууны үзлийг төлөвшүүлэх талаар хичээл оруулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах;
- Хүүхдүүдийн шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шударга үйлдэл хийсэн хүүхдүүдийг эцэг, эх, найз нөхөд, анги хамт олны дунд шалгаруулан урамшуулах, шагнах зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулж, ярилцах, хүүхдүүдийг өргөнөөр хамруулан хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх,
- Багш, сурган хүмүүжүүлэгч нарыг хүүхдүүдийн дэргэд зүй зохисгүй зан гаргах, аливаа шударга ёс зүйн хэм хэмжээг зөрчих үйлдэл хийхгүй байх талаар багш нарын дунд тогтмол сургалт зохион байгуулж байх,
- Засгийн Газрын 2019 оны 33 тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг сахиж биелүүлэхтэй холбоотой боловсролын салбарын албан хаагчдад сургалт, сурталчилгаа явуулж багш, сурган хүмүүжүүлэгчдийг ёс суртахууны өндөр хэм хэмжээг үлгэрлэх ажлыг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.


ЭЦЭГ, ЭХ БОЛОН БУСАД НАСАНД ХҮРЭГСДИЙН ХУВЬД:

- Эцэг, эх болон бусад хүмүүсийн хувьд шударга байдлаараа гэр бүл, үр хүүхдүүддээ үлгэр дууриалал үзүүлж байх;
- Хүүхдүүдэд буруу зүйл хийснийг нь ойлгуулж, тайлбарлаж байх, шударга үйл хийсэн бол тэднийг урамшуулж, сайшааж байх;
- Хүүхдүүдийн найз, нөхдийн хүрээ, хүсэл сонирхлыг нь анхааран мэдэрч байх;
- Хүүхдүүдээ цаг гаргаж шударга ёсны талаар байнга ярилцаж байх талаар олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, зурагт, радиогоор соён гэгээрүүлэх ажлыг эрчимтэй явуулах.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг телевиз, радио болон интернетээс авч байгаа бөгөөд тухайлбал, телевиз, радиогоор хүүхдийн шударга ёсыг дэмжсэн, сонирхол татахуйц хөтөлбөр, нэвтрүүлгийг бэлтгэн хүргэж байх;
- Хүүхдийн ёс зүй, шударга байдлыг нэмэгдүүлэх талаар санал, санаачилга гаргах, энэ талаар холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх;
- Хүүхдэд зориулагдсан хөтөлбөр, нэвтрүүлгийн агуулгад шударга бус явдал, үйлдлийг дэмжсэн, сайшаасан зүйл оруулахгүй байхад анхаарах.

**ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
СУДАЛГАА-2019**



УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл: Авлигатай тэмцэх газар 2008 оноос хойш жил тутам “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулж судалгааны үр дүнг Мянганы хөгжлийн 9 дэх зорилтын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгох, хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх нэг шалгуур болгож ирсэн.

Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхэд мэдээллийн чухал их сурвалж болох учиртай.

2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос эхлэн тус хоёр хүрээг тусд нь авч үзэж, “Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” болон “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г хийдэг болсон юм. Уг хоёр судалгааг “Максима Консалтинг” ХХК хоёр жил дараалан хийж гүйцэтгэв.

Судалгааны хүрээнд дараах зорилтыг тавьж зохион байгуулав.

- Авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, авлигын хэлбэрийг авч үзэх;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын шалтгаан, нөхцөл түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэмжээ, түүний хор уршиг, үр дагаврыг гаргах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх хүрээн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зэрэг болно.

Судалгааны арга зүй: “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г тоон болон чанарын судалгааны аргаар хийж явуулсан. Ингэхдээ нийтийн алба (шүүх, хууль сахиулах салбараас бусад), шүүх, хууль сахиулах салбар, хэвлэл мэдээллийн салбар, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, бодлогын судалгаа, олон нийтийн санал бодлын судалгаа, бизнесийн салбар, иргэдийн төлөөллийг ижил тэнцүү оролцуулан нийт 66 шинжээчийг хамруулсан.


Тоон судалгааны мэдээллийг цуглуулахдаа нүүр тулсан ярилцлагын асуулгын аргыг ашигласан ба шинжээчдээр асуулт бүрийг “1-ээс 5” гэсэн баллаар үнэлүүлэн тооцоолсон. Баллын үнэлгээ буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол баллын үнэлгээ өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.

Өмнө нь дан тоон судалгааны аргыг ашигладаг байсан бол 2018 оноос эхлэн чанарын судалгааны аргыг нэмэлтээр нэвтрүүлж эхэлсэн ба ингэхдээ фокус бүлгийн хэлэлцүүлгийн аргыг ашигласан бөгөөд 6 удаагийн хэлэлцүүлэгт нийт 48 шинжээчийг оролцуулан судалгааны асуултуудыг дэлгэрүүлж, гүнзгийрүүлж хэлэлцсэн. Харин 2019 оны судалгааны хүрээнд фокус бүлгийн хэлэлцүүлгийн оронд чанарын судалгааны *экспертийн ярилцлагын* аргыг ашиглаж, дээр дурдсан найман

салбараас нийт 10 эксперттэй дэлгэрэнгүй ярилцсан. Экспертийн ярилцлагын судалгааны товч дүнг тус тайлангийн дүгнэлтэнд тусгасан болно.

2018 онд судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ боломжтой тохиодолд “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2017 оны судалгаа”-наас шүүх, хууль хяналтын байгууллагатай холбогдолтой тоо баримтыг салган шинээр тусд нь тооцоолж 2018 оны үзүүлэлттэй харьцуулан шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тогтоож байсан. Бусад боломжгүй тохиодолд ямар нэгэн өөрчлөлтийг тогтоох бус гагцхүү баримжаалах зориулттай 2018 оны үзүүлэлтийг 2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын нэгтгэсэн дүнтэй зэрэгцүүлэн толилуулж байсан. Харин 2019 оны судалгаанаас эхлэн ижил аргачлалаар хийгдсэн, харьцуулагдах бүрэн боломжтой 2018 оны дата дээр суурилан харьцуулж дүн шинжилгээ хийх боломжтой боллоо.


График 1. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үнэлгээ, үзүүлэлтийн схем.



НЭГ. 2019 ОНЫ ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШИН

Судалгааны үр дүнд 2019 онд шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 3.86 гарлаа. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 0.18 пунктээр өссөн байна. Тус салбарын индексийг анх удаагаа 2018 онд гаргасан тул олон жилийн динамикийг шууд тогтоох боломжгүй. Гэхдээ баримжаалах зориулалтаар өмнөх жилүүдэд нэгтгэсэн байдлаар гаргаж байсан улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн индексийг авч үзэхэд 2008-2017 онуудад 3.58-аас 4.09-ийн хооронд хэлбэлзэн 3.86 гэсэн дундажтай байв. Түүнчлэн ижил аргачлалаар тусд нь хийгдэх болсон 2018 болон 2019 оны улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индекс тус бүр 3.93 болон 4.08 гарсан болно.

График 2. Улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 2008-2017 онд, шүүх, хууль хяналтын хүрээний авлигын түвшин 2018, 2019 онд.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг тогтоохдоо дараах үндсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашигласан: цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөл, хор уршиг/үр дагавар.

Ижил аргачлалаар нэгэн зэрэг хийж явуулсан 2018 болон 2019 оны улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа болон 2017 оны жилийн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх судалгаанаас салгаж тооцоолж болох шүүх, хууль хяналтын байгууллагын үзүүлэлттэй харьцуулахад энэ салбарт улс төрийн хүрээнээс арай бага авлигын үнэлгээ өгдөг хандлага ажиглагдаж байгаа юм. Тухайлбал энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлтээс шүүх, хууль хяналтын байгууллагын үндсэн шалгууруудын үзүүлэлт 0.09-0.38 пунктээр бага байгаа бол 2018 онд 0.15-0.30 пунктээр бага байлаа.

График 3. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээний үнэлгээ 3.75 гарч өмнөх оныхоос үл ялих 0.06-аар өссөн байна. Харин энэ оны улс төрийн хүрээний авлигын цар хүрээний үнэлгээ 4.13 гарсан.

Цар хүрээний үнэлгээг 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлох бөгөөд дүнг доорх график 4-т харуулав. Индексээс гадна чанарын хувьд дэд үзүүлэлт бүрийн хувьд хэр өндөр үнэлгээ өгснийг “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрээр харуулахад (хаалтанд 2018 он үзүүлэлтийг харуулав):

1. Авлигын түгээмэл байдал **72.7%** (75.8%),
2. Авлигын түвшний өөрчлөлт **33.3%** (42.2%),
3. Авлигын цар хүрээ салбар, хүрээ/байгууллагаар дундаж **39.6%** (46.3%),
4. Авлигын түвшин тодорхой үйл ажиллагааны төрлөөр дундаж **43.2%** (36.7%),
5. Авлигын чиглэлгэгдсэн байдлаар **59.5%** (59.0%) гарлаа.

График 4. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээний үнэлгээ.




Дэд үзүүлэлт 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.21 гарлаа (+ 0.08 пункт: 2018 онд 4.13). Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.32 гарч, 2017 оны нэгтгэсэн үзүүлэлт 4.18 байв.

Хувиар авч үзвэл шинжээчдийн 72.8% нь тус салбарт авлига “их” болон “маш их” хэмжээнд түгээмэл гэж үнэлсэн (улс төрийн хүрээний үзүүлэлт 83.3%).

График 5. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин.




Дэд үзүүлэлт 2. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлтийн үнэлгээ 3.60 (+ 0.01: 2018 онд 3.59) гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний авлигын түвшний өөрчлөлтийн үнэлгээ 3.69 гарсан. Харин 2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын нэгтгэсэн үзүүлэлт 3.59 байсан.

Хувиар авч үзвэл шинжээчдийн 33.4% нь тус салбарт авлига их, бага ямар нэг хэмжээнд нэмэгдсэн гэж үнэлсэн (улс төрийн хүрээний үзүүлэлт 56.1%).

График 6. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт.



Дэд үзүүлэлт 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА ДАХЬ АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Шүүх, хууль хяналтын байгууллага тус бүр дэх авлигын тархалтын цар хүрээний үнэлгээ 3.52 пункттэй өмнөх оны үзүүлэлтээс 0.05 пунктээр буурсан үзүүлэлттэй гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний авлигын түгээмэл байдлын үнэлгээ 3.92 гарсан бол 2017 оны шүүх, хууль хяналтын байгууллагын үзүүлэлт 3.86 байв.

Хувиар авч үзвэл салбар, байгууллагуудын авлига “их” болон “маш их” тархмал гэсэн үнэлгээний дундаж 39.6% байгаа ч хоорондоо их зөрүүтэй үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Салбар, хүрээ/байгууллагад авлига тархсан цар хүрээ.

	Байгууллага	2018	2019	Өөрчлөлт	"Их/маш их" тархсан
1	Шүүх	3.97	4.07	+ 0.10	68.2%
2	Прокурор	4.02	4.05	+ 0.03	68.2%
3	Цагдаагийн байгууллага	3.68	3.64	- 0.03	51.5%
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3.54	3.51	- 0.03	42.4%
5	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар	3.42	3.50	+ 0.08	34.8%
6	Шүүхийн шинжилгээний байгууллага	3.50	3.38	- 0.12	34.8%
7	Тагнуулын байгууллага	3.43	3.32	- 0.10	24.2%
8	Авлигатай тэмцэх байгууллага	3.53	3.14	- 0.39	21.2%
9	Хил хамгаалах байгууллага	3.05	2.76	- 0.28	10.6%
10	Дотоодын цэрэг ¹	-	-	-	-
	Нийт	3.57	3.52	-0.05	-

Дэд үзүүлэлт 4. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Авлига тархсан байдлыг байгууллагуудаас гадна тэдгээрийн явуулдаг тодорхой үйл ажиллагааны хүрээгээр үнэлүүлэхэд 3.70 гарсан (+ 0.26: 2018 онд 3.44). Харин энэ оны улс төрийн хүрээний энэ үзүүлэлт 4.37 гарсан байна. Үнэлгээг тухайн салбарын үндсэн 10 үйл ажиллагааны хүрээнд гаргасан.

Хүснэгт 2. Шүүх, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын түвшин.


	Шүүх, хууль сахулах үйл ажиллагаа	2018	2019	Өөрчлөлт
1	Прокурорын хяналт	3.82	4.02	+ 0.20
2	Эрүүгийн хэрэг шүүхэд таслан шийдвэрлэх ажиллагаа	3.71	3.95	+ 0.24
3	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа	3.62	3.93	+ 0.31
4	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа	3.85	3.80	- 0.05
5	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа	3.40	3.80	+ 0.40
6	Шүүхийн шинжилгээний ажиллагаа	3.53	3.71	+ 0.17
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	3.30	3.70	+ 0.40
8	Иргэний харьяалал, шилжилт, хөдөлгөөний бүртгэл	3.42	3.64	+ 0.22
9	Хил хамгаалах ажиллагаа	2.85	3.03	+ 0.18
10	Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа	2.87	2.95	+ 0.08
	Нийт индекс	3.44	3.70	+ 0.26

Дэд үзүүлэлт 5. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН НӨЛӨӨЛӨЛ, ЧИГЛЭЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын авлига бусад салбар, хүрээний үйл ажиллагаа руу хэр чиглэж байгаа буюу нөлөөллийн (авлигын чиглэл буюу аль салбар, үйл ажиллагаатай хэр холбогдсон байдал) үнэлгээний үзүүлэлт 3.93 (+ 0.21: 2018 онд 3.72) гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн авлигын тус шалгуурын үзүүлэлт 4.12 гарсан байна.

¹ Дотоодын цэргийн хувьд үнэлгээнд мэдэхгүй хувь хэт өндөр байсан тул үнэлгээг нь гаргаагүй болно.

График 7. Шүүх, хууль сахиулах байгууллагын авлига бусад салбар, үйл ажиллагаа руу чиглэгдсэн байдал.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ 3.83 гарлаа (+ 0.31; 2018 онд: 3.52). Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний авлигын хэлбэрийн үнэлгээ 4.04 гарсан бол 2017 оны улс төрийн болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 3.81 гарч байсан байна.

Цар хүрээний үнэлгээг хээл хахуулийн хэлбэр, хээл хахууль өгөх, авах арга, бүлэглэлүүдийн харилцаа холбоо, авлигын хэлбэр болон хууль бус нөлөөллийн хэлбэр гэсэн 5 дэд үзүүлэлтийн хүрээнд үнэлүүлж гаргасан.

График 8. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ.




Дэд үзүүлэлт 1. ХЭЭЛ ХАХУУЛИЙН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ 3.80 гарлаа (+ 0.23; 2018 онд 3.57). Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний ижил шалгуурын үнэлгээ 3.84 гарсан байна. Харин 2017 оны улс төрийн болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 3.69 гарч байжээ.

Хээл хахуулийн олон хэлбэр байгаагаас хамгийн түгээмэл гэж үзсэн дараах 13 хэлбэрийг сонгон үнэлүүлсэн (зураг 9). Өндөр үзүүлэлттэй гарсан хэлбэрүүдийн үзүүлэлтийн тодруулах үүднээс тэдгээрийн “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрийг харуулбал,

- ажил албан тушаалд томилох, оруулах 66.7%,
- шагнал, цол, тэмдгээр шагнах 65.2%,
- бэлэн мөнгө өгөх 63.6%,
- үнэтэй бэлэг өгөх 59.1%
- ашиг, орлого хуваалцах 47.0%-тай байна.

График 9. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ.



Дэд үзүүлэлт 2. ХУУЛЬ БУС НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ нь 3.86 гарлаа (+ 0.18; 2018 онд: 3.68). Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний ижил шалгуурын үнэлгээ 4.12 гарсан байна. Харин 2017 оны улс төрийн болон шүүх,

Хүснэгт 3. Бүлэглэлүүдийн харилцаа, хамаарал, нөхцөл байдлын үнэлгээ.

	Бүлэглэлүүдийн нөхцөл байдал	2018	2019	Өөрчлөлт
1	Хууль сахиулахын хүрээн дэх авлига илүү далд хэлбэрт шилжсэн	4.14	4.21	+ 0.07
2	Улс төрчид шүүгч/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4.29	4.11	- 0.18
3	Улс төрчид шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	4.45	3.95	- 0.50
4	Бизнес бүлэглэл шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	3.93	3.66	- 0.27
5	Бизнес шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4.03	3.65	- 0.38
6	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд бизнес бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3.83	3.57	- 0.25
7	Шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд улс төрчдийг эрхшээлдээ оруулсан	3.75	3.49	- 0.26
8	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд гэмт бүлэглэлийн эрхшээлд орсон	3.68	3.06	- 0.62
9	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон гэмт бүлэглэл нэгдсэн	3.61	3.06	- 0.56
10	Гадны бизнесийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	3.39	2.87	- 0.52
11	Гадны улс төрийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	3.46	2.85	- 0.61
12	Гадны бизнесийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудтай нэгдсэн	3.28	2.85	- 0.43
13	Гадны улс төрийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудтай нэгдсэн	3.19	2.55	- 0.64

Үзүүлэлтийн тодруулах үүднээс тэдгээрийн “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрийг харуулбал,

- Улс төрчид шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан 81.8%,
- Улс төрчид шүүгч/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн 77.3%,
- Хууль сахиулахын хүрээн дэх авлига илүү далд хэлбэрт шилжсэн 71.2%,
- Бизнес шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн 68.2%,
- Бизнес бүлэглэл шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан 60.6%
- Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд бизнес бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан 59.1%
- Шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд улс төрчдийг эрхшээлдээ оруулсан 56.1% байна.


Дэд үзүүлэлт 4. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ 3.94 гарсан. (Энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 4.35, 2017 оны нэгтгэсэн үзүүлэлт 4.18.)

Үүнийг хувиар тодруулбал: “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрийн дундаж 58.1.8% байхад,

- Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулах 74.2%
- Албан тушаалын байдлаа урвуулан ашиглах 74.2%
- Албан тушаал, эрх мэдлээ хэтрүүлэх 72.7%
- Бизнесийн бүлэглэлийн захиалгаар шийдвэр гаргах 71.2%
- Аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох 69.7%
- Шан харамж авах, өгөх 65.2%
- Хээл хахууль авах, өгөх, зуучлах 63.6% байна.

График 11. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэр.




Дэд үзүүлэлт 5. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ АРГА

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудыг хэрэглэсэн байдлын үнэлгээ 3.68 гарлаа. (Энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 3.79, 2017 оны нэгтгэсэн үзүүлэлт 3.81.)

Нийт 11 аргыг үнэлүүлэхэд ойр дотны хүмүүсээр дамжуулах, зуучлагчаар дамжуулах, ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдний компанид давуу байдал олгох болон өмгөөлөгчөөр дамжуулах аргууд хамгийн түгээмэл хэрэглэгддэг гэсэн үнэлгээ гарсан (“их” болон “маш их” гэсэн үнэлгээний нийлбэрээр 30.3-57.6%).

График 12. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээ.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудыг хэрэглэсэн байдлын үнэлгээ 3.68 гарлаа. (Энэ оны улс төрийн хүрээний үнэлгээ 3.79, 2017 оны нэгтгэсэн үнэлгээ 3.81.)

Авлигын шалтгаан, нөхцөлийн үзүүлэлтийг авигад нөлөөлөх хүчин зүйлс, авлигын түвшинд нөлөөлөх (төрийн албаны) дутагдал, доголдол болон бүлэглэл, хүрээлүүдийн нөхцөл байдал гэсэн 3 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлдог.

График 13. Авлигын шалтгаан, нөхцөл.



**Дэд үзүүлэлт 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГАД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС**

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ 3.96 гарлаа (+ 0.14; 2018 онд: 3.82). Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний ижил үнэлгээ 4.33 гарч, 2017 оны улс төрийн болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 4.25 байлаа.

Авлигад нөлөөлөх 11 хүчин зүйлсийг үнэлүүлсэн бөгөөд өндөр үнэлгээний нийлбэрээр (“их” болон “маш их” гэсэн үнэлгээ) албан тушаалын томилгоо 78.8%, хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц 69.7%-тай, бусад хүчин зүйлс 50-60% орчим гаруй байна.

Хүснэгт 4. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ.

	Авлигад нөлөөлөх хүчин зүйлс	2018 он	2019 он	Өөрчлөлт	“их/маш их”- ийн нийлбэр
1	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.31	4.31	- 0.01	78.8%
2	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	3.86	4.07	- 0.21	69.7%
3	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.93	4.02	- 0.09	62.1%
4	Намын санхүүжилтийн механизм	3.81	3.98	- 0.17	57.6%
5	Сонгуулийн санхүүжилтийн механизм	3.75	3.97	- 0.21	63.6%
6	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.69	3.95	- 0.26	59.1%
7	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	3.79	3.95	- 0.16	56.1%
8	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.75	3.93	- 0.19	62.1%
9	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	3.86	3.84	+ 0.02	57.6%
10	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	3.8	3.79	+ 0.01	54.5%
11	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.43	3.75	- 0.33	48.5%

Дэд үзүүлэлт 2. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ДУТАГДАЛ, ДОГОЛДОЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад төрийн албан дахь доголдол, дутагдал хэрхэн нөлөөлж буйн үнэлгээ 4.09 гарлаа (+ 0.07; 2018 онд: 4.02). Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний ижил үнэлгээ 4.28 гарч, 2017 оны улс төрийн болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 4.10 байлаа.

Хүснэгт 5. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол.

Хариулт		2018 он	2019 он	Өөрчлөлт
1	ТАХ-ийн ур чадвар дутмаг	4.24	4.36	+ 0.12
2	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.18	4.32	+ 0.13
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	4.17	4.32	+ 0.15
4	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	4.28	4.21	- 0.07
5	Хүнд суртал	4.10	4.15	+ 0.04
6	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	4.10	4.11	+ 0.01
7	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.19	4.06	- 0.12
8	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	4.13	4.03	- 0.10
9	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	3.98	4.02	+ 0.03
10	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	3.71	3.98	- 0.27
11	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	3.62	3.83	+ 0.21
12	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.56	3.79	+ 0.23

Дэд үзүүлэлт 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ ХҮРЭЭЛЛҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн бүлэглэл, хүрээллийн нөхцөл байдал буюу ямар төрлийн хүрээлүүд түгээмэл, нөлөөлөлтэй байгаа талаарх үнэлгээ 3.79 гарлаа (+ 11; 2018 онд 3.68). Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний үнэлгээ 3.93 гарч, 2017 улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын үзүүлэлт 4.08 байлаа.

Ингэхэд өндөр үнэлгээний нийлбэрийн хувиар ч хувийн эрх ашгийг илүүд үзсэн нам тойрсон хүрээлэл (75.8%), хувийн эрх ашгийг илүүд үзсэн бизнесийн хүрээлэл (71.2%), нам дамнасан хүрээлэл (69.7%), нэг хүнийг тойрсон хүрээлүүдийн (60.6%) нөлөөлөл өндөр байна.

График 14. Шүүх, хууль хяналтын хүрээн дэх хүрээллүүдийн нөхцөл байдал.



**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН
ДЭХ АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР**

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор ур уршиг, үр дагаврын үзүүлэлт 3.89 (+ 0.23; 2018 онд: 3.66) гарлаа. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 3.98 гарч, 2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 3.91 байлаа.

Авлигын төсөөллийн индексийг тогтоох 4 дэх үндсэн шалгуур болох энэ үзүүлэлтийг авлигын хор уршиг, үр дагавар болон авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт гэсэн хоёр дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлдог.

График 15. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагавар.



**Дэд үзүүлэлт 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР**

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршгийн үзүүлэлт 3.98 гарсан (+ 0.19; 2018 онд: 3.79) бол энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 4.09 гарч, 2017 оны улс төр болон шүүх, хууль хяналтын хүрээний нэгтгэсэн үзүүлэлт 4.09 гарч байсан байна.

Хүснэгт 6. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин.

	Авлигын сөрөг үр дагавар	2018	2019	Өөрчлөлт	"их/маш их"
1	Иргэдийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэл буурсан	4.28	4.34	+ 0.06	78.8%
2	Хуулийн хэрэгжилт суларсан	4.17	4.23	+ 0.06	74.2%
3	Ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан	4.02	4.21	+ 0.19	74.2%
4	Төрийн албаны чадавхи суларсан	4.08	4.20	+ 0.12	72.7%
5	Шударга ёс алдагдсан	4.05	4.14	+ 0.09	74.2%
6	Өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдсэн	3.86	4.10	+ 0.23	69.7%
7	МУ-ын нэр хүнд олон улсын түвшинд унасан	3.65	4.08	+ 0.43	65.2%
8	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэн	3.73	4.02	+ 0.29	63.6%
9	Хүний эрхийн зөрчил нэмэгдсэн	3.82	4.00	+ 0.18	65.2%
10	Улс орны эдийн засгийн хүч чадал суларсан	3.48	3.95	+ 0.47	63.6%
11	Ядуурал нэмэгдсэн	3.61	3.92	+ 0.31	60.6%
12	Гэмт хэрэг нэмэгдсэн	3.69	3.77	+ 0.08	54.5%
13	Нийгмийн дэг журам алдагдсан	3.75	3.73	- 0.02	56.1%
14	Гадаадын зээл тусламжийн үр ашиг буурсан	3.56	3.68	+ 0.12	47.0%
15	Ажилгүйдэл нэмэгдсэн	3.46	3.65	+ 0.19	51.5%
16	Гадаадын хөрөнгө оруулалт буурсан	3.44	3.63	+ 0.18	48.5%


Дэд үзүүлэлт 2. АВЛИГААР ОЛСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээ 3.81 гарсан нь өнгөрсөн оноос 0.29 пунктээр өссөн байна (2018 оны үзүүлэлт 3.52). Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын талаар улс төрийн болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд нэгтгэсэн нэг асуултаар үнэлүүлсэн.

Уг үзүүлэлт хамаарах 19 дэд үзүүлэлтийн 17 үзүүлэлтийн үнэлгээ ямар нэг хэмжээнд өссөнөөс "хөшөө дурсгал, суварга босгох" (+ 0.59), "эмчилгээнд зарцуулах" (+ 0.56), "хурдан морь худалдан авах" (+ 0.45), "урлагийн бүтээл худалдан авах" (+ 0.42), "гадаадад орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах" (+ 0.39), "гэр бүлийн гишүүний сургалтын төлбөрт зарцуулах" (+ 0.38), "гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах" (+ 0.35) хэлбэрүүдийн үнэлгээ хамгийн их өссөн байна.

Харин "дотоодын банкинд хадгалах" гэсэн нэг л үзүүлэлт буурч (- 0.05), "өдөр тутмынхаа хэрэгцээд зарцуулах" гэсэн нэг л үзүүлэлт хэвээр байна (+ 0.01).

График 16. Улс төрийн (түүнчлэн шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний) авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт.




ХОЁР. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлгийн хүрээнд шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлигын үндсэн үнэлгээнээс гаднах бусад үзүүлэлтүүдийн байдлаар авлигын ерөнхий ойлголт, төсөөллийг дэлгэрүүлж гаргаж ирэхийг зорьсон болно.

АВЛИГЫН ЕРӨНХИЙ ТҮВШИН

Судалгааны хүрээнд улс төрийн хүрээгээр хязгаарлалгүй Монголын нийгэм дэх авлигын ерөнхий хандлага, түгээмэл байдлыг шинжээчдээр үнэлүүлэхэд 56.1 хувь нь их болон маш их гэж үнэлсэн байгаа юм.

График 17. Монголын нийгэм дэх авлигын түвшин.



АВЛИГЫН ХҮРЭЭНИЙ ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Монголын нийгэм дэх авлигын ерөнхий хандлагын зэрэгцээ цар хүрээгээр нь тодорхойлохыг зорьсон юм. Улс орны авлига ямар түвшинд байгаа нь цар хүрээний тархацтай шууд холбоотой юм. Нийт 11 дэд хүрээнээс 9-д нь 40%-иас дээш авлига “их” болон “маш их” хэмжээнд түгээмэл гэж шинжээчид үнэлсэн юм. Ингэхдээ засгийн газрын хүрээнд авлигын тархалтын үзүүлэлт хамгийн өндөр гарч, удаагаар төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, улс төрийн намын, УИХ, прокурор, шүүх байгаа бол төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хүрээнд харьцангуй бага пункттэй гарчээ. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн “их” болон “маш их” гэсэн үнэлгээний нийлбэр 40.9 хувьтай байгаа нь анхаарал татаж байна.

Хүснэгт 7. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдал (%).

		Огт үгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Их	Маш их	Σ “их/ маш их”
1	Засгийн газар (яам, агентлаг)	0.0%	3.0%	9.1%	39.4%	47.0%	86.4%
2	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой ААН	0.0%	3.0%	10.6%	27.3%	48.5%	75.8%
3	Улс төрийн нам	1.5%	6.1%	9.1%	33.3%	42.4%	75.8%
4	Улсын Их Хурал	0.0%	9.1%	4.5%	40.9%	33.3%	74.2%
5	Прокурор	0.0%	4.5%	12.1%	28.8%	43.9%	72.7%
6	Шүүх	0.0%	7.6%	12.1%	27.3%	43.9%	71.2%
7	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	0.0%	4.5%	21.2%	30.3%	34.8%	65.2%
8	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	0.0%	9.1%	28.8%	25.8%	22.7%	48.5%
9	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3.0%	7.6%	31.8%	19.7%	21.2%	40.9%
10	Хувийн хэвшил	12.1%	34.8%	19.7%	12.1%	3.0%	15.2%
11	Төрийн бус байгууллага	22.7%	28.8%	16.7%	1.5%	3.0%	4.5%

Хэрэв индексжүүлж өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал дараах дүр зураг харагдана.

Хүснэгт 8. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдал (индекс).

		2018 оны үнэлгээ	2019 оны үнэлгээ	Өөрчлөлт
1	Төрийн болон орон нутгийн өмчит ААН	3.83	4.36	+0.53
2	Засгийн газар (яам, агентлаг)	4.27	4.32	+0.05
3	Прокурор	4.00	4.25	+0.25
4	Шүүх	4.09	4.18	+0.10
5	Улс төрийн нам	4.28	4.18	-0.10
6	Улсын Их Хурал	4.02	4.12	+0.10
7	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	3.84	4.05	+0.21
8	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	3.57	3.72	+0.15
9	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3.91	3.58	-0.33
10	Хувийн хэвшил	2.75	2.50	-0.25
11	Төрийн бус байгууллага	2.27	2.08	-0.19

АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛСӨН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгааны хүрээнд Монгол Улс дахь авлигын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар шинжээчдээс нээлтэй хэлбэрээр асуухад нийт 115 хариулт өгөгдсөнийг нэгтгэн боловсруулахад 24 төрлийн хүчин зүйл дурдагдсан юм. Тэдгээрийн эрэмбэлэхэд дараах дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 9. Монгол Улсын авлигын ерөнхий түвшинд нөлөөлсөн гол нөхцөл байдал.

	Хариулт
1	1. Авилга сүүлийн 5 жилд эрс өссөн. Авилгын түвшин тогтоолт бодит бус юм. 2. Улс орны удирдлага нь олигархийн гар хөл гэмт хэрэгтэнүүд учраас өөрчлөлт гарахгүй
2	1. Авилгажсан нам, 2. Худалдаж авсан албан тушаал, 3. Хүнд суртал, 4. Хуулийн хийдэл, зөрчил, давхцал
3	Rent-seeking behaviour, Төрийн албаны чадавхи, ёс зүй, Resource Curse
4	Авилга авсан гэж үзээд мэдэгдсэн ч ял шийтгэлгүй замхран алга болдог. Нөхөн төлбөр авдаггүй.
5	Авилга УИХ-ын гишүүдийн дунд дэлгэрснээс болоод авилгын нөхцөл байдал муудсан
6	Авилгатай тэмцэх ажил бага зэрэг идэвхижнээс авилга буух хандлагатай байгаа. Гэвч хэрэгжилт нь муу байгаагаас үр дүн сайнгүй байгаа
7	Авилгын мэдээлэл, баримт, тохиолдлуудыг талууд маш их улс төржүүлдэг. Улс төрчид өөрт ашигтай байдлаар нөлөөлөн дэмждэг буюу зогсоодог болсонтой холбоотой
8	Ажил олгогчийн эрх ашиг хязгаарлагдсан. Ажилчдын эрх ашиг дээгүүр тавигдсан. Сул орон тоо, нүсэр бүтцийг бий болгосон. Ажлын бүтээмж үр дүнг тооцохгүй байна.
9	Албан тушаалын томилгоо шударга бус ба чадваргүй төрийн албан хаагчид олширсон. Томилсон даргадаа үйлчилдэг байдал. Ёс зүйгүй хариуцлагагүй байдал газар авсан.
10	Дээд түвшний албан тушаалтнуудын дураараа авирлалт, хуулийн байгууллагын хараат байдал (тэрнээс)
11	Дээд түвшний буюу нам дамжсан бүлэглэл, франкцын үйл ажиллагааны эсрэг нам дотроо томоохон өөрчлөлт <<цэвэрлэгээ>> хийсэн. Дээд түвшинд өөрчлөлт, шинэчлэлт хийж болдгийг олон нийтэд харуулсан.
12	Ёс суртахууны доройтол. Хүмүүжлийн доголдол. Шунал. Эрх мэдлийн төлөө өрсөлдөөн.

13	Ёс суртахууны үнэлэмж, тогтоолт байхгүй
14	Клиенталист сүлжээ, улс төржилт нөлөөлж байна.Томилгоо, тендер авилгатай холбогдож байна.
15	Монгол улсын засаглал тогтворгүй, төр барьж байгаа хүмүүс өөрсдөө авилгад автсан, хуулийн хэрэгжилт байхгүй, гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх, хэвлэл мэдээлэл гээд засаглалын бүтцүүдийн чиг үүрэг холилдсон
16	Нийгмийн сэтгэхүй, ёс суртахууны доройтол, дүрэм журам хуулийн хэрэгжилт муу учраас
17	Нэг жилийн хугацаа бүхэл системд онц нөлөөлөөгүй. Хэвэндээ байгаа.
18	Онц өөрчлөлт байхгүй болов уу. Шүүх байгууллага, хууль хэрэгжүүлэх байгууллагуудын томилгоотой холбоотойгоор эрх мэдэл нэг бүлгээс нөгөөд шилжих үйл явж явагдаж байна. Авилга сүртэй ихэсч буураагүй болов уу.
19	ОТ гэрээг өөрчлөх, зардлыг шалгах ажил, мөн санхүүгийн хямрал зэргээс хөрөнгө оруулагчид үндэсний том корпорациуд хуульд нөлөөлөх зорилгоор их хэмжээний авилга өгч байна.
20	Өмнөхөө багасч буй хэдий ч бүр далд хэлбэрт шилжиж байгаа. Тендерийг бүтээж өгсний хувийг бэлнээр авахаас илүүтэй хамааралтай компаниар, санал болгосон компаниар гүйцэтгүүлэх гэх мэт
21	Салбар салбартаа л аливаа зүйл хаалттай шахуу байдагт байх
22	Сүүлийн 1 жилийн дотор яг нөлөөлөөд ихэсгэсэн гэхээсээ илүүтэйгээр аль ч түвшиндөө авлига ер буурахгүй байгаа нь үүсгээд байгаа нөхцөл шалтгаан нь амь бөхтэй оршсоор ялангуяа дээд түвшний авилгын хэрэг шийдэгдэхгүй замхраад байгааатай шууд холбоотой
23	Сүүлийн 20 гаруй жилд зөвхөн 2 намын эрхшээлд хэт автаж, хөгжил бүхэлдээ чөдөрлөгдсөн. Систем гажсан. Эрх баригч нарын нөлөө төр захиргааны бүх шатанд нэвт шингэсэн. Иргэдийн орлого буурч, ядуурал, ажилгүйдэл ихэссэн. Мэдээлэл, далд, ил тод бус. ХНХ хараат байдал дэндүү.
24	Тодорхой бус эрхзүйн орчин
25	Төр засгийнх нь ажлын хоорондын уялдаа холбоо байхгүй, үйл ойлголцол байгаа учраас төрийн албан хаагчид нэгдсэн удирдлагаар хангагдахгүй, тодорхойгүй байдал үүсээд байна.
26	Төр, засгийн эрхийг авахын тулд бүлэглэл үүсгэж, тухайн бүлэглэлийн ямар нэг аргаар мөнгөтэй болохыг урьтал болгодог.
27	Төрийн албаны хүнд суртал, олон дамжлага
28	Төрийн байгууллагад шилэн данс хэрэгжихгүй болсон.
29	Төрийн байгууллагын хүн суртал, олон дарга нарын дамжлага, намын харьяалал
30	Төрийн дээд албан тушаалтнуудын албан тушаалын хүрээнд ажлын байрыг дураараа солих явдал
31	Төрийн дээд болон дунд албан тушаалтнууд хууль хэрэгжүүлдэггүй, нам эвсэл, танил тал, төрөл төрөгсдөө албан тушаалд томилж хамгаалдаг. Хууль эрхзүйн орчин муу
32	Төрийн тогтворгүй байдал, улс төржилт
33	Төрийн тогтолцоо муу
34	Төсвийн зардал ихсэж, төрийн хяналт суларсан
35	Удирдлагын түвшний болон шийдвэр гаргах түвшний хүмүүс зөвхөн хувийн баяжих сонирхолтой учраас
36	Улс төр, бизнесийн бүлэглэл төрийн эрх мэдлийг авсан
37	Улс төрийн буруу тогтолцоо бий болж, хээл хахууль эрх мэдлийг гааршуулсан явдал
38	Улс төрийн сонгууль, томилгоо шударга бус, цалин бага, төрөөс хамаарсан зөвшөөрөл, лиценз их байдгаас шалтгаална.
39	Улс төрийн тогтворгүй байдал

40	Улс төрийн тогтворгүй байдал, Мэдлэг боловсролтой хүмүүс төрийн албыг хаших боломж олгох, Албан тушаалыг мөнгө гэж харах хандлага бий болсон
41	Улс төрийн тогтворгүй байдал, нам, улс төрчдийн улс төрийн сонирхол, төрийн нөөцийг ашиглахыг хүссэн улс төр-бизнесийн бүлэглэл нөлөөлж байна.
42	Хариуцлага тооцож чадахгүй, шалгаад хэрэг үүсгээд хаадаг
43	Хариуцлагагүй байдал, ёс суртахуун, шунал, мөнгөний сонирхол
44	Хариуцлагын тогтолцоо хэт суларсан. Хэн ч хариуцлага хүлээхгүй бийнэ. Хууль нь оновчтой биш.
45	Хуулийн хэрэгжилт муу. Шийдвэр гаргагчдын муу үлгэр дуурайлал. Шийтгэл ногдуулдаггүй байдал.
46	Хуулийн хэрэгжилт сул. Хяналт тавьдаггүй.
47	Хууль сахиулах, хуулийн хэрэгжилт суларсан. Хууль дээдлэх зарчим алдагдсан. Шүүх засаглал шударга бус шийдвэр гаргадаг. шүүгч нар авилгад өртөх болсон. олон нийтийн хяналт суларсан, давхар хянах зарчим алдагдсан. АТГ ажлаа сайн хийж байгаа.
48	Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл улс төрийн өрсөлдөгч нэг бүлгээс нөгөөд шилжсэн нь авлигын талаарх нөхцөл байдлыг хувийн зүгээс үнэлэхэд хэрэгтэй мэдээллийг нийгэмд цацсан. Гэхдээ энэ нь хэт улс төржих, эцэстээ үр дүн багатай төгсгөлд хүрэх эрсдлийг агуулж байна.
49	Хууль эрх зүйн орчин таатай бус бөгөөд төр хувийн хэвшлийн харилцаа тогтворгүй, нөгөө талаас улс төр тогтворгүй, хууль хяналтын байгууллагын удирдлагын томилгоо нь улс төрөөс хамааралтай.
50	Хүн амын ядуурал, Ажилгүйдэл авилгын үр дүн. Хууль эрх зүйн орчин сул байгаатай холбоотой. Мөн АТГ, Прокурор, Шүүх байгаа авилгын эсрэг тэмцлийг дорвитой хийхгүй байна. Улс төрийн хүрээний авилга, хээл хахууль далд хэлбэрт байгаатай холбоотой.
51	Хэт улс төржин, аливаа ажлыг улс орны эрх ашгийн төлөө бус зөвхөн хэдхэн цөөн бүлэглэлд зохицуулж ажиллаж байгаагаас гэж үзэж байна.
52	Шүүхээр шийдэгдсэн тохиолдол бага. Шалгаж байгаа ч шүүхийн шийдвэр гардаггүй.
53	Эдийн засгийн өсөлттэй гэх боловч эдийн засаг хумигдаж байна. Ихэнх ажил төрийн захиалга, худалдан авалт болж байгаа тул түүнийг дагаад авлига өссөн
54	Эрхзүйн орчин хангалтгүй, ЭХХШ-ийн хууль цоорхой ихтэй. мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтнууд хууль буруу хэрэглэх, нөлөөнд автах нь түгээмэл.

БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЗАРЦУУЛЖ БУЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ

Бизнес эрхлэгчид үйл ажиллагааныхаа явцад өгч буй авлигын үнэлгээг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл тусгай зөвшөөрөл авахад, тендерийн шалгаруулалтад ялахад, төсөл хөтөлбөрт хамрагдахад илүү өндөр авлига өгдөг гэжээ.

Хүснэгт 10. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ (%).

		<5 хувь	6-10 хувь	11-15 хувь	16-20 хувь	21< хувь
1.	Тусгай зөвшөөрөл авахад	4.5%	15.2%	9.1%	19.7%	28.8%
2.	Тендерийн шалгаруулалтад ялахад	0.0%	24.2%	18.2%	16.7%	27.3%
3.	Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	3.0%	25.8%	15.2%	16.7%	18.2%
4.	Хяналт шалгалтаар зөрчил дутагдалгүй гарахад	7.6%	21.2%	9.1%	16.7%	18.2%
5.	Татвараас чөлөөлүүлэх, бууруулахад	7.6%	15.2%	21.2%	13.6%	16.7%

6.	Гадаадаас ажиллах хүч авахад	12.1%	7.6%	18.2%	10.6%	16.7%
7.	Бараа, ажил, үйлчилгээ хүлээлгэн өгөхөд	10.6%	18.2%	13.6%	12.1%	18.2%
8.	Өр төлбөр барагдуулах, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэхэд	10.6%	15.2%	18.2%	15.2%	7.6%
9.	Зээл авахад	9.1%	27.3%	24.2%	13.6%	7.6%

ХЭЭЛ ХАХУУЛЬД ЗАРЦУУЛСАН МӨНГӨНИЙ ХЭМЖЭЭ

Хээл хахуульд өгч буй мөнгөн дүнг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход, гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад зэрэгт хамгийн их өгдөг гэж шинжээчид хариулжээ.

Хүснэгт 11. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ / зорилгоор/, сая төгрөгөөр.

		<1 сая	1-5 сая	5-10 сая	10-20 сая	20-50 сая	50 сая <
1	Ашиг сонирхолдоо нийцсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад	1.5%	3.0%	4.5%	7.6%	9.1%	50.0%
2	Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход	1.5%	1.5%	4.5%	13.6%	12.1%	40.9%
3	Гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад	1.5%	6.1%	7.6%	16.7%	10.6%	31.8%
4	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход	4.5%	4.5%	7.6%	16.7%	18.2%	27.3%
5	Эрүүгийн хэрэг үүсгэхэд	6.1%	7.6%	7.6%	13.6%	13.6%	24.2%
6	Тусгай зөвшөөрөл авахад	3.0%	3.0%	9.1%	27.3%	21.2%	21.2%
7	Ажил, албан тушаалд ороход	4.5%	15.2%	15.2%	18.2%	16.7%	13.6%
8	Хуурамч бичиг баримт үйлдэхэд	4.5%	15.2%	10.6%	15.2%	10.6%	12.1%

ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Авлигатай тэмцэх үйл ажиллагааны сэдэвтэй холбогдуулан шинжээчдээс хаалттай хэлбэрээр нийт 21 арга хэмжээний ач холбогдлын талаар асууж үнэлүүлсэн юм. Өгсөн ач холбогдлоор нь эрэмбэлэхэд дараах дүр зураг харагдаж байна.

График 18. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ.



ГУРАВ. ШИНЖЭЭЧДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

График 19. Шинжээчдийн хүйс.




График 20. Шинжээчдийн нас.





График 21. Шинжээчдийн салбарын харяалал.



ДҮГНЭЛТ

2019 оны шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 3.86 гарлаа. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс 0.18 пунктээр өссөн үзүүлэлт боллоо. Ингэхдээ индексийг бүрэлдүүлэх үндсэн дөрвөн шалгуур бүгд өсч, тус бүр 0.06-оос 0.31 пунктээр нэмэгдсэн. Үүнийг хувьд шилжүүлбэл индекс 3.6%-иар, шалгуурууд 1%-өөс 6%- ийн хооронд өссөн гэж ойлгож болно. Харьцуулахад энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 0.15 пунктын өсөлттэй 4.08 гарсан. Үндсэн шалгууруудыг бүрдүүлэгч дэд үзүүлэлтүүдийн түвшинд буурсан тохиолдол цөөн, бараг бүгд харьцангуй жигд өссөн хандлага ажиглагдана.

Авлигын *цар хүрээний* хувьд (+0.06) салбар хүрээ болон байгууллага, институци дахь тархалт, түгээмэл байдлын үзүүлэлтэд өөрчлөлт төдийлөн гараагүй бол шүүх, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын түвшин болон тэдгээрийн авлигын чиглэгдсэн байдлын үнэлгээнд өсөлт гарсан. Ингэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх, (иргэний, захиргааны, эрүүгийн) хэрэг шүүхэд таслан/хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дээр хамгийн их өсөлт гарсан бол түвшний хувьд прокурорын хяналт, эрүүгийн болон захиргааны хэрэг шийдвэрлэх хамгийн өндөр байна. Чиглэлийн хувьд шүүх, дэд бүтэц, хууль сахиулахад хамгийн өндөр өсөлт гарсан бол түвшний хувьд уул уурхай, шүүх, төрийн алба, дэд бүтэц, хууль сахиулах тэргүүлж байна.

Авлигын *хэлбэрийн* шалгуур дээр хамгийн их өсөлт гарсан (+0.31). Ингэхдээ авлигын хэлбэр болон бүлэглэлүүдийн нөхцөл байдлын үнэлгээн дээр нилээд хэмжээний өсөлт гарсан. Түвшний хувьд авлигын хэлбэр болон хууль бус нөлөөллийн хэлбэр хамгийн өндөр үнэлэгдсэн. Ажил албан тушаал томилох, албан тушаал, эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэх, шан харамж авах, ашиг сонирхолдоо нийцсэн эсвэл захиалгаар шийдвэр гаргах, гаргуулах, хээл хахууль өгөх, авах, зуучлах явдал авлига, хээл хахуулийн хамгийн хамгийн чухал хэлбэр байсаар байна. Хууль бус нөлөөллийн хувьд төрөл бүрийн хэлхээ холбоог ашиглах үндсэн хэлбэр болохын зэрэгцээ дарамт, шахалт үзүүлэхийн үзүүлэлт эрс өсч тэргүүлэх зэрэгт үнэлэгдсэн. Бүлэглэлүүдийн нөхцөл байдлын хувьд “хууль сахиулахын хүрээн дэх авлига илүү далд хэлбэрт шилжсэн”, “улс төрчид шүүгч/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн” болон “эрхшээлдээ оруулсан” гэж үзэх байр суурь голлож байна.

Шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлигын *шалтгаан нөхцлийг* (+0.14) бүрэлдүүлэгч шалгууруудын хувьд өсөлт бага хэмжээнд гарсан. Авлигад нөлөөлөх хүчин зүйлсийн дунд нэгдүгээрт албан тушаалын томилгоо, удаагаар хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц, үүн дахь ашиг сонирхлын зөрчил, цаашлан намын болон сонгуулийн санхүүжилтийн механизм, УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хянах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил болон улс төр-бизнесийн бүлэглэлүүдийн нөлөөлөл шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил голлох үүрэг гүцэтгэж байгаа бол салбар дахь алдаа доголдлын дунд төрийн албан хаагчийн ур чадварын дутмаг байдал, хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал, албан хаагчийн ёс зүйн доголдол, албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж, хүнд суртал, аливаа ил тод бус байдал хамгийн сөргөөр үнэлэгдсэн байна. Хүрээллүүдийн нөхцөл байдлын хувьд төдийлэн өөрчлөлт гараагүй ба нам тойрсон болон нам дамнасан хүрээллүүдийн зэрэгцээ бизнесийн болон нэг хүнийг тойрсон хүрээллүүд хамгийн түгээмэлд тооцогдож байна.

Авлигын *хор уршгийн* хувьд (+0.23) улс орны эдийн засгийн хүч чадал суларсан,

Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан гэсэн дэд үзүүлэлтүүд нилээд өссөн. Түвшний хувьд иргэдийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэл буурсан, хуулийн хэрэгжилт суларсан, ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан, төрийн албаны чадавхи суларсан, шударга ёс алдагдсан зэрэг хамгийн ноцтойд үнэлэгдэж байна. Түүнчлэн авлигын замаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээн дээр нилээд өсөлт гарсан.

**УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
СУДАЛГАА-2019**



УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл: Авлигатай тэмцэх газар 2008 оноос хойш жил тутам “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулж, судалгааны үр дүнг Мянганы хөгжлийн 9 дэх зорилтын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгох, хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх нэг шалгуур болгож ирсэн.

Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхэд мэдээллийн чухал их сурвалж болох учиртай.

2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос эхлэн тус хоёр хүрээг тусд нь авч үзэж, “Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” болон “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г хийдэг болсон юм. Уг хоёр судалгааг “Максима Консалтинг” ХХК хоёр жил дараалан хийж гүйцэтгэв.

Судалгааны хүрээнд дараах зорилтыг тавьж зохион байгуулав.

- Авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, авлигын хэлбэрийг авч үзэх;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын шалтгаан, нөхцөл түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын хэмжээ, түүний хор уршиг, үр дагаврыг гаргах;
- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зэрэг болно.

Судалгааны арга зүй: “Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г нийгмийн эмпирик судалгааны тоон болон чанарын судалгааны аргаар хийж явуулсан. Ингэхдээ нийтийн алба (шүүх, хууль сахиулах салбараас бусад), шүүх, хууль сахиулах салбар, хэвлэл мэдээллийн салбар, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, бодлогын судалгаа, олон нийтийн санал бодлын судалгаа, бизнесийн салбар, иргэдийн төлөөллийг ижил тэнцүү оролцуулан нийт 66 шинжээчийг хамруулсан.


Тоон судалгааны мэдээллийг цуглуулахдаа нүүр тулсан ярилцлагын асуулгын аргыг ашигласан ба шинжээчдээр асуулт бүрийг “1-ээс 5” гэсэн баллаар үнэлүүлэн тооцоолсон. Баллын үнэлгээ буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол баллын үнэлгээ өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.

Өмнө нь дан тоон судалгааны аргыг ашигладаг байсан бол 2018 оноос эхлэн чанарын судалгааны аргыг нэмэлтээр нэвтрүүлж эхэлсэн ба ингэхдээ фокус бүлгийн хэлэлцүүлгийн аргыг ашигласан бөгөөд 6 удаагийн хэлэлцүүлэгт нийт 48 шинжээчийг оролцуулан судалгааны асуултуудыг дэлгэрүүлж, гүнзгийрүүлж хэлэлцсэн. Харин 2019 оны судалгааны хүрээнд фокус бүлгийн хэлэлцүүлгийн оронд чанарын судалгааны экспертийн ярилцлагын аргыг ашиглаж, нийт 10 эксперттэй дэлгэрэнгүй ярилцсан.

Экспертийн ярилцлагын судалгааны дүгнэлтийг ярилцлагын транскриптын хамт тусд нь тайлан болгон үйлдсэн болно.

Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ “Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2018 оны судалгаа”-ны тоо баримттай харьцуулан шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тогтоосон болно.


График 1. Улс төрийн хүрээн дэх авлигын үнэлгээ, үзүүлэлтийн схем.



НЭГ. 2019 ОНЫ УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШИН

Судалгааны үр дүнд 2019 онд улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 4.08 гарлаа. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 0.15 баллаар өссөн байна. Тус судалгаа хийгдэж ирсэн өнгөрсөн 12 жилийн үзүүлэлтийг харьцуулан харахад авлигын төсөөллийн индексийн дундаж 3.89 байгаа ба 2008 оны анхдагч үзүүлэлтээс 0.4-0.5 хүртэл баллаар буурч байсан 2013-2016 онуудыг эс тооцвоос сүүлийн гурван жилийн туршид буцаад 2008-2012 онуудын 4 балл орчмын өндөр түвшинд тогтвортой хэлбэлзэх хандлага илэрч байна.

График 2. Улс төрийн авлигын түвшин, 2008-2019 онд.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улс төрийн авлигын түвшинг тогтоохдоо дараах үндсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашигладаг: цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөл, хор уршиг/үр дагавар.

Үндсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн хувьд ч 2019 оны судалгаагаар бага зэргийн өсөлт тогтоогдлоо.

Улс төрийн авлигын цар хүрээ нь өмнөх оноос 0.14 пунктээр нэмэгдсэн бол авлигын хэлбэр 0.23 пунктээр, авлигын шалтгаан нөхцөл 0.12 пунктээр, хор уршиг, үр дагавар 0.17 пунктээр тус бүр өссөн байна.

График 3. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Улс төрийн хүрээний авлигын цар хүрээний үнэлгээ 2019 онд 4.13 гарч, өмнөх оны дүнгээс 0.14 пунктээр илүү гарлаа.

Улс төрийн авлигын цар хүрээг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлох бөгөөд тус бүр дараах өөрчлөлт гарсан байна:

1. Улс төрийн авлигын түгээмэл байдал - 0.02;
2. Улс төрийн авлигын түвшний өөрчлөлт + 0.13;
3. Тодорхой салбар, хүрээн (төрийн институц) дэх улс төрийн авлигын тархалтын цар хүрээ - 0.01;
4. Төрийн байгууллагын тодорхой үйл ажиллагаан дахь авлигын түвшин + 0.20;
5. Тодорхой салбар, үйл ажиллагаанд улс төрийн авлига чиглэгдсэн байдал (буюу ямар салбар, үйл ажиллагаатай улс төрийн авлига хэр холбогдсон болох) + 0.15.

График 4. Улс төрийн авлигын цар хүрээний үнэлгээ.




Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Улс төрийн авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.32 гарч өмнөх оныхоос 0.02 пунктээр (2018 онд 4.32) буурсан буюу бараг өөрчлөлтгүй байна.

Ингэхдээ шинжээчдийн 83.3% нь Монголын улс төрийн хүрээнд авлига их болон маш их түгээмэл гэж үнэлсэн. Харьцуулахад 2018 онд тус хоёр үзүүлэлтийн нийлбэр бараг ялгаагүй 83.4%-тай гарч байсан хэдий ч “маш их” гэж үнэлэх хувь 45.5%-аас 54.5% болж өссөн байна.

График 5. Улс төрийн хүрээн дэх авлигын түгээмэл байдал.




Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Улс төрийн хүрээн дэх авлигын түвшин өөрчлөгдсөн байдалд өгсөн үнэлгээ 3.69 гарч өмнөх оноос 0.13 пунктээр (2018 онд 3.56) өссөн бага зэргийн өөрчлөлттэй байна.

Ингэхдээ шинжээчдийн 56.1% нь улс төрийн хүрээнд авлига өмнөх оны байдалтай харьцуулахад “нэмэгдсэн” болон “маш их нэмэгдсэн” гэж үнэлсэн. Харьцуулахад 2018 оны тус хоёр үзүүлэлтийн нийлбэр 48.5% байв.

График 6. Улс төрийн хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт.



Дэд үзүүлэлт 3. ТӨРИЙН ИНСТИТУЦ ДЭХ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Төрийн институт дэх улс төрийн авлигын тархалтын үзүүлэлт 3.92 пункттэй өмнөх оныхоос өөрчлөлтгүй гарлаа (2018 оны индекс 3.92).

Ингэхдээ ерөнхийлөгчийн засаглалын хүрээ болон Улсын Их Хурлын үзүүлэлт бага зэрэг өссөн (+ 0.18 болон +0.16) бол улс төрийн намууд, аймаг/нийслэл, сум/дүүргийн засаг дарга/ЗДТГ болон Нутгийн өөрөө удирдах байгууллагын үзүүлэлт - 0.11-0.20 баллын хооронд бага зэрэг буурсан байна. Харин засгийн газар, түүний харъяа байгууллагуудын хувьд өөрчлөлт гарсангүй (- 0.01). Ингэхдээ засгийн газар, түүний харъяа байгууллага болон улс төрийн намууд урьдын адил авлига хамгийн түгээмэл институтээр тооцогдсон хэвээр байна.


Хүснэгт 1. Салбар хүрээн (төрийн институц) дэх авлига тархсан байдал.

	Институци	2018	2019	Өөрчлөлт
1	Засгийн газар /яам, агентлаг/	4.23	4.22	- 0.01
2	Улс төрийн намууд	4.21	4.08	- 0.13
3	Монгол Улсын Их Хурал	3.87	4.04	+ 0.16
4	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ	3.97	3.85	- 0.11
5	Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ	3.57	3.75	+ 0.18
6	Нутгийн өөрөө удирдах байгууллага /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/	3.75	3.56	- 0.20

Дэд үзүүлэлт 4. ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Төрийн үйл ажиллагаан дахь авлигын цар хүрээг (шүүх, хууль хяналтын үйл ажиллагаанс бусад) тодорхой зургаан чиглэлээр авч үнэлүүлэхэд нэгтгэсэн үзүүлэлт 4.37 гарч, өмнөх оны үзүүлэлттэй (4.17) харьцуулахад 0.20 пунктээр өссөн. Бүх үйл ажиллагааны үнэлгээ өссөн үзүүлэлттэй гарсан хэдий ч тусгай сангуудын үйл ажиллагааны талаарх шуугиан экспертүүдийн байр сууринд нөлөөлсөн нь илт харагдана.

График 7. Нийтийн алба/төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын тархалтын цар хүрээ.



Дэд үзүүлэлт 5. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН НӨЛӨӨЛӨЛ, ЧИГЛЭЛ

Улс төрийн авлига бусад салбар хүрээний үйл ажиллагаа руу хэр чиглэж байгаа буюу нөлөөллийн (авлигын чиглэл буюу аль салбар, үйл ажиллагаатай хэр холбогдсон байдал) үнэлгээний үзүүлэлт 4.12 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.15 пунктээр бага зэрэг өссөн байна (2018 оны үзүүлэлт 3.97).

Нийт 11 салбар, үйл ажиллагааны хүрээнд үнэлгээг гаргасан ба тэдгээр дотроо дараах өөрчлөлтүүд гарсан байна.


Ач холбогдол өгмөөр хэмжээнд өссөн салбарууд:

- шүүх + 0.41,
- дэд бүтэц + 0.33,
- хууль тогтоох, шийдвэр гаргах + 0.31,
- хууль сахиулах + 0.27,
- хэвлэл мэдээллийн хэрэгсэл + 22. Бага хэмжээний өсөлт гарсан салбарууд:

- төрийн алба + 0.17
- барилга + 0.17,
- гадаадын хөрөнгө оруулалт + 0.12. Бууралт гарсан салбарууд:
- аж үйлдвэр - 0.39,
- бизнес, хувийн хэвшил - 0.18.

Уул уурхайн салбар бараг өөрчлөлтгүй гарсан ч (+ 0.04) нэгдүгээрт үнэлэгдэж байна.

График 8. Улс төрийн хүрээний авлигын чиглэл.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ 4.04 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.23 пунктээр өссөн байна (2018 оны үзүүлэлт 3.81).

Улс төрийн авлигын хэлбэрийг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлох бөгөөд энэ удаа бүгд өсөлттэй гарсан. Тодруулбаас тус бүр дараах өөрчлөлт гарсан байна.

1. Хээл хахуулийн хэлбэр + 0.25;
2. Хээл хахууль өгөх, авах аргууд + 0.08;
3. Бүлэглэлүүдийн нөхцөл байдал + 0.22;
4. Авлигын хэлбэр + 0.29;
5. Хууль бус нөлөөллийн хэлбэр + 0.16.

График 9. Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ.




Дэд үзүүлэлт 1. ХЭЭЛ ХАХУУЛИЙН ХЭЛБЭР

Улс төрийн хүрээн дэх хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ 3.84 гарч өмнөх оноос 0.25 пунктээр өссөн үзүүлэлттэй байна (2018 оны үзүүлэлт 3.59).

Хээл хахуулийн олон хэлбэр байгаагаас хамгийн түгээмэл гэж үзсэн дараах хэлбэрийг сонгон үнэлүүлсэн (график 10) болно. Улс төрийн авлигын хүрээн дэх хээл хахуулийн 13 хэлбэрээс бараг бүгдээрээ өссөн дүнтэй гарсан бол 2 хэлбэрийн хувьд бараг өөрчлөлт гарсангүй (+/- 0.06). Ингэхэд дараах хэлбэрүүдийн хувьд үзүүлэлт мэдэгдэхүйц өссөн байна:

- гадаадын банкинд данс нээж өгөх + 0.41,
- хувьцаа өгөх + 0.38,
- үнэтэй бэлэг өгөх + 0.35,
- бэлэн мөнгө өгөх + 0.34.

График 10. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ.




Дэд үзүүлэлт 2. ХУУЛЬ БУС НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР

Улс төрчид, өндөр албан тушаалтнууд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ нь 4.12 гарч өмнөх оноос 0.16 пунктээр өссөн байна (2018 онд 3.96).

Хууль бус нөлөөллийг тогтоох 9 дэд үзүүлэлт бараг бүгд өсөлттэй гарснаас “дарамт шахалт үзүүлэх” болон “айлган сүрдүүлэх” хэлбэр 0.55 болон 0.30 пунктээр тус бүр мэдэгдэхүйц өссөн байна. Харьцуулахад 2017-оос 2018 оны хооронд “дарамт, шахалт үзүүлэх” хэлбэр 0.16 пунктээр, айлган сүрдүүлэх хэлбэр 0.09 пунктээр буурч байсан байна.

График 11. Хууль бус нөлөөллийн үнэлгээ.



Дэд үзүүлэлт 3. УЛС ТӨРИЙН НАМ, БҮЛЭГЛЭЛ, УЛС ТӨР, БИЗНЕС, ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮДИЙН ХАРИЛЦАА ХАМААРАЛ

Төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчид болон улс төрийн нам, бүлэглэл, гадаад, дотоод бизнесийн бүлэглэл, гэмт бүлэглэлийн харилцаа хамаарлын үнэлгээ 3.96 гарч өнгөрсөн оноос 0.22 пунктээр өссөн байна (2018 оны үзүүлэлт 3.74).

Нийт 11 нөхцөл байдлын үзүүлэлтээс 1 үзүүлэлтийн үнэлгээ бага зэрэг буурч, бусад нь бүгд өсч, ингэхдээ 3 үзүүлэлтийн хувьд мэдэгдэхүйц өсөлт гарсан байна: “гэмт бүлэглэл улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан” + 0.43, “улс төрчид бизнесийн бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан” + 0.41, “улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан” + 0.34.

Хүснэгт 2. Бүлэглэлүүдийн харилцаа хамаарал, нөхцөл байдлын үнэлгээ.

Бүлэглэлүүдийн нөхцөл байдал		2018	2019	Өөрчлөлт
1	Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4.35	4.46	+ 0.11
2	Улс төрчид шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4.15	4.30	+ 0.15
3	Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.19	4.28	+ 0.09
4	Бизнесийн бүлэглэл улс төрчдийг эрхшээлдээ оруулсан	4.20	4.21	+ 0.02
5	Улс төрчид бизнесийн бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3.80	4.21	+ 0.41
6	Гэмт бүлэглэл улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3.29	3.72	+ 0.43
7	Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3.36	3.70	+ 0.34
8	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3.75	3.66	- 0.09
9	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3.42	3.63	+ 0.21
10	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	3.40	3.44	+ 0.04
11	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	3.27	3.40	+ 0.13


Дэд үзүүлэлт 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ 4.35 гарч өнгөрсөн оноос 0.29 пунктээр мэдэгдэхүйц өссөн үзүүлэлттэй байна (2018 оны үзүүлэлт 4.06).

Нийт 15 дэд үзүүлэлтийн бүгдэд нь тодорхой хэмжээний өсөлт гарснаас тал гаруйн хувьд мэдэгдэхүйц өссөн байна:

- аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох + 0.42,
- мөнгө угаах + 0.41,
- хууль бусаар дампууруулах + 0.40,
- төрийн өмчийг хувьдаа завших + 0.40,
- төсвийг хувийн ашиг сонирхлын дагуу хуваарилах + 0.38,
- төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулах + 0.34,
- ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулах + 0.30,
- албан тушаал, эрх мэдлээ хэтрүүлэх + 0.26,
- шан харамж авах, өгөх + 0.25,
- төрийн өмчийг хууль бус арга замаар хувьчлах + 0.22.

График 12. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэр.



Дэд үзүүлэлт 5. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ АРГА

Улс төрийн хүрээний хээл хахууль өгөх, авах аргуудыг хэрэглэсэн байдлын үнэлгээ 3.79 гарч өмнөх оноос 0.08 пунктээр өссөн байна (2018 оны үзүүлэлт 3.71).

Нийт 11 түгээмэл үзүүлэлтийн 3 үзүүлэлтийн үнэлгээ бага зэрэг буурсан бол бусад бүгд өсч, тэдгээрээс 3 нь мэдэгдэхүйц өссөн байна.


Дараах үзүүлэлтийн үнэлгээ мэдэгдэхүйц өссөн:

- хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх + 0.30,
- үйл ажиллагааны зардал болгож өгөх + 0.24,
- өмгөөлөгчөөр дамжуулах + 0.22.

Харин дараах үзүүлэлтийн үнэлгээ буурсан:

- эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах - 0.04
- эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах - 0.07
- биечлэн үүлзаж өгч, авах - 0.19.

График 13. Улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээ.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 3. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Улс төрийн авлигын шалтгаан нөхцөлийн үзүүлэлт 2019 онд 4.21 гарч өнгөрсөн оноос 0.12 пунктээр өссөн байна (2018 оны үзүүлэлт 4.09). Шалтгаан, нөхцлийн үзүүлэлтийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зорилгоор 3 дэд үзүүлэлтийн хүрээнд шинжилгээ хийж тодорхойлов.

Улс төрийн авлигын шалтгаан, нөхцлийн үзүүлэлтээс авлигад нөлөөлөх хүчин зүйлс (+ 0.09) болон авлигын түвшинд нөлөөлөх дутагдал, доголдолын үзүүлэлтэд (+ 0.15) бага зэргийн өсөлт гарч харин бүлэглэл, хүрээллүүдийн нөхцөл байдлын үзүүлэлт бараг өөрчлөлтгүй байв (+ 0.04).

График 14. Авлигын шалтгаан, нөхцөл.



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГАД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ 4.33 гарч өнгөрсөн оноос 0.09 пунктээр бага зэрэг өссөн байна (2018 онд 4.24).

Улс төрийн авлигын нөлөөллийг 11 дэд хүчин зүйлсээр хэмжсэн бөгөөд үүний 2 дэд үзүүлэлт (бараг) өөрчлөлтгүй, 2 дэд хүчин зүйлсийн үнэлгээ буурсан эерэг үнэлгээтэй байгаа бол 7 дэд хүчин зүйлсийн үнэлгээ өссөн сөрөг дүн гарсан байна.

“Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц” болон “хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил” үзүүлэлт 0.38 болон 0.30 пунктээр тус бүр хамгийн их өссөн бол “улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил” (- 0.23), “албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)” (- 0.15) үзүүлэлтэнд бууралт гарсан байна.

Хүснэгт 3. Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ.

	Авлигад нөлөөлөх хүчин зүйлс	2018	2019	Өөрчлөлт
1	Намын санхүүжилтийн механизм	4.58	4.63	+ 0.06
2	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.74	4.59	- 0.15
3	Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.43	4.48	+ 0.06
4	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4.21	4.40	+ 0.18
5	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4.05	4.35	+ 0.30
6	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	4.52	4.29	- 0.23
7	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	4.25	4.22	- 0.03
8	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4.19	4.19	0.00
9	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	3.81	4.19	+ 0.38
10	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	4.02	4.17	+ 0.16
11	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.90	4.05	+ 0.15

Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ДУТАГДАЛ, ДОГОЛДОЛ

Улс төрийн авлигад нөлөөлөх төрийн үйл ажиллагааны дутагдал, доголдлын нөлөөллийн үнэлгээ 4.28 гарч өнгөрсөн оноос 0.15 пунктээр өссөн байна (2018 оны үзүүлэлт 4.13).

Төрийн үйл ажиллагааны дутагдал, доголдлыг 12 дэд үзүүлэлтэд хамааруулж хэмжсэн бөгөөд үүний 11 дэд үзүүлэлтийн үнэлгээ өсөлттэй буюу сөрөг гарчээ. Ингэхдээ “төрийн үйлчилгээний хүртээмж муу” (+ 0.33), “хүнд суртал” (+ 0.27), “албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж” (+ 0.23), “шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг” (+ 0.22), “төрийн албан хаагчийн ур чадварын дутмаг байдал” (+ 0.21) хамгийн их өссөн байна.

Хүснэгт 4. Улс төрийн авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол.

	Алдаа, доголдол	2018	2019	Өөрчлөлт
1	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	4.24	4.48	+ 0.23
2	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.19	4.41	+ 0.22
3	ТАХ-ийн ур чадвар дутмаг	4.19	4.40	+ 0.21
4	Хүнд суртал	4.08	4.35	+ 0.27
5	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.26	4.32	+ 0.07
6	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	4.21	4.31	+ 0.10
7	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	4.17	4.27	+ 0.09
8	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	4.21	4.25	+ 0.04
9	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	4.11	4.23	+ 0.12
10	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	4.27	4.22	- 0.05
11	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.97	4.11	+ 0.14
12	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	3.68	4.02	+ 0.33

Дэд үзүүлэлт 3. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХҮРЭЭЛЛҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улс төрийн хүрээн дэх тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн хүрээллийн нөхцөл байдал буюу ямар төрлийн хүрээллүүд түгээмэл байгаа талаарх үнэлгээ 3.93 гарч өнгөрсөн оноос 0.04 пунктээр өссөн буюу бараг өөрчлөлтгүй байна (2018 оны үзүүлэлт 3.89).

Нийт 7 дэд үзүүлэлтээс 3 дэд үзүүлэлтийн үнэлгээ буурсан, 1 үзүүлэлтийн үнэлгээ өссөн, 3 үзүүлэлтийн үнэлгээ бараг өөрчлөлтгүй дүнтэй гарчээ. “Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нам *дамнасан* хүрээллийн” үзүүлэлт - 0.11, “хувийн эрх ашгийг илүүд үзсэн, найз нөхдийн хүрээллийн” үзүүлэлт - 0.09, “хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нам *тойрсон* хүрээллийн” үзүүлэлт - 0.08 пунктээр буурсан бол “нийтийн эрх ашгийн төлөө хүрээллийн үнэлгээ” 0.40 пунктээр өссөн нь анхаарал татаж байгаа ч 2015 болон 2016 оны үзүүлэлттэй ижил түвшинд байна.

График 15. Улс төрийн хүрээ дэх хүрээллүүдийн нөхцөл байдал.




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Улс төрийн авлигын түвшний шалгуураас авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 2019 онд 3.98 гарч өнгөрсөн оноос 0.17 пунктээр өссөн байна (2018 онд 3.81).

Хор уршиг, үр дагаврын үзүүлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлийг хоёр дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлов. Ингэхэд улс төрийн авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 0.07 пунктээр буурч, харин авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үзүүлэлт 0.29 пунктээр нэмэгдсэн байна.

График 16. Улс төрийн авлигын хор уршиг, үр дагавар.



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ

Улс төрийн авлигын хор уршгийн үзүүлэлтийн үнэлгээ 4.06 болж өнгөрсөн оноос 0.07 пунктээр өссөн байна (2018 оны үзүүлэлт 4.09).


Нийт 16 дэд үзүүлэлтээс 8 үзүүлэлтийн үнэлгээ өссөн байна. Ингэхэд дараах үзүүлэлтийн үнэлгээ хамгийн их өссөн:

- Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан + 0.24,
- хүний эрхийн зөрчил нэмэгдсэн + 0.22,
- ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан + 0.21,
- улс орны эдийн засгийн хүч чадал суларсан + 0.19,
- шударга ёс алдагдсан + 0.15,
- ядуурал нэмэгдсэн + 0.11,
- гэмт хэрэг нэмэгдсэн + 0.10. Харин 5 үзүүлэлтийн үнэлгээ буурсан:

- хуулийн хэрэгжилт суларсан - 0.12,
- байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэн - 0.07,
- нийгмийн дэг журам алдагдсан - 0.06,
- төрийн албаны чадавхи суларсан - 0.05,
- гадаадын зээл тусламжийн үр ашиг буурсан - 0.04.

Гадаадын хөрөнгө оруулалт буурсан, ажилгүйдэл нэмэгдсэн, өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдсэн гэсэн үзүүлэлтүүд бараг өөрчлөлтгүй байв (-/+ 0.1-02).

График 17. Улс төрийн хүрээний авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин.




Дэд үзүүлэлт 2. АВЛИГААР ОЛСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээ 3.81 гарсан нь өнгөрсөн оноос 0.29 пунктээр өссөн байна (2018 оны үзүүлэлт 3.52). Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын талаар улс төрийн болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд нэгтгэсэн нэг асуултаар үнэлүүлсэн.

Уг үзүүлэлт хамаарах 19 дэд үзүүлэлтийн 17 үзүүлэлтийн үнэлгээ ямар нэг хэмжээнд өссөнөөс “хөшөө дурсгал, суварга босгох” (+ 0.59), “эмчилгээнд зарцуулах” (+ 0.56), “хурдан морь худалдан авах” (+ 0.45), “урлагийн бүтээл худалдан авах” (+ 0.42), “гадаадад орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах” (+ 0.39), “гэр бүлийн гишүүний сургалтын төлбөрт зарцуулах” (+ 0.38), “гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах” (+ 0.35) хэлбэрүүдийн үнэлгээ хамгийн их өссөн байна.

Харин “дотоодын банкинд хадгалах” гэсэн нэг л үзүүлэлт буурч (-0.05), “өдөр тутмынхаа хэрэгцээд зарцуулах” гэсэн нэг л үзүүлэлт хэвээр байна ($+0.01$).

График 18. Улс төрийн (түүнчлэн шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний) авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт.




ХОЁР. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлгийн хүрээнд улс төрийн авлигын үндсэн үнэлгээнээс гаднах бусад үзүүлэлтүүдийн байдлаар авлигын ерөнхий ойлголт, төсөөллийг дэлгэрүүлж гаргаж ирэхийг зорьсон болно.

АВЛИГЫН ТҮВШИН

Судалгааны хүрээнд улс төрийн хүрээгээр хязгаарлалгүй Монголын нийгэм дэх авлигын ерөнхий хандлага, түгээмэл байдлыг шинжээчдээр үнэлүүлэхэд 56.1 хувь нь их болон маш их гэж үнэлсэн байгаа юм.


График 19. Монголын нийгэм дэх авлигын түвшин.



УЛС ТӨРИЙН НАМУУДЫН АВЛИГАД АВТСАН БАЙДАЛ

Судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлгээгээр 2019 онд улс төрийн намуудын авлигад автсан байдлыг тус бүрд нь тооцож үзвэл Монгол Ардын Нам болон Ардчилсан Нам хоёр ижил хэмжээнд тус бүр 40.7 болон 37.9 хувьтайгаар авлигад хамгийн их автагдсанаар тооцогдож байна. Удаагаар Монгол Ардын Хувьсгалт Нам 15.0 хувьтай, Хөдөлмөрийн Үндэсний Нам 3.6 хувьтай үнэлэгдэж байна.

График 20. Монгол Улс дахь улс төрийн намуудын авлигад автсан байдал.



АВЛИГЫН ХҮРЭЭНИЙ ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Монголын нийгэм дэх авлигын ерөнхий хандлагын зэрэгцээ цар хүрээгээр нь тодорхойлохыг зорьсон юм. Улс орны авлига ямар түвшинд байгаа нь цар хүрээний тархацтай шууд холбоотой юм. Нийт 11 дэд хүрээнээс 9-д нь 40%-иас дээш авлига “их” болон “маш их” хэмжээнд түгээмэл гэж шинжээчид үнэлсэн юм. Ингэхдээ засгийн газрын хүрээнд авлигын тархалтын үзүүлэлт хамгийн өндөр гарч, удаагаар

төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, улс төрийн намын, УИХ, прокурор, шүүх байгаа бол төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хүрээнд харьцангуй бага пункттэй гарчээ. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн “их” болон “маш их” гэсэн үнэлгээний нийлбэр 40.9 хувьтай байгаа нь анхаарал татаж байна.

Хүснэгт 5. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдал (%)

		Огт үгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Их	Маш их	Σ “их/ маш их”
1	Засгийн газар (яам, агентлаг)	0.0%	3.0%	9.1%	39.4%	47.0%	86.4%
2	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой ААН	0.0%	3.0%	10.6%	27.3%	48.5%	75.8%
3	Улс төрийн нам	1.5%	6.1%	9.1%	33.3%	42.4%	75.8%
4	Улсын Их Хурал	0.0%	9.1%	4.5%	40.9%	33.3%	74.2%
5	Прокурор	0.0%	4.5%	12.1%	28.8%	43.9%	72.7%
6	Шүүх	0.0%	7.6%	12.1%	27.3%	43.9%	71.2%
7	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	0.0%	4.5%	21.2%	30.3%	34.8%	65.2%
8	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	0.0%	9.1%	28.8%	25.8%	22.7%	48.5%
9	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3.0%	7.6%	31.8%	19.7%	21.2%	40.9%
10	Хувийн хэвшил	12.1%	34.8%	19.7%	12.1%	3.0%	15.2%
11	Төрийн бус байгууллага	22.7%	28.8%	16.7%	1.5%	3.0%	4.5%

Хэрэв индексжүүлж өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал дараах дүр зураг харагдана.

Хүснэгт 6. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдал (индекс)

		2018 оны үнэлгээ	2019 оны үнэлгээ	Өөрчлөлт
1	Төрийн болон орон нутгийн өмчит ААН	3.83	4.36	+0.53
2	Засгийн газар (яам, агентлаг)	4.27	4.32	+0.05
3	Прокурор	4.00	4.25	+0.25
4	Шүүх	4.09	4.18	+0.10
5	Улс төрийн нам	4.28	4.18	-0.10
6	Улсын Их Хурал	4.02	4.12	+0.10
7	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	3.84	4.05	+0.21
8	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	3.57	3.72	+0.15
9	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3.91	3.58	-0.33
10	Хувийн хэвшил	2.75	2.50	-0.25
11	Төрийн бус байгууллага	2.27	2.08	-0.19

АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛСӨН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгааны хүрээнд Монгол Улс дахь авлигын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар шинжээчдээс нээлттэй хэлбэрээр асуухад нийт 54 нь хариулт өгснийг тус бүрт нь хүснэгтэнд харуулж байна.

Хүснэгт 7. Монгол Улсын авлигын ерөнхий түвшинд нөлөөлсөн гол хүчин зүйлс, нөхцөл байдал.

	Хариулт
1	1. Авилга сүүлийн 5 жилд эрс өссөн. Авилгын түвшин тогтоолт бодит бус юм. 2. Улс орны удирдлага нь олигархийн гар хөл гэмт хэрэгтэнүүд учраас өөрчлөлт гарахгүй
2	1. Авилгажсан нам, 2. Худалдаж авсан албан тушаал, 3. Хүнд суртал, 4. Хуулийн хийдэл, зөрчил, давхцал
3	Rent-seeking behaviour, Төрийн албаны чадавхи, ёс зүй, Resource Curse
4	Авилга авсан гэж үзээд мэдэгдсэн ч ял шийтгэлгүй замхран алга болдог. Нөхөн төлбөр авдаггүй.
5	Авилга УИХ-ын гишүүдийн дунд дэлгэрснээс болоод авилгын нөхцөл байдал муудсан
6	Авилгатай тэмцэх ажил бага зэрэг идэвхижнээс авилга буух хандлагатай байгаа. Гэвч хэрэгжилт нь муу байгаагаас үр дүн сайнгүй байгаа
7	Авилгын мэдээлэл, баримт, тохиолдлуудыг талууд маш их улс төржүүлдэг. Улс төрчид өөрт ашигтай байдлаар нөлөөлөн дэмждэг буюу зогсоодог болсонтой холбоотой
8	Ажил олгогчийн эрх ашиг хязгаарлагдсан. Ажилчдын эрх ашиг дээгүүр тавигдсан. Сул орон тоо, нүсэр бүтцийг бий болгосон. Ажлын бүтээмж үр дүнг тооцохгүй байна.
9	Албан тушаалын томилгоо шударга бус ба чадваргүй төрийн албан хаагчид олширсон. Томилсон даргадаа үйлчилдэг байдал. Ёс зүйгүй хариуцлагагүй байдал газар авсан.
10	Дээд түвшний албан тушаалтнуудын дураараа авирлалт, хуулийн байгууллагын хараат байдал (тэрнээс)
11	Дээд түвшний буюу нам дамжсан бүлэглэл, франкцын үйл ажиллагааны эсрэг нам дотроо томоохон өөрчлөлт <<цэвэрлэгээ>> хийсэн. Дээд түвшинд өөрчлөлт, шинэчлэлт хийж болдгийг олон нийтэд харуулсан.
12	Ёс суртахууны доройтол. Хүмүүжлийн доголдол. Шунал. Эрх мэдлийн төлөө өрсөлдөөн.
13	Ёс суртахууны үнэлэмж, тогтоолт байхгүй
14	Клиенталист сүлжээ, улс төржилт нөлөөлж байна. Томилгоо, тендер авилгатай холбогдож байна.
15	Монгол улсын засаглал тогтворгүй, төр барьж байгаа хүмүүс өөрсдөө авилгад автсан, хуулийн хэрэгжилт байхгүй, гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх, хэвлэл мэдээлэл гээд засаглалын бүтцүүдийн чиг үүрэг холилдсон
16	Нийгмийн сэтгэхүй, ёс суртахууны доройтол, дүрэм журам хуулийн хэрэгжилт муу учраас
17	Нэг жилийн хугацаа бүхэл системд онц нөлөөлөөгүй. Хэвэндээ байгаа.
18	Онц өөрчлөлт байхгүй болов уу. Шүүх байгууллага, хууль хэрэгжүүлэх байгууллагуудын томилгоотой холбоотойгоор эрх мэдэл нэг бүлгээс нөгөөд шилжих үйл явж явагдаж байна. Авилга сүртэй ихэсч буураагүй болов уу.
19	ОТ гэрээг өөрчлөх, зардлыг шалгах ажил, мөн санхүүгийн хямрал зэргээс хөрөнгө оруулагчид үндэсний том корпорациуд хуульд нөлөөлөх зорилгоор их хэмжээний авилга өгч байна.
20	Өмнөхөө багасч буй хэдий ч бүр далд хэлбэрт шилжиж байгаа. Тендерийг бүтээж өгсний хувийг бэлнээр авахаас илүүтэй хамааралтай компаниар, санал болгосон компаниар гүйцэтгүүлэх гэх мэт
21	Салбар салбартаа л аливаа зүйл хаалттай шахуу байдагт байх

22	Сүүлийн 1 жилийн дотор яг нөлөөлөөд ихэсгэсэн гэхээсээ илүүтэйгээр аль ч түвшиндөө авлига ер буурахгүй байгаа нь үүсгээд байгаа нөхцөл шалтгаан нь амь бөхтэй оршсоор ялангуяа дээд түвшний авилгын хэрэг шийдэгдэхгүй замхраад байгаатай шууд холбоотой
23	Сүүлийн 20 гаруй жилд зөвхөн 2 намын эрхшээлд хэт автаж, хөгжил бүхэлдээ чөдөрлөгдсөн. Систем гажсан. Эрх баригч нарын нөлөө төр захиргааны бүх шатанд нэвт шингэсэн. Иргэдийн орлого буурч, ядуурал, ажилгүйдэл ихэссэн. Мэдээлэл, далд, ил тод бус. ХНХ хараат байдал дэндүү.
24	Тодорхой бус эрхзүйн орчин
25	Төр засгийнх нь ажлын хоорондын уялдаа холбоо байхгүй, үйл ойлголцол байгаа учраас төрийн албан хаагчид нэгдсэн удирдлагаар хангагдахгүй, тодорхойгүй байдал үүсээд байна.
26	Төр, засгийн эрхийг авахын тулд бүлэглэл үүсгэж, тухайн бүлэглэлийн ямар нэг аргаар мөнгөтэй болохыг урьтал болгодог.
27	Төрийн албаны хүнд суртал, олон дамжлага
28	Төрийн байгууллагад шилэн данс хэрэгжихгүй болсон.
29	Төрийн байгууллагын хүн суртал, олон дарга нарын дамжлага, намын харьяалал
30	Төрийн дээд албан тушаалтнуудын албан тушаалын хүрээнд ажлын байрыг дураараа солих явдал
31	Төрийн дээд болон дунд албан тушаалтнууд хууль хэрэгжүүлдэггүй, нам эвсэл, танил тал, төрөл төрөгсдөө албан тушаалд томилж хамгаалдаг. Хууль эрхзүйн орчин муу
32	Төрийн тогтворгүй байдал, улс төржилт
33	Төрийн тогтолцоо муу
34	Төсвийн зардал ихсэж, төрийн хяналт суларсан
35	Удирдлагын түвшний болон шийдвэр гаргах түвшний хүмүүс зөвхөн хувийн баяжих сонирхолтой учраас
36	Улс төр, бизнесийн бүлэглэл төрийн эрх мэдлийг авсан
37	Улс төрийн буруу тогтолцоо бий болж, хээл хахууль эрх мэдлийг гааршуулсан явдал
38	Улс төрийн сонгууль, томилгоо шударга бус, цалин бага, төрөөс хамаарсан зөвшөөрөл, лиценз их байдгаас шалтгаална.
39	Улс төрийн тогтворгүй байдал
40	Улс төрийн тогтворгүй байдал, Мэдлэг боловсролтой хүмүүс төрийн албыг хаших боломж олгох, Албан тушаалыг мөнгө гэж харах хандлага бий болсон
41	Улс төрийн тогтворгүй байдал, нам, улс төрчдийн улс төрийн сонирхол, төрийн нөөцийг ашиглахыг хүссэн улс төр-бизнесийн бүлэглэл нөлөөлж байна.
42	Хариуцлага тооцож чадахгүй, шалгаад хэрэг үүсгээд хаадаг
43	Хариуцлагагүй байдал, ёс суртахуун, шунал, мөнгөний сонирхол
44	Хариуцлагын тогтолцоо хэт суларсан. Хэн ч хариуцлага хүлээхгүй бийна. Хууль нь оновчтой биш.
45	Хуулийн хэрэгжилт муу. Шийдвэр гаргагчдын муу үлгэр дуурайлал. Шийтгэл ногдуулдаггүй байдал.
46	Хуулийн хэрэгжилт сул. Хяналт тавьдаггүй.
47	Хууль сахиулах, хуулийн хэрэгжилт суларсан. Хууль дээдлэх зарчим алдагдсан. Шүүх засаглал шударга бус шийдвэр гаргадаг. шүүгч нар авилгад өртөх болсон. олон нийтийн хяналт суларсан, давхар хянах зарчим алдагдсан. АТГ ажлаа сайн хийж байгаа.
48	Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл улс төрийн өрсөлдөгч нэг бүлгээс нөгөөд шилжсэн нь авлигын талаарх нөхцөл байдлыг хувийн зүгээс үнэлэхэд хэрэгтэй мэдээллийг нийгэмд цацсан. Гэхдээ энэ нь хэт улс төржих, эцэстээ үр дүн багатай төгсгөлд хүрэх эрсдлийг агуулж байна.

49	Хууль эрх зүйн орчин таатай бус бөгөөд төр хувийн хэвшлийн харилцаа тогтворгүй, нөгөө талаас улс төр тогтворгүй, хууль хяналтын байгууллагын удирдлагын томилгоо нь улс төрөөс хамааралтай.
50	Хүн амын ядуурал, Ажилгүйдэл авилгын үр дүн. Хууль эрх зүйн орчин сул байгаатай холбоотой. Мөн АТГ, Прокурор, Шүүх байгаа авилгын эсрэг тэмцлийг дорвитой хийхгүй байна. Улс төрийн хүрээний авилга, хээл хахууль далд хэлбэрт байгаатай холбоотой.
51	Хэт улс төржин, аливаа ажлыг улс орны эрх ашгийн төлөө бус зөвхөн хэдхэн цөөн бүлэглэлд зохицуулж ажиллаж байгаагаас гэж үзэж байна.
52	Шүүхээр шийдэгдсэн тохиолдол бага. Шалгаж байгаа ч шүүхийн шийдвэр гардаггүй.
53	Эдийн засгийн өсөлттэй гэх боловч эдийн засаг хумигдаж байна. Ихэнх ажил төрийн захиалга, худалдан авалт болж байгаа тул түүнийг дагаад авлига өссөн
54	Эрхзүйн орчин хангалтгүй, ЭХХШ-ийн хууль цоорхой ихтэй. мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтнууд хууль буруу хэрэглэх, нөлөөнд автах нь түгээмэл.

БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЗАРЦУУЛЖ БУЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ

Бизнес эрхлэгчид үйл ажиллагааныхаа явцад өгч буй авлигын үнэлгээг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл тусгай зөвшөөрөл авахад, тендерийн шалгаруулалтад ялахад, төсөл хөтөлбөрт хамрагдахад илүү өндөр авлига өгдөг гэжээ.

Хүснэгт 8. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ (%)

		<5 хувь	6-10 хувь	11-15 хувь	16-20 хувь	21< хувь
1.	Тусгай зөвшөөрөл авахад	4.5%	15.2%	9.1%	19.7%	28.8%
2.	Тендерийн шалгаруулалтад ялахад	0.0%	24.2%	18.2%	16.7%	27.3%
3.	Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	3.0%	25.8%	15.2%	16.7%	18.2%
4.	Хяналт шалгалтаар зөрчил дутагдалгүй гарахад	7.6%	21.2%	9.1%	16.7%	18.2%
5.	Татвараас чөлөөлүүлэх, бууруулахад	7.6%	15.2%	21.2%	13.6%	16.7%
6.	Гадаадаас ажиллах хүч авахад	12.1%	7.6%	18.2%	10.6%	16.7%
7.	Бараа, ажил, үйлчилгээ хүлээлгэн өгөхөд	10.6%	18.2%	13.6%	12.1%	18.2%
8.	Өр төлбөр барагдуулах, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэхэд	10.6%	15.2%	18.2%	15.2%	7.6%
9.	Зээл авахад	9.1%	27.3%	24.2%	13.6%	7.6%

ХЭЭЛ ХАХУУЛЬД ЗАРЦУУЛСАН МӨНГӨНИЙ ХЭМЖЭЭ

Хээл хахуульд өгч буй мөнгөн дүнг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход, гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад зэрэгт хамгийн их өгдөг гэж шинжээчид хариулжээ.


Хүснэгт 9. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ /зорилгоор/, сая төгрөгөөр.

		<1 сая	1-5 сая	5-10 сая	10-20 сая	20-50 сая	50 сая <
1	Ашиг сонирхолдоо нийцсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад	1.5%	3.0%	4.5%	7.6%	9.1%	50.0%
2	Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход	1.5%	1.5%	4.5%	13.6%	12.1%	40.9%
3	Гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад	1.5%	6.1%	7.6%	16.7%	10.6%	31.8%
4	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход	4.5%	4.5%	7.6%	16.7%	18.2%	27.3%
5	Эрүүгийн хэрэг үүсгэхэд	6.1%	7.6%	7.6%	13.6%	13.6%	24.2%
6	Тусгай зөвшөөрөл авахад	3.0%	3.0%	9.1%	27.3%	21.2%	21.2%
7	Ажил, албан тушаалд ороход	4.5%	15.2%	15.2%	18.2%	16.7%	13.6%
8	Хуурамч бичиг баримт үйлдэхэд	4.5%	15.2%	10.6%	15.2%	10.6%	12.1%

ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улс төрийн (дээд түвшний) авлигатай тэмцэх үйл ажиллагааны сэдэвтэй холбогдуулан шинжээчдээс хаалттай хэлбэрээр нийт 21 арга хэмжээний ач холбогдлын талаар асууж үнэлүүлсэн юм. Өгсөн ач холбогдлоор нь эрэмбэлэхэд дараах дүр зураг харагдаж байна.

График 21. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ.



ГУРАВ. ШИНЖЭЭЧДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

График 22. Шинжээчдийн хүйс.




График 23. Шинжээчдийн нас.





График 24. Шинжээчдийн салбарын хаярьяалал.



ДУГНЭЛТ

2019 оны улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 4.08 гарлаа. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс 0.15 пунктээр өссөн үзүүлэлт боллоо. Ингэхдээ индексийг бүрэлдүүлэх үндсэн дөрвөн шалгуур бүгд өсч, тус бүр 0.12-оос 0.23 пунктээр нэмэгдсэн. Үүнийг хувьд шилжүүлбэл индекс 3%-иар, шалгуурууд 2.4%-өөс 4.6%-ийн хооронд өссөн гэж ойлгож болно. Үндсэн шалгууруудыг бүрдүүлэгч дэд үзүүлэлтүүдийн түвшинд ч буурсан тохиолдол цөөн, бараг бүгд харьцангуй жигд өссөн хандлага ажиглагдана.

Авлигын *цар хүрээний* хувьд (+0.14) салбар хүрээ болон байгууллага, институци дахь тархалт, түгээмэл байдлын үзүүлэлтэд өөрчлөлт гараагүй бол төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын түвшин болон улс төрийн авлигын чиглэгдсэн байдлын үнэлгээнд өсөлт гарсан. Ингэхдээ тусгай сангуудын үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтын үзүүлэлт дээр, чиглэлийн хувьд шүүх, хууль тогтоох, хууль сахиулах, түүнчлэн дэд бүтэц, хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр хамгийн их өсөлт гарсан. Түвшний хувьд авлигын түгээмэл байдал болон үйл ажиллагаан дахь авлига хамгийн өндөр байна.

Авлигын *хэлбэрийн* хувьд (+0.23) хээл хахуулийн хэлбэр, авлигын хэлбэр болон бүлэглэлүүдийн нөхцөл байдлын үнэлгээн дээр тодорхой хэмжээний өсөлт гарсан. Түвшний хувьд авлигын хэлбэр болон хууль бус нөлөөллийн хэлбэр хамгийн өндөр үнэлэгдсэн. Ажил, албан тушаалд томилох, албан тушаал, эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэх, эдгээрийг даган нийтийн эд хөрөнгийг төрөл бүрээр завших болон сонгогчдын саналыг худалдан авах явдал авлига, хээл хахуулийн хамгийн чухал хэлбэр байсаар байна. Хууль бус нөлөөллийн хувьд төрөл бүрийн хэлхээ холбоог ашиглах үндсэн хэлбэр болохын зэрэгцээ дарамт, шахалт үзүүлэх үзүүлэлт эрс өсч тэргүүлэх зэрэгт үнэлэгдсэн. Бүлэглэлүүдийн нөхцөл байдлын хувьд төдийлөн өөрчлөлт гараагүй бөгөөд улс төр-бизнесийн бүлэглэл болон улс төр-шүүх, хууль сахиулахын албан тушаалтнуудын хууль бус ашиг сонирхлын нэгдэл голлох байр суурьтай байна.

Улс төрийн авлигын *шалтгаан нөхцлийг* (+0.12) бүрдүүлэгч шалгууруудын хувьд өсөлт бага хэмжээнд гарсан ч үнэлгээ нь өндөр байна. Улс төрийн авлигад нөлөөлөх хүчин зүйлсийн дунд намын санхүүжилтийн механизм, албан тушаалын томилгоо, сонгуулийн санхүүжилтийн механизм, шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил голлох үүрэг гүцэтгэж байгаа бол төрийн албан дахь алдаа доголдлын дунд албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж, шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг байдал, төрийн албан хаагчийн ур чадварын дутмаг байдал, хүнд суртал, хариуцлага тооцдоггүй байдал хамгийн сөргөөр үнэлэгдсэн байна. Хүрээллүүдийн нөхцөл байдлын хувьд төдийлэн өөрчлөлт гараагүй ба нам тойрсон болон нам дамнасан хүрээллүүд хамгийн түгээмэлд тооцогдож байна.

Улс төрийн авлигын *хор уршигийн* өсөлтөнд (+0.17) авлигын замаар олсон хөрөнгийн зарцуулалтын үзүүлэлт мэдэгдэхүйц өссөн нь нөлөөлснөөс хор уршиг, үр дагаврын үзүүлэлт нь бүхэлдээ төдийлөн өсөөгүй болно. Гэхдээ дэд үзүүлэлтийн түвшинд Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан, хүний эрхийн зөрчил нэмэгдсэн, ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан, улс орны эдийн засгийн хүч чадал суларсан гэсэн үзүүлэлт дээр тодорхой хэмжээнд өсөлт гарсан.

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ИРГЭДИЙН АВЛИГЫН ТАЛААРХ
ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫГ
ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА-2019**



I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны ажлын үндэслэл, зорилго

Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд авлигын нөлөөллийг бууруулах шаардлага бодитоор оршин буйн зэрэгцээ түүний хамрах хүрээ, шалтгааныг илрүүлэх, тэмцэх чиглэлээр оролдлогууд тасралтгүй хийгдсээр байгаа билээ. Үүний нөлөөнд хууль эрх зүйн орчин боловсронгуй болж, зарим ахиц дэвшлүүд гарч байгаа хэдий ч олон улсын болон дотоодын судалгааны байгууллагуудын дүгнэлтээр Монгол дахь авлигын үзүүлэлтүүд төдийлөн багасахгүй байна.¹

Авлига нь ядуурал, тэгш бус байдлын гол үүсгэгч болохыг харуулсан судалгаанууд байдаг² бөгөөд хүн амын эмзэг бүлэг, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь төрийн ажил, үйлчилгээнээс ихээхэн хамааралтай байдгаараа авлигад илүү өртөмхий, авлигын хэмжээ нь тэдний орлогын өндөр хувийг эзэлдэг тул хүн амын бусад хэсэгтэй харьцуулахад хамгийн их хохирдог тухай НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн тайланд дурджээ. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах төрийн байгууллага, албан тушаалтны үүрэг хариуцлага, эерэг манлайлал нэн шаардлагатай юм.

Гэтэл МУ-ын Хүний эрхийн үндэсний комиссын 2018 оны тайланд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн оролцоход учирч буй саад бэрхшээлийг арилгахад төрийн байгууллагууд хойрго хандаж байгааг дурдсан байна.³

Иймд дээрх нөхцөл байдалд авлига, хүнд суртал нөлөөлж буй эсэхийг тодруулах, хэрэв тийм бол түүний шалтгаан, онцлогыг тодорхойлох шаардлага үүсч байна. Энэ тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн бэрхшээлийн онцлогоос хамаарч төрийн ямар нэг үйлчилгээ авахад авлигын талаарх мэдлэг, ойлголт дутуу байдал үүсдэг эсэх, тэр нь авлигын асуудалд холбогдох, хохирогч болоход нөлөөлдөг эсэхийг тодруулах шаардлагатай юм. Цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг хэрхэн явуулах талаар бодлого, саналуудыг боловсруулж хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Түүнчлэн авлигатай тэмцэх нь нэг байгууллага дангаар хэрэгжүүлэх ажил биш болж институцийн хөгжил, иргэний нийгмийн хяналт, оролцоонд тулгуурлах болсноор иргэдийг мэдээллийн ил тод байдлаар хангаж эхэлсэн өнөө үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийн хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх, түүнд тулгуурласан идэвхтэй хяналт, оролцооны асуудал мөн чухлаар тавигдаж байна.

Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, авлигын асуудалд хандах хандлага, авлигатай холбоотойгоор гарч буй эрсдэлүүдийг тодорхойлж, цаашид авлигыг бууруулах, авлигатай тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэхэд ашиглах санал, зөвлөмж дэвшүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- Авлига, түүний нөхцөл байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүрээн дэх уг үзэгдлийг онол, практикийн талаас судлах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох асуулга боловсруулж, үнэлгээ хийх

¹ Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа, Азийн Сан, 2000-2019 он.

² Eric Chetwynd, Frances Chetwynd, Bertram Spector, Авлига ба ядуурал: судалгааны тойм, 2003 он.

³ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл, Хүний Эрхийн Үндэсний Комисс, 2018 он.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авлигын асуудлаас сэргийлэхэд чиглэсэн бодлого, орчныг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах

1.2. Судалгааны арга, аргачлал

Судалгааны зорилго, судлах асуудал, судалгааны асуулга, хамрах хүрээ, хязгаарыг 2019 оны 10 дугаар сард МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш нар, “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ-ын судлаачдын багийн хамтарсан хэлэлцүүлгийн хүрээнд тодорхойлсон. Үүнийг Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны санал, зөвлөмжид үндэслэн эцэслэн боловсруулсан болно. Мөн Засгийн газрын гүйцэтгэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга, ажилтнуудтай уулзаж судалгаа хийх хэрэгцээ шаардлага, онцлогийн талаар санал солилцсон.

Судалгааг тоон болон чанарын судалгааны арга зүйгээр явуулж, анкетийн асуулга, фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага хийх замаар мэдээллийг 2019 оны 11 сарын 01-ээс 11 сарын 29-ны хооронд цуглуулж судалгааны дүнг нэгтгэлээ. Үүнд:

- Анкетийн асуулгыг судалгаанд хамруулах нийт респондентуудаас авсан.
- Фокус бүлгийн ярилцлагыг харааны бэрхшээлтэй, сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлтэй тус тус хийлээ.
- Ганцаарчилсан ярилцлагыг буцаалттай түүврийн аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд судалгааг төлөвлөгөөний дагуу хугацаандаа гүйцэтгэж дүгнэлээ.

Судалгааны дүнг мэдээлэл боловсруулах SPSS программ ашиглан нэгтгэн дүгнэсэн болно.

1.3. Судалгааны хамрах хүрээ, түүвэр


2019 оны нэгдүгээр сарын байдлаар Улаанбаатар хотод 18 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй нийт 35580 гаруй иргэд амьдардаг гэсэн Үндэсний статистикийн хорооны 2019 оны статистик байна. Судалгааны түүврийн хувьд судалгаанд оролцох боломжтой 18 болон түүнээс дээш насны иргэдийг хамруулах бөгөөд судалгааны түүвэрлэлтийн алдааны нарийвчлал ± 5 хувь байхаар, үнэмшлийн түвшин 95 хувийн магадлалтайгаар тооцоход түүврийн хэмжээг 378 гэж тооцоолсон. Ингэхдээ Улаанбаатар хотод амьдардаг хөдөлгөөний бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй, сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч болон бусад төрлийн бэрхшээлтэй иргэдээс нийт 355 судалгааг тоон судалгааны аргаар авлаа. Харин чанарын судалгааны аргаар судалгааг авахад фокус бүлгийн ярилцлагад 12, ганцаарчилсан ярилцлагад 35 хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцлоо.

Хүснэгт 1: Судалгаанд оролцогчдын хөгжлийн бэрхшээлийн төрөл

Бэрхшээлийн төрөл	Судалгаанд оролцсон	Судалгаанд эзлэх %
Хөдөлгөөний бэрхшээлтэй	116	32.7%
Харааны бэрхшээлтэй	71	20.0%
Сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй	77	21.7%
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч	57	16.1%
Бусад бэрхшээлтэй	34	9.6%
НИЙТ	355	100%

Судалгаанд оролцогчдын түүврийг бүрдүүлэхэд төрийн байгууллагаар үйлчлүүлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагчдын төлөөллийг хамруулахаар болсон тул энэ жилийн судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч болон бусад бэрхшээлтэй иргэдийг оролцуулсан.

График 1: Судалгаанд оролцогчдын хүйс



Судалгаанд нийт 355 оролцогч хамрагдсанаас 59% нь эрэгтэй, 41% нь эмэгтэй байна. Судалгаанд оролцогчдын насны хувьд 26-35 (39%), 36-50 (30%) насны оролцогчид давамгайлжээ.

График 2: Судалгаанд оролцогчдын нас




График 3: Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин





График 4: Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлт



Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин харьцангуй өндөр буюу 40% нь дээд боловсролтой, 30% нь бүрэн дунд боловсролтой байна. Дээд боловсролтой иргэдийн хувь өндөр байгаа нь энэ жилийн судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид болон бусад бэрхшээлтэй иргэд нэмэгдсэн нь боловсролын болон ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэхэд нөлөөлсөн болно. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд төрийн бус байгууллагад ажиллагсад, МСҮТ-ийн оюутан, группт болон ажилгүй гэж хариулсан оролцогчдын хувь харьцангуй өндөр байна.

II. СУДАЛГААНЫ ДҮН

2.1. Авлигын талаарх ойлголт, хандлага

Тоон судалгааны аргаар:

Асуулт - 1. Та дараах байр суурьтай санал нийлж байна уу?

Хүснэгт 2: Авлигын талаарх нийтлэг байр суурь

	1.1 Авлига манай улсад нийтлэг үзэгдэл болсон.	1.2 Авлига тодорхой хэмжээнд байхыг хүлээн зөвшөөрнө.	1.3 Хүнд суртлыг шийдвэрлэх арга зам нь авлига өгөх явдал юм.	1.4 Авлига шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг.
Санал нийлж байна	75%	10.6%	24%	23.7%
Бага зэрэг санал нийлэхгүй	11.5%	12.8%	10.6%	19%
Төдийлөн санал нийлэхгүй	4%	14.6%	13.4%	10.3%
Огт санал нийлэхгүй	4.4%	53.3%	46.1%	38%
Мэдэхгүй	5.3%	8.7%	5.9%	9%
нийт	100%	100%	100%	100%

Авлигатай тэмцэх газрын захиалгаар 2018 онд “Хэрэглээний Боловсрол Судлал” ТББ-ийн хийсэн судалгааны дүнтэй харьцуулж үзвэл авлига манай улсад нийтлэг

үзэгдэл болсон гэж үзэх иргэдийн тоо өмнөх оноос 2.5 хувиар буурч 75 хувьтай болсон бол санал нийлэхгүй иргэдийн тоо 2018 онд 9.5 хувьтай байсан бол 2019 онд 19.9% болж өсчээ. 2018 оны уг судалгаанд оролцогчдын 66.4 % нь авлига тодорхой хэмжээнд ч байхыг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ илэрхийлж байсан бол, энэ удаагийн бидний судалгаагаар оролцогчдын 80,7% нь авлигыг хүлээн зөвшөөрөх ёсгүй гэж үзсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд авлигын эсрэг байр суурь жилээс жилд нэмэгдэж буйг харуулж байна.

Цаашилбал, судалгаанд оролцогчдын 24% хүнд суртлыг шийдвэрлэх арга зам нь авлига өгөх явдал гэж үздэгээ илэрхийлсэн нь өмнөх оны судалгаанд оролцогчдынхоос 2,6 хувиар өссөн байгаа нь хүнд суртлаас үүдэлтэй авлигын эрсдэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд өссөөр байгааг илтгэж байна. Авлига шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг гэсэн байр суурьтай 23.7% нь санал нийлж, 67,3% нь санал нийлэхгүй, 9 % нь мэдэхгүй гэж хариулсан нь өмнөх оны судалгаанд оролцогчдын шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг гэдэгтэй санал нийлэхгүй байгаагаа илэрхийлсэн 48,1 хувиас даруй хорь орчим хувиар нэмэгдсэн байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд авлигатай тэмцэх, төрийн байгууллагын шударга бус, оновчгүй зохицуулалт, дүрэм журмыг авлигын замаар шийдвэрлүүлж шаардлагатай үйлчилгээгээ авах ёсгүй гэсэн байр суурь нэмэгдсээр байгааг баталж байна.

Хүснэгт 3: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой авлигын талаарх нийтлэг байр суурь

	1.5. Авлигаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хохирдог.	1.6. Хөгжлийн бэрхшээлээс болж ялгаварлагдан авлига, хээл хахуулиар шийдвэрлэх асуудал тулгардаг.	1.7. Авлигыг багасгахын тулд иргэд өөрсдөө илүү хариуцлагатай байх ёстой.
Санал нийлж байна	67%	49.2%	78.2%
Бага зэрэг санал нийлж байна	12.1%	19.9%	10%
Төдийлөн санал нийлэхгүй	6.9%	6.9%	2.8%
Огт санал нийлэхгүй	4.4%	10%	5%
Мэдэхгүй	9.7%	14%	4%
Нийт	100%	100%	100%

Авлигаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хохирдог гэж үзэж буй иргэдийн тоо 40.8 хувиас 67% болж өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлээс болж ялгаварлан гадуурхагдах асуудлаа авлигаар шийдвэрлэдэг гэж 49.2% нь хариулж, үүнийг шийдвэрлэхэд иргэд өөрсдөө хариуцлагатай байх ёстой хэмээн 78.2% нь үзжээ. Эндээс харахад авлигаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хохирдог (26.2 хувиар нэмэгдсэн) бөгөөд тэдний бараг тэн хагас (49.2) нь өөрсдөд учирдаг ялгаварлан гадуурхалтаа авлигаар шийдвэрлэдэг тул үүний эсрэг иргэдийн хариуцлага, ухамсар, оролцоо нэмэгдэх ёстой гэсэн байр суурь улам (78.2 % буюу өмнөх оныхоос 11.4 хувиар) нэмэгдсээр байна.


Асуулт- 2. Таны бодлоор дараах салбаруудаас аль нь авлигад илүү өртсөн бэ?

Хүснэгт 4: Авлигад өртөмтгий салбар

	Маш их	Нилээд хэмжээнд	Тодорхой хэмжээнд	Бага зэрэг	Огт байхгүй	Мэдэхгүй	Нийт
Эрүүл мэнд	33.3%	19%	22.7%	14.3%	5.3%	5.3%	100%
Боловсрол	22.7%	23.4%	24.6%	12.8%	7.2%	9.3%	100%
Нийгмийн халамж, үйлчилгээ	12.8%	12.8%	22.7%	28%	9.3%	14.3%	100%
Хорооны ЗД-ын ажлын алба	10.9%	11.5%	14.6%	23.4%	16.5%	23.1%	100%
Дүүргийн ЗД-ын ажлын алба	11.8%	12.1%	19.9%	19.6%	8.1%	28.3%	100%
Нийгмийн даатгал	11.8%	10.9%	14.6%	19.9%	11.2%	31.5%	100%
Газрын алба	35.8%	15.3%	11.5%	9%	4.7%	23.7%	100%
Татварын байгууллага	20.2%	12.5%	17.4%	12.8%	9.3%	27.7%	100%
Улсын бүртгэлийн байгууллага	11.2%	8.4%	18.7%	19%	11.2%	31.5%	100%
Гаалийн байгууллага	31.8%	10.3%	12.1%	9%	7.5%	29.3%	100%
Мэргэжлийн хяналтын байгууллага	30.2%	15.6%	11.8%	15.3%	6.2%	20.9%	100%
Цагдаагийн байгууллага	21.5%	14%	21.8%	14.3%	7.5%	20.9%	100%
Бусад	11.8%	7.5%	9.0%	9.7%	28.7%	33.3%	100%

Таны бодлоор дараах салбаруудаас аль нь авлигад илүү өртсөн бэ? гэсэн асуултад “маш их”, “нилээд хэмжээнд”, “тодорхой хэмжээнд” хэмээсэн буюу “авлига байгаа” хэмээн үзсэн хариулт дээр тулгуурлан салбарууд дахь авлигыг дараах графикаар харуулав.


График 5. Авлигад хамгийн өртөмтгий салбар



Судалгаанд оролцогчдын 75.1% нь эрүүл мэндийн салбар, 70.7% нь боловсролын салбарт авлига “маш их, нилээд хэмжээнд, тодорхой хэмжээнд” байдаг хэмээн хариулсан байна. Үүнээс харвал Эрүүл мэнд, боловсролын салбар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд “хамгийн ээлгүй” салбар гэж хэлж болохоор байна.

Асуулт - 3. Таны бодлоор сүүлийн жилүүдэд авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?

График 6: Авлигын түвшингийн өөрчлөлт



Судалгаанд оролцогчдоос авлигын түвшин сүүлийн жилүүдэд хэрхэн өөрчлөгдөж байгаа талаарх байр суурийг нь сонирхож үзэхэд 43.9% нь өссөн гэсэн бол, 15.3% нь буурсан, 26.5 % өөрчлөгдөөгүй, харин 14.3% мэдэхгүй гэж хариулжээ. Эдгээр хариултаас харахад өмнөх жилд хийгдсэн судалгаанаас ялгаатай буюу иргэдийн байр суурийг илүү тодруулахын тулд авлигын нийтлэг төвшний нөхцөл байдлыг “мэдэхгүй” байж болох иргэдэд сонголт олгосноор бидний энэхүү судалгаанд мэдэхгүй гэсэн хариулт өгсөн оролцогчид 14.3 хувьтай гарсан нь мэдээлэл багатай хэсгийг тогтоох, тодруулан гаргахад арга зүйн ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Асуулт - 4. Авлигатай тэмцэхийн тулд юу хийх ёстой вэ?

Хүснэгт 5: Авлигатай тэмцэх арга хэмжээний тухай

Хийх зүйлс	Хувь
Авах арга хэмжээ, шийтгэлийг хатуу болгох	30.2%
Төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах	18.2%
Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	12.1%
Олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх	11.5%
Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх	11.2%
Бусад (авлигын эсрэг мэдээллийн нууцлалыг сайжруулах, АТГ-т итгэх итгэлийг нэмэгдүүлэх...)	6%
Төрийн албан хаагчдын үүрэг хариуцлагыг тооцох тодорхой стандарттай болгох	5.8%
Авлигаас ангид байх, авлигын эсрэг ажиллах сонгуулийн мөрийн хөтөлбөр бүхий нам, нэр дэвшигчид саналаа өгөх	4.9%
Нийт	100%


Судалгаанд оролцогчдын зүгээс авлигатай тэмцэхийн тулд авлигын эсрэг авах арга хэмжээ, шийтгэлийг чангатгах шаардлагатай гэж хамгийн олон буюу 30.2%, төрийн албан хаагчдын үүрэг хариуцлагыг тооцох тодорхой стандарттай болгох гэж 5.8% хариулсан байгаа нь энэ чиглэлийн ажилд хариуцлага, хяналт, шийтгэлийн оновчтой тогтолцоо шаардлагатай болохыг харуулж байна. Улмаар төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах (18.2%), шийдвэр гаргах

үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх (12.1%), олон нийтийг соён гэгээрүүлэх (11.5%) ажлуудад нийт судалгаанд оролцогчдын 41.5% ач холбогдол өгч буйгаа илэрхийлжээ. Тэгвэл төрийн албан хаагчдын цалинг нэмэх замаар авлигатай тэмцэх боломжтой гэж 11.2%, авлигаас ангид байр суурьтай улс төрийн нам, нэр дэвшигчийг сонгож, санал өгөх нь оновчтой гэж 4.9% үзсэн нь цалин санхүүгийн дарамтаас ангид төрийн албан хаагчид, төлөвшсөн бодлого, байр суурьтай улс төрийн намыг сонгох замаар авлига хэмээх гаж үзэгдэлтэй тэмцэх боломжтой гэж үзэж буй иргэдийн байр суурийн илэрхийлэл гэж харагдаж байна.

2.2 Авлигатай холбоотой хувийн туршлага


Асуулт - 5. Та өөрт болон гэр бүлд тулгарсан бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлүүлж чадахгүй үе тулгарвал хээл хахууль өгөх үү?

График 7: Хээл хахууль өгөх эсэх



Авлигатай холбоотой хувийн туршлагыг тодруулах зорилгоор дээрх асуултыг тавихад бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлэхийн тулд ямар ч тохиолдолд хахууль өгөхгүй байж чадна гэж 55.5% саналаа өгсөн нь өмнөх жилийн судалгаанд оролцогчдын байр сууриас ихээхэн ялгаатай буюу ямар ч тохиолдолд хээл хахууль өгөхгүй байж чадна гэсэн хариулт өгч байсан 84.7 хувьтай харьцуулахад буурсан төлөвтэй байгаа нь манай улсын хувьд хахууль өгөхийг тулгах эрсдэлт нөхцөл улам бүр нэмэгдэж буйг харуулж байна. Улмаар уг асуултын хариултын дараагын хувилбар болох асуудлаа шийдэхийн тулд хахууль өгөхийг илүүд үзнэ гэсэн хариу өмнөх оны судалгаанаас 27.4 хувиар (42.7%) нэмэгдсэн явдал авлигын нөхцөл байдал жилээс жилд хүндэрч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд ч энэ нь мэдэгдэхүйц дарамт болж байгааг нотолж байна.


График 25: Авлигатай тэмцэх арга хэмжээний тухай –Бэрхшээл бүрээр



Асуулт–5: Та өөрт болон гэр бүлд тулгарсан бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлүүлж чадахгүй үе тулгарвал хээл хахууль өгөх үү? гэсэн асуултад хариулсан оролцогчдыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь харвал асран хамгаалагчдын 59.3% нь өгсөн дээр гэж үзсэн бол сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн 66.7% нь ямар ч байсан өгөхгүй байж чадна гэж хариулжээ.

Асуулт - 6. Сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд ямар нэгэн хэлбэрээр хээл хахууль өгсөн үү?


График 8: Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн эсэх



Сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн эсэхэд судалгаанд оролцогчдын 67.3% нь үгүй гэж хариулжээ. Харин 21.8% нь хахууль өгсөн гэж хариулсан байна. Хээл хахууль өгсөн гэж хариулсан оролцогчдын 62.9% нь нэг удаа, 21.4% нь хоёроос гурван удаа, 15.7% нь гурваас дээш удаа өгсөн гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогчдоос сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн гэж хариулсан иргэд эмч нарт 51.4%, багш нарт 12.9% нь хээл хахууль өгсөн гэж хариулсан байдлаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хамгийн их харилцдаг буюу харилцах хэрэгцээ тулгардаг албан хаагчид нь боловсрол, эрүүл мэндийн ажилтнууд болох нь харагдаж байна.


График 9: Хэдэн удаа хээл хахууль өгсөн



Сүүлийн 12 сар ямар нэг хэлбэрээр хээл хахууль өгсөн оролцогчдыг хөгжлийн бэрхшээлийнх нь төрлөөр харвал хараа болон, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчид тус бүр 31.4% буюу нийт хээл хахууль өгсөн иргэдийн 62.8 хувийг эзлэж байна.

Асуулт - 7. Хэрэв тийм бол хэдэн удаа өгсөн бэ?


График 9: Хэдэн удаа хээл хахууль өгсөн



Сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн эсэхэд гэсэн асуултад “ТИЙМ” гэж хариулсан оролцогчдоос “хэдэн удаа өгсөн бэ?” гэж асуухад 62.9% нь 1 удаа, 21.4% нь 2-3 удаа, 15.7% нь 3-аас олон удаа өгсөн хэмээн хариулсан байна.

Асуулт - 9. Хэрэв тийм бол та хэнд хээл хахууль өгсөн бэ?

График 10: Хэнд хээл хахууль өгсөн



Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн эсэх гэсэн асуултад “ТИЙМ” гэж хариулсан оролцогчдоос “хэнд авлига өгсөн вэ?” гэсэн асуултад 51.4% нь эмчид, 12.9% нь багшид хэмээн хариулсан байна. Харин судалгаанд оролцогчдоос прокурорт авлига өгч байсан тохиолдол гараагүй байна.

Асуулт - 10. Таны болон танай гэр бүлийн бусдад өгсөн хээл хахуулийн тохиолдол доорх нөхцлүүдийн алинд хамаарах вэ?

График 11: Хээл хахууль өгсөн нөхцөл



Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн эсэх гэсэн асуултад “ТИЙМ” гэж хариулсан оролцогчдоос хээл хахууль өгсөн шалтгааныг тодруулбал, 40% нь “дүрэм журмын шат дамжлагыг хурдасгахын тулд” хэмээн хариулжээ.

Харин авлига авахаар нэхсэн буюу шаардсан тохиолдолд өгсөн гэж 10% нь хариулсан байгаа нь өмнөх оны судалгаан дахь 55.3 хувьтай харьцуулахад бага үзүүлэлт хэдий ч энд хариултын боломжит хувилбаруудыг тэлсэн шалтгааныг харгалзан үзэх ёстой. Гэхдээ иргэд үл ойшоож, алагчилж харьцдагаас асуудлыг өөрт

нааштайгаар шийдүүлэх гэж хахууль өгсөн болохоо 11.4% нь тэмдэглэсэн байна. Эндээс харилцааны эмгэг доголдолтой албан хаагчид, иргэдэд хүндрэл үүсгэдэг төрийн албаны шат дамжлагаас залхсан иргэд хуулийн дагуу авах ёстой “зүй ёсны” ажил, үйлчилгээгээ хүртэхийн тулд зүй бусаар хахууль өгөх шаардлагатай гаж тогтолцоо бий болсныг харж болохоор байна.

Асуулт - 11. Та хээл хахууль өгөх шаардлагатай гэдгийг хэрхэн мэдсэн бэ?


График 12: Авлига өгөх шаардлагатайг хэрхэн мэдсэн



Сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн эсэхэд гэсэн асуултад “ТИЙМ” гэж хариулсан оролцогчдын 30.6% нь авлигыг аргагүйн эрхэнд буюу асуудлыг нь шийдвэрлэж өгөхгүй удааж “уяж” байгааг түргэтгэх зорилгоор өгсөн гэж хариулсан байхад, авлига өгөхийг шууд болон шууд бусаар ойлгуулсан учраас гэж 35.2% нь, бусдыг дагаж 18.5%, өөрийн хүслээр ажлаа бүтээх гэж 9.3% нь авлига өгсөн болохоо илэрхийлжээ.

Асуулт - 12. Та ямар шатны албан тушаалтанд хээл хахууль өгсөн бэ?

График 13: Ямар шатны албан тушаалтанд хээл хахууль өгсөн




Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд төрийн байгууллагын аль шатны албан хаагчидтай илүү их харилцдаг, тэдгээрийн зүгээс хэрхэн хандаж үйлчилдэг болохыг тодруулах зорилгоор сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн эсэхэд “ТИЙМ” гэж хариулсан оролцогчдын дээрх асуултыг тавьсан бөгөөд оролцогчдын өгсөн хариултаас харахад төрийн албаны дунд шатны албан хаагчид-мэргэжилтнүүдэд

оролцогчдын 70% нь хээл хахууль өгөх шаардлага үүсч байсан гэж хариулсан бол, удирдах болон доод шатны албан хаагчдийн хувьд асуулгад оролцогчдын 24.3% нь хахууль өгч байсан гэжээ.

Асуулт - 13. Та авлигыг ямар замаар гүйцэтгүүлсэн бэ?


График 14: Авлигыг гүйцэтгүүлсэн арга зам



Судалгаанаас харахад иргэдийн дунд асуудлаа түргэн шуурхай шийдвэрлүүлэхийн тулд хээл хахуулийг ихэвчлэн өөрийн биеэр өгөх явдал 47.1 хувьтай, бусдаар буюу гэр бүл хамаатан садан, танил талаараа дамжуулан өгдөг байдал 52.8 хувьтай байна.

Асуулт - 14. Та авлигын ямар хэлбэрт өртсөн бэ?


График 15: Авлигад өртсөн хэлбэр



Түүнчлэн хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэд ихэвчлэн (буюу 58.6% нь) бэлэн мөнгө хэлбэрээр өгсөн бол, цөөн хэсэг нь (10%) л материаллаг зүйлээр өгсөн гэж хариуллаа.

Асуулт - 15. Авлигад зарцуулсан мөнгөн дүн танай өрхийн төсөвт хэрхэн нөлөөлсөн бэ?


График 16: Авлигад зарцуулсан мөнгөн дүн өрхийн төсөвт хэрхэн нөлөөлсөн



Авлигаас үүдэлтэй дарамт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрхийн төсөвт их хэмжээгээр нөлөөлдөг гэж 27.1%, дунд болон бага зэрэг нөлөөлсөн гэж 58.6% нь хариулсан бол, огт нөлөөлөөгүй гэж 14.3% хариулжээ.

Асуулт - 16. Таны амьдралд хөгжлийн бэрхшээлээс болж ялгаварлагдан авлига, хээл хахуулиар шийдвэрлэх асуудал тулгарч байсан уу? (Хөгжлийн бэрхшээлтэй биш байсан бол авлига өгөх шаардлагагүй байсан)


График 17: Хөгжлийн бэрхшээлээс болж ялгаврлагдан авлига, хээл хахуулиар шийдвэрлэх асуудал тулгарч байсан эсэх



Судалгаанд оролцогчдын 25.5% хөгжлийн бэрхшээлтэйн улмаас ялгаварлан гадуурхалтад өртөж авлига өгөх замаар асуудлаа шийдвэрлүүлэх шаардлага тулгарч байсан гэж хариулсан бол, 74.5% нь энэ талын дарамт байгаагүй гэж хариулжээ.


Хөгжлийн бэрхшээлтэйгээс шалтгаалж авлига, хээл хахуулиар шийдвэрлэх асуудал тулгарч байсан эсэхийг хөгжлийн бэрхшээл бүрээр нь ялган харвал,

График 24: Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр - Хөгжлийн бэрхшээлээс болж ялгаврлагдан авлига, хээл хахуулиар шийдвэрлэх асуудал тулгарч байсан эсэх



Асуулт - 18. Та хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд бүрэн хамрагдсан уу?

График 18: Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд бүрэн хамрагдсан эсэх



Судалгаанд оролцогчдын 12% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгогддог нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаагаа илэрхийлсэн бол, 54.8% нь бүрэн хамрагдсан, 33% нь ямар нэг байдлаар хамрагдсан гэж хариулсан нь халамж, хамгааллын чиглэлийн ажлын хүртээмж тодорхой төвшинд байгаа ч нийт иргэдийг ямар нэгэн асуудалгүй хамруулах шаардлагатай байна гэж дүгнэхэд хүрлээ.

Асуулт – 19: Танд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж, хамгааллын дараах үйлчилгээнүүдэд хамрагдахад авлига өгөхөөс өөр аргагүй бэрхшээл тулгарч байсан уу?


График 22: Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ авахад авлига өгөх нөхцөл байдал үүсдэг эсэх



18-р асуултаар оролцогчдын 87.8% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд тодорхой хэмжээгээр хамрагддаг гэж хариулсан. Харин 19-р асуултаар тэдгээр иргэд зорилтот халамжийн үйлчилгээгээ авахад авлигын нөхцөл байдал үүсдэг эсэхийг тодруулахад 62.3% нь авлига өгөхөөр нөхцөл байдал үүсэж байгаагүй гэсэн бол тусламж хөнгөлөлт эдлэхэд 12.5% нь, нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж авахад 10.3% нь нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авахад 10.6%, нөхцөлт мөнгөн тэтгэмж авахад 10.9%, эрүүл мэндийн үйлчилгээ авахад 12.5% д нь авлига өгөх нөхцөл үүсэж байсан хэмээн хариулсан байна.

Асуулт - 20. Танд авлигын талаарх мэдээлэл өгөх эрмэлзэл байдаг уу?

График 19: Авлигын талаарх мэдээлэл өгөх эрмэлзэл




Харин авлига хээл хахуулийн тухай, зүй бус авир харилцааны талаар иргэд мэдээлэл өгдөг, хяналт хариуцлага тооцох шаардлага хүргүүлэх эрмэлзэл байдаг эсэх талаар оролцогчдоос сонирхоход ердөө 11.5% нь үргэлж мэдээлдэг гэсэн бол, огт мэдээлдэггүй гэж 69%, заримдаа л мэдээлдэг гэж 19.3% хариулсан нь хангалтгүй байна. Үргэлж ба заримдаа мэдээлдэг гэсэн хариулт 30.8 хувьтай байгаа

нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын эсрэг байр суурь, тэмцэл тун ч идэвхгүй төлөвт байгааг харуулж байна.

Асуулт - 21. Яагаад мэдээлдэггүй вэ?

График 20: Авлигын талаар мэдээлдэггүй шалтгаан



Судалгаанд оролцогчид ийнхүү мэдээлэхээс цааргалдаг, идэвхгүй байдлаа дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд, хаана хандахаа мэддэггүй гэж 31.2% нь үзсэн бол, хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй мэдээллээ хүргэх боломж, нөхцөл, ойлголцох байдал хүртээмжгүйгээс гэж 18.7% нь хариулжээ. Харин мэдээллийн нууцлал алдагдахаас эмээдэг тул мэдээлэл өгч байгаагүй гэж 17.4% хариулсан бол, мэдээлэл өгсөн ч үр дүнд хүрч байгаагүй тул мэдээлдэггүй гэж 10.9% итгэл алдран хариулжээ.

Эндээс мэдээлэлийн нууцлал, мэдээлэгчийн аюулгүй байдлыг хамгаалах тогтолцоо бүрдээгүй, мэдээлэл өгөх суваг, байгууллага, бүтэц бүрэн хэлбэржээгүй, энэ талаарх мэдлэг, мэдээлэл иргэдийн дунд нэн хомс байгаа болох нь харагдаж, энэ чиглэлийн ажлыг яаралтай анхааралдаа авч хэрэгжүүлэх шаардлага бий болсныг харуулж байна.

Асуулт – 21 дээрх авлигын талаар мэдээлдэггүй шалтгааныг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь нарийвчлан харвал, хөгжлийн аль ч бэрхшээлтэй иргэд “Хаана хандахаа мэддэггүй” байгаа нь харагдаж байна.


Хүснэгт 9: Авлигын талаар мэдээлдэггүй шалтгаан- Бэрхшээлийн төрлөөр

	Асран хамгаалагч	Бусад бэрхшээлтэй	Сонсгол, хэл ярианы	Хөдөлгөөний бэрхшээлтэй	Харааны бэрхшээлтэй
АТГ-т очиход бидэнд зориулсан дэд бүтэц, ойлголцох байдал хүртээмжгүй учраас	16.9%	5.7%	31.8%	20.2%	11.3%
Бусад	23.7%	11.4%	4.5%	27%	35.5%
Мэдээллийн нууцлал алдагдахаас эмээдэг	18.6%	14.3%	15.2%	19%	17.7%

Мэдээлэл өгсөн ч үр дүн гарч байгаагүй	20.3%	8.6%	15.2%	7.1%	4.8%
Хаана хандахаа мэддэггүй	20.3%	60%	33.3%	26.3%	30.6%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Асуулт - 22. Авлигын талаарх мэдээллийг та хаанаас авдаг вэ?

График: 21: Авлигын талаар мэдээлэл авдаг сувгууд



Иргэд авлига, хээл хахуулийн талаарх мэдээллийг хүлээн авдаг үндсэн сувгууд бол телевиз болон интернет орчин гэж 57.3% нь хариулсан бол, үүний дараа ам дамжсан яриа, найз нөхдөөсөө авдаг гэж 28.3%, өөрт тохиолдсон туршлагаас мэддэг гэж 8.7% хариулжээ. Иймээс иргэдэд мэдээлэл дамжуулах гол суваг болж буй телевиз, цахим мэдээллийн сайтуудын мэдээллийн үнэн, бодит байдлыг хангах явдал хурцаар тавигдахын зэрэгцээ эдгээр сувгийг бид үр дүнтэй ашиглаж чадвал авлигатай тэмцэх ажлын мэдээллийн гол суваг болохын зэрэгцээ сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд ч бас тулгуур болгох боломж байгаа нь харагдаж байна.

Асуулт - 22 Авлигын талаарх мэдээллийг та хаанаас авдаг вэ? гэсэн асуултад хариулсан судалгаанд оролцогчдыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь харвал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй асран хамгаалагчдын 32.2%, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн 25.8% нь интернэт цахим орчноос авлигын талаарх мэдээллийг авдаг гэсэн бол бусад бэрхшээл, хөдөлгөөний бэрхшээл, харааны бэрхшээлтэй иргэдийн хувьд телевиз мэдээллийн гол суваг байсаар байна.

Хүснэгт 8: Мэдээлэл авдаг суваг: хөгжлийн бэрхшээлийн төрлөөр

	Асран хамгаалагч	Бусад бэрхшээлтэй	Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй	Хөдөлгөөний бэрхшээлтэй	Харааны бэрхшээлтэй
Ам дамжсан яриа	16.9%	25.7%	16.7%	22.2%	19.4%
Бусад	3.4%	2.9%	4.5%	2%	3.2%
Гэр бүл, найз нөхөд	6.8%	2.9%	21.2%	4%	3.2%
Интернет, цахим орчин	32.2%	17.1%	25.8%	19.2%	12.9%
Өөрт тохиолдсон туршлага	20.3%	8.6%	4.5%	7.1%	3.2%
Сонин, хэвлэл	3.4%	2.9%	7.6%	3%	3.2%
ТВ	16.9%	40%	19.7%	42.4%	54.8%
нийт	100%	100%	100%	100%	100%

Асуулт - 23. Та авлигатай холбоотой, авлигын талаарх мэдээллийг хаана, хэрхэн өгөх талаарх дараах зүйлүүдийг сонсож байсан уу?

Хүснэгт 7: Авлигын талаарх мэдээлэл өгөх мэдлэгийн талаар

	Сайн мэднэ	Ер нь мэднэ	Мэдэхгүй	нийт
АТГ-д очиж мэдээлэх	18.4%	29.9%	51.7%	100%
Нийслэлийн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-үүдэд байрлах АТГ-ын олон нийтийн төвд хандах	7.5%	17.8%	74.8%	100%
Авлигын эсрэг 110 утсанд мэдээлэх	11.5%	13.4%	75.1%	100%
Бусад	6.9%	11.5%	81.6%	100%

Судалгааны ажлын энэ хэсэгт бид авлигын талаарх мэдээллийг хүлээж авах газрууд, тэдгээрийн байршил, үйл ажиллагааны талаар мэддэг эсэхийг нь судалгаанд оролцогчдоос тодруулахыг зорьсон. Ингэхэд иргэд АТГ-т очиж мэдээлэх боломжтой гэдгийг ер нь мэддэг ба сайн мэддэг гэж 48.3% хариулсан бол, огт мэдэхгүй гэж бараг тал нь буюу 51.7% хариулжээ. Харин нийслэлийн “Нэг цэгийн үйлчилгээний төв”-үүдэд байрлах АТГ-ын олон нийтийн төвд хандах, авлигын эсрэг 110 утсанд мэдээлэх боломжтой гэдгээ огт мэдддэггүй хэсэг тус бүр 70-аас дээш хувьтай байгаа нь эдгээр байгууллага, үйлчилгээний талаарх мэдээлэл иргэдийн дунд тун хангалтгүй байгааг харуулж байна.

Чанарын судалгааны аргаар:

Тоон судалгааны агуулга чиглэлд багтаагүй асуудлаар авлигад өртсөн байж болзошгүй болон авлигатай холбогдож байсан оролцогчдоос дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор чанарын судалгааг фокус бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагын аргаар явууллаа. Судалгааны мэдээлэл цуглуулалтад тухайн оролцогчийн хувийн мэдээллийг хамгаалах үүднээс хөндлөнгийн нөлөөгүй, үнэн бодит мэдээллийг авч судалгаанд ашигласан болно.

Фокус бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагын явцад судалгаанд оролцогчдын хөгжлийн бэрхшээл, онцлогоос хамаарч авлигын асуудал өөр өөр байна. Гэхдээ нийтлэг байдлаар авлига давтагдаж байгаа салбаруудыг доор жагсааж, холбогдох жишээ, кейсийг хавсарган дүгнэлээ.

1. Эрүүл мэндийн салбар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн бүхий л салбараас үйлчилгээ авдаг ч эмнэлгийн тусламж авахад хамгийн хүндрэлтэй асуудлуудтай тулгардаг, энэ тохиолдол элбэг. Эрүүл мэндийн салбарт хамгийн их ялгаварлан гадуурхалт явагдаж байдаг. Эмч нарын хандлага, ялгаварлах, гар харах, хээл хахууль авах зэрэг нь эдгээр иргэдийг эмнэлгийн үйлчилгээ авахад хүндрэл учруулж байна.

... Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн хувьд хүүхдээ харахын тулд эцэг эхчүүдийн нэг нь ажил хийхгүй хүүхдээ асрах шаардлагатай болдог. Тэгэхээр тэр гэр бүлийн орлого шууд буурдаг хэрнээ хүүхдийнхээ эм тариа, эмчилгээ сувилгаанд зарцуулах зардал харин нэмэгдчихдэг. Тэгэхээр тухайн гэр бүлд хүүхдэд төрөөс өгч буй халамжийн мөнгө, хөнгөлөлт ямар чухал гэдгийг харуулж байна. Гэхдээ энэ халамж нь тийм их мөнгө биш шүү дээ. Хүүхдийнхээ эм тариаг ч авч хүрэхгүй. Харин тэр мөнгийг авахын тулд хорооны эмч нар, халамжийн мэргэжилтнүүдтэй харилцдаг. Миний хувьд лав эмчийн зөвлөлийн хурлаар орох гээд материалаа өгсөн чинь хурал болох болоогүй, хойшилсон гээд удаад байхаар нь эмчдээ цайны мөнгө өгч байсан. Уг нь миний хүүхдийн нөхцөл байдлыг харвал хурдан шийдээд өгчихмөөр л байгаа юм. (Ганцаарчилсан ярилцлагаас. Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ээж, 27 настай)

Иргэдийн эрүүл энхийн төлөө тангараг өргөсөн эмч нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хайнга харьцах, үл тоох, эмнэлгийн үйлчилгээг дутуу дулимаг үзүүлэх, эмийн жор олгохдоо аль хямд гэсэн эмийг бичдэг зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл амьдрах эрхэд сөргөөр нөлөөлж байна.

Оролцогч 4- Эмнэлэгт очоод үзүүлэхээс авахуулаад хагалгаанд орох ч юмуу, энгийн үйлчилгээ авахад чинь ерөөсөө заавал гар хараад байдаг. “Яасан юм, зүгээр байна, яах гээд байгаа юм” гээд бичиг бичээд гаргаад хаячихна. Эмчилгээ, бичиг заалтыг нь үзүүлсэн үзлэгт орохоор “чи үнэтэй эм авч чадах уу? Антибиотик авах уу?” гээд антибиотик бичнэ. Үнэтэй эм авч чадах уу? гэдэг асуултыг байнга асуудаг. Ингэж асууж байгаа нь ялгаварлан гадуурхалт. Тэр эмч ингэж асууна гэдэг аягүй бүдүүлэг байхгүй юу. Хүний эрхийг гажуудуулсан доромжлол. Хямдхан эм бичих үү?, үнэтэй эм бичих үү? гэж асууж байгаа юм шиг. Сонсгологүй хүнд эмчийн үзлэг хийхдээ үзэхгүйгээр шууд гаднаас нь хараад тэгээд дур мэдэн эмийн жор бичиж өгдөг. (Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэг онцлог нь эмнэлгийн салбарт хамгийн их үйлчлүүлдэг, эмнэлгийн салбартай хамгийн ойр байдаг. Тэр ч утгаараа төр, засгийн зүгээс эрүүл мэндийн салбарт тусгайлан бодлого боловсруулж, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилдэг дохионы хэлтэй эмч нарыг бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг иж бүрэн, чирэгдэлгүй үзүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэх нь зүйтэй.

Оролцогч 5- Дарханд нөхөр нь сонсгологүй иргэдийн ТББ-ын тэргүүн. Эхнэр нь сургалтын багш, нэг хөгжлийн бэрхшээлтэй хүний хүүхэд Дарханы өрхийн эмнэлэгт эмчээр ажилладаг, дохионы хэл сайн мэддэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дүүргийн эмнэлэгт үзүүлэх гэхээр дохионы хэлтэй эмч байхгүй, ойлголцохгүй учраас бүгд тэр дохионы хэлтэй эмчийн ажилладаг өрхийн эмнэлэгт очиж үйлчлүүлдэг. Тэр эмчээр үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд ярихдаа тэр эмчийг өрхийн эмнэлэгт биш аймгийн эмнэлэгт ажиллахгүй яваа, аймгийнхаа том эмнэлэг рүү ороод үйлчилгээ авах боломж бүрдэнэ шүү дээ гэж ярьцгааж байсан. (Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн хувьд эрүүл мэндийн тусламжийг түргэн шуурхай авахад ухаалаг гар утас маш их хэрэгтэй болох нь доорх кейсээс харагдаж байна.

Оролцогч 4- Манай охин өвдөөд гэнэт халуураад хүндэрсэн. Тэгэхэд би жирэмсэн, миний даралт ихсээд, утсаар ярьж чадахгүй байсан. 103-руу ярихыг мэдээд байгаа ч аав нь бас сонсголгүй, охин өвдсөн байсан. Тэгээд 103 руу охин маань ярьсан чинь хүүхдийн дуудлага хүлээж авахгүй, том хүнээр яриул гэхэд манай нөхөр хэлгүй, би сонсголгүй яаж ярихав. Тэгээд гар утасны тусламжтайгаар видео калл хийж би найзруугаа яриад, найз маань 103-руу холбогдсоноос цаг алдаж, түргэн шуурхай эмнэлгийн тусламж, үйлчилгээг авч чадаагүй. (Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

2. Боловсролын салбар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хүүхдийнхээ цэцэрлэг, сургуулийн асуудлаас болж боловсролын салбар дахь авлигатай холбогдох нөхцөл үүсдэг. Энд боловсролын салбарт гардаг авлигын нийтлэг хэлбэр буюу тухайн тойргийн бус цэцэрлэг, сургуульд хүүхдээ оруулах, шилжүүлэн сургахад тухайн боловсролын байгууллагын багш, эрхлэгчид 150000-500000 хүртэлх төгрөгийг өгч байсан тохиолдол тэмдэглэгдсэн байна. Гэхдээ энэ нь хөгжлийн бэрхшээлтэйгээс үүдэлтэй бус бүх иргэдэд нийтлэг тохиолддог авлигын хэлбэр юм. Гэвч зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхтэй учраас хүүхдийг нь ялгаварлан гадуурхах хандлага гардаг байна.

Оролцогч 3- Хүүхдийнхээ багшид нэгж, заримдаа ангийн хуримтлалын мөнгийг хураалгахдаа яаж ийгээд илүү өгдөг. Хэрвээ ингэж өгөхгүй бол аав нь харааны бэрхшээлтэй гээд хүүхдийг маань ангийн багш нь ялгаварлан гадуурхдаг, ангиараа салхинд гарах зэрэг зарим олон нийтийн арга хэмжээнд оролцуулахгүй үлдээчихсэн байдаг. Гэтэл миний хүүхэд ямар буруутай юм? Тэгэхээр хүмүүсийн хандлага их онцгүй л байгаа юм. Багш хүн эцэг эхийнх нь хөгжлийн бэрхшээлээс болж хүүхдийг нь ялгаж харьцах ёсгүй биздээ? (Харааны бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас. Харааны бэрхшээлтэй, эрэгтэй, 39 настай)

Зарим тохиолдолд, тухайлбал сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдэд хичээл ордог дохионы хэлтэй багш байхгүй, дутмаг байдгаас ялгаварлан гадуурхагдах нь элбэг байна.

...Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй хүмүүсийн бүтээмж маш өндөр, аливаа зүйлийг чин сэтгэлээсээ хийдэг. Оюутан болоод сурч байгаа хүүхдүүдийг багш нь дохионы хэл мэдэхгүй учраас тэр хүүхэд тэр чигтээ хичээлээс хоцордог, хичээлдээ дургүй болдог зүйлүүд байдаг. Уг нь өөрсдөө сурах их сонирхолтой, даанч сургах орчин, сэтгэл бусад хүмүүст ерөөсөө байхгүй. Ялгаварлан гадуурхалтад маш их өртдөг. Хүн байнга ялгаварлаад байхаар чинь маш хэцүү байна биздээ. Өөр дээрээ бодоод үздээ!? (Ганцаарчилсан ярилцлагаас. Сонсголын бэрхшээлтэй эмэгтэй, 36 настай)

Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын хувьд хүүхдийг боловсрол эзэмшүүлэхэд асар их асуудалтай тулгардаг. Тусгай цэцэрлэг, сургуульд суралцуулдаг ч сүүлийн үед боловсролын үйлчилгээнд тэгш оролцуулах буюу хүүхдээ энгийн сургуульд хамруулах нь хүүхдийн нийгэмшил, ахиц дэвшилд ихээхэн ач холбогдолтой болоод байна. Тиймээс эцэг эхчүүд хүүхэд нь энгийн сургуульд суралцаж байгаа тохиолдолд, ангийн багшийг хүүхэддээ анхаарал хандуулахад нь нөлөөлөх зорилгоор бэлэг, зарим тохиолдолд бэлэн мөнгө өгдөг байна.

... Хүүхдээ энгийн сургуульд явуулахад бидэнд их хүндрэл тохиолддог л доо. Хүүхдээ тэврээд, үүрээд, тэргэн дээр нь түрээд л зөөнө. Энгийн хүүхэдтэй хүмүүсийг бодвол тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй эцэг эх, гэр бүлд маш их ачаалал ирдэг. Тэгээд тэр хичээл орж байгаа багшийн аяыг харна, хүүхэдтэйгээ овоо харьцуулж, жоохон ч болох нь юм заалгахын тулд нэлээн хэдэн удаа янз бүрийн бэлэг өгч байсан. Гэхдээ бэлэн мөнгө өгч байгаагүй. Багш нь танай хүүхэд удаан, илүү цаг зарцуулж байгаа, анги их олон хүүхэдтэй байна гэх зэргээр бидэнд хэлдэг учраас багшид бэлэг өгдөг. (Ганцаарчилсан ярилцлагаас. Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ээж, 35 настай)

Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын сургалтын төрийн сангийн тэтгэлгийн журам дахь “өрхийн нэг суралцагч” гэсэн заалтад өөрчлөлт оруулж тухайн өрхийн бусад суралцагчдыг сурах боломжоор хангах зохицуулалт хийх нь зүйтэй.

Оролцогч 4- Миний дээд сургуульд сурах сургалтын төлбөрийг буцалтгүй тусламжаар бүрэн төлнө гэсний дагуу сургуульд элсэн суралцсан. Гэтэл гэнэт сургалтын алба мөнгөөгүй байна, төлбөр мөнгөө өг гэсэн. Тэгээд байсхийгээд л дандаа ийм ч мөнгө аваад ир, тийм ч мөнгө аваад ир гээд нэхдэг. Би дохионы хэлний орчуулагчаар дамжуулаад асуухаар ерөөсөө нарийн мэдээлэл агч чаддаггүй. Тэгсэн хэрнээ юунд зарцуулагдаж байгаа нь мэдэгдэхгүй мөнгө аваад байдаг.

Бас дүн бол их ялгаатай гардаг. Маш их ялгавартай ханддаг. Англи хэлний багш нар бол аягүй том ялгаварлан гадуурхалт явуулдаг. Манай ангийн хүүхдүүд дохионы хэлтэй, тэгээд надад тусалж хэлж өгөх гээд байхад нь Англи хэлний багш битгий хэл гээд байдаг болохоор нь сүүлдээ би хичээлдээ суух сонирхолгүй болсон. Ер нь хөгжлийн бэрхшээлээрээ ялгагдаад хамгийн муу сурч байгаа. Тэр англи хэлний багш нь өөрөө аягүй хэцүү зан араншинтай. Багш оюутнуудыг ялгадаг юмуу, мөнгө хардаг юмуу мэдэхгүй би ойлгодоггүй. Би англи хэлд өөрөө дуртай мөртлөө даанч дохионы орчуулагчийг болохоор би ойлгодоггүй, багш нь ч энийг мэдэхийг хүсдэггүй. Бас тэгээд хамгийн арын ширээнд суудаг.

(Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Япон улсад хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын сурах нөхцөл бололцоог хангах тал дээр анхаарал хандуулдаг дараах сайн туршлага байна. Тухайлбал, лекцийн хичээл дээр хөгжлийн бэрхшээлтэй оюутан багшийнхаа компьютертэй гар утаснаасаа Bluetooth-ээр холбогдож мэдээллийг хуулж бичиж авснаар лекцийг шууд унших боломжтой болдог байна. Мөн шалгалт өгөх, ганцаарчилсан бие даалт буюу ярилцлагад орох, багшийн асуултад хариулахад дохионы хэлний орчуулагчийг дуудан авчруулж шалгалт өгөх боломжоор хангадаг. Монгол Улсын хувьд ч энэ мэт боломжит гарцыг эрэлхийлж хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг сурах нөхцөл боломжоор хангах шаардлагатай байна.

Оролцогч 1- Тусгай ...-р сургуульд одоог хүртэл авлигын асуудал бүх шатанд байгаа, улам ихэссэн байх. Уг сургуульд зураг зүйн багш тэтгэвэртээ гарсны дараа зурагзүйн мэргэжлийн багш хүн ажилд аваагүй. Мэргэжлийн бус 50 настай, эмэгтэй хүнийг ажиллуулсан. Тэр хүн технологийн багш, дохионы хэл мэддэггүй. Бас ямар аргаар, багшаар орсныг мэдэхгүй. Тэр хүн яаж орсныг сайн ойлгоогүй. Сайн мэдэхгүй байна. Уг нь одоо тэр асуудлыг бичээд Яаманд хандмаар байна. Одоо түр үүрэг гүйцэтгэж байгаа хүн ингээд мэргэжлийн бус хүн оруулаад дахиад нэг жил болчихоод байна шүү дээ. Өнөөдөр ямар ч хариуцлага алга байна. Тэгээд энэ түр орлон гүйцэтгэж байгаа захирлуудын зохион байгуулж байгаа, хууль бус үйлдлүүд ихсэж, тэдний хүмүүс бүр олон болно шүү дээ. Ялангуяа сонсголын бэрхшээлтэй, сул сонсголотой багш нарыгаа ялгаварлан гадуурхдаг. Ингэж болохгүй шүү дээ. Сургууль бол улсын байгууллага болохоос ургийн байгууллага биш шүү дээ.

Оролцогч 2- Би их сургуульд дипломоо хамгаалах гээд илтгэл тавих гэтэл дохионы хэлний орчуулагч байдаггүй. Тэгээд нөгөө орчуулагч нар ирэх боломжгүй болохоор нь би бичгээр харилцах гэсэн ч хүндрэл гарсан. (Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

3. Нийгмийн халамж, үйлчилгээний салбар

Төрийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг хуулийн дагуу үзүүлдэг ч энэхүү үйлчилгээг үзүүлэх явцад хууль бус, зөрчил бэрхшээлүүд гарсаар байгаа нь чанарын судалгаагаас ажиглагдлаа. Нийгмийн халамж, үйлчилгээний ажилтнуудын ёс зүйн зөрчилтэй холбоотойгоор үүсч буй асуудлууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүндрэл болж байна.

... Миний нэг таньдаг эмэгтэй хөгжлийн бэрхшээлтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн жилдээ нэг удаа сувилалд амарсан тохиолдолд тэрхүү мөнгөнийх нь талыг буцааж авах эрхтэй байдаг. Хөнгөлөлтөө авахын тулд эхлээд хороон дээрээ очоод өргөдлөө хорооны засаг даргаар уламжлуулан дүүргийн халамж руу явуулдаг. Тэр хооронд их хүнд сурталтай, уддаг, явдал суудал болдог. Тэгж удаан хүлээж байснаас хорооны халамжийн ажилтанд хоолны мөнгө гээд өгчихөөр маш хурдан шийдээд өгчихдөг юм шдээ гэж надад ярьж байсан. (Ганцаарчилсан ярилцлага. Хөдөлгөөний бэрхшээлтэй эмэгтэй, 38 настай)

Нийгмийн халамж, үйлчилгээний талаарх мэдлэг мэдээлэлд ойр, эсвэл энэ талаарх мэдээлэлгүй зэргээс хамаарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг зөрчдөг асуудлууд байна. Үүнээс гадна, эрүүл атлаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авдаг группын мөнгийг авдаг хүмүүс байдаг байна.

... Халамжийн тогтолцоо бол огт хяналтгүй, төрийн бизнес болсон. Энэ халамжийн тогтолцоог хөгжүүлэх хүсэлгүй, эмзэг буюу сул л байлгах хүсэлтэй байгаад байна. Нийслэлийн иргэд бол мэдээлэлд арай ойр байх шиг байгаа юм. Харин хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрөөс өгч буй халамжийн үйлчилгээнүүдийн талаар ямар ч мэдээлэл, ойлголт байдаггүй. Жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд жилдээ нэг удаа олгодог түлээ, нүүрсний мөнгийг хуулиараа бол тухайн хүн авах ёстой. Гэтэл “Түлээ, нүүрсний эрхийн бичиг” гээд жаазлаад өгсөн байгаа юм. Тэгэхээр өөрт нь очих ёстой байсан халамжийн үйлчилгээг бөөн сүр болгож өгч байгаа нь бас болохгүй шүү дээ.

Бас хөдөө орон нутагт группт орохын тулд тэр комисст байгаа хүмүүст “өвлийн идэш”-ийг өгдөг, даадаг гэсэн жишээ байна. (Ганцаарчилсан ярилцлагаас. Хөдөлгөөний бэрхшээлтэй эмэгтэй, 35 настай)

... Яг миний таньдаг ямар ч хөгжлийн бэрхшээлгүй, эрүүл саруул 2 хүн группт орохын тулд дүүргийн эмнэлгээс дотор эрхтний асуудалтай гэж тодорхойлолт аваад 200 мянган төгрөг тухайн зохицуулдаг хүнд нь өгөөд группт орчихсон байсан. Гэтэл яг хөгжлийн бэрхшээлтэй төрөөс халамжаа авах ёстой хүмүүс нь бүх үйлчилгээгээ бүрэн авч чадахгүй байхад дундуур нь мөнгө төгрөг өгөөд өмнөөс нь үйлчилгээг нь аваад байгаа хүмүүс байна. Энэ их шударга биш санагддаг. (Ганцаарчилсан ярилцлагаас. Хөдөлгөөний бэрхшээлтэй эмэгтэй, 38 настай)

... Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэрийг барьж авлигын асуудал гаргадаг хүмүүс их байна. Эрүүл атлаа группт орохын тулд мөнгө өгч группын мөнгө авдаг хүмүүс их байдаг. Энийг бид байнга ярьдаг хэрнээ ямар нэг арга хэмжээ авч ерөөсөө чадахгүй байна. Энийг Авлигатай тэмцэх газраас ч юм уу бүр шалгах хэрэгтэй шдээ. Хотод бол зарим нь 700-800 мянган төгрөг өгдөг гэдэг юм билээ. Нэг удаа их мөнгө өгч байгаа юм шиг боловч дараа нь тогтмол группын мөнгө авна гэхээр болдог юм байлгүй. (Ганцаарчилсан ярилцлагаас. Бусад төрлийн (эпилепси) бэрхшээлтэй эрэгтэй, 38 настай)

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонсголын аппарат гэх мэт нэн хэрэгцээт зүйлсийг үнэгүй тараах, олгох ажлын явцад шамшигдуулах, жинхэнэ очих ёстой эзэндээ эдгээр эрүүл мэндийн хэрэгслүүд нь очдоггүй, чанаргүй, хямд хэрэгслүүдийг олгох гэх мэт зөрчил дутагдлууд байсаар байна. Журмын дагуу ажлаа гүйцэтгэдэггүй энэ мэт явдлын ард авлигын асуудал ч байхыг үгүйсгэхгүй талаар доорх кейст дурдагдаж байна.

Оролцогч 2- Бид нарт халамж, үйлчилгээний газраас өгч байгаа сонсголын аппарат нь хятадын аппарат, муу аппарат байдаг. Тэр нь бид нарын сонсох шаардлагыг хангахгүй гологддог учраас тэр аппаратыг авахгүй, өөрөө мөнгө нэмж авдаг. Аппаратны сонголт байхгүй болохоор аппарат авахгүй, ямар ч хүртээмжгүй. Бид нарын зүүж байгаа аппарат нь дижитал аппарат. Жишээлбэл, миний аппарат гэхэд 4 сая төгрөгний аппарат. зарим нь 1 сая 500 мянган төгрөгний үнэтэй ч байдаг. 1 сая 500 мянган төгрөг болон 4 сая төгрөгний аппарат авахад халамжийн хуулиараа 350 мянган төгрөгийг гаргаж өгсөн. Харин үлдсэн мөнгийг би өөрөө гаргана. Гэтэл энэ аппаратны хүчин чадал 3 жил болоод солих ёстой байдаг ч би аппаратаа сольж чадахгүй одоо 6 дахь жилдээ зүүж байна. Заримдаа массадаг, энэ аппарат ингээд эвдрээд дуусвал би яах вэ? Яаж аппаратаа авах вэ? гэх мэт асуудлууд үүсдэг.

Оролцогч 3- Надад ч гэсэн яг адилхан. Хэрэв би аппаратгүй болчихвол хэрэгтэй мэдээллээ авч чадахгүй. Бид нар аппараттай болохоор өөрсдийгөө хөгжлийн бэрхшээлтэй гэж ярьдаггүй юм. Гэхдээ аппарат чинь тодорхой тоотой орж ирж байгаа ч гэсэн бид нарт олгогдох ёстой. Хаагуур, юугаараа, явж байгаа нь мэдэгдэхгүй бас хувь хүний бизнесийн л асуудал болчихсон байдаг. Авлигын асуудал байдаг байх гэж боддог.

(Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Мөн нийгмийн халамж хамгааллын бодлого алдагдсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээ сул, тэдний эрх ашгийг хамгаалах талаар дорвитой ажил

хийдэггүй зэрэг дутагдлууд ч байсаар байна.

Сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гадаад болон дотоод шалтгаанаар олон болж байна. Энд нэлээд хүчин зүйл нөлөөлж байгаа. Гэтэл энэ хүүхдүүдийн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээ авах, цэцэрлэг, сургуульд хамрагдах, цаашлаад их сургуульд сурч мэргэжил эзэмших, тэгээд тогтвортой ажлын байран дээр ажиллах зэрэг эрхүүд хангагдахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн төлөө ажилладаг ээж аавууд, төрийн бус байгууллага, холбоод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа боловч төрөөс үзүүлэх дэмжлэг бага байгаа.

... Тусгай хэрэгцээт хүүхдүүдийг төрөөс ямар нэгэн үйлчилгээ авахад ялгаварлан гадуурхдаг, бас нийгэм буюу энгийн хүмүүсийн хандлага нь ч бас сонин шдээ. Эцэг эхчүүд эмнэлгээр үйлчлүүлэхдээ, боловсролын байгууллагаар үйлчлүүлэхдээ ямар нэгэн байдлаар авлига өгч байсан тохиолдлууд байсаар байгаа. Авлигатай тэмцэх газарт тухайн өгсөн авлигынхаа талаар мэдээлж чадахгүй. Яагаад гэвэл бид чинь хүүхдийнхээ төлөө тийм үйлдэл хийж байгаа болохоор, цаашдаа яаж ийгээд хүртээмжтэй үйлчилгээ авах юмсан гэсэндээ жижиг сажиг авлигад оролцоод байна. Энэ жил харин авлигын эрсдэлийг тодорхойлж байгаад талархалтай байна. Энэ судалгааны дүнг Авлигатай тэмцэх газар анхаарч зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулах биш тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холбоотой асуудлуудыг ч бас давхар анхаарч үзээсэй гэж хүсэж байна. (Ганцаарчилсан ярилцлагаас. Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ээж, 46 настай)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн маш олон эрх зөрчигдөж байгаагийн дотор нэн чухал нь тэдгээрийн аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрх хамгийн ихээр зөрчигдөж байна. Эдгээр иргэд нийгэмд хөл нийлүүлж алхах наад захын боломжууд алга байна. Тухайлбал, зориулалтын зам, гарц, шат зэрэг байхгүйгээс тэдгээр иргэд гэрээсээ гараад л аюулгүй орчинд амьдрах, амьд явах баталгаагүй нөхцөлтэй нүүр тулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй амьдрах гадаад, дотоод орчны бүхий л асуудлуудыг цогцоор шийдэж өгөх нэн шаардлагатай. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж, хамгааллын асуудлыг сайжруулж ажлын байрыг бий болгож ажиллах нөхцөл боломжоор хангах тал дээр анхаарал хандуулах цаг хэдийн болжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хөдөлмөр хийхэд хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй, туршилтын хугацаанд ажиллуулдаг, цалинг бага тогтоодог, зарим тохиолдолд ажилласан хугацааны цалин хангамжийг өгөхгүй хохироодог асуудлууд тулгардаг байна.

Оролцогч 3- Хөдөлмөр эрхлэлтийн тал дээр сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн ажлын бүтээмж өндөр байдаг. Барилгын ажил хийдэг хүн маш их байгаа. Тэгээд нэг бүлэг болоод барилгын ажил хийдэг. Ажлаа хийчихээд цалингаа авч чадахгүй эрх нь зөрчигддөг. Хөдөлмөрлөөд цалингаа авах гэхээр өгдөггүй, хэцүү асуудлууд тулгардаг. Халамж үйлчилгээний газар болохоор өөрсдийнхөө нөөц боломжийг, давуу талаа гаргаж ирж ашиглаж чадахгүй, энэ чиглэлд стратегийн бодлого дутагдалтай байна. (Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

4. Цагдаа, шүүхийн байгууллага

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдсөн асуудлаар цагдаагийн байгууллагад хандахад тухайн иргэний бэрхшээлийн онцлогийг ойлгож мэддэггүйгээс анхан шатны туслалцааг авч чаддаггүй, зарим тохиолдолд тулгарсан асуудал шүүх шатанд очиход хөгжлийн бэрхшээлтэй гэдгээр хүний эрхийн асуудлууд зөрчигддөг байна.

... Харааны бэрхшээлтэй хүмүүсийг төрийн албан хаагчид маш их ялгаварладаг. Миний нэр төртэй холбоотой асуудал үүсээд цагдаад хандахад ерөөсөө тоож авч үзээгүй. Тэгээд хөөцөлдсөний эцэст тэр асуудал маань шүүх дээр очиход намайг харааны бэрхшээлтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй гээд өөрийг минь шүүх хуралдаанд оруулахгүйгээр шүүх ажиллагаа явуулж эрхийг минь зөрчсөн. Гэтэл би дээд боловсролтой, ослоос шалтгаалж олдмол байдлаар бүр сүүлд харааны бэрхшээлтэй болсон болохоос бүүр хүнд хөгжлийн бэрхшээлтэй биш шүү дээ. (Ганцаарчилсан ярилцлагаас. Харааны бэрхшээлтэй эрэгтэй, 39 настай)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалсан хуулийн зөвлөгөө өгдөг зөвлөх үйлчилгээ нийтлэг байдаггүйгээс дийлэнх иргэдийн хувьд өөрт шаардлагатай хуулийн зөвлөгөө, мэдлэг, мэдээлэл олж авах боломж хомс байна. Иймд МУИС болон бусад их, дээд сургуулийн хуулийн салбарын төгсөх ангийн оюутнуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагуудад дадлага хийлгэх, зөвлөгөө мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх ажилд татан оролцуулах боломж байна. Дадлагад гарсан оюутнууд эргээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолой болж, эрх зүйн зохицуулалтад үгүйлэгдэж байгаа асуудлуудыг гаргаж тавихад тус дөхөм үзүүлэх нь гарцаагүй. Мөн дохионы хэлийг мэргэжлийн биш хэрнээ эцэг эх, найз нөхөд зэрэг хувийн хүрээлэлдээ хэрэглэсээр яриад сурчихсан оюутнууд ч цөөнгүй байдаг тул тэдгээр оюутан залуучуудыг дэмжээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах нийгмийн салбаруудад бодлогоор ажиллуулах, мэргэжилтэн болгож бэлтгэх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, аюулгүй орчинд ажиллаж, амьдрахад томоохон тус дөхөм болох юм.

Оролцогч 5- МУИС болон бусад их, дээд сургуулиудын зөвхөн төгсөх курсынхан гэхгүй наана нь ядаж дөрөвдүгээр курсээсээ дохионы хэлээ аваад юмуу ядаж гурав дөрөвдүгээр, гурваасаа эхэлж дохионы хэлээ аваад яг сонсголгүй хүмүүсийн юмуу, халамж дээр очоод үйлчилгээгээ авч байя, группээ авч байгаа юм. Биеэрээ дадлагаар хийж үзээд тавдугаар курс дээрээ жинхэнэ дипломын ажил хийхэд чиглэл чиглэл салбарынх нь асуудлыг ингээд хуулийн талаас нь судлаад гаргаж ирвэл зүгээр санагдаж байна. (Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

5. Төсөл, тендерийн сонгон шалгаруулалт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх, хувиараа бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээлийг олгодог. Гэтэл энэ зээлийн талаарх мэдээлэл төдийлөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд түгээмэл зарладаггүй, энэ талаарх ойлголт муутайгаас нийгмийн халамж, үйлчилгээний ажилтнууд тухайн иргэнээс тэрхүү зээлийн тодорхой хувийг авдаг байна.

...Миний хувьд хэдэн жилийн өмнө дүүргийн халамжийн мэргэжилтэн надруу яриад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээлд материалаа бүрдүүлээд өгөөдөх гээд маш богино хугацаанд хэлсэн материалыг нь бүрдүүлээд өгсөн чинь нэг сая төгрөг авсан. Тэгээд тэр мэргэжилтэн миний материалыг бүтээж өгснийхөө шанд тэр мөнгөний талыг нь авч байсан. Тухайн үед юу болоод байгааг сайн ойлгоогүй, тэгээд л өнгөрсөн. Сүүлд бодохнээ тэр хүн намайг ашиглаж мөнгө авсан байгаа юм. Гэтэл тэр хүн ажлаа хийж байгаа хүн байж тэгж авлига авч, мөнгө завшиж болохгүй гэдгийг ойлгосон. Одоо ч гэсэн тэр зээлийг авч байгаа хүмүүс тэр хүндээ хувь өгдөг юм билээ. (Ганцаарчилсан ярилцлагаас. Хөдөлгөөний бэрхшээлтэй эрэгтэй, 43 настай)

Оролцогч 4- Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төслийн зээл буюу буцалтгүй тусламж авах гээд төсөл бичсэн байна. Нөгөө хүмүүс чинь бичгийн чадваргүй учраас төслөө өөр хүмүүс дээр аваачиж төлбөртэй хийлгэсэн. Төслөө бичүүлээд, хөдөлмөр халамжийн санд оруулаад өгсөн чинь нөгөө төсөл нь дэмжигддэггүй. Удаа дараа төсөл өгөөд ч дэмжигддэггүй. Яагаад гэвэл нэг харсан чинь өөр хүмүүс төсөл авчихсан, тендерт шалгарчихсан явж байна. Тэгэхээр энд нөгөө танил тал, арын хаалга миний чиний хүн гэдгээрээ л ялгаварлан гадуурхагдаад, хэсэг хүмүүсийг нь оруулаад нөгөө хэдийг нь оруулдаггүй. Мөн тендерийн шалгаруулалт дээр хамгийн их авлигын асуудал явж байдаг. Энэ бол яг манай Монголд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах нөхцлийн хамгийн том авлига. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн, улсын нийгмийн халамжийн ерөнхий газар дээр энэ бол хамгийн том проблем. (Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үл тоох, ялгаварлан гадуурхах байдлаас болж тендер шалгаруулалтын үйл явц будлиантай болдог. Төрийн байгууллагын албан хаагчид тендерийн шалгаруулалтын үед ашиг сонирхлын зөрчилтэй үйлдлүүд ихээр хийдэг. Тендерийн шалгаруулалт дээр хамгийн их авлига байдгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хийсэн судалгаанаас харагдаж байна.

... Сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагууд маш олон байгуулагдаж, үйл ажиллагаа явуулдаг болсон. Төрийн байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан, тэднээр хийлгэх гэсэн олон тендэрүүд зарлагддаг болчихсон. Тэгээд тэр тендэрүүдэд оролцоход тендэр хариуцсан ажилтнууд нь биднээс “тендэрийн тодорхой хувийг аваад танайхыг шалгаруулаад өгье” гээд наймаалцаж байсан. Хэдэн төгрөг, хэдэн хувийг тэр хүнд өгөх вэ гэдэг нь тухайн тендэрийн нийт үнийн дүнгээс хамаараад 10-15 % байсан. Тэр хувь өгч байгаа мөнгийг тэр төрийн албан хаагч өөрийнхөө дансаар авдаггүй, олон хүн цугласан газар уулзаж бэлнээр авдаг юм байна лээ. Миний оролцсон тендэрийн хувьд төдийлөн туршлагагүй, яадгийг нь мэдэхгүй байсан учраас тухайн үедээ тендэрээ авахын тулд тухайн нэхсэн мөнгийг өгч байсан. (Ганцаарчилсан ярилцлагаас. Сонсголын бэрхшээлтэй эмэгтэй, 45 настай)

... Манай байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэд эвлэлдэн нэгдсэн байгууллага л даа. Төрийн байгууллагаас зарласан тендэрт оролцоод шалгарч байсан. Тухайн тендэрийн мөнгө нь тийм их биш, бид үйл ажиллагааны зардалдаа зарцуулаад л дууссан. Гэтэл эргээд нөгөө тендэр авсан байгууллагаас биднийг байнга дарамталж, шаналгах болсон. Энд тендэрийн мөнгөнөөс тухайн хүмүүст мөнгө эсвэл хувь өгөх зүйл яригдаагүй байна.

Юу гэхээр мөнгөн бус хэлбэрээр авлигын хэлбэр явагддаг. “Манайхаас явуулж байгаа хүмүүнлэгийн аянд танайхаас хандив хэрэгтэй байна, шинэ жилээр ч юм уу янз бүрийн баяруудаар хүмүүс шагнах гэсэн юм, шагналд хувь оруулаач, шинэ жил зохион байгуулах гэсэн чинь зардал дутаад байна” гэх зэргээр эргээд тэр байгууллагаасаа бид хараат болчихдог. (Ганцаарчилсан ярилцлагаас. Хөдөлгөөний бэрхшээлтэй эрэгтэй, 36 настай)

... Зарим том улс төрч, өндөр албан тушаалтай хүмүүсийн хамааралтай төрийн бус байгууллагуудад шууд давуу байдал олгоод тендрийг өгдөг тохиолдол яг байдаг шүү. Бидэн шиг олон жил үйл ажиллагаа явуулсан, салбараа мэддэг хүмүүсийн байгууллагыг биш, дөнгөж шинээр бүртгүүлээд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудад тендэр өгчихдөг. Ялгаварлан гадуурхаж байгаа юм. Бараг 2010 оноос хойш байна уу даа, ямар төрийн бус байгууллага ямар төсөл авсан, ямар тайлан гарсан, тухайн төслийг ямар хүмүүс шалгаруулж өгсөн зэрэг мэдээллүүд олон нийтэд ил тод биш байгаа. Том дарга нартай холбоотой буюу хамааралтай төрийн бус байгууллагууд тендэр авчихдаг. Тэр байгууллагуудад нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байхгүй, хэрэв байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй хүний нэрийг зүгээр оруулаад хавчуулчихсан байдаг. Яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс нэгдсэн төрийн бус байгууллагуудад үнийн дүн багатай, ойролцоогоор 10 сая төгрөгний тендэрүүд очдог. Харин тэр дарга нарын хамааралтай байгууллагуудад бол багцаагаар 15 сая төгрөгний тендэрүүд очдог юм билээ. Тэгэхээр энэ чинь бидний нэрийг бариад төрийн мөнгийг авч ашиглаж байгаа асуудал мөн байгаа биз дээ. (Ганцаарчилсан ярилцлагаас. Хөдөлгөөний бэрхшээлтэй эмэгтэй, 58 настай)

Дээрх шалтгаануудаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байраар хангагдах, ажил хөдөлмөр эрхлэх эрх нь зөрчигдөж, хаагдаж байдаг. Үүнийгээ дагаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргаа доогуур байхад зарим талаар нөлөөлж байна.

III. ДҮГНЭЛТ

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд авлига хамгийн түгээмэл тохиолддог салбар нь тоон болон чанарын судалгааны үр дүнгүүдээр нэгдүгээрт, эрүүл мэндийн салбар, хоёрдугаарт, боловсролын салбар, гуравдугаарт, нийгмийн халамж, үйлчилгээний салбар (тендер, худалдан авалт), дөрөвдүгээрт, цагдаа, шүүхийн салбар гэж дүгнэгдлээ.
- Авлигатай тэмцэх газар иргэд, олон нийт рүү чиглэсэн кампанит ажлуудыг сүүлийн үед хийж байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн үйл ажиллагааг явуулдаггүй болох нь ажиглагдлаа. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэрхшээлийн төрөл бүрт зориулсан авлигын талаарх ойлголтыг өгөх хөтөлбөр, арга зүй байх хэрэгтэй гэдэг нь судалгааны явцад ажиглагдсан.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хийсэн чанарын судалгааны явцад гарсан кейсүүдээс харахад авлигад өртөх, ялгаварлан гадуурхагдах, үл ойшоогдох, эрх, эрх чөлөөг нь зөрчих, чирэгдүүлэх, дарамтлах гэх мэт шударга бус асуудлууд тогтмол тулгардаг болох нь харагдаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд авлигад өртөж байгаагаа зарим нь мэддэггүй, тэрчлэн авлигын талаар ойлголт, мэдээлэл муутайг нь ашиглаж авлига авч байсан тохиолдлууд гарсаар байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд авлига, хүнд сурталтай тулгарч байгаа ч тэдэнд эрүүл эсвэл хөнгөлөлт эдлэх нөхцөл бүрдээгүй атал зүй бусаар эмнэлгийн онош, эрүүл мэндийн дүгнэлт үйлдүүлэх замаар нийгмийн халамж, үйлчилгээ хүртэгчид, ийнхүү хамрагдахын тулд төрийн албан хаагчдад авлига, хээл хахууль өгдөг зүй бус этгээдүүд байдлыг улам хүндрүүлдэг гэж үзэж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд авлигын асуудалтай холбогдсон ч хаана, хэрхэн хандахаа мэддэггүй, мэдээллийн нууцлал хангагдах эсэхэд итгэлгүй байдгаас авлигыг мэдээлдэггүй байна. Зарим тохиолдолд авлигын асуудалд холбогдсон бол өөрөө нотлож чаддаггүй, баримт нотолгоотой байсан ч цагдаа, шүүхийн байгууллага дээр очиход эрх зүйн мэдлэггүйгээс хүндрэл үүсдэг, эргээд өөрөө асуудалд ордог тул авлигыг мэдээлэх сонирхолгүй болох нь харагдлаа.
- Уг судалгааны явцад судалгааны баг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Авлигатай тэмцэх газраас хэвлүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчил, шударга ёс, гомдол мэдээлэл хүлээн авах 110 утасны танилцуулга материалыг өгч, авлигын талаарх ойлголтыг танилцуулан авлигын эсрэг мэдлэг олгоход тодорхой хувь нэмэр орууллаа. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс судалгаа авах явцад авлига, авлигын талаарх ойлголтуудын талаар ямар нэгэн байдлаар тайлбарлах шаардлага тулгарч байв.
- Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн хувьд тусгай сургуульд дохионы хэл мэддэг багш нар хангалтгүйгээс сурч боловсрох, цаашид их дээд сургуульд дэвшин суралцах боломж хязгаарлагддаг, улмаар нийгмийн харилцаанд оролцох, хүний эрхээ эдлэхэд ч том саад болж, ажил амьдралын олон талбарт нөлөөлсөөр байдаг. Түүнчлэн энэ төрлийн бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд дохионы хэлээр харилцах ажилтан байдаггүйгээс харилцааны бэрхшээл байнга үүсч, үйлчилгээ авах, эрхээ эдлэх явдал нь хязгаарлагдсаар иржээ.
- Харааны бэрхшээлтэй иргэд олон нийтийн дунд чөлөөтэй зорчих боломж

ямагт хязгаарлагддагаас нийгмийн харилцааны гадна үлдэх, өөрсдийнх нь харааны бэрхшээлээс үүдэж хүүхдэд нь ялгавартай хандах хандлагыг мэдрэх, үүнийг арилгахын тулд сургууль, цэцэрлэгийн багш, удирдлагад авлига хахууль өгөх нөхцөлтэй нүүр тулдаг.

- Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд дэд бүтцийн хувьд хүртээмжгүй, ажилтнууд нь хүнд сурталтай, ямар нэг асуудал хөөцөлдөхөд шат дамжлага их, олон өөр газарт очиж хөөцөлдөх, асууж лавлах хэрэгтэй болдгоос цаг хугацаа их алддаг зэрэг бэрхшээлтэй асуудлаа хөнгөвчлөхийн тулд авлигатай холбоотой асуудлууд үүсдэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын хувьд хүүхэд нь эрүүл мэндийн болон боловсролын салбараар үйлчлүүлэхэд ялгаварлан гадуурхалт болон авлигын асуудалд холбогддог байна.
- Бусад бэрхшээлтэй иргэдийн хувьд төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцуулахад харьцангуй сүүлд өвдсөн, олдмол хөгжлийн бэрхшээлтэй байдаг тул группт орж нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах, зарим тохиолдолд группээс хасагдах шалтгаантай ч хасагдахгүйн тулд төрийн байгууллагын ажилтнуудад авлига өгдөг байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын эсрэг баримтлах үндсэн арга зүй нь *хүний эрхэд суурилсан хандлага*⁴ тул НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, Хүний эрхийн олон улсын конвенцийг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБ-ын системийн байгууллагууд болон төрийн байгууллагуудын бодлого, үйл ажиллагааны уялдаа, иргэний нийгмийн хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай. Энэ ажлыг Авлигатай тэмцэх газар болон Засгийн газрын гүйцэтгэгч агентлаг буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хамтран ажиллах.
2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт⁵ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг авлигын асуудлыг авч үзээгүй тул Авлигатай тэмцэх газрын цаашдын үйл ажиллагаанд тэдний онцлог үл хайхрагдах эрсдэлтэйг анхаарч ажиллах.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэдний бэрхшээлийн төрлөөс хамаарч авлигын талаарх мэдлэг, ойлголттой болгох, мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах иргэний нийгмийн байгууллагуудад Авлигатай тэмцэх газраас арга зүйн болон санхүүгийн бүх талын дэмжлэгийг үзүүлж, хамтран ажиллах. Ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, үүрэг, төрийн байгууллагаар нийтлэг үйлчлүүлдэг салбарыг тодорхойлж, тухайн төрийн үйлчилгээг хэрхэн авах, холбогдох материалыг хэрхэн бүрдүүлэх, хүлээн авч, шийдвэрлэвэл зохих шат шатны ажилтан, албан байгууллагын талаар болон авлига, зүй бус үйлдэлтэй хэрхэн тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үүрэг, боломж нөхцлийн талаар сургалт, мэдээллийг тогтмол явуулж, таниулан сурталчлах ажлыг бэрхшээлийн онцлогийг харгалзан хийх. Тухайлбал, харааны бэрхшээлтэй иргэдэд брайл үсэгтэй танилцуулах материал, гарын авлага бэлдэх, сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд дохионы хэлний орчуулгатай видео, танилцуулга хийх, хөдөлгөөний болон бусад бэрхшээлтэй иргэдийн хувьд цахим орчинд мэдээллийг инфографик, контент зэрэг хэлбэрүүдээр бэлтгэн хүргэх.
4. Төрийн байгууллагын шударга, ил тод байдлыг хангах, иргэдэд нээлттэй байх зэрэг Авлигатай тэмцэх газрын баримталж ирсэн төрийн байгууллагуудад тавьдаг шаардлага, шалгуурт хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчдад тухайн байгууллагын хүртээмжтэй байдлын үнэлгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээ авах, хэрэгжилтийг дүгнэх. Тухайлбал, дэд бүтэц, вэб сайтад хандалт хийхэд хөгжлийн бэрхшээлийн төрлөөс үл хамаарч сонирхсон, хүссэн мэдээллийг авч чаддаг байх, тухайн байгууллагаар үйлчлүүлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй харилцах, тэдний онцлогийг мэддэг (дохионы хэлтэй гэх мэт) ажилтан ажиллуулах, ингэхдээ тэрхүү ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг очер дугаар харгалзахгүйгээр, олон шат дамжлага бүхий төрийн үйлчилгээг чиглүүлж, хамтран туслах “хөтөч” хийх, эргээд тухайн асуудлын үр дүнг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэдээлдэг, тайлбарладаг гэх мэт.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэрхшээлийн төрлөөс хамааралтай авлигын асуудлаар нарийвчлан судалгаа хийх, авлигатай холбоотойгоор гарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн зөрчилд тогтмол үнэлгээ хийх, тайлагнах. Ингэхдээ тайлангийн удирдамжийг хүний эрхийг хангах,

4 Human Rights-based Approach to Programming. https://www.unicef.org/policyanalysis/rights/index_62012.html

5 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, 2016 он. <https://www.legalinfo.mn/annex/details/7496?lwid=12293>

- авлигын эсрэг арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг баримтлан гаргах.
6. Авлигын талаар мэдээлэл, санал, гомдол өгсөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчдын мэдээллийн нууц болон аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэсэн авлигын хохирогч, гэрч, шүгэл үлээгчийг хамгаалах хөтөлбөр бий болгож, санхүүжилтийг баталгаажуулах. Ингэхдээ авлигаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийн хохирогч болсноо мэдэгдэж буй хөгжлийн бэрхшээлтэй хувь хүн, бүлгийн төлөөлөлтэй харилцах асуудал маш болгоомжтой, хүний эрхийн суурь зарчмуудыг хүндэтгэсэн байдлаар хийгдэх ёстой. Мөрдөн байцаагчийн зүгээс авлигын хэргийн нотлох баримт бүрдүүлэх, хоорондын учир шалтгааныг тогтооход хохирогч, гэрчийн бэрхшээлийн зэрэглэлийг тооцсон тусгай арга, аргачлалаар хандах.
 7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын асуудлаар гаргаж буй санал хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах нэгдсэн сүлжээ (утас, төв, фэйсбүүк групп, үйлчлэх ажилтан) бүхий бүтцийг бий болгох. Ингэхдээ Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн төвд энэхүү бүтцийг ажиллуулах, асуудлыг хянаж, хариу арга хэмжээ авснаа мэдээлдэг тогтмол үйл ажиллагаатай байх.
 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг бэрхшээлүүдийн талаар нийгэмд зөв ойлголт түгээх, улмаар тэдэнтэй харилцах харилцаа хандлагад эерэг байдлыг хэвшүүлэхэд нэн яаралтай анхаарал хандуулж, кампанит ажлыг зохион байгуулж иргэдийн харилцаа, хандлагыг эерэг болгох. Ингэхдээ зөвхөн төрийн байгууллага бус хувийн хэвшил, нийгмийн хандлага гэсэн нийтлэг байдлаар хандах. Энэ ажилд их дээд сургуулийн оюутнуудыг татан оролцуулж идэвхжүүлэх.
 9. Нэн түрүүнд төрийн үйлчилгээний байгууллагуудад “авлигагүй төрийн үйлчилгээ”, “авлигыг үл тэвчих”, “хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, түнш, дэмжигч байгууллага болох” жишиг уралдаант ажлыг зарлах, зохион байгуулах, зөв эерэг жишгийг нийтэд хэвшүүлэх үүднээс сайн байгууллагуудыг нийтэд мэдээлэх, сурталчлах, эсрэг муу жишээг ч нийтэд мэдээлдэг тогтолцоо бий болгох.
 10. Төрийн алба, тэр дундаа төрийн захиргааны болон үйлчилгээний (эмнэлэг, цэцэрлэг, сургууль) албан хаагчдын дунд авлигын эсрэг төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, тэдгээртэй холбогдох хариуцлагын талаар цогц сургалтыг тогтмол явуулж хэвшил болгох. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн %д хамгийн ихээр харилцдаг төдийгүй авлигын эрсдэл үүсэх боломжтой эрүүл мэндийн болон боловсролын байгууллагуудад нийгмийн халамж, үйлчилгээний газар дараах ажлыг хэвшил болгох шаардлагатай⁶. Ингэхдээ аливаа байгууллагын хүрээнд авлига, зүй бус үйлдэлтэй хийх тэмцлийг:
 1. Хамгаалах (буюу урьдчилан сэргийлэх)
 2. Илрүүлэх
 3. Хариу арга хэмжээ авах гэсэн үе шаттай хэрэгжүүлдэг болох

6 Австралийн Квинслэнд мужийн захиргааны Орон сууц, нийтийн үйлчилгээний газрын хүрээнд боловсруулсан “Авлига, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх” бодлогын баримт бичиг. https://www.hpw.qld.gov.au/__data/assets/pdf_file/0021/6258/fraudcorruptionpreventionpolicy.pdf

**Урьдчилан
сэргийлэх**

- Авлигын эсрэг, зүй бус үйлдлийг үл тэвчих, шударга, ёс зүйтэй байгууллагын соёл, уур амьсгал бүрдүүлэх,
- Авлига, зүй бус үйлдлийн эрсдлийг бууруулах удирдлагын тогтолцоог бүрдүүлэх
- Шударга бус явдал, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох ажилтан, албан хаагчдыг томилох, сонгох
- Байгууллагын ёс зүйн дүрмийг батлах, мөрдөх, хяналт тавих, хариуцлага тооцох, мэдээлэх эрх бүхий ажилтанг сургах, бэлтгэх, ажилуулах
- Мэргэжлийн болон ёс зүйн өндөр стандартыг тогтвортой хангаж ажиллах сургалт, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хийх
- Дээрх ажлын хэрэгжилтийн талаар тогтмол, нийтэд мэдээлдэг байх

Илрүүлэх

- Авлига, зүй бус үйлдлийн эрсдлийн үнэлгээний талаархи тайлан, мэдээллийг улирал бүр тогтмол хэлэлцдэг байх
- Эрсдлийн орчны талаарх дотоод хяналтын оновчтой тогтолцоог хөгжүүлэх
- Сэжигтэй үйлдлийн талаарх дотоод мэдээллийг хөхүүлэн дэмжих, урамшуулах
- Мэдээллийн системийг бүрдүүлэх замаар зүй бус үйдэлтэй тэмцэх

**Хариу арга
хэмжээ авах**

- Сэжигтэй үйлдлийг илрүүлэх, үр дүнтэй хариу арга хэмжээ авч, хариуцлага тооцох
- Гадаад хяналт-мэдээллийн байгууллагад мэдэгдэх, хамтарч ажиллах (АТГ, Цагдаагын ерөнхий газар, Аудитын албад гм.)
- Авлига, зүй бус үйлдэл нь нотлогдсон бол тохирох удирдлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үүнд:
- Сахилгын арга хэмжээ /үүрэгт ажлаас нь чөлөөлөх хүртэл/
- Холбогдох шатны шүүх, хяналтын байгууллагад шилжүүлэх /цагдаа, шүүх прокурор гм/
- Хохирлыг нөхөн барагдуулах
- Зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, 2016 он. <https://www.legalinfo.mn/annex/details/7496?lawid=12293>
- Attitudinal Barriers for People with Disabilities, The National Collaborative on Workforce and Disability for Youth (NCWD/Youth) <http://www.ncwd-youth.info/publications/attitudinal-barriers-for-people-with-disabilities/>
- Chetwynd, E., Chetwynd, F. and Spector, B., 2003. Corruption and poverty: A review of recent literature. *Management Systems International*, 600, pp.5-16. https://pdf.usaid.gov/pdf_docs/PNACW645.pdf
- Fraud and corruption prevention and control policy of the International Federation of Red Cross and Red Crescent Societies. https://media.ifrc.org/ifrc/wp-content/uploads/sites/5/2018/03/IFRC-Fraud-and-Corruption-prevention-and-control-policy_English.pdf
- Fraud and corruption prevention policy, 2016. The Department of Housing and Public Works, Queensland Government, Australia. https://www.hpw.qld.gov.au/__data/assets/pdf_file/0021/6258/fraudcorruptionpreventionpolicy.pdf
- Human Rights-based Approach to Programming.: https://www.unicef.org/policyanalysis/rights/index_62012.html
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл. Хүний Эрхийн Үндэсний Комисс. 2018 он
- Sofia Wickberg, U4 Expert Answer Literature review on costs of corruption for the poor. Transparency International, 2013 Number: 382
- The Guardian, (2017) What is life really like for disabled people? The Disability Diaries reveal all. <https://www.theguardian.com/inequality/2017/nov/15/whats-life-really-like-for-disabled-people-disability-diaries-reveal-all>
- The Negative Impact Of Corruption On The Enjoyment Of Human Rights. The Office of the High Commissioner for Human Rights <https://www.ohchr.org/Documents/HRBodies/HRCouncil/AdvisoryCom/Corruption/OHCHR.pdf>
- United Nations, Promoting Inclusion through Social Protection, 2018. Chapter V. Persons with disabilities: Breaking down barriers. <https://www.un.org/development/desa/dspd/wp-content/uploads/sites/22/2018/07/Chapter-VPersons-with-disabilities-breaking-down.pdf>

**ШУДАРГА БАЙДЛЫН
ҮНЭЛГЭЭ-2019**

Уг судалгааг зохион байгуулахад АТГ-аас санхүүжилт, арга зүйгээр хангасан хэдий ч, АТГ нь энэхүү тайланд тусгагдсан мэдээлэл, дүгнэлтийн үнэн зөв, бодит, эсхүл хэвлэлийн алдаанд хариуцлага хүлээхгүй болно. Шударга байдлын үнэлгээний судалгааны мэдээллийг цуглуулах, боловсруулах, үр дүнг тооцох, тайлан бэлтгэх үйл ажиллагааг хараат бус байдлаар зөвлөх үйлчилгээ үзүүлсэн компани гүйцэтгэсэн бөгөөд АТГ оролцоогүй болно.

Шударга байдлын үнэлгээний дүн нь зөвхөн тухайн байгууллагын үнэлгээний дүн бөгөөд үүнийг тухайн байгууллагын албан тушаалтан, ялангуяа, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ), эсхүл авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан албан тушаалтны ажлын үнэлгээ гэж ойлгож болохгүй.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ, ТАЙЛБАР

АТГ	Авлигатай тэмцэх газар
ГШБҮ	Гадаад шударга байдлын үнэлгээ
ДШБҮ	Дотоод шударга байдлын үнэлгээ
БОУ	Бодлогод оролцогчдын үнэлгээ
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ШБҮ	Шударга байдлын үнэлгээ
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

ТАНИЛЦУУЛГА

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас Авлигын индексийг 2009, 2011, 2013 онд, Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг 2010, 2012, 2014, 2015 онд тооцож, олон нийтэд мэдээлж байсан. Бусад улс орны сайн туршлагад үндэслэн 2015 онд дээрх 2 судалгааг нэгтгэн “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны А/129 дугаар тушаалаар батлуулсан. Уг аргачлалын дагуу 4 дэх удаагийн буюу 2019 оны “Шударга байдлын үнэлгээ”-ний судалгааг зохион байгуулав.

Шударга байдлын үнэлгээ (ШБҮ) нь тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ (үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн үнэлгээ), дотоод шударга байдлын үнэлгээ (төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчдын үнэлгээ), бодлогод оролцогчдын үнэлгээ (шинжээчдийн үнэлгээ) гэсэн 3 дэд үнэлгээнээс бүрдсэн нэгдсэн үнэлгээ юм.

ШБҮ-г 0-100 хүртэл оноогоор хэмжих бөгөөд утга нь 100-тай тэнцүү бол шударга байдлын дээд түвшинг илэрхийлнэ. 2019 оны ШБҮ-нд нийт 62 байгууллага (яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ)-ыг хамруулаад байна. ШБҮ-ний 2019 оны судалгаанд нийтдээ 9,555 нэгж (ГШБҮ-нд 7,400 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, Дотоод шударга байдлын үнэлгээнд 1,360 төрийн албан хаагч, Бодлогод оролцогчдын үнэлгээнд 795 шинжээч)-ийг хамруулсан болно.

Төрийн байгууллагууд 2019 онд ШБҮ-ээр 100 онооноос дунджаар 74.1 оноо авсан нь өмнөх оныхоос 5.4 пунктээр өссөн байна. ШБҮ-г бүрдүүлж буй дэд үнэлгээ тус бүрээр нь авч үзвэл тухайн төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өгсөн үнэлгээ 8.4 пунктээр, төрийн албан хаагчдын өгсөн үнэлгээ 4.0 пунктээр, бодлогод оролцогчдын өгсөн үнэлгээ 3.8 пунктээр тус тус өсчээ.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны 12 дугаарын сарын 10-ны өдрийн А/129 тушаалын 1-р хавсралтаар “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг, 2-р хавсралтаар “Шударга байдлын үнэлгээний судалгааг зохион байгуулах удирдамж”-ийг, 3-р хавсралтаар “Судалгааны асуулгын маяг”-ыг тус тус баталсан билээ.

Шударга байдлын үнэлгээний зорилго, зорилт

Шударга байдлын үнэлгээг дараах зорилго, зорилтын хүрээнд зохион байгуулсан.

- ✓ Шударга ёсыг бэхжүүлэх, авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, авлигыг таслан зогсоох болон төрийн байгууллагаас авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг суурь мэдээллээр хангах;
- ✓ Тухайн байгууллагын үнэлгээг нэмэгдүүлэхэд зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох;
- ✓ Үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх замаар төрийн байгууллагын зүгээс үнэлгээний үр дүнг сайжруулах хүсэл зоригийг нэмэгдүүлэх, авлигыг бууруулах санал, санаачилгыг өрнүүлэх эрмэлзлийг бий болгох.

Шударга байдлын үнэлгээний бүтэц

Шударга байдлын үнэлгээ нь тухайн байгууллагын ГШБҮ, ДШБҮ, БОҮ-ний нийт 62 дэд үзүүлэлтэд тулгуурласан үнэлгээ юм.

Үүнд:

- Гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ) гэж тухайн байгууллагын шударга байдалд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн өгч буй үнэлгээг;
- Дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ) гэж тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын зүгээс байгууллагынхаа талаар өгч буй үнэлгээг;
- Бодлогод оролцогчдын үнэлгээ (БОҮ) гэж тухайн байгууллагын шударга байдлын талаарх бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын өгсөн үнэлгээг тус тус ойлгоно.

Шударга байдлын үнэлгээний бүтэц

Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээг гаргахдаа дотоод ДШБҮ, ГШБҮ, БОҮ гэсэн 3 дэд үнэлгээг ашигладаг.

- ✓ Гадаад шударга байдлын үнэлгээнд авлигын индекс болон ил тод хариуцлагатай байдлын индексийн нийт 20 үзүүлэлт багтана.
- ✓ Дотоод шударга байдлын үнэлгээнд соёлын индекс болон үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн нийт 26 үзүүлэлт багтана.
- ✓ Шинжээчдийн үнэлгээнд авлигын талаарх төсөөлөл, бодит тохиолдол болон авлигыг хянах механизм, удирдлагын хүсэл эрмэлзлийн нийт 16 үзүүлэлт багтана.

Шударга байдлын үнэлгээний арга зүйн загварыг дараах зурагт дэлгэрэнгүй үзүүлсэн болно.

Зураг 1: ШБҮ-ний арга зүйн загвар 2019



СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭРЛЭЛТ

Хамрах хүрээ

Шударга байдлын үнэлгээнд зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний байгууллага буюу яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг хамруулдаг. ШБҮ-ний 2019 оны судалгаанд нийтдээ 62 байгууллага (яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ)-ыг хамруулсан.

Түүврийн хэмжээ

Энэхүү судалгаанд 13 яам, 27 агентлаг, 21 аймаг болон нийслэлийн ЗДТГ хамрагдсан. Үүнийг нэгжийн хувьд авч үзвэл ГШБҮ-нд нийт 7,400 иргэн, ДШБҮ-нд 1,360 төрийн албан хаагч, БОҮ-нд 795 шинжээч буюу нийт 9,555 оролцогчийг хамруулсан.

Зураг 2: Шударга байдлын үнэлгээний систем, хамрах хүрээ




СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Шударга байдлын үнэлгээний судалгааг АТГ-аас нэгдсэн удирдамжаар хангаж ажилласан бөгөөд мэдээлэл цуглуулалтыг судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК гүйцэтгэсэн.

Мэдээлэл цуглуулах ажлыг улсын хэмжээнд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 6-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулсан. ШБҮ-ний мэдээлэл цуглуулалтын ажилд Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 14 багийн ахлагч, 32 ярилцлага авагч, 2 хяналтын ажилтан ажилласан.

Мэдээлэл цуглуулалтыг хийхдээ багийн зохион байгуулалтаар ажилласан бөгөөд багийн ахлагч өөрийн багт хуваарилагдсан байгууллагуудын ЭБАТ-тай холбогдож судалгааны талаар танилцуулж тухайн байгууллагад очиж уулзах цаг товлох, товлосон хугацаанд тухайн байгууллага дээр очиж уулзалт хийх, албан хаагчдын нэрсийн жагсаалтыг гаргуулан авч түүвэрлэлтийг хийх, шинжээчдийг тодорхойлох, багийн гишүүдэд албан хаагчдыг хуваарилан судалгааг авхуулах, шинжээч, бодлогод оролцогчидтой цаг товлон уулзах, иргэнээс авах судалгааг зохион байгуулах байдлаар ажилласан.

Зураг 3: Мэдээлэл цуглуулалтын шат дараалал



Орон нутагт мэдээлэл цуглуулах багийг дараах байдлаар зохион байгуулсан.

Зураг 4: Орон нутагт мэдээлэл цуглуулсан багийн зохион байгуулалт




СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны үр дүн шударга байдлын ерөнхий үнэлгээ, гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээ гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэж байгаа бөгөөд энэхүү бүлэгт шударга байдлын ерөнхий үнэлгээг дэлгэрэнгүй авч үзнэ.

ШУДАРГА БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Төрийн байгууллагууд ШБҮ-ээр 100 онооноос 2019 онд дунджаар 74.1 оноо авсан нь өмнөх оныхоос 5.4 пунктээр өссөн байна. ШБҮ ийнхүү өсөхөд тухайн төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн өгсөн үнэлгээ 8.4 пунктээр, төрийн албан хаагчдын өгсөн үнэлгээ 4.0 пунктээр, бодлогод оролцогчдын өгсөн үнэлгээ 3.8 пунктээр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


График 1: ШБҮ, оноор



Хэмжих нэгж: Оноо

ШБҮ нь 2015 оноос хойш 4 удаа зохион байгуулагдсан бөгөөд төрийн байгууллагын албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг харьцангуй өндрөөр үнэлдэг болох нь харагдаж байна. ГШБҮ-ний хувьд 2018 онд 63.3 байсан бол 2019 онд 71.7 болж үнэлгээ илт сайжирсан байна. ГШБҮ ийнхүү өсөхөд аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ 72.4 болж, өмнөх оноос 11.8 пунктээр өссөн нь нөлөөлжээ. Харин БОҮ сүүлийн 3 жил харьцангуй тогтмол өсөлттэй байна.


График 2: ШБҮ, оролцогчдын төрлөөр, оноор



Хэмжих нэгж: Оноо

Үнэлгээг байгууллагын төрлөөр авч үзвэл яамны үнэлгээ 73.2 болж, өмнөх оноос 4.3 пунктээр, ЗГ-ын агентлагийн үнэлгээ 75.2 болж, 4.5 пунктээр, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 73.2 болж, 7.1 пунктээр тус тус өсчээ.


График 3: ШБҮ, байгууллагын төрлөөр, оноор



Хэмжих нэгж: Оноо

ШБҮ-нд хамрагдсан байгууллагуудыг 0-100 оноогоор үнэлэхэд 2019 онд 64.8-83.7 оноо авсан байна. Үнэлгээнээс харахад байгууллагуудын ил тод хариуцлагатай байдал дутмаг, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог зэрэг шалтгааны улмаас оноо алдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар үнэлгээ буурсан хэдий ч хамгийн өндөр үнэлгээ авсан 5 байгууллагын жагсаалтад орсон байна. Харин Биеийн тамир, спортын газрын үнэлгээ өмнөх оноос өссөн хэдий ч хамгийн бага үнэлгээ авсан 5 байгууллагын жагсаалтад орсон байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1-ээс үзнэ үү.

Зураг 5: ШБҮ, Хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан 5 байгууллага



Хэмжих нэгж: Оноо

Яамдын ШБҮ 2019 онд дунджаар 73.2 болж, 4.3 пунктээр өсчээ. Нийт 13 яамнаас 1 яамны үнэлгээ өнгөрсөн оноос 3.5 пунктээр буурсан нь Гадаад харилцааны яам байна. Гадаад харилцааны яамны ШБҮ өмнөх оноос буурсан хэдий ч яамдын ШБҮ-ний дундаж онооноос 3.5 пунктээр өндөр байна. Үр дүнгээс харахад Зам, тээврийн хөгжлийн яамны үнэлгээ 0.1 пунктээр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үнэлгээнээс 0.3 пунктээр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам 3.5 пунктээр, Батлан хамгаалах яам 3.6 пунктээр өссөн байгаа нь бусад яамнаас харьцангуй бага өсөлттэй байна. Үр дүнгээс харахад яамдын ДШБҮ 82.0 болж 5.3 пунктээр өссөн байгаа нь яамдын авлигатай тэмцэх дотоод үйл ажиллагаа сайжирч байгааг илтгэж байна.

Хүснэгт 1: Яамдын ШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Яам	2018	2019	Өөрчлөлт
Шударга байдлын үнэлгээ	68.9	73.2	+4.3
Батлан хамгаалахын яам	76.8	80.4	+3.6
Гадаад харилцааны яам	80.2	76.7	-3.5 ↓
Сангийн яам	67.1	75.5	+8.4 ↑
Хууль зүй, дотоод хэргийн яам	66.2	73.6	+7.4 ↑
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	73.2	73.5	+0.3
Эрчим хүчний яам	64.9	73.5	+8.6 ↑
Барилга, хот байгуулалтын яам	68.0	73.2	+5.2
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	66.1	71.9	+5.8
Эрүүл мэндийн яам	66.3	71.5	+5.2
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	66.8	70.9	+4.1
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	67.1	70.6	+3.5
Зам, тээврийн хөгжлийн яам	70.3	70.4	+0.1
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	64.6	70.2	+5.6

Хэмжих нэгж: Оноо.

Улаан шугамаар медианыг илэрхийлсэн болно. Медиан нь өгөгдлийн голын утгыг илэрхийлнэ.

Засгийн газрын агентлагуудын ШБҮ 2019 онд дунджаар 75.2 болж, өмнөх оноос 4.5 пунктээр нэмэгджээ. Засгийн газрын агентлагуудын ШБҮ ийнхүү нэмэгдэхэд үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллийн өгсөн үнэлгээ 72.9 болж, 8.3 пунктээр нэмэгдсэнтэй холбоотой байна. Засгийн газрын 27 агентлагаас 5 агентлагийн үнэлгээ өмнөх оноос буурсан байгаагийн дотор Үндэсний хөгжлийн газрын үнэлгээ 10.7 пунктээр, Иргэний нисэхийн ерөнхий газрын үнэлгээ 2.9 пунктээр, Гаалийн ерөнхий газрын үнэлгээ 2.9 пунктээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үнэлгээ 1.7 пунктээр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үнэлгээ 0.8 пунктээр тус тус буурсан байна.

Хүснэгт 2: Агентлагуудын ШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Агентлаг	2018	2019	Өөрчлөлт
Шударга байдлын үнэлгээ	70.7	75.2	+4.5
Соёл, урлагийн газар	83.6	83.7	+0.1
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	83.1	82.3	-0.8 ↓
Гадаадын иргэн, харьяатын газар	76.6	82.3	+5.7
Онцгой байдлын ерөнхий газар	70.6	81.7	+11.1 ↑
Оюуны өмчийн газар	76.1	81.6	+5.5
Цаг уур, орчны шинжилгээний газар	76.0	80.7	+4.7
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	75.5	79.3	+3.8

Архивын ерөнхий газар	66.1	79.2	+13.1 ↑
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	80.4	78.7	-1.7 ↓
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	72.0	78.2	+6.2
Улсын бүртгэлийн ерөнхий газар	67.9	78.2	+10.3 ↑
Нийгмийн даатгалын ерөнхий газар	73.7	77.8	+4.1
Мал эмнэлэг, үржлийн газар	70.3	76.7	+6.4
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	74.2	75.1	+0.9
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	70.4	75.0	+4.6
Цагдаагийн ерөнхий газар	69.2	74.6	+5.4
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	72.6	73.9	+1.3
Ашигт малтмал, газрын тосны газар	65.9	73.9	+8.0 ↑
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	72.9	73.0	+0.1
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	65.9	72.4	+6.5
Стандарт, хэмжил зүйн газар	68.2	70.3	+2.1
Татварын ерөнхий газар	63.4	70.1	+6.7
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	66.9	69.5	+2.6
Иргэний нисэхийн ерөнхий газар	68.9	66.0	-2.9 ↓
Үндэсний хөгжлийн газар	76.4	65.7	-10.7 ↓
Биеийн тамир, спортын газар	62.7	65.0	+2.3
Гаалийн ерөнхий газар	67.7	64.8	-2.9 ↓

Хэмжих нэгж: Оноо

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ-г авч үзэхэд ЗДТГ-уудын үнэлгээ ерөнхийдөө өссөн үзүүлэлттэй гарсан. Харин 2 аймгийн ЗДТГ үнэлгээ өмнөх оноос буурч гарсан нь Завхан аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 2.1 пунктээр, Увс аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 1.6 пунктээр тус тус буурчээ. Завхан аймгийн ЗДТГ-ын үнэлгээ өмнөх оноос буурсан хэдий ч ЗДТГ-ын дундаж онооноос 7.9 пунктээр өндөр байна. ЗДТГ-уудын ШБҮ өсөхөд ГШБҮ 72.4 болж өмнөх оноос 11.8 пунктээр өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 3: ЗДТГ-уудын ШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар


Засаг даргын тамгын газар	2018	2019	Өөрчлөлт
Шударга байдлын үнэлгээ	66.1	73.2	+7.1
Завхан аймгийн ЗДТГ	83.2	81.1	-2.1 ↓
Төв аймгийн ЗДТГ	63.9	77.3	+13.4 ↑
Өвөрхангай аймгийн ЗДТГ	61.4	77.2	+15.8 ↑
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	71.7	77.0	+5.3
Дархан-Уул аймгийн ЗДТГ	72.0	76.6	+4.6
Орхон аймгийн ЗДТГ	57.8	76.6	+18.8 ↑
Дорноговь аймгийн ЗДТГ	70.9	75.9	+5.0
Дорнод аймгийн ЗДТГ	69.0	75.7	+6.7
Хэнтий аймгийн ЗДТГ	66.8	75.6	+8.8
Булган аймгийн ЗДТГ	68.1	75.1	+7.0
Архангай аймгийн ЗДТГ	62.5	73.1	+10.6 ↑
Увс аймгийн ЗДТГ	74.0	72.4	-1.6 ↓
Говьсүмбэр аймгийн ЗДТГ	67.2	72.0	+4.8
Хөвсгөл аймгийн ЗДТГ	64.7	71.8	+7.1
Баянхонгор аймгийн ЗДТГ	66.7	71.3	+4.6
Нийслэлийн ЗДТГ	67.7	71.2	+3.5
Сүхбаатар аймгийн ЗДТГ	68.3	69.8	+1.5
Дундговь аймгийн ЗДТГ	55.5	69.8	+14.3 ↑
Өмнөговь аймгийн ЗДТГ	67.9	68.7	+0.8
Говь-Алтай аймгийн ЗДТГ	59.3	68.3	+9.0
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	55.6	67.7	+12.1 ↑
Ховд аймгийн ЗДТГ	61.2	66.7	+5.5

I. Гадаад шударга байдлын үнэлгээний үр дүн

Төрийн байгууллагаас үйлчилгээ авч буй болон сүүлийн 12 сарын хугацаанд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийн үнэлгээгээр ГШБҮ-г гаргасан. Уг үнэлгээг ил тод, хариуцлагатай байдлын индексийг тодорхойлох 2 үзүүлэлт, авлигын индексийг тодорхойлох 3 үзүүлэлт, нийт 5 үзүүлэлтээр гаргасан.

ГШБҮ 2019 онд 71.7 болж өмнөх оноос 8.4 пунктээр өссөн байна. ГШБҮ-г байгууллагын төрлөөр авч үзвэл яамдын үнэлгээ 3.0 пунктээр, агентлагуудын үнэлгээ 8.3 пунктээр, аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үнэлгээ 11.8 пунктээр тус тус өсчээ. Нөгөө талаас ГШБҮ 71.7 буюу ШБҮ-нээс 2.4 пунктээр бага байгаа нь үйлчлүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл төрийн байгууллагуудын шударга байдалд харьцангуй бага үнэлгээ өгч байгааг илтгэж байна.

График 4: ГШБҮ, оноор



Хэмжих нэгж: Оноо

Байгууллагууд ГШБҮ-ээр 2019 онд 55.2-82.1 оноо авсан байна. Үр дүнгээс харахад байгууллагуудын гадагшаа чиглэсэн үйл ажиллагаа сайжирч, авлигын шууд болон шууд бус тохиолдол буурч, авлигын индекс сайжирчээ. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдаас шан харамж авах тохиолдол тодорхой хэмжээгээр багассан байна. Харин байгууллагууд оноо алдахад байгууллагын ил тод байдал дутмаг, албан үүргээ хариуцлагатай гүйцэтгэдэггүй байдал нь нөлөөлжээ. Доорх зурагт ГШБҮ-ээр хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагуудыг харууллаа.

Зураг 6: ГШБҮ, Хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан 5 байгууллага



Хэмжих нэгж: Оноо

Яамдын ГШБҮ-ний үр дүнгээс харахад нийт 13 яамнаас 5 яамны үнэлгээ өмнөх оноос буурсан байна. Үүнд: Гадаад харилцааны яам 66.8 оноо авч 13.4 пунктээр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 73.7 оноо авч 10.8 пунктээр, Батлан хамгаалах яам 76.8 оноо авч 9.1 пунктээр, Зам, тээврийн хөгжлийн яам 58.5 оноо авч 9.0 пунктээр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам 55.2 оноо авч 4.5 пунктээр тус тус буурсан байна. Яамдын 2019 оны ГШБҮ-ний онооны эрэмбийг харахад Батлан хамгаалах яам хамгийн өндөр үнэлгээ авсан бол Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам хамгийн бага оноо авсан байна.

Яамдын ГШБҮ 55.2-76.8 байгаа нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл яамдын шударга байдлыг харьцангуй багаар үнэлдэг болох нь харагдаж байна.

Хүснэгт 4: Яамдын ГШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Яам	2018	2019	Өөрчлөлт
Гадаад шударга байдлын үнэлгээ	65.1	68.1	+3.0
Батлан хамгаалахын яам	85.9	76.8	-9.1 ↓
Сангийн яам	59.1	75.0	+15.9 ↑
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	84.5	73.7	-10.8 ↓
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	59.8	72.0	+12.2 ↑
Барилга, хот байгуулалтын яам	58.6	70.5	+11.9 ↑
Эрчим хүчний яам	60.6	69.0	+8.4
Эрүүл мэндийн яам	63.5	68.8	+5.3
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	59.1	67.5	+8.4
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	53.6	67.4	+13.8 ↑
Гадаад харилцааны яам	80.2	66.8	-13.4 ↓
Хууль зүй, дотоод хэргийн яам	54.2	64.8	+10.6 ↑
Зам, тээврийн хөгжлийн яам	67.5	58.5	-9.0 ↓
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	59.7	55.2	-4.5 ↓

Хэмжих нэгж: Оноо

ГШБҮ-нд нийт 23 агентлагийг хамруулсан. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний хөгжлийн газар, Цаг уур, орчны шинжилгээний газар, Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шууд үйлчилгээ үзүүлдэггүй байгууллагууд учраас ГШБҮ-д хамруулаагүй. Мөн 2018 онд Соёл урлагын газар болон Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газрын иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг судалгаанд хамруулаагүй болно.

Үнэлгээнд хамрагдсан агентлагуудын хувьд 2019 онд 60.1-82.1 оноо авсан нь өнгөрсөн оны үнэлгээнээс дунджаар 8.3 пунктээр өссөн байна. Энэ нь агентлагуудын гадагшаа чиглэсэн үйл ажиллагаа сайжирч байгааг илтгэж байна.

Үнэлгээг байгууллагаар харвал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 65.7 оноо авч 18.9 пунктээр, Оюуны өмчийн газар 81.4 оноо авч 0.2 пунктээр тус тус буурсан байна. Харин бусад агентлагийн хувьд үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн өгч буй үнэлгээ өнгөрсөн оноос өссөн үр дүн харагдаж байна.

Хүснэгт 5: Агентлагуудын ГШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Агентлаг	2018	2019	Өөрчлөлт
Гадаад шударга байдлын үнэлгээ	64.6	72.9	+8.3
Архивын ерөнхий газар	57.2	82.1	+24.9 ↑
Оюуны өмчийн газар	81.6	81.4	-0.2 ↓
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	73.0	81.3	+8.3
Онцгой байдлын ерөнхий газар	52.3	81.0	+28.7 ↑

Гадаадын иргэн, харьяатын газар	75.9	80.1	+4.2
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	78.4	79.6	+1.2
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	77.2	78.1	+0.9
Соёл, урлагийн газар		76.8	
Мал эмнэлэг, үржлийн газар	67.6	75.9	+8.3
Стандарт, хэмжил зүйн газар	64.4	75.1	+10.7
Улсын бүртгэлийн ерөнхий газар	60.2	75.3	+15.1 ↑
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	53.5	74.0	+20.5 ↑
Нийгмийн даатгалын ерөнхий газар	69.0	73.1	+4.1
Ашигт малтмал, газрын тосны газар	63.6	71.4	+7.8
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	59.4	70.9	+11.5
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	62.5	69.9	+7.4
Татварын ерөнхий газар	53.8	68.8	+15.0 ↑
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	61.8	66.6	+4.8
Биеийн тамир, спортын газар	55.6	66.3	+10.7
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	84.6	65.7	-18.9 ↓
Цагдаагийн ерөнхий газар	49.3	62.8	+13.5
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар		60.5	
Гаалийн ерөнхий газар	56.7	60.1	+3.4

Хэмжих нэгж: Оноо

Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хувьд ГШБҮ өнгөрсөн оноос харьцангуй өссөн үзүүлэлттэй буюу 63.6-78.2-ийн хооронд байна. Нийт 22 аймаг, нийслэлийн ЗДТГ-аас 3 аймгийн ЗДТГ-ын үнэлгээ өнгөрсөн оноос буурсан байна. Үүнд Завхан аймгийн ЗДТГ 77.7 оноо авч 12.3 пунктээр, Увс аймгийн ЗДТГ 69.6 оноо авч 8.5 пунктээр, Сүхбаатар аймгийн ЗДТГ 70.9 оноо авч 1.7 пунктээр тус тус буурчээ.

Хүснэгт 6: ЗДТГ-уудын ГШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Засаг даргын тамгын газар	2018	2019	Өөрчлөлт
Гадаад шударга байдлын үнэлгээ	60.6	72.9	+12.1
Өвөрхангай аймгийн ЗДТГ	52.7	78.2	+25.5 ↑
Завхан аймгийн ЗДТГ	90.0	77.7	-12.3 ↓
Төв аймгийн ЗДТГ	59.6	77.0	+17.4
Орхон аймгийн ЗДТГ	44.9	76.3	+31.4 ↑
Дорноговь аймгийн ЗДТГ	61.7	75.8	+14.1
Булган аймгийн ЗДТГ	54.7	75.7	+21.0 ↑
Архангай аймгийн ЗДТГ	57.3	75.4	+18.1
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	66.5	74.5	+8.0
Говьсүмбэр аймгийн ЗДТГ	54.1	73.9	+19.8
Дорнод аймгийн ЗДТГ	65.3	73.4	+8.1
Говь-Алтай аймгийн ЗДТГ	47.7	73.4	+25.7 ↑
Өмнөговь аймгийн ЗДТГ	61.4	73.2	+11.8
Дархан-Уул аймгийн ЗДТГ	65.6	72.5	+6.9
Дундговь аймгийн ЗДТГ	51.2	72.1	+20.9 ↑
Сүхбаатар аймгийн ЗДТГ	72.6	70.9	-1.7 ↓
Хэнтий аймгийн ЗДТГ	51.7	70.3	+18.6
Баянхонгор аймгийн ЗДТГ	63.9	70.2	+6.3
Увс аймгийн ЗДТГ	78.1	69.6	-8.5 ↓
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	59.0	66.9	+7.9
Хөвсгөл аймгийн ЗДТГ	62.6	66.5	+3.9
Ховд аймгийн ЗДТГ	54.9	66.2	+11.3
Нийслэлийн ЗДТГ	58.6	63.6	+5.0


Хэмжих нэгж: Оноо

Ил тод, хариуцлагатай байдлын индекс

Тухайн байгууллагаас үйлчилгээ авахад ил тод хариуцлагатай байсан эсэхийг үнэлүүлж индексийг тооцоход төрийн байгууллагуудын дундаж үнэлгээ 61.6 гарсан нь өмнөх оноос 4.7 пунктээр өссөн байна. Үнэлгээг бүрдүүлж буй 2 үзүүлэлтийг харьцуулахад хариуцлагатай байдлын үнэлгээ ил тод байдлын үнэлгээнээс 7.1 пунктээр илүү байна. Харин байгууллагын төрлөөр харахад аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ил тод байдлын үнэлгээ, агентлагуудын хариуцлагатай байдлын үнэлгээ харьцангуй өндөр байна.

Ил тод байдлын үнэлгээ ил тод хариуцлагатай байдлын индексийн дунджаас доогуур үзүүлэлттэй байгаа нь цаашид төрийн байгууллагууд шинээр ажилтан авах гэх мэт хүний нөөцийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэх шаардлагатай байгааг харуулж байна.

График 5: Ил тод, хариуцлагатай байдлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор, байгууллагын төрлөөр



Хэмжих нэгж: Оноо


Авлигын индекс

Тухайн байгууллагаас үйлчилгээ авч буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллөөс уг байгууллагын авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдлыг тодруулж авлигын индексийг тооцоход 2019 онд 82.8 оноо авч авлигын индекс 12.8 пунктээр буурсан байна. Ийнхүү авлига буурахад авлигын шууд болон шууд бус тохиолдол багассан нь нөлөөлжээ.

Авлига өгсөн тохиолдлыг тодруулбал 2019 онд Төрийн үйлчилгээ авч буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын 2.3 хувь нь төрийн үйлчилгээг авахдаа нэмэлт төлбөр, 2.0 хувь нь шууд болон шууд бус байдлаар бэлэг, 2.8 хувь нь хандив, бусад санхүүгийн тусламж зэргийг тухайн байгууллага/албан тушаалтанд өгсөн байна. Гэхдээ энэ нь өмнөх оноос 12 пунктээр буурсан байна.

Мөн судалгаанд оролцогчоос “Танай найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотнын хэн нэгэн тухайн байгууллагаас үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэргийг сүүлийн 12 сарын хугацаанд өгч байсныг мэдэх үү? гэж асуухад судалгаанд оролцогчдын 5.5 хувь нь “тийм” гэж хариулсан байгаа нь өмнөх оноос 19.3 пунктээр буурчээ. Үр дүнгээс харахад өмнөх онд авлигын шууд бус тохиолдол их байсан бол энэ онд авлигын шууд тохиолдол их байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллага авлигын асуудалд илүү нухацтай болгоомжтой ханддаг болж гэж үзэж болохоор байна.


График 6: Авлигын индекс, дэд үзүүлэлтээр, оноор



Хэмжих нэгж: Оноо

Авлигын индексийг байгууллагын төрлөөр харахад яамдын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 59.7, авлигын шууд бус тохиолдол 83.8 буюу харьцангуй бага үнэлгээтэй байна. Эндээс харахад яамдад авлигын шууд бус тохиолдол нэлээдгүй ажиглагддаг бөгөөд үүнийг дагаад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл яамд авлига авдаг гэсэн төсөөлөл харьцангуй өндөртэй байна.


График 7: Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр



Хэмжих нэгж: Оноо

Төрийн үйлчилгээ авахдаа тухайн байгууллага/албан тушаалтанд нэмэлт төлбөр, бэлэг, хандив тусламж зэргийг өгч байсан гэж хариулсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллөөс дээр дурдсан зүйлсийг яг аль үед өгсөн болохыг тодруулахад “Үйлчилгээ авахаас өмнө” гэсэн хариултыг хамгийн их өгсөн бол эдгээр зүйлсийг өгөх болсон шалтгаанаа “Ажлаа хурдан бүтээхийн тулд” хэмээн хариулсан байна. Дэлгэрэнгүй үр дүнг Зураг 7-д харуулсан болно.

Зураг 7: Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг яг аль үед өгсөн, өгөх болсон шалтгаан




Хэмжих нэгж: Хувь

II. Дотоод шударга байдлын үнэлгээний үр дүн

Байгууллагын ДШБҮ-г тухайн байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдын үнэлгээнд үндэслэн гаргасан. Дотоод шударга байдлыг үнэлэхдээ соёлын индексийг тодорхойлох 2 үзүүлэлт, ажлын байрандахь шударга байдлын индексийг тодорхойлох 4 үзүүлэлт нийт 6 үзүүлэлтээр үнэлгээг гаргасан. ДШБҮ үнэлгээ буюу байгууллагын ажилтан албан хаагчдын үнэлгээ 80.8 буюу ерөнхий үнэлгээнээс 6.7 пунктээр өндөр гарсан байгаа нь төрийн албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг өндрөөр үнэлдэг болох нь харагдаж байна.

Төрийн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын өгсөн үнэлгээг байгууллагын төрлөөр харвал яамдын хувьд хамгийн өндөр буюу 100 онооноос 82.0 оноо авсан байна. Өмнөх онтой харьцуулахад яамдын дундаж үнэлгээ өмнөх оноос 5.3 пунктээр, агентлагуудын дундаж үнэлгээ 3.2 пунктээр, аймаг, нийслэлийн дундаж үнэлгээ 4.2 пунктээр тус тус өсжээ.

График 8: ДШБҮ, оноор, байгууллагын төрлөөр



Хэмжих нэгж: Оноо

Байгууллагууд ДШБҮ-ээр 2019 онд 60.5-87.2 оноо авсан байна. Үр дүнгээс хамгийн өндөр үнэлгээ авсан 5 байгууллагын үнэлгээ өнгөрсөн оноос бүгд сайжирсан байгаа нь харагдаж байна. Доорх зурагт ДШБҮ-ээр хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагуудыг харууллаа.

Зураг 8: ДШБҮ, Хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан 5 байгууллага



Хэмжих нэгж: Оноо

Яамдын ДШБҮ 2019 онд 76.5-86.6 онооны хооронд байна. Энэ нь нэг талаас яамдын албан хаагчид өөрийн байгууллагаа илүү сайнаар үнэлж байгааг харуулж байна. Нөгөө талаас яамдын үнэлгээ бүгд сайжирсан байгаа нь яамдын дотоод үйл ажиллагаа сайжирч байгааг илтгэж байна.

Хүснэгт 7: Яамдын ДШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Яам	2018	2019	Өөрчлөлт
Дотоод шударга байдлын үнэлгээ	76.7	82.0	+5.3
Сангийн яам	81.1	86.6	+5.5
Батлан хамгаалахын яам	76.5	85.7	+9.2 ↑
Хууль зүй, дотоод хэргийн яам	78.4	85.5	+7.1 ↑
Гадаад харилцааны яам	83.0	85.1	+2.1
Барилга, хот байгуулалтын яам	83.1	84.1	+1.0
Зам, тээврийн хөгжлийн яам	74.2	84.0	+9.8 ↑
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	77.9	82.9	+5.0
Эрчим хүчний яам	75.5	82.7	+7.2 ↑
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	78.0	79.8	+1.8
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	73.9	79.5	+5.6 ↑
Эрүүл мэндийн яам	67.5	76.9	+9.4 ↑
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	75.1	76.5	+1.4
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	72.3	76.5	+4.2

Хэмжих нэгж: Оноо

Агентлагуудын хувьд ДШБҮ 2019 онд 60.5-87.2 байна. Нийт 27 агентлагаас 7 агентлагийн үнэлгээ өнгөрсөн оноос буурсан байгаа нь Стандарт хэмжил зүйн газар, Үндэсний хөгжлийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Биеийн тамир спортын газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар байна.

Хүснэгт 8: Агентлагуудын ДШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Агентлаг	2018	2019	Өөрчлөлт
Дотоод шударга байдлын үнэлгээ	77.5	80.7	+3.2
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	82.4	87.2	+4.8
Онцгой байдлын ерөнхий газар	80.6	87.1	+6.5
Соёл, урлагийн газар	84.8	86.9	+2.1
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	82.6	85.7	+3.1
Гадаадын иргэн, харьяатын газар	81.7	85.7	+4.0
Оюуны өмчийн газар	72.5	85.3	+12.8 ↑
Цаг уур, орчны шинжилгээний газар	74.6	85.0	+10.4
Нийгмийн даатгалын ерөнхий газар	79.9	84.7	+4.8
Ашигт малтмал, газрын тосны газар	71.1	84.6	+13.5 ↑
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	84.3	84.6	+0.3
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	85.4	84.3	-1.1 ↓
Гаалийн ерөнхий газар	78.0	84.0	+6.0
Улсын бүртгэлийн ерөнхий газар	75.8	83.1	+7.3
Цагдаагийн ерөнхий газар	79.8	82.7	+2.9
Мал эмнэлэг, үржлийн газар	73.5	81.5	+8.0
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	79.2	80.9	+1.7
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	75.1	80.2	+5.1
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	78.0	79.9	+1.9
Архивын ерөнхий газар	69.6	79.2	+9.6
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	82.1	79.2	-2.9 ↓

Татварын ерөнхий газар	76.4	79.1	+2.7
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	80.2	77.4	-2.8 ↓
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	82.0	76.5	-5.5 ↓
Иргэний нисэхийн ерөнхий газар	66.3	73.4	+7.1
Стандарт, хэмжил зүйн газар	76.6	71.0	-5.6 ↓
Үндэсний хөгжлийн газар	75.4	69.8	-5.6 ↓
Биеийн тамир, спортын газар	63.9	60.5	-3.4 ↓

Хэмжих нэгж: Оноо

Аймгуудын ДШБ-ын дундаж үнэлгээ 2019 онд 80.2 байгаа нь өмнөх оноос 4.2 пунктээр өссөн хэдий ч Нийслэлийн ЗДТГ болон Өмнөговь, Говьсүмбэр, Увс аймгуудын ЗДТГ-ын ДШБҮ өмнөх оноос бага зэрэг буурсан байна.

Хүснэгт 9: ЗДТГ-уудын ДШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар


Засаг даргын тамгын газар	2018	2019	Өөрчлөлт
Дотоод шударга байдлын үнэлгээ	76.0	80.2	+4.2
Завхан аймгийн ЗДТГ	80.3	85.5	+5.2
Өвөрхангай аймгийн ЗДТГ	78.7	85.5	+6.8
Орхон аймгийн ЗДТГ	69.4	85.1	+15.7 ↑
Хэнтий аймгийн ЗДТГ	82.5	84.3	+1.8
Булган аймгийн ЗДТГ	83.0	84.1	+1.1
Дорноговь аймгийн ЗДТГ	75.5	82.8	+7.3
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	79.7	82.3	+2.6
Архангай аймгийн ЗДТГ	80.9	82.1	+1.2
Төв аймгийн ЗДТГ	78.1	81.9	+3.8
Дорнод аймгийн ЗДТГ	67.4	81.0	+13.6 ↑
Дархан-Уул аймгийн ЗДТГ	76.3	81.0	+4.7
Говьсүмбэр аймгийн ЗДТГ	84.1	80.8	-3.3 ↓
Увс аймгийн ЗДТГ	82.5	79.9	-2.6 ↓
Хөвсгөл аймгийн ЗДТГ	78.6	79.9	+1.3
Дундговь аймгийн ЗДТГ	69.5	79.9	+10.4 ↑
Говь-Алтай аймгийн ЗДТГ	68.5	78.0	+9.5
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	60.9	77.6	+16.7 ↑
Өмнөговь аймгийн ЗДТГ	81.2	77.0	-4.2 ↓
Баянхонгор аймгийн ЗДТГ	74.2	75.8	+1.6
Сүхбаатар аймгийн ЗДТГ	71.9	74.6	+2.7
Нийслэлийн ЗДТГ	81.1	72.7	-8.4 ↓
Ховд аймгийн ЗДТГ	67.7	72.7	+5.0

Хэмжих нэгж: Оноо

Соёлын индекс

Дотоод шударга байдлын үнэлгээ нь тухайн байгууллага дахь соёлын индекс болон үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексээс бүрдэж байгаа юм. Үнэлгээний үр дүнгээс харахад байгууллагын соёлын индекс харьцангуй бага буюу ДШБ-ын дундаж үнэлгээнээс 8.3 пунктээр бага байгаа нь албан хаагчдын албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэх байдал хангалтгүй, хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавих, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах, бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлөх зэрэг байдлаас ихээхэн хамааралтай байна. Мөн байгууллагад авлигын эсрэг тогтолцоо сайн бүрдээгүй, авлига ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалах, авлигыг хянах дотоод хяналтын механизмыг бүрдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Цаашид зөрчил гаргасан албан хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг, энэ талаар ажилтан албан хаагчдад ил тод байдлаар мэдээлдэг байх нь байгууллагын авлигын эсрэг тогтолцоог сайжруулахад ихээхэн түлхэц үзүүлнэ гэж үзэж байна.

График 9: Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор, байгууллагын төрлөөр




Хэмжих нэгж: Оноо

Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс

Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс нь хүний нөөцийн асуудал, төсвийн зарцуулалт, удирдлагын үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх асуудал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийн үзүүлэлтээс бүрдэж байгаа бөгөөд эдгээрээс удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийн үзүүлэлт 70.0 буюу хамгийн бага үнэлгээ авсан байна. Ажилтан албан хаагчдын үзэж байгаагаар байгууллагад нь авлигын нөлөө буурсан хэдий ч байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа муудсан байна.


График 10: Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор



Хэмжих нэгж: Оноо

Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийг байгууллагын төрлөөр бүрдүүлж буй үзүүлэлтээр салгаж харахад төдийлөн ялгаа харагдахгүй байна. Мөн 2019 онд төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан байдал 1.1 пунктээр буюу бага зэрэг нэмэгдсэн байна. Энэ асуудал нь агентлаг болон ЗДТГ илүү ажиглагдаж байна.

График 11: Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр



Хэмжих нэгж: Оноо

Төрийн албан хаагчдаас сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол байгаа эсэхийг тодруулахад 3.1 хувь нь “тийм” гэж хариулсан бол зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгааныг удирдах албан тушаалтны шийдвэрээр гэж 48.1 хувь нь, хяналт сулаас гэж 19.2 хувь нь, уламжлал болсон учир гэж 11.5 хувь нь тус тус хариулсан байна. Энэ нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал нь удирдлагын шийдвэртэй шууд хамааралтай болохыг харуулж байна. Энэ нь цаашид байгууллагын удирдлага, албан хаагчдыг санхүүгийн сахилга баттай болгох тал дээр анхаарах, хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Мөн “Уламжлал болсон учир” гэсэн хариулт нэлээд хувийг эзэлж байна. Тиймээс энэ тал дээр анхаарал хандуулж шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч уламжлал болсон зүйл гэсэн сэтгэлгээнээс төрийн албан хаагчдыг салгах хэрэгтэй байна.

График 12: Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгаан




Хэмжих нэгж: Хувь

III. БОДЛОГОД ОРОЛЦОГЧДЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

БОУ буюу шинжээчдийн үнэлгээнд тухайн байгууллагын харьяад ээд байгууллагын төлөөлөл, бодлого боловсруулагч болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, аудитор, хяналтын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оролцуулсан. БОУ нь авлигын талаарх төсөөлөл, авлигын хяналт, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл гэсэн 4 индексийн үнэлгээнээс бүрдэж байгаа юм.

Бодлогод оролцогчдын дундаж үнэлгээ 100 онооноос 69.8 байгаа нь өмнөх оноос 3.8 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Өсөлтийг байгууллагын төрлөөр харахад яамдын дундаж үнэлгээ 4.5 пунктээр, агентлаг 2.1 пунктээр, аймаг, нийслэлийн ЗДТГ 5.3 пунктээр тус тус өссөн байна. Гэсэн хэдий ч бодлогод оролцогчдын үнэлгээ ерөнхий үнэлгээнээс 4.3 пунктээр бага байна. Энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэлд холбоо хамааралтай, харьцангуй мэдээлэл сайтай хүмүүс үнэлгээ бага өгч байгааг харуулж байна.

График 13: БОУ, оноор, байгууллагын төрлөөр



Хэмжих нэгж: Оноо

Яамдад өгсөн БОУ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бусад яамны хувьд өссөн байна. Энэ өсөлт нь Батлан хамгаалах яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд илүүтэй ажиглагдаж байна. Харьцангуй бага үнэлгээ авсан яамдыг дурдвал Байгаль орчин, аялал жуулчлалын яам 64.3 оноо, Сангийн яам 64.8 оноо, Барилга, хот байгуулалтын яам 65.2 оноо тус тус авсан байгаа нь харьцангуй бага оноо болж байна.

Хүснэгт 10: Яамдын БОУ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Яам	2018	2019	Өөрчлөлт
Бодлогод оролцогчдын үнэлгээ	65.1	69.6	+4.5
Батлан хамгаалахын яам	67.3	78.7	+11.4 ↑
Гадаад харилцааны яам	76.6	78.4	+1.8
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	63.1	73.8	+10.7 ↑
Хууль зүй, дотоод хэргийн яам	64.5	70.6	+6.1
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	63.7	70.4	+6.7
Зам, тээврийн хөгжлийн яам	68.4	68.9	+0.5
Эрүүл мэндийн яам	68.9	68.9	0.0
Эрчим хүчний яам	61.7	68.7	+7.0
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	59.8	66.5	+6.7
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	67.8	65.5	-2.3 ↓
Барилга, хот байгуулалтын яам	60.3	65.2	+4.9
Сангийн яам	60.8	64.8	+4.0
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	63.2	64.3	+1.1

Хэмжих нэгж: Оноо

Агентлагуудад өгсөн бодлогод оролцогчдын дундаж үнэлгээ 2019 онд 72.1 байгаа нь өмнөх оноос 2.1 пунктээр өссөн байна. Байгууллагаар авч үзвэл Гаалийн ерөнхий газар 50.2, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 57.8, Иргэний нисэхийн ерөнхий газар 57.7 оноо тус тус авсан нь хамгийн бага үзүүлэлттэй байгаагаас гадна өмнөх оноос буурсан харагдаж байна. Харин Соёл урлагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар харьцангуй өндөр буюу 100 онооноос 80-аас дээш оноо авсан байна.

Хүснэгт 11: Агентлагуудын БОУ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Агентлаг	2018	2019	Өөрчлөлт
Бодлогод оролцогчдын үнэлгээ	70.0	72.1	+2.1
Соёл, урлагийн газар	80.3	87.4	+7.1
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	74.2	83.3	+9.1
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	84.3	82.7	-1.6 ↓
Гадаадын иргэн, харьяатын газар	73.3	81.0	+7.7
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	70.3	80.1	+9.8
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	63.4	79.0	+15.6 ↑
Цагдаагийн ерөнхий газар	77.6	78.2	+0.6
Оюуны өмчийн газар	74.0	78.0	+4.0
Онцгой байдлын ерөнхий газар	79.4	77.0	-2.4 ↓
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	74.8	76.4	+3.0
Цаг уур, орчны шинжилгээний газар	75.5	76.4	+0.9
Архивын ерөнхий газар	70.1	76.3	+6.1
Улсын бүртгэлийн ерөнхий газар	67.4	76.1	+8.7
Нийгмийн даатгалын ерөнхий газар	72.3	75.5	+3.2
Мал эмнэлэг, үржлийн газар	68.5	72.7	+4.2
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	62.9	70.5	+7.6
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	75.8	70.0	-5.8 ↓
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	56.6	69.7	+13.1 ↑
Биеийн тамир, спортын газар	67.6	68.0	+0.4
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	59.4	66.7	+7.3
Ашигт малтмал, газрын тосны газар	63.2	65.6	+2.4
Стандарт, хэмжил зүйн газар	62.5	64.7	+2.2
Татварын ерөнхий газар	59.5	62.3	+2.8
Үндэсний хөгжлийн газар	75.7	61.6	-14.1 ↓
Иргэний нисэхийн ерөнхий газар	70.2	58.7	-11.5 ↓
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	62.9	57.8	-5.1 ↓
Гаалийн ерөнхий газар	67.4	50.2	-17.2 ↓

Хэмжих нэгж: Оноо

Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хувьд нийт 22 байгууллагаас 7 байгууллагын үнэлгээ буурсан байна. Эдгээр байгууллагын нэрийг дурдвал Говь-Алтай, Дорноговь, Өмнөговь, Булган, Дорнод, Говьсүмбэр, Ховд аймгийн ЗДТГ-ууд болно. Харин Завхан, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Дорнод, Хэнтий аймгуудын ЗДТГ болон Нийслэлийн ЗДТГ бодлогод оролцогчдоос харьцангуй өндөр үнэлгээ авсан байна.


Хүснэгт 12: ЗДТГ-уудын БОУ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар

Засаг даргын тамгын газар	2018	2019	Өөрчлөлт
Бодлогод оролцогчдын үнэлгээ	61.8	67.1	+5.3
Завхан аймгийн ЗДТГ	78.2	80.2	+2.0
Нийслэлийн ЗДТГ	63.7	77.1	+13.4 ↑
Дархан-Уул аймгийн ЗДТГ	73.7	76.4	+2.7
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	68.3	74.3	+6.0
Төв аймгийн ЗДТГ	53.2	73.1	+19.9 ↑
Дорнод аймгийн ЗДТГ	73.6	72.7	-0.9 ↓
Хэнтий аймгийн ЗДТГ	65.4	72.1	+6.7
Дорноговь аймгийн ЗДТГ	75.3	69.1	-6.2 ↓
Хөвсгөл аймгийн ЗДТГ	53.0	68.9	+15.9 ↑
Орхон аймгийн ЗДТГ	59.0	68.5	+9.5
Баянхонгор аймгийн ЗДТГ	63.5	68.0	+4.5
Өвөрхангай аймгийн ЗДТГ	53.8	67.9	+14.1 ↑
Увс аймгийн ЗДТГ	61.2	67.7	+6.5
Булган аймгийн ЗДТГ	66.8	65.5	-1.3 ↓
Сүхбаатар аймгийн ЗДТГ	60.3	64.0	+3.7
Архангай аймгийн ЗДТГ	49.9	62.0	+12.1 ↑
Говьсүмбэр аймгийн ЗДТГ	62.0	61.4	-0.6 ↓
Ховд аймгийн ЗДТГ	61.4	61.1	-0.3 ↓
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	47.2	58.7	+11.5
Дундговь аймгийн ЗДТГ	47.0	57.5	+10.5
Өмнөговь аймгийн ЗДТГ	61.9	56.0	-5.9 ↓
Говь-Алтай аймгийн ЗДТГ	61.0	53.6	-7.4 ↓

Хэмжих нэгж: Оноо

Бодлогод оролцогчдын зүгээс тухайн байгууллагын авлигын хяналтад өгч буй үнэлгээ хамгийн бага буюу 50.9, удирдлагын хүсэл эрмэлзэлд өгч буй үнэлгээ харьцангуй бага буюу 60.5 оноо авсан байна. Үр дүнгээс шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төдийлөн үр дүнтэй ажиллаж чадахгүй, дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцох байдал хангалтгүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалж чадахгүй байгаа нь харагдаж байна.

График 14: БОУ, оноор, индексээр




Хэмжих нэгж: Оноо

Бодлогод оролцогчдын үнэлгээнээс харахад яамдад авлигын бодит тохиолдол хамгийн бага байгаа хэдий ч удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-тай харьцуулахад харьцангуй бага байна.

Харин аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд байгууллагын удирдлага авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл багатай үүнийгээ дагаад хяналт сул байгаа нь харагдаж байна.

График 15: БОУ, байгууллагын төрлөөр, индексээр



Хэмжих нэгж: Оноо


IV. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГА

Энэхүү бүлэг нь төрийн байгууллагын шударга байдлын түвшинг тодорхойлохтой холбоогүй бөгөөд зөвхөн Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг харуулах зорилготой юм. Монгол Улс дахь авлигыг үнэлэхдээ судалгаанд оролцогч талуудаас Монгол Улсад авлига хэр түгээмэл байгааг, авлига хамгийн их тархсан институц аль болохыг, ирэх 2 жилд авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөнө гэж бодож байгааг авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг хэрхэн үнэлж байгааг тодруулсан.

Монгол Улсын авлигын өнөөгийн байдал

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хэр түгээмэл байгааг тодруулахад 28.1 хувь нь ихээхэн түгээмэл гэж хариулсан нь өмнөх оноос 5.1 пунктээр, 50.6 хувь нь түгээмэл гэж хариулсан нь 2.2 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Үр дүнгээс харахад авлигын цар хүрээ буурч байгаа хэдий ч нийт судалгаанд оролцогчдын 78.7 хувь нь Монгол Улсад авлига байсаар байна гэж үзжээ.


График 16: Монгол Улсын авлигын өнөөгийн байдал, оноор



Хэмжих нэгж: Хувь

Монгол Улсын авлигын өнөөгийн байдлыг оролцогч талуудаар харахад төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 29.7 хувь буюу 10 хүн тутмын 3 нь Монгол Улсад авлига ихээхэн түгээмэл байна хэмээн үзсэн байна.

График 17: Монгол Улсын авлигын өнөөгийн байдал, оролцогч талуудын үнэлгээгээр



Хэмжих нэгж: Хувь


Монгол Улсын ирэх 2 жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдлын талаарх төсөөлөл

Монгол Улсын ирэх 2 жилийн авлигын нөхцөл байдлын талаарх төсөөллийг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдоос ирэх 2 жилд Монгол Улсын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаар тодруулахад 43.5 хувь нь буурна гэж үзжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 26.7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Мөн 2018 оны үнэлгээнээс харахад ирэх 2 жилд авлига өснө гэсэн хандлага 26.2 хувь байсан бол энэ онд 13.6 хувь болж, 12.6 пунктээр буурсан байна. Эндээс ирэх 2 жилд авлигын нөхцөл байдал буурна гэсэн хүлээлттэй байгаа нь харагдаж байна.

Авлигын нөхцөл байдал буурч байгаа нь шударга байдлын ерөнхий үнэлгээ, ДШБҮ, ГШБҮ, БОҮ үр дүнгүүд өсөхөд нөлөөлсөн байж болох юм.

График 18: Авлигын нөхцөл байдлын талаарх ирэх 2 жилийн төсөөлөл, оноор




Хэмжих нэгж: Хувь

Дээрх үр дүн оролцогч талуудаар ялгаатай байгаа эсэхийг харахад төрийн байгууллагаас үйлчилгээ авч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн Монгол Улсын авлигын түвшин ирэх 2 жилд хэрхэн өөрчлөгдөх талаар судалгаанд

оролцогчдын өгсөн хариултыг оролцогч талуудаар ялгаатай байгаа эсэхийг гаргахад бодлогод оролцогчдын 47.0 хувь, албан хаагчдын 42.7 хувь, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн 40.7 хувь буюу нийт судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын 4-5 нь буурна гэж үзжээ. Мөн судалгаанд оролцогчдын 100 хүн тутмын 3-4 нь өөрчлөгдөхгүй гэж хариулсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын авлигын нөхцөл байдал ирэх 2 жилд буурна гэсэн хүлээлт бусад 2 оролцогч талтай харьцуулахад өндөр байна.

График 19: Авлигын нөхцөл байдлын талаарх ирэх 2 жилийн төсөөлөл




Хэмжих нэгж: Хувь

Монгол Улсад авлига хамгийн их тархсан институт

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институт аль нь болохыг тодруулахад Шүүх өнгөрсөн оноос 4.1 хувиар авлига нэмэгдсэн үзүүлэлттэйгээр 1-рт, 8-рт эрэмбэлэгдэж байсан Гаалийн байгууллага 12.6 хувиар авлига нэмэгдсэн үзүүлэлттэйгээр 2-рт, 9-рт эрэмбэлэгдэж байсан Мэргэжлийн хяналтын байгууллага 10.7 хувиар авлига нэмэгдсэн үзүүлэлттэйгээр 3-рт эрэмбэлэгджээ. Харин өнгөрсөн онд авлига хамгийн их тархсан институт буюу 2-рт эрэмбэлэгдэж байсан Газрын алба, 3-рт эрэмбэлэгдэж байсан Эрүүл мэндийн байгууллага тус тус 2 байр ухарсан байна. Харин бидний судалгааны нэгж болох яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ 2018 онд 4-рт эрэмбэлэгдэж байсан бол 2019 онд 2 байр ухарч, 6-рт эрэмбэлэгдсэн байна.

Үр дүнгээс харахад Шүүх, Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага 2 онд дараалан эхний 5-д эрэмбэлэгдсэн байна. Тиймээс эдгээр институтэд тархсан авлигыг бууруулах, таслан зогсоох тал дээр нэн тэргүүнд анхаарал хандуулж авлигатай тэмцэх чиглэлээр зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох хэрэгтэй байна.

График 20: Монгол Улсад авлига их тархсан институц, оноор




Хэмжих нэгж: Хувь

Дээрх үр дүнг судалгаанд оролцогч талуудын хувьд ялгаатай байдал байгаа эсэхийг харахад бодлогод оролцогчид болон төрийн албан хаагчид Шүүх, Гаалийн байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллага зэргийг авлига хамгийн их тархсан институц гэж үзэж байгаа бол иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл Эрүүл мэндийн байгууллагыг 2-рт эрэмбэлсэн байна. Энэ нь иргэдэд эрүүл мэндийн салбараас үйлчилгээ авах хэрэгцээ их байдаг хэдий ч үйлчилгээний хүртээмж бага байдагтай холбоотой гэж үзэж байна.

Бодлогод оролцогчдын 42.3 хувь, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн 39.8 хувь нь төрийн захиргааны байгууллага яам, агентлагт авлига их тархсан гэсэн бол төрийн албан хаагчдын 22.7 нь төрийн захиргааны байгууллага яам, агентлагт авлига их тархсан гэж хариулсан нь харьцангуй бага хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны байгууллагад ажиллаж буй албан хаагчид өөрсдийн ажиллаж буй институцийг харьцангуй сайнаар үнэлсэн байна. Энэ хамаарал нь нутгийн захиргааны байгууллагын хувьд ч мөн ажиглагдаж байна. Доорх графикаас харьцуулсан үр дүнг харна уу.


График 21: Монгол Улсад авлига их тархсан институц, оролцогч талуудын үнэлгээгээр



Хэмжих нэгж: Хувь

Судалгаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллөөс Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад цалин орлого бага, ажлаа хурдан бүтээх хэрэгцээ шаардлагаар, амьжиргааны түвшин доогуур, хүнд суртлаас, хууль эрх зүйн тогтолцоо муу, хэрэгжилт сулаас зэрэг шалтгааныг хамгийн их дурджээ.

График 22: Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан



Хэмжих нэгж: Хувь


V. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

Судалгааны асуулгын дагуу судалгаанд оролцогчдоор Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг үнэлүүлэхэд нийт судалгаанд оролцогчдын 36.0 хувь нь үр ашигтай, 42.6 хувь нь дунд зэрэг гэж үнэлжээ. Үнэлгээнд оролцогч талуудаар харвал иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн үр ашигтай гэж өгсөн үнэлгээ албан хаагч болон бодлогод оролцогчдын үнэлгээнээс харьцангуй бага буюу 29.1 хувьтай байна.

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг 1-5 оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 3.35 буюу дунджаас дээгүүр гарсан. Үнэлгээг оролцогч талуудаар харвал хамгийн бага буюу 3.09 оноог иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл хамгийн өндөр буюу 3.61 оноог төрийн албан хаагчид өгсөн бол бодлогод оролцогчид 3.35 оноо өгсөн байна.

Үнэлгээ нь 1-5 хүртэлх онооны сонголттой бөгөөд 1 бол огт үр ашиггүй, 2 үр ашиггүй, 3 дунд зэрэг, 4 үр ашигтай, 5 ихээхэн үр ашигтай гэсэн утгыг илэрхийлж байсан.

График 23: Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Хэмжих нэгж: Хувь

ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Гадаад шударга байдлын үнэлгээний судалгаанд оролцогчдыг төлөөлж буй төлөөллөөр нь авч үзвэл 10 оролцогч тутмын 3 нь аж ахуйн нэгж, байгууллага төлөөлж, 10 оролцогч тутмын 7 нь хувь хүний хувьд төрийн байгууллагаас үйлчилгээ авсан байна.

Зураг 9: Судалгаанд оролцогчдын төлөөлөл

10 оролцогч тутмын **3** нь аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл




10 оролцогч тутмын **7** нь хувь хүн



Гадаад шударга байдлын үнэлгээний судалгаанд оролцогчдын 41.3% нь эрэгтэй, 58.7% нь эмэгтэй байсан. Насны хувьд 30-39 насныхан хамгийн их буюу нийт ГШБҮ-нд оролцогчдын 29.6%, 20 хүртэлх насныхан хамгийн бага буюу 1.6%-ийг эзэлж байна.

График 24: Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн бүтэц



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ


-  Шударга байдлын үнэлгээний судалгаанд нийт 62 байгууллага (яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ)-ыг үнэлсэн бөгөөд нийт 9,555 нэгж (ГШБҮ-нд 7,400 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, ДШБҮ-нд 1,360 төрийн албан хаагч, БОҮ-нд 795 шинжээч)-ээс мэдээлэл цуглуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгууллаа.
-  Төрийн байгууллагууд ШБҮ-ээр 100 онооноос 2019 онд дунджаар 74.1 оноо авсан нь өмнөх оноос 5.4 пунктээр өссөн байна. ШБҮ ийнхүү өсөхөд тухайн төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өгсөн үнэлгээ 8.3 пунктээр, төрийн албан хаагчдын өгсөн үнэлгээ 4.0 пунктээр, бодлогод оролцогчдын өгсөн үнэлгээ 3.8 пунктээр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.
-  ШБҮ-нд хамрагдсан байгууллагуудыг 0-100 оноогоор үнэлэхэд 2019 онд 64.8-83.7 оноо авсан байна. Үнэлгээнээс харахад байгууллагуудын ил тод хариуцлагатай байдал дутмаг, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог зэрэг шалтгааны улмаас оноо алдсан байна.
-  Үр дүнгээс харахад төрийн байгууллагын албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг өндрөөр үнэлдэг болох нь харагдаж байна. Харин ГШБҮ 71.6 буюу ШБҮ-нээс 2.5 пунктээр бага байгаа нь үйлчлүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл төрийн байгууллагуудын шударга байдалд харьцангуй бага үнэлгээ өгч байгааг илтгэж байна.
-  Үр дүнгээс харахад байгууллагуудын гадагшаа чиглэсэн үйл ажиллагаа сайжирч, авлигын индекс өссөн байна. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдаас шан харамж авах тохиолдол нэлээд багассан байна. Харин байгууллагууд оноо алдахад байгууллагын ил тод байдал дутмаг, албан үүргээ хариуцлагатай гүйцэтгэдэггүй байдал нь нөлөөлжээ.
-  Ил тод байдлын үнэлгээ ил тод хариуцлагатай байдлын индексийн дунджаас доогуур үзүүлэлттэй байгаа нь цаашид төрийн байгууллагууд шинээр ажилтан авах гэх мэт хүний нөөцийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэх шаардлагатай байгааг харуулж байна.
-  ШБҮ-нд хамрагдсан байгууллагуудыг 0-100 оноогоор үнэлэхэд 62 байгууллагын авсан үнэлгээ 64.6-83.8 онооны хооронд байна. Үнэлгээ өссөн нь нэг талаас төрийн байгууллагууд өмнөх оны үнэлгээнд үндэслэж авлигатай тэмцэх үйл ажиллагаагаа эрчимжүүлж байгаатай, хоёрдугаарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг судалгаанд хамруулахдаа яг тухайн байгууллагаас үйлчилгээ авч байгаа, авсан төлөөллийг хамруулсантай холбоотой. Мэдээлэл цуглуулалтын үеэр байгууллагын нэр хүндтэй холбоотой асуудал учир энэ чиглэлд үйл ажиллагааг илүү сайжруулсан, анхаарч ажиллаж байгаа гэдгээ байгууллагууд илэрхийлж байсан.
-  Үр дүнгээс харахад өмнөх онд авлигын шууд бус тохиолдол их байсан бол энэ онд авлигын шууд тохиолдол их байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллага авлигын асуудалд илүү нухацтай болгоомжтой ханддаг болж гэж үзэж болохоор байна. Байгууллагын төрлөөр харахад яамдад авлигын шууд бус тохиолдол нэлээдгүй ажиглагддаг бөгөөд үүнийгээ дагаад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл яамд авлига

авдаг гэсэн төсөөлөл харьцангуй өндөртэй байна.

-  Иргэд төрийн үйлчилгээ авахдаа ажлаа хурдан бүтээх, бусдаас давуу байдал олж авахын тулд Үйлчилгээ авахаасаа өмнө тухайн байгууллага/албан тушаалтанд нэмэлт төлбөр, бэлэг, хандив тусламж зэргийг өгдөг байна.
-  Бодлогод оролцогчдын зүгээс тухайн байгууллагын авлигын хяналтын индекс, удирдлагын хүсэл эрмэлзлийн индексэд харьцангуй бага үнэлгээ өгсөн байна. Үр дүнгээс Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төдийлөн үр дүнтэй ажиллаж чадахгүй, дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцох байдал хангалтгүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалж чадахгүй байгаа нь харагдаж байна.
-  Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хэр түгээмэл байгааг тодруулахад 28.1 хувь нь ихээхэн түгээмэл гэж хариулсан нь өмнөх оноос 5.1 хувиар, 50.6 хувь нь түгээмэл гэж хариулсан нь 2.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Үр дүнгээс харахад авлигын цар хүрээ буурч байгаа хэдий ч нийт судалгаанд оролцогчдын 78.7 хувь нь Монгол Улсад авлига байсаар байна гэж үзжээ.
-  Судалгаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллөөс Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад цалин орлого бага, амьжиргааны түвшин доогуур байдал, ажлаа хурдан бүтээх хэрэгцээ шаардлагаар, хүнд суртлаас болоод, хууль эрх зүйн тогтолцоо муу, хэрэгжилт сулаас зэрэг доорх шалтгаануудыг хамгийн түгээмэл байна.
-  Цаашид төрийн байгууллагууд шударга байдлын үнэлгээгээ нэмэгдүүлэхийн тулд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, албан хаагчдын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлах, хариуцлага тооцох механизмыг илүү сайжруулах, ил тод мэдээлэх, авлига ашиг сонирхлын зөрчил гаргасан этгээдийг мэдээлсэн мэдээлэгчийг бүрэн хамгаалах, байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, нийт албан хаагчдын ёс зүй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зэрэгт анхаарал хандуулж тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. ШБҮ 2019 онд



Хавсралт 2. ШБҮ 2018, 2019 онд

Байгууллагын нэр	2018	2019	Өөрчлөлт
Шударга байдлын үнэлгээ	68.7	74.1	+5.4
ЯАМ	68.9	73.2	+4.3
Батлан хамгаалахын яам	76.8	80.4	+3.6
Гадаад харилцааны яам	80.2	76.7	-3.5
Сангийн яам	67.1	75.5	+8.4
Хууль зүй, дотоод хэргийн яам	66.2	73.6	+7.4
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	73.2	73.5	+0.3
Эрчим хүчний яам	64.9	73.5	+8.6
Барилга, хот байгуулалтын яам	68.0	73.2	+5.2
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	66.1	71.9	+5.8
Эрүүл мэндийн яам	66.3	71.5	+5.2
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	66.8	70.9	+4.1
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	67.1	70.6	+3.5
Зам, тээврийн хөгжлийн яам	70.3	70.4	+0.1
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	64.6	70.2	+5.6
АГЕНТЛАГ	70.7	75.2	+4.5
Соёл, урлагийн газар	83.6	83.7	+0.1
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	83.1	82.3	-0.8
Гадаадын иргэн, харьяатын газар	76.6	82.3	+5.7
Онцгой байдлын ерөнхий газар	70.6	81.7	+11.1
Оюуны өмчийн газар	76.1	81.6	+5.5
Цаг уур, орчны шинжилгээний газар	76.0	80.7	+4.7
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	75.5	79.3	+3.8
Архивын ерөнхий газар	66.1	79.2	+13.1
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	80.4	78.7	-1.7
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	72.0	78.2	+6.2
Улсын бүртгэлийн ерөнхий газар	67.9	78.2	+10.3
Нийгмийн даатгалын ерөнхий газар	73.7	77.8	+4.1
Мал эмнэлэг, үржлийн газар	70.3	76.7	+6.4
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	74.2	75.1	+0.9
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	70.4	75.0	+4.6
Цагдаагийн ерөнхий газар	69.2	74.6	+5.4
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	72.6	73.9	+1.3
Ашигт малтмал, газрын тосны газар	65.9	73.9	+8.0
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	72.9	73.0	+0.1
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	65.9	72.4	+6.5
Стандарт, хэмжил зүйн газар	68.2	70.3	+2.1
Татварын ерөнхий газар	63.4	70.1	+6.7
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	66.9	69.5	+2.6
Иргэний нисэхийн ерөнхий газар	68.9	66.0	-2.9
Үндэсний хөгжлийн газар	76.4	65.7	-10.7
Биеийн тамир, спортын газар	62.7	65.0	+2.3
Гаалийн ерөнхий газар	67.7	64.8	-2.9
ЗДТГ	66.1	73.2	+7.1
Завхан аймгийн ЗДТГ	83.2	81.1	-2.1
Төв аймгийн ЗДТГ	63.9	77.3	+13.4
Өвөрхангай аймгийн ЗДТГ	61.4	77.2	+15.8
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	71.7	77.0	+5.3
Орхон аймгийн ЗДТГ	57.8	76.6	+18.8
Дархан-Уул аймгийн ЗДТГ	72.0	76.6	+4.6
Дорноговь аймгийн ЗДТГ	70.9	75.9	+5.0
Дорнод аймгийн ЗДТГ	69.0	75.7	+6.7
Хэнтий аймгийн ЗДТГ	66.8	75.6	+8.8
Булган аймгийн ЗДТГ	68.1	75.1	+7.0
Архангай аймгийн ЗДТГ	62.5	73.1	+10.6

Увс аймгийн ЗДТГ	74.0	72.4	-1.6
Говьсүмбэр аймгийн ЗДТГ	67.2	72.0	+4.8
Хөвсгөл аймгийн ЗДТГ	64.7	71.8	+7.1
Баянхонгор аймгийн ЗДТГ	66.7	71.3	+4.6
Нийслэлийн ЗДТГ	67.7	71.2	+3.5
Дундговь аймгийн ЗДТГ	55.5	69.8	+14.3
Сүхбаатар аймгийн ЗДТГ	68.3	69.8	+1.5
Өмнөговь аймгийн ЗДТГ	67.9	68.7	+0.8
Говь-Алтай аймгийн ЗДТГ	59.3	68.3	+9.0
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	55.6	67.7	+12.1
Ховд аймгийн ЗДТГ	61.2	66.7	+5.5

Хавсралт 3. ГШБҮ 2019 онд

Байгууллагын нэр	ГШБҮ	Ил тод, хариуцлагатай байдлын индекс	Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол
Гадаад шударга байдлын үнэлгээ	71.6	61.6	58.0	65.1	81.7	62.7	90.2	92.2
ЯАМ	68.1	58.2	53.1	63.2	78.1	59.7	90.8	83.8
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	72.0	61.1	55.7	66.5	82.9	65.0	93.8	90.0
Батлан хамгаалахын яам	76.8	67.9	64.8	71.0	85.8	68.2	99.2	90.0
Гадаад харилцааны яам	66.8	57.7	50.9	64.4	76.0	56.6	83.6	87.8
Сангийн яам	75.0	65.0	60.8	69.3	85.0	69.9	97.3	87.8
Хууль зүй, дотоод хэргийн яам	64.8	48.5	38.1	58.9	81.1	52.5	97.4	93.3
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	67.4	59.3	53.3	65.4	75.4	61.1	85.2	80.0
Барилга, хот байгуулалтын яам	70.5	59.9	56.5	63.3	81.0	62.3	93.9	86.7
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	55.2	44.4	38.1	50.7	65.9	43.9	72.8	81.1
Зам, тээврийн хөгжлийн яам	58.5	53.3	49.9	56.7	63.7	47.3	80.4	63.3
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	67.5	61.6	57.9	65.4	73.4	62.5	88.7	68.9
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	73.7	64.9	62.7	67.2	82.4	63.9	98.8	84.4
Эрчим хүчний яам	69.0	57.5	50.2	64.9	80.4	64.2	91.5	85.6
Эрүүл мэндийн яам	68.8	54.8	52.1	57.4	82.8	59.0	98.2	91.1
АГЕНТЛАГ	72.9	62.8	58.8	66.8	83.0	64.7	89.5	94.9
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	69.9	63.6	60.6	66.7	76.2	64.4	76.6	87.8
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	66.6	62.9	58.3	67.4	70.4	61.6	66.2	83.3
Онцгой байдлын ерөнхий газар	81.0	72.1	66.4	77.9	89.9	69.8	100.0	100.0
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	74.0	60.0	55.7	64.3	88.0	66.1	98.0	100.0
Стандарт, хэмжил зүйн газар	75.1	60.8	52.6	69.0	89.4	68.7	99.5	100.0
Гаалийн ерөнхий газар	60.1	52.1	49.5	54.6	68.1	50.3	69.5	84.4
Татварын ерөнхий газар	68.8	59.2	54.7	63.8	78.3	63.2	81.9	89.9
Цагдаагийн ерөнхий газар	62.8	48.3	44.6	52.0	77.3	44.2	91.5	96.3
Улсын бүртгэлийн ерөнхий газар	75.3	66.5	63.0	70.0	84.1	62.7	94.1	95.6
Архивын ерөнхий газар	82.1	73.6	71.8	75.4	90.7	74.0	99.2	98.8
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	65.7	54.9	46.1	63.7	76.5	61.5	73.7	94.2
Гадаадын иргэн, харьяатын газар	80.1	71.0	70.6	71.3	89.3	73.1	98.3	96.6
Нийгмийн даатгалын ерөнхий газар	73.1	60.1	57.4	62.8	86.1	61.2	99.4	97.8
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	78.1	68.3	65.7	70.8	87.8	71.1	96.1	96.3
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	81.3	71.4	70.2	72.5	91.2	73.6	100.0	100.0
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	60.7	47.8	43.5	52.0	73.6	43.2	86.7	90.9
Биеийн тамир, спортын газар	66.3	55.1	48.4	61.8	77.6	60.5	78.5	93.8
Соёл, урлагийн газар	76.8	66.4	60.6	72.2	87.2	72.2	89.4	100.0
Ашигт малтмал, газрын тосны газар	71.4	63.6	60.0	67.2	79.3	66.7	75.9	95.2
Мал эмнэлэг, үржлийн газар	75.9	67.3	64.6	70.0	84.5	68.9	91.3	93.3
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	70.9	57.0	52.0	62.1	84.7	58.7	98.8	96.7

Оюуны өмчийн газар	81.4	72.6	71.0	74.2	90.3	76.4	98.8	95.6
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	79.6	69.9	65.7	74.0	89.3	75.2	95.4	97.3
ЗДТГ	72.4	62.3	60.1	64.6	82.4	62.3	90.6	94.4
Архангай аймгийн ЗДТГ	75.4	65.6	63.7	67.5	85.1	65.9	96.3	93.2
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	66.9	55.6	52.2	58.9	78.3	55.2	84.5	95.2
Баянхонгор аймгийн ЗДТГ	69.2	58.9	57.6	60.3	79.4	59.7	84.7	93.7
Булган аймгийн ЗДТГ	75.7	65.9	64.8	67.0	85.6	66.7	96.5	93.7
Говь-Алтай аймгийн ЗДТГ	73.4	62.9	59.0	66.8	84.0	64.2	92.4	95.4
Говь сүмбэр аймгийн ЗДТГ	73.9	66.3	65.0	67.5	81.6	66.0	83.3	95.6
Дархан-Уул аймгийн ЗДТГ	72.5	63.1	61.6	64.7	81.8	61.5	91.6	92.3
Дорноговь аймгийн ЗДТГ	75.8	65.6	63.5	67.6	86.1	65.1	96.1	97.1
Дорнод аймгийн ЗДТГ	73.4	61.0	59.4	62.6	85.7	64.6	97.6	94.9
Дундговь аймгийн ЗДТГ	72.1	63.6	61.6	65.5	80.7	61.8	86.0	94.3
Завхан аймгийн ЗДТГ	77.7	67.9	64.7	71.0	87.5	68.7	98.5	95.4
Орхон аймгийн ЗДТГ	76.3	64.4	61.4	67.3	88.2	66.0	99.0	99.5
Өвөрхангай аймгийн ЗДТГ	78.2	69.6	67.9	71.3	86.8	69.0	93.3	97.9
Өмнөговь аймгийн ЗДТГ	73.2	64.7	64.5	64.9	81.6	63.2	90.1	91.6
Сүхбаатар аймгийн ЗДТГ	70.9	57.8	56.1	59.5	84.0	59.5	95.2	97.3
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	74.5	67.0	65.0	69.0	82.0	66.7	86.3	93.0
Төв аймгийн ЗДТГ	77.0	68.8	68.4	69.3	85.1	68.8	91.3	95.3
Увс аймгийн ЗДТГ	69.6	59.9	55.9	63.9	79.3	57.5	91.4	89.0
Ховд аймгийн ЗДТГ	66.2	52.1	47.2	57.0	80.4	49.6	93.6	97.9
Хөвсгөл аймгийн ЗДТГ	66.5	58.3	54.8	61.8	74.8	57.3	77.3	89.8
Хэнтий аймгийн ЗДТГ	70.3	59.1	57.8	60.3	81.5	59.3	90.8	94.4
Нийслэлийн ЗДТГ	63.6	53.5	49.7	57.4	73.7	53.8	77.6	89.8

Хавсралт 4. ДШБҮ 2019 онд

Байгууллагын нэр	ДШБҮ	Соёлын индекс	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Ажлын байран дахь шударга байдлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл
Дотоод шударга байдлын үнэлгээ	80.8	72.5	80.3	64.8	89.1	97.5	90.7	87.9	99.2	70.0
ЯАМ	82.0	73.8	81.1	66.6	90.1	97.9	94.8	87.9	99.2	70.9
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	79.5	69.1	78.4	59.7	89.8	97.7	96.3	87.9	100.0	67.3
Батлан хамгаалахын яам	85.7	78.4	85.2	71.6	92.9	99.4	98.3	92.3	97.5	77.1
Гадаад харилцааны яам	85.1	78.7	84.6	72.8	91.5	97.3	95.6	90.7	100.0	73.6
Сангийн яам	86.6	79.8	87.4	72.2	93.4	97.4	98.5	93.8	100.0	77.2
Хууль зүй, дотоод хэргийн яам	85.5	78.6	85.1	72.0	92.4	98.2	97.7	94.2	100.0	72.1
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	79.8	69.3	78.9	59.6	90.3	98.0	98.5	85.5	100.0	69.5
Барилга, хот байгуулалтын яам	84.1	76.2	79.2	73.1	92.0	97.3	97.8	89.3	100.0	75.8
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	82.9	74.6	79.9	69.3	91.2	98.8	98.3	88.5	100.0	70.3
Зам, тээврийн хөгжлийн яам	84.0	76.4	82.8	70.1	91.6	98.4	98.0	90.3	98.3	72.8
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	76.5	69.9	78.4	61.4	83.1	96.8	88.8	66.6	97.5	66.1
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	76.5	68.7	77.6	59.7	84.4	98.0	70.2	88.1	98.3	67.2
Эрчим хүчний яам	82.7	74.3	82.5	66.2	91.1	98.0	98.6	89.0	100.0	70.0
Эрүүл мэндийн яам	76.9	65.7	74.0	57.5	88.1	97.7	95.9	86.4	98.3	62.3
АГЕНТЛАГ	80.7	72.6	79.9	65.2	88.9	97.6	90.1	87.4	99.5	69.9
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	77.4	68.5	81.7	55.2	86.3	98.9	98.3	60.6	100.0	73.5
Үндэсний хөгжлийн газар	69.8	59.7	71.2	48.2	80.0	97.1	62.0	83.8	100.0	56.8
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	79.2	69.0	78.1	59.9	89.3	98.3	99.3	85.5	100.0	63.5
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	80.9	71.3	77.5	65.1	90.4	96.5	98.4	88.0	100.0	69.4
Онцгой байдлын ерөнхий газар	87.1	80.6	86.5	74.7	93.6	99.0	98.5	95.4	100.0	75.0
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	84.3	76.0	86.8	65.1	92.6	96.9	98.2	92.1	100.0	75.8
Стандарт, хэмжил зүйн газар	71.0	59.8	68.1	51.4	82.3	92.5	83.4	85.6	97.5	52.6
Цаг уур, орчны шинжилгээний газар	85.0	77.8	85.9	69.6	92.1	99.5	96.0	93.4	100.0	71.7
Гаалийн ерөнхий газар	84.0	77.0	82.7	71.3	91.0	97.2	97.7	88.2	100.0	72.0
Татварын ерөнхий газар	79.1	72.0	76.3	67.8	86.1	96.4	73.1	88.1	100.0	73.1
Цагдаагийн ерөнхий газар	82.7	74.7	77.6	71.7	90.8	97.8	94.3	90.7	98.3	72.9
Улсын бүртгэлийн ерөнхий газар	83.1	77.8	81.6	74.0	88.5	98.4	80.1	89.3	97.1	77.5
Архивын ерөнхий газар	79.2	69.8	78.8	60.9	88.7	96.7	99.3	78.6	97.5	71.2
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	87.2	79.8	85.6	74.0	94.6	98.6	98.1	95.1	100.0	81.3
Гадаадын иргэн, харьяатын газар	85.7	78.3	83.6	73.1	93.1	98.2	97.6	91.6	100.0	78.2
Нийгмийн даатгалын ерөнхий газар	84.7	76.5	84.2	68.8	93.0	98.5	99.7	94.4	100.0	72.5

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	80.2	71.5	78.2	64.7	88.9	95.9	97.7	85.2	100.0	65.6
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	76.5	67.9	79.7	56.1	85.1	98.7	71.4	87.1	100.0	68.3
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	85.7	81.0	88.8	73.3	90.4	99.2	74.2	98.0	100.0	80.8
Биеийн тамир, спортын газар	60.5	49.1	59.6	38.6	72.0	91.3	41.9	79.2	96.7	50.8
Соёл, урлагийн газар	86.9	82.8	86.2	79.4	91.1	99.0	97.5	84.0	100.0	75.0
Иргэний нисэхийн ерөнхий газар	73.4	61.9	72.5	51.2	84.9	96.6	87.6	78.0	100.0	62.1
Ашигт малтмал, газрын тосны газар	84.6	76.6	78.4	74.7	92.6	98.8	97.8	93.6	100.0	73.0
ЗДТГ	80.2	71.7	80.1	63.3	88.7	97.2	89.1	88.6	98.8	69.7
Архангай аймгийн ЗДТГ	82.1	71.9	81.3	62.6	92.3	99.3	98.6	90.4	100.0	73.1
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	77.6	66.6	77.9	55.3	88.6	97.3	96.1	87.2	100.0	62.5
Баянхонгор аймгийн ЗДТГ	75.8	64.5	73.5	55.5	87.2	96.1	89.8	86.6	95.0	68.3
Булган аймгийн ЗДТГ	84.1	76.1	82.7	69.6	92.0	98.0	95.6	92.5	100.0	73.8
Говь-Алтай аймгийн ЗДТГ	78.0	70.9	80.0	61.8	85.2	98.3	68.0	89.0	100.0	70.6
Говь сүмбэр аймгийн ЗДТГ	80.8	76.8	83.0	70.6	84.8	95.8	83.1	86.1	95.0	63.9
Дархан-Уул аймгийн ЗДТГ	81.0	72.8	81.0	64.7	89.1	99.5	87.6	86.8	100.0	71.9
Дорноговь аймгийн ЗДТГ	82.8	72.4	85.7	59.0	93.3	99.4	98.8	91.0	100.0	77.1
Дорнод аймгийн ЗДТГ	81.0	71.3	80.2	62.4	90.7	98.8	96.3	90.0	97.5	71.1
Дундговь аймгийн ЗДТГ	79.9	70.2	77.2	63.2	89.5	97.8	95.5	83.9	100.0	70.5
Завхан аймгийн ЗДТГ	85.5	81.9	87.2	76.6	89.1	99.7	78.8	96.0	100.0	71.0
Орхон аймгийн ЗДТГ	85.1	76.9	84.8	68.9	93.3	99.5	97.2	95.6	100.0	74.4
Өвөрхангай аймгийн ЗДТГ	85.5	79.3	85.8	72.9	91.7	99.2	88.4	93.2	100.0	77.6
Өмнөговь аймгийн ЗДТГ	77.0	67.9	77.9	57.9	86.2	98.4	82.1	84.8	97.5	68.1
Сүхбаатар аймгийн ЗДТГ	74.6	62.4	72.7	52.0	86.7	97.2	90.3	85.3	100.0	60.9
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	82.3	74.8	80.6	69.0	89.8	98.6	81.7	92.5	100.0	76.4
Төв аймгийн ЗДТГ	81.9	78.1	82.3	73.9	85.8	75.8	92.9	92.1	95.0	73.1
Увс аймгийн ЗДТГ	79.9	70.1	80.8	59.5	89.6	98.3	92.4	89.5	100.0	67.9
Ховд аймгийн ЗДТГ	72.7	63.6	73.6	53.5	81.9	96.1	67.4	88.9	95.0	61.9
Хөвсгөл аймгийн ЗДТГ	79.9	69.5	77.9	61.1	90.2	97.9	96.2	89.3	100.0	67.8
Хэнтий аймгийн ЗДТГ	84.3	76.4	83.5	69.2	92.2	99.5	98.2	92.5	100.0	71.1
Нийслэлийн ЗДТГ	72.7	64.0	73.8	54.2	81.5	97.2	85.9	66.1	97.8	60.6

Хавсралт 5. БОУ 2019 онд

Байгууллагын нэр	БОУ	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
Бодлогод оролцогчдын үнэлгээ	69.8	72.6	51.2	94.3	61.0
ЯАМ	69.6	72.1	51.2	96.6	58.4
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	64.3	71.2	42.3	96.4	47.5
Батлан хамгаалахын яам	78.7	79.6	61.0	100.0	74.1
Гадаад харилцааны яам	78.4	81.8	65.6	100.0	66.0
Сангийн яам	64.8	65.4	46.3	87.1	60.2
Хууль зүй, дотоод хэргийн яам	70.6	70.0	60.4	96.2	55.8
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	65.5	69.6	46.0	100.0	46.2
Барилга, хот байгуулалтын яам	65.2	60.2	49.4	92.5	58.7
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	73.8	76.6	59.0	100.0	59.6
Зам, тээврийн хөгжлийн яам	68.9	77.8	41.9	100.0	55.6
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	66.5	62.9	50.5	96.2	56.5
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	70.4	67.9	50.3	100.0	63.4
Эрчим хүчний яам	68.7	73.7	49.9	92.8	58.4
Эрүүл мэндийн яам	68.9	80.8	43.5	94.4	56.9
АГЕНТЛАГ	72.1	76.1	54.6	94.3	63.2
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	69.7	70.5	56.5	85.0	66.8
Онцгой байдлын ерөнхий газар	77.0	83.1	64.7	92.9	67.5
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	76.4	79.8	61.1	100.0	64.6
Стандарт, хэмжил зүйн газар	64.7	72.2	47.1	88.2	51.4
Цаг уур, орчны шинжилгээний газар	76.4	79.3	61.5	100.0	65.0
Гаалийн ерөнхий газар	50.2	57.6	26.4	75.0	41.7
Татварын ерөнхий газар	62.3	65.2	49.9	70.1	63.9
Цагдаагийн ерөнхий газар	78.2	73.0	70.8	100.0	69.1
Улсын бүртгэлийн ерөнхий газар	76.1	72.6	68.2	90.0	73.5
Архивын ерөнхий газар	76.3	82.3	55.4	100.0	67.4
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	83.3	91.0	65.7	100.0	76.6
Гадаадын иргэн, харьяатын газар	81.0	84.1	66.2	100.0	73.8
Нийгмийн даатгалын ерөнхий газар	75.5	74.8	57.5	100.0	69.6
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	66.7	66.6	42.7	100.0	57.5
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	80.1	83.5	60.1	100.0	76.7
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	79.0	76.5	64.5	95.0	80.0
Биеийн тамир, спортын газар	68.0	72.3	44.9	95.0	60.0
Соёл, урлагийн газар	87.4	92.9	70.7	100.0	85.9
Иргэний нисэхийн ерөнхий газар	58.7	56.7	45.2	80.7	52.2
Ашигт малтмал, газрын тосны газар	65.6	71.4	46.6	100.0	44.4
Мал эмнэлэг, үржлийн газар	72.7	78.0	57.3	100.0	55.6
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	57.8	67.8	29.1	84.4	49.8
Оюуны өмчийн газар	78.0	85.2	59.3	100.0	67.5
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	82.7	91.7	67.0	100.0	72.2
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	69.7	70.5	56.5	85.0	66.8
Онцгой байдлын ерөнхий газар	77.0	83.1	64.7	92.9	67.5
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	76.4	79.8	61.1	100.0	64.6
Стандарт, хэмжил зүйн газар	64.7	72.2	47.1	88.2	51.4
Цаг уур, орчны шинжилгээний газар	76.4	79.3	61.5	100.0	65.0
ЗДТГ	67.1	68.6	46.9	92.9	59.9

Архангай аймгийн ЗДТГ	62.0	58.0	47.4	88.1	54.4
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	58.7	55.7	40.2	85.6	53.3
Баянхонгор аймгийн ЗДТГ	68.0	68.3	43.6	100.0	60.0
Булган аймгийн ЗДТГ	65.5	67.5	41.1	100.0	53.6
Говь-Алтай аймгийн ЗДТГ	53.6	54.9	33.1	75.5	50.7
Говь сүмбэр аймгийн ЗДТГ	61.4	62.4	38.1	95.0	50.1
Дархан-Уул аймгийн ЗДТГ	76.4	81.3	60.0	100.0	64.2
Дорноговь аймгийн ЗДТГ	69.1	72.8	42.2	100.0	61.4
Дорнод аймгийн ЗДТГ	72.7	77.5	49.9	100.0	63.4
Дундговь аймгийн ЗДТГ	57.5	56.6	39.7	78.8	54.9
Завхан аймгийн ЗДТГ	80.2	92.5	61.1	93.1	74.2
Орхон аймгийн ЗДТГ	68.5	71.7	51.1	92.9	58.3
Өвөрхангай аймгийн ЗДТГ	67.9	67.1	48.1	91.4	65.2
Өмнөговь аймгийн ЗДТГ	56.0	56.4	32.7	88.7	46.2
Сүхбаатар аймгийн ЗДТГ	64.0	70.4	37.9	96.7	50.8
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	74.3	77.4	50.4	100.0	69.4
Төв аймгийн ЗДТГ	73.1	75.2	49.6	93.3	74.2
Увс аймгийн ЗДТГ	67.7	69.7	49.4	96.7	55.1
Ховд аймгийн ЗДТГ	61.1	60.3	44.1	82.6	57.5
Хөвсгөл аймгийн ЗДТГ	68.9	62.8	51.1	93.3	68.3
Хэнтий аймгийн ЗДТГ	72.1	72.4	51.9	100.0	64.2
Нийслэлийн ЗДТГ	77.1	78.3	68.3	92.3	69.6

АВЛИГА МЭДЭЭЛЭХ УТАС

Ярианы
төлбөргүй **110**



**ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАР,
ОРЧИН ДАХЬ ЁС ЗҮЙН ТАНДАЛТ
СУДАЛГАА-2019**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АТГ	Авлигатай тэмцэх газар
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль
ЦХҮТ	Цогц хөгжлийн үндэсний төв

УДИРТГАЛ

Судалгааны зорилго, зорилт

“Цогц Хөгжлийн Үндэсний Төв” нь “Авлигатай тэмцэх газар”-ын захиалгаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4-р зүйл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.1.10.2 дахь хэсэгт заасан “Авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй “Дээд боловсролын салбар, орчин дахь ёс зүйн тандалт судалгаа”-ны ажлыг гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны хүрээнд иргэд, олон нийттэй өдөр бүр харилцаж, ёс зүйн асуудал ихээхэн хөндөгддөг мэргэжлүүд болох багш, эмч, цагдаагийн албан хаагчдыг бэлтгэдэг төрийн өмчийн их сургуулиудаар төлөөлүүлэн дээд боловсролын салбарын ёс зүйн нөхцөл байдлыг тодруулахыг зорин ажиллалаа. Уг судалгааны хүрээнд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Оюутан, багш, ажилчдын ёс зүйн талаарх ойлголтыг тодруулах
- Оюутнуудын баримталдаг үнэт зүйлсийн хэм хэмжээг судлах
- Дээд боловсролын оролцогч талуудын ёс зүйн зөрчлийг тодруулах
- Судалгаанд хамрагдах их сургуулиудын ёс зүйн дүрэм журамд шинжилгээ хийх зэрэг юм.

Судалгааны арга зүй

“Дээд боловсролын салбар, орчин дахь ёс зүйн тандалт судалгаа”-нд нийгмийн судалгааны тоон болон чанарын аргуудыг хослуулан хэрэглэлээ. Үүнд:

- Тоон судалгааны мэдээлэл цуглуулах асуулгын арга
- Сургуулиудын дотоод дүрэм журам, холбогдох тушаал, шийдвэр болон сургалтын төлөвлөгөөнд баримт бичгийн шинжилгээ, контент анализ
- Оюутан болон багш, ажилчдын чанарын судалгаа

Судалгааны хүрээнд 2 бүлэг 138 асуулга бүхий анкетыг оюутнуудаас, 2 бүлэг 114 асуулга бүхий анкетыг багш, ажилчдаас нийт 983 респондентоос тоон судалгаа авсан. Судалгааны мэдээллийг SPSS программ ашиглан боловсруулж, үр дүнг тооцон гаргалаа.

Судалгааны түүвэр

Энэхүү судалгаанд Дотоод хэргийн их сургуулийн 1741 оюутнаас 276, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 6358 оюутнаас 266, Монгол улсын боловсролын их сургуулийн 14424 оюутнаас 300 оюутныг санамсаргүй түүврийн аргаар тус тус сонгож нийт 842 оюутан, 110 багш, ажилчдыг тоон судалгаанд хамруулсан.

Судалгаанд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль /АШУҮИС/-ийн бүрэлдэхүүн Анагаах ухааны сургууль, Био-Анагаахын сургууль, Эм зүйн сургууль, Монгол анагаахын олон улсын сургууль, Нүүр ам судлалын сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Сувилахуйн сургууль;

Дотоод хэргийн их сургууль /ДХИС/-ийн бүрэлдэхүүн Цагдаагийн сургууль, Хилийн албаны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Онцгой байдлын сургууль, Ахлагчийн сургууль, Эрх зүй нийгмийн ухааны сургууль;

Монгол улсын боловсролын их сургууль /МУБИС/-ийн бүрэлдэхүүн Математик, байгалийн ухааны сургууль, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Боловсрол судлалын сургууль, Багшийн сургууль, Дүрслэх урлаг, технологийн сургууль, Биеийн тамирын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын сургууль зэрэг салбар сургуулиудын төлөөлөл бүрэн хамрагдсан.

Хүснэгт 1: Судалгаанд оролцсон оюутны түүврийн шинж төрх


Шинж төрх	Давтамж (тоо)	Хувь (%)
Нас		
17 нас	28	3.2
18 нас	204	23.3
19 нас	213	24.4
20 нас	163	18.6
21 нас	152	17.4
22 ба түүнээс дээш	112	13.1
Хүйс		
Эрэгтэй	305	35
Эмэгтэй	567	65
Суралцаж буй түвшин		
1-р курс	109	14.3
2-р курс	287	33.8
3-р курс	226	26.1
4-р курс	149	17.3
5-р курс	32	3.8
6-р курс	39	4.6
Сургууль		
Монгол улсын боловсролын их сургууль	300	35.6
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	266	31.6
Дотоод хэргийн их сургууль	277	32.9

Хүснэгт 2: Судалгаанд оролцсон багш нарын түүврийн шинж төрх


Шинж төрх	Давтамж (тоо)	Хувь (%)
Нас		
29 хүртэл	9	8.2
30-39 нас	51	46.4
40-49 нас	33	30.0
50 ба түүнээс дээш	17	15.5
Хүйс		
Эрэгтэй	54	49.1
Эмэгтэй	56	50.9
Ажилласан жил		
1 хүртэл жил	11	10.0
2-5 жил	23	20.9
6-10 жил	33	30.0
11-20 жил	15	13.6
21-ээс дээш жил	8	7.3
Сургууль		
Монгол улсын боловсролын их сургууль	29	26.4
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	34	30.9
Дотоод хэргийн их сургууль	47	42.7

ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Зураг 1: Судалгаанд оролцогч оюутнуудын түүвэрт эзлэх хувь, сургуулиар



Зураг 2: Судалгаанд оролцогч оюутнуудын хүйс, хувиар



Зураг 3: Судалгаанд оролцогч оюутнууд, сурч буй түвшнээр, хувиар



Зураг 4: Судалгаанд хамрагдсан багш, албан хаагчид, сургуулиар, хувиар



БҮЛЭГ 1. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ЁС ЗҮЙН ТУХАЙ

Дээд боловсрол нь нийгэмд тус болох үүднээс хэрэгждэг угаас үнэ цэнэтэй үйл ажиллагаа (CINE & IBE 2005, 9) юм. Үнэндээ их, дээд сургууль нь гэр бүл, нутаг ус, шашны байгууллага гэх мэт нийгмийн ямар ч орчноос илүү нийтийг хамарсан, нийтлэг үнэт зүйлийг дэмждэг. Ялангуяа хүмүүнлэгийн ухааны дээд боловсрол нь тухайн нийгэмд чухал ач холбогдолтой ёс зүй, ёс суртахууны үнэт зүйлсийг хамгийн нухацтай эргэцүүлэх гэр орон болох (European Centre for Higher Education 2004, 11) бөгөөд ёс зүйн боловсрол нь хүний сурч боловсрох эрхийн нэг хэсэг (Haase, et al. 2013) гэж тооцогдоно.

Их, дээд сургууль, коллеж нь оюутнуудынхаа зан чанарын хөгжилд оюутан насны олон талт үйл ажиллагаагаар дамжуулан ихээхэн нөлөө үзүүлдэг (European Centre for Higher Education 2004, 28). Шударга үнэнч байдлыг төлөвшүүлэх, түүнийг оюутны хотхон дотор ч, гадна ч хэрэгжүүлэхэд их сургуулийн багш, удирдлагууд чухал үүрэг гүйцэтгэнэ (Couch and Dodd 2005). Дээд боловсролын "сайн засаглал" нь сургалт, судалгаа, түүнээс урган гарах үйлчилгээнүүдийг сайжруулахаар зүтгэхдээ бүхэл тогтолцоо, түүний байгууллагуудыг удирдан чиглүүлэхэд туслах ёс зүйн тодорхой хүрээнд засаглалыг хэрэгжүүлэх учиртай бөгөөд үүний хамт эрдэм шинжилгээний тэгш байдал, үл алагчлах байдлыг зөрчих, судалгааны үр дүнг хуурамчаар үйлдэх, бурууг үйлдэх, ашиг сонирхлын зөрчилд орохоос аль болох их урьдчилан сэргийлэх ёстой (Kohler 2004). Дэд бүтэц, санхүүгийн хөрөнгө чухал хэдий ч эрдэм шинжилгээний үнэт зүйл, ёс зүйн чиг баримжаа нь тухайн байгууллагын сургалт, судалгааны чанарыг баталгаажуулдаг төдийгүй урьдчилан тооцоолоогүй сорилтыг даван туулахад хэрэгтэй "ёс суртахууны капитал" болж үйлчилдэг (Clark 1973) гэдгийг тооцох нь чухал.

Гэвч их сургуулиудын ёс зүйн уур амьсгалын талаарх судалгаа хязгаарлагдмал (Al-Omari 2012), дээд боловсрол дахь ёс зүй нь судалгааны талбарын хувьд орхигдсон байна. Зарим судлаачийн үзсэнээр ёс зүйн томоохон шуугианд өртөж байгаагүй их, дээд сургуулиуд ёс зүйн тогтсон соёлын хэрэгцээ хийгээд ёс зүйн санаачлагыг дэмжих шаардлагыг үл ойшоох хандлагатай (Kelley and Chang 2007). Тэгээд ч дээд боловсролын ёс зүйн асуудал нь бизнес, улс төр, анагаах ухааны ёс зүйн зөрчилтэй харьцуулахад олны анхаарал бага татдаг агаад дээд боловсролын ёс зүйн асуудлыг нухацтай судлахыг ихэнхдээ үл тоомсорлодог (Robinson and Moulton 2005, 1), үл тоомсорлосноор иржээ. Нөгөө талаар их сургууль нь ёс зүйтэй тун жигтэй харилцаатай байдаг бололтой. Тэрээр өөрөөсөө бусад бүх л мэргэжилд ёс зүйг заадаг (Keenan 2015) атлаа өөрийнхөө ёс зүйг төдий л сонирхдоггүй байна.

Үнэн хэрэгтээ их, дээд сургуулиуд нь байгууллагын ёс зүйн бэрхшээл зовлон, бүтэлгүйтлээс ангид биш (Al-Omari 2012), ёс зүйн зөрчил бол дээд боловсролын байнгын асуудал юм (Philip 2017). Тухайлбал дээд боловсрол дахь авлига магадгүй анхны коллеж үүд хаалгаа нээсэн цагаас эхлэн байсан (Lahi 2013) бөгөөд боловсролын авлига түгээмэл, харин төрөл хэлбэр нь л нэг бүсээс нөгөөд ялгаатай (Heuneman 2011). Хахуульдах, хамаатнаа татах, танил тал харах гэх мэт элсэлтийн авлига нь "арын хаалгаар" байр суурь олж авах аргад багтах бөгөөд элсэлтийн үйл явц дахь авлигын эртний хэлбэр гэж тооцогддог (Transparency International 2013).

Хүснэгт 3: Их, дээд сургуулийн орчин дахь ёс зүйн зөрчлийн жишээ

Үүргээ үл хэрэгжүүлэх	Хичээлд холбогдолгүй материалыг сургалтанд их ашиглах, хичээл, шалгалтын хуваарийг зөрчих, хичээл, ажилд хамааралгүй шалгуураар үнэлэх, мэргэжлийн түвшинд зааж чадахгүй байх, хичээл хийхгүй байх, үнэлгээг шалтгаангүйгээр хойшлуулах, сурч боловсрох үүргээ биелүүлэхгүй байх, хичээл хоцрох, таслах, сургуулийн орчинд архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх гэх мэт
Тэгш бус хандах	Оюутан болон бусдыг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, хөрөнгө, үзэл бодол, эрүүл мэндийн онцлог гэх мэт болон хувийн шалтгаанаар гадуурхах, ялгаварлах гэх мэт
Эрх мэдлээ урвуулан ашиглах	Давуу байдлаа ашиглан бусдын санаа бодолд хүчээр нөлөөлөх, үзэл бодлоо тулгах, загнах, сүрдүүлэх, төрөл бүрийн дарамт үзүүлэх зэргээр зүй бус авирлах, бичсэн номоо шахах, сургуулийн орчинд наймаа хийх гэх мэт
Саад учруулах	Сургуулиас санаачилсан, зохион байгуулсан зүй ёсны үйл ажиллагаанд санаатайгаар саад болох, бусад багш ажилтныг үүрэгт ажлаа гүйцэтгэхэд, сурах үйл ажиллагаанд саад учруулах, зүй ёсоор нэр алдар хүртэх хийгээд давуу байдал олох боломжийг нь хаах, саатуулах гэх мэт
Хувьдаа завших	Сургуулийн нөөц буюу тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хувийн болон арилжаа, улс төр, шашны зорилгоор ашиглах, сургуулийн нэрээр ашиг хонжоо олох, оюутны хөдөлмөрийг ашиглах, ажлын цагаар хувийн ажил хөөцөлдөх гэх мэт
Хуурах	Хувийн үзэл бодлоо санаатайгаар сургуулийн байр суурь гэж ойлгуулах, шударга бус, хууль бус давуу байдал олохын тулд хэн нэгийг зориуд мэхлэх, зохиолын хулгай хийх, дүн засварлах, судалгааны үр дүнг дөвийлгөх, гуйвуулах, хийгээгүй ажилд нэрээ оруулахыг тулгах, бусдын талаар худал мэдээлэх, бусадтай шударга бусаар өрсөлдөх, бусдын өмнөөс шалгуулах, бусдыг өөрийн өмнөөс шалгуулах, хуурамч бичиг баримт үйлдэх гэх мэт
Сонирхлын зөрчилтэй байх	Ач, зээдээ дүн тавих эсвэл тэдний найз охин, найз залуугийн бичсэн ажлыг удирдах, сургуультай холбоотой ажил, үйлчилгээнд хувийн ашиг сонирхолтой байх гэх мэт
Үгсэх	Оюутнуудын буруу зан үйлийг үл тоох, анзаараагүй мэт царайлах, багш, судлаачид бие биенийхээ бүтээлийг шаардлагагүй байхад эш татах, нэр хүндийг нь худал өргөх, удирдлагууд нээлттэй тендерт өмнөх гэрээнд үндэслэн ялагчийг сонгох гэх мэт
Хахуульдах	Ёс зүйгүй, хууль бус эсвэл итгэл эвдсэн үйлдлийн төлөө урамшуулал санал болгох, амлах, өгөх, авах, давуу байдал шаардах, дүн засуулахаар мөнгө төгрөг өгөх, авах, өөрийнхөө өмнөөс бусдад мөнгө төлж бичүүлэх, сургууль үйлчилгээ нийлүүлэгчдээс хээл хахууль нэхэх, зохих шалгуур тэнцэхгүй хүнд туслах, шан харамж амлуулах, авах гэх мэт. Урамшуулал нь бэлэг сэлт, зээл, төлбөр, шагнал, татвар, үйлчилгээ, хандив зэрэг хэлбэртэй байж болно.
Лоббидох	Арилжааны бараа бүтээгдэхүүнийг сургалт, судалгаанд дэмжин давуу байдал олгох гэх мэт
Тал засах	Сургуулийн өмч хөрөнгө, нөөцийг улс төрийн нам, хүч, хувь хүмүүст ашиглуулах, хандивлах, сургуулийн нэрийг барьж хувьдаа болон дотно харилцаатай, сонирхол бүхий этгээдэд ашиг хонжоотой ажил хэргийг шууд, шууд бусаар гэрээлэх, сэдэх, зохион байгуулах, танил тал, найз нөхдийн холбоогоор дамжуулан бусдад давуу байдал олгох, зохих шалгуур хангаагүй хүнийг дэвшүүлэх, томилох, урамшуулах, арын хаалгадах гэх мэт

Энэ мэтээр их, дээд сургуулийн орчинд элсэлтийн шалгалтаас эхлээд төгссөний дараах баримт бичгийн бүрдүүлэлт хүртэл бүхий л шатанд ёс зүйн зөрчил илэрч болно. Их, дээд сургуулиуд анги танхимаа түрээслэх, сургуулийн мэдлийн газрыг зарах, ажил мэргэжлийн мэдлэг чадвар дорой хүмүүсийг танил тал, улс төрчдийн шахалтаар ажилд авснаар боловсролын стандартын түвшинг доройтуулдаг. Дүн, кредит, диплом, цол хэргэмийг худалдаж авах, хууль бусаар олж авах, багш нар тогтсон төлбөрөөс гадна нэмэлт төлбөр төлөхийг оюутнаас шаардах зэрэг нь боловсролын салбарыг сөгдүүлэхэд хүргэдэг байна (МУШУТИС 2017, 2).

2014 онд ЮНЕСКО-н Боловсролын төлөвлөлтийн олон улсын хүрээлэнгээс гаргасан судалгаанд боловсролын салбар авлигад өртөж болох боломжуудыг тодорхойлсон байна. Энд авилгыг залилан, хээл хахууль, луйвар, шахалт, тал тохой татах гэсэн 5 үндсэн төрөлд хуваан авч үзжээ (МУШУТИС 2017, 3). Зарим судлаач тал засах, хамаатнаа татах, давуу тал олгох, танил тал харах зэрэг олон үйл ажиллагааг багтаасан өргөн хүрээний үйлдлийг авлига гэсэн ерөнхий нэрээр ихэвчлэн нэрлэдэг гэдгийг онцлоод, дээд боловсролын талбарын авилгын хэлбэрт хахууль, үгсэх, ашиг сонирхлын зөрчил, тал засах, луйвар, лоббидох зэргийг жишээлэн харуулжээ (Denisova-Schmidt 2018, 63-64). Мөн шалгалт, шүүлгийн үеэр хуулах, шалгалтын дүнг өөрчлөх гэх мэт хууран мэхлэх; зохих ёсоор талархахгүйгээр бусдын санаа, өгөгдөл, илэрхийллийг өөрийн юм шиг ашиглах зэргийг багтаасан зохиолын хулгай хийх; туршилтад зориулж өгөгдөл зохиох, хуурамч мэдээлэл оруулах, байхгүй өгүүлэл, эх сурвалж дурдах, эшлэх гэх мэт хуурамчаар үйлдвэрлэх; эрдмийн олон шаардлагыг биелүүлэхийн тулд нэг ажлыг олон дахин ашиглах; оюутны дүнгийн мэдээ, диплом зэргийг хуурамчаар үйлдэх, үйлдэхийг завдах; гэрийн даалгаврыг өмнөөс хийх, өмнөөс нь шалгуулах гэх мэтээр шударга бус зүйлд туслах; шалгалтын материалд зөвшөөрөлгүй нэвтрэх эрх олж авах, хангаж өгөх, даалгавраа гүйцэтгэхэд нь бусад оюутанд саад учруулах, саад болох, шалгалт эсвэл бичгийн ажлыг сунгах хэрэгтэй тухай худал мэдээлэх, шалгалтын цаг дуусчхаад байхад үргэлжлүүлэн бичих, номын сангийн материалыг өөрийн хэрэгцээнд зориулан хав дарах, үгүй хийх зэргээр шударга бус давуу тал олох (European Centre for Higher Education 2004, 21-22) үйлдлийг ёс зүйгүй үйлдэлд тооцсон байна.

Манай орны хувьд энэ талын судалгаа цөөн байгаа ч их, дээд сургууль, коллежийн багшийн ажлын хариуцлага, ёс зүйн асуудлыг дээд боловсролын шинэчлэлийн зураглал 2010-2021, дээд боловсролын тухай хууль, боловсролын тухай хууль, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын тэтгэлэг, тэтгэмж, нийгмийн баталгааны тухай хууль, хүн амын эрүүл мэндийн боловсрол үндэсний хөтөлбөр, Монгол улсын засгийн газраас боловсролын салбарт 1997-2005 онд хийх өөрчлөлтийн үндсэн чиглэл зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд судлан, төрийн өмчийн болон хувийн статустай 10 гаруй их, дээд сургууль, коллежийн багшийн ажлын хариуцлага, ёс зүйн дүрмийн заалт, их, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн ёс зүйн ерөнхий дүрмийг задлан шинжилж, НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын их, дээд сургуулийн багшлах боловсон хүчний статусын тухай зөвлөмж зэрэг олон улсын зарим баримт бичгийг судалсны үндсэн дээр дээд боловсролын байгууллагууд ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээ, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай (МУШУТИС 2018) гэдгийг санал болгосон байдаг.

Ер нь байгууллагын хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн уур амьсгал, ажилчдынх нь ёс зүйн үйлдэл хооронд холбоо хамаарал байдаг бөгөөд ёс зүйн уур амьсгал нь ёс зүйн үйлдлийн урьдчилан мэдээлэгч болж чаддаг (Philip 2017). Виктор, Каллен нар


(1987; 1988) ёс зүйн уур амьсгалын үзэл баримтлалаар дамжуулан ёс зүйн үйлдлийг удирдан зохицуулах асуудлыг хөнджээ. Ёс зүйн уур амьсгал гэдэг нь байгууллагын ажилтнуудын баримталдаг, тэдний шийдвэр гаргах, ёс зүйн асуудалд хариу үзүүлэхэд нөлөөлдөг ёс зүйн зохих үйлдэлд хамаарах хэм хэмжээ, үнэт зүйл, дадлын тухай нийтлэг төсөөлөл юм. Ёс зүйн уур амьсгал нь ёс зүйн үйлдэлд эерэг, сөрөг янз бүрийн нөлөөтэй (Simha and Cullen 2011). Ёс зүйн зөрчлийг ёс зүйн уур амьсгалын нөлөө рүү мөшгөн судалж болдог (Arnaud 2010). Хувь хүмүүс ёс суртахууны хувьд хөгжихийн хэрээр ёс зүйн асуудлыг шийдэхийн тулд өөрийн сонирхол, сайхан сэтгэл, зарчим зэргийг багтаасан ёс зүйн төрөл бүрийн шалгуурыг ашигладаг (1981; 1984) байна. Ёс зүйн уур амьсгалын талаарх ойлголт нь байгууллагын доторх ёс зүйн үйлдлийг илүү сайн удирдахад тусална. Ёс зүйгүй үйлдэл нь байгууллага, цаашлаад нийгэмд маш хохиролтой нь батлагдсан учраас энэхүү ойлголт онцгой ач холбогдолтой (Wimbush, Shepard and Markham 1997, 1706). Байгууллага дахь ёс зүйн уур амьсгалыг илрүүлж, хэмжих чадвартай байх нь ёс зүйн ирээдүйн үйлдэлд анхаарал хандуулах боломжийг олгодог (Victor ба Cullen 1987) ажээ. Хэрэв ёс зүйн давамгайлал уур амьсгал ёс зүйгүй үйлдэлд хүргэж болзошгүй нь илэрвэл удирдлагын гишүүд хөндлөнгөөс оролцож, ёс зүйн уур амьсгалыг сайжруулж болно (Wimbush, Shepard and Markham 1997).

Дээд боловсролд ёс зүйгүй үйлдэл үргэлжилсээр байвал оюутнууд сургууль, эрдэм шинжилгээний салбартаа итгэх итгэлээ алдахаас гадна энэ нь маргаашийн манлайлагчдад айдас төрүүлэм өнгө аяс суулгах тул цаад хор уршиг нь маш хатуу (Philip 2017, 10). Иймд их, дээд сургуулийн орчны ёс зүйг судлан, оролцогч талуудын ёс зүйн талаарх төсөөллийг илрүүлэх нь чухал юм.

БҮЛЭГ 2. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ЁС ЗҮЙН ТАЛААРХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТӨСӨӨЛӨЛ


Судалгааны хүрээнд их, дээд сургууль дахь ёс зүй, оролцогч талуудын ёс зүйн үйлдлийг тодорхойлж болох нэг хүчин зүйл нь ёс зүйн асуудалд хэр ач холбогдол өгч буй байдал юм.

Зураг 5: Ёс зүйтэй байх нь таны хувьд хэр зэрэг чухал вэ?




Ёс зүйтэй байх нь хэр чухал вэ гэсэн асуултад багш нарын 81.8 хувь нь маш чухал гэж хариулсан бол ойролцоогоор 20 оюутан тутмын 1 нь буюу 56.1 хувь нь чухал гэж хариулжээ. Багш нарын ёс зүйг эрхэмлэх байдал оюутнуудаас өндөр байна. Сургуулиудаар төдийлөн ялгаатай биш ч нарийвчлан шинжилбэл МУБИС-ийн багш, оюутны үнэлгээ ойролцоо бол ДХИС-ийн багш, оюутны үнэлгээ нэлээд ялгаатай байна.

Зураг 6: Багш, оюутнуудын ёс зүйг эрхэмлэх байдал, сургуулиар (5-маш чухал, 4-чухал, 3-дунд зэрэг, 2-чухал биш, 1-огт чухал биш)



Зураг 7: Нийгмийн амьдралын хүрээнд ёс зүйн үнэт зүйлс хэр чухал болохыг тодорхойлсон байдал (Үнэлгээний утга: маш их чухал -5, чухал -4, дунд зэрэг -3, чухал биш -2, огт чухал биш -1)




Оюутнуудаас ёс зүйг гэр бүл, найз нөхөд, боловсрол, нийгэм, ажил зэрэг таван хүрээнд хэр чухал болох талаар үнэлүүлэхэд хамгийн өндөр үнэлгээг гэр бүл (4.74), боловсрол (4.7), ажил дээр (4.7) тус тус авчээ. Харин үүнийг оюутнуудын курсээр харвал курс ахих тусам ёс зүйн үнэт зүйлсийг эдгээр бүх хүрээнд эрхэмлэх хандлага нэмэгдэж байна.

Судалгаанд хамрагдсан багш нараас их сургуулийн орчны ёс зүй нийгмийн бусад хүрээний ёс зүйгээс ялгарах онцлог, мөн чанарын талаар нээлттэй асуултын хүрээнд тодруулахад Хүснэгт 1-д дурдагдсан шинж чанаруудыг нийтлэг дэвшүүлсэн байна. Юуны өмнө эрдэм мэдлэгийг түгээдэг академик орчин учраас багш, оюутны хувьд шинэ санаа инноваци нэвтрүүлэх, бүтээл туурвих, үзэл бодлоо илэрхийлэх нь чухалд тооцогддог, түүнчлэн ирээдүйн мэргэжилтний төлөвшлийн үндсийг тавьж өгдөг, олон оролцогч талтай (нийгмийн ялгаатай давхаргыг төлөөлсөн), тэдгээрийн хооронд удирдлага, зохион байгуулалтын нарийн хэв маяг зонхилдог зэрэг онцлогтой гэж үзжээ.

Хүснэгт 4: Их сургуулийн орчны ёс зүйн онцлог, мөн чанарын талаар багш нарын хариултын нэгтгэл


- ❖ Академик байгууллага учраас академик эрх чөлөө, хариуцлагын асуудал чухал.
- ❖ Ирээдүйн мэргэжилтний хандлага, итгэл үнэмшил, үндэс суурийг тавьдаг.
- ❖ Босоо удирдлагатай тул удирдлагын ёс зүй хандлага харилцаа чухал.
- ❖ Мэргэжилтний мэргэшсэн байдлын үндэс нь ёс зүйн төлөвшил байдаг.
- ❖ Өөр өөр давхаргын хүмүүсийн хооронд харилцаа явагддаг. Ижил тэгш харилцах, хүнлэг хандах хэрэгтэй.
- ❖ Сахилга бат, дүрэм журам чухал.
- ❖ Хичээл сургалтын чанар чухал.
- ❖ Шинэ санаа, инноваци бий болж нэвтэрч байдаг. Түүнийг зохицуулахад ёс зүй хэрэгтэй
- ❖ Шинжлэх ухаан, эрдэм мэдлэгийг түгээдэг орчин тулд эерэг хандлага, ёс зүй чухал
- ❖ Багш нар сайн үлгэрлэн дагуулагч байх шаардлагатай. Оюутан залуучуудтай харьцдаг.

Зураг 8: Ёс зүйн талаар хэнээс/юунаас суралцах ёстой талаар оюутны хариулт (курсээр)



Оюутнуудаас ёс талаар хэнээс илүү суралцах ёстой тухай тодруулсан асуултад багшаас гэсэн хариулт хамгийн өндөр хувийг эзэлж байгаа хэдий ч энэ үзүүлэлт оюутнуудын курс ахих тусам буурах хандлагатай байна. Нэгдүгээр курсийн 2 оюутан тутмын 1 нь багшаас ёс зүйн талаар суралцах ёстой гэж үзэж байсан бол энэ хариулт 4-р курсийнхний дунд 3 оюутан тутмын 1 болж буурсан байна.

Зураг 9: Их сургуулийн орчинд ёс зүйгүй байдал хэр газар авсан үзэгдэл болох талаар оюутны хариулт, курсээр (1-маш бага, 2-бага, 3-дунд зэрэг, 4-их, 5-маш их)



Түүнчлэн их сургуулийн орчинд ёс зүйгүй байдал хэр их газар авсан үзэгдэл болохыг оюутнаар үнэлүүлэхэд (1-маш бага, 2-бага, 3-дунд зэрэг, 4-их, 5-маш их) нийт оюутны үнэлгээний дундаж үзүүлэлт 3.24 буюу дунд зэрэг гэсэн үнэлгээ гарчээ. Энэ үзүүлэлтийг курсээр харьцуулж харахад курс ахих тусам өсөн нэмэгдсэн үр дүн гарсан нь оюутнуудын курс ахих тусам их сургуулийн орчинд ёс зүйгүй үзэгдэл газар авсан гэж үзэх хандлага нэмэгдэж байгааг илэрхийлж байна.


Хүснэгт 5: Оюутнуудын ёс зүйн төлөвшлийг авч буй эх сурвалжийн онооны дундаж, курсээр

Курс	1-р курс Дундаж (Стандарт хазайлт)	2-р курс Дундаж (Стандарт хазайлт)	3-р курс Дундаж (Стандарт хазайлт)	4-р курс Дундаж (Стандарт хазайлт)	5-р курс Дундаж (Стандарт хазайлт)	6-р курс Дундаж (Стандарт хазайлт)	Нийт Дундаж (Стандарт хазайлт)
1. Гэр бүл	2.81 2.56	2.42 2.48	2.31 2.39	2.94 2.81	1.85 1.70	2.68 2.61	2.53 2.52
2. Найз нөхөд	4.00 1.97	3.73 1.86	3.79 1.89	3.95 1.88	3.64 1.52	3.98 1.94	3.83 1.88
3. Багш	3.95 2.25	3.52 1.96	3.50 1.89	3.72 2.05	2.88 1.63	3.85 2.02	3.60 2.00
4. Ах дүү, хамаатан садан	4.62 1.77	4.49 1.86	4.54 1.88	4.37 1.69	4.79 1.98	3.95 2.12	4.49 1.84
5. Анги танхим, сургууль	4.53 1.82	4.21 1.63	4.42 1.63	4.41 1.67	3.45 1.66	4.73 1.84	4.34 1.69
6. Интернет, цахим сүлжээ	5.02 2.03	5.54 1.99	5.41 1.97	5.46 1.96	5.30 2.07	4.65 2.12	5.37
7. Хэвлэмэл бүтээл	5.93 2.14	5.88 2.06	5.79 2.24	5.81 2.20	6.52 1.91	5.58 2.27	5.86 2.15
8. Радио телевиз	5.77 2.28	6.02 1.96	5.90 2.13	5.93 2.29	6.36 1.98	5.45 2.31	5.92 2.13

Оюутнуудын ёс зүйн төлөвшлийг авч буй эх сурвалжид өгсөн онооны дунджийг харахад багш нь гэр бүл ба найз нөхдийн дараа гуравдугаарт эрэмбэлэгдсэн байна. Харин анги танхим, сургууль нь ах дүү хамаатан садны дараа дөрөвдүгээрт оржээ.


Хувь хүний зан чанаруудыг ач холбогдлоор нь 1-10 онооны хооронд үнэлсэн оюутны үнэлгээний дунджаар зан чанаруудыг буурах эрэмбээр байрлуулахад зураг 3-д үзүүлсэн зан чанарууд хамгийн өндрөөр үнэлэгдсэн ба хүйсийн хувьд эмэгтэй оюутнууд эрэгтэйчүүдээс илүү дээрх зан чанаруудыг ач холбогдолтойд үзсэн байна.

Зураг 10: Оюутнуудаас хамгийн өндөр үнэлгээ авсан зан чанар (хүйсээр)




Харин багш нарын зан чанаруудыг ач холбогдлоор нь 1-10 хүртэлх оноогоор үнэлсэн үнэлгээний дунджуудыг эрэмбэлбэл хариуцлагатай байдал (8.95), хөдөлмөрч зан (8.92), мэдлэг чадвар (8.84), хувийн сахилга бат (8.81), шударга хандлага (8.72) ба идэвх зүтгэл (8.64) зэрэг зан чанарууд эхний эгнээнд эрэмбэлэгдсэн.

Зураг 11: Их, дээд сургуулийн багш, оюутнуудын хамгийн өндрөөр үнэлж буй зан чанарууд (багш, оюутнуудын хариулт)



Харин зан чанаруудыг үнэлсэн байдлыг багш, оюутнаар харьцуулж харвал шударга хандлагыг үнэлсэн байдал багш, оюутнаар бага зэрэг ялгаатай буюу багш нар шударга хандлагыг оюутнуудаас илүү өндөр үнэлсэн байна.

Зураг 12: Зан чанаруудыг эрхэмлэх байдал ба хэрэгжүүлдэг байдлын үнэлгээний дунджуудын харьцуулалт, багш, оюутнаар



Багш, оюутнаар зан чанаруудыг үнэлүүлэхдээ тухайн зан чанар түүний хувьд хэр чухал болох болон амьдралд хэрэгжүүлдэг байдал гэсэн үндсэн 2 шалгуур тус бүрээр 1-10 оноогоор үнэлүүлсэн. Эдгээр шалгуурын дагуу багш, оюутны үнэлгээний дунджийг харьцуулан харвал тухайн зан чанарыг чухалчлан үзэж буй байдал ба бодит байдал дээр хэрэгжүүлдэг байдлын хооронд зөрүүтэй байна. Тодруулбал багш нарын зан чанаруудыг чухалд үзэх байдлын дундаж үзүүлэлт 8.1 ба түүнийг хэрэгжүүлдэг байдалд өгсөн үнэлгээний дундаж 7.2 байгаа бөгөөд энэ 2 дунджийн хоорондын зөрүү 0.9 байгаа бол оюутнуудын үнэлгээний зөрүү 1.0 байна. Эндээс их

сургуулийн багш, оюутнуудын хувьд эрхэмлэж буй зан чанараа бодит байдал дээр төдийлөн хэрэгжүүлж чаддаггүй гэсэн үр дүн харагдаж байна.

Хүснэгт 6: Зан чанаруудыг эрхэмлэх байдал ба хэрэгжүүлдэг байдлын үнэлгээний дунджуудын харьцуулалт, багш, оюутнаар

		Хэр чухал болох	Хэрэгжүүлдэг байдал	Дунджийн зөрүү
		Дундаж		
1.	Багш нарын үнэлгээ	8.1	7.2	0.9
2.	Оюутнуудын үнэлгээ	8.4	7.4	1.0

Оюутнуудаар зан чанаруудыг 1-10 хүртэл оноогоор хэр чухал болох болон хэрэгжүүлдэг байдлыг үнэлүүлсэн үнэлгээний мэдээлэлд фактор анализ хийж үзэхэд 18 зан чанарыг үнэлж буй үнэлгээгээр 5 бүлэг ангилал тодорхойлогдсон. Оюутнууд зан чанаруудыг эрхэмлэх байдлаараа хуваагдаж буй бүлгүүдийн эрхэмлэж буй зан чанарын нийтлэг хэв шинжүүдийг тодорхойлбол эхний бүлэг оюутнууд хувийн сахилга бат, идэвх зүтгэл, шударга хандлага, хариуцлагатай байдал, тууштай, цөхөршгүй байдал ба мэдлэг чадварыг үнэлж байгаагаараа нийтлэг бол хоёрдугаар бүлгийн оюутнууд өрөвч, өгөөмөр зан, даруу байдал ба талархах сэтгэлийг чухалчилдаг байна. Харин олон нийтэч, нөхөрсөг, хөгжилтэй занг эрхэмлэдэг оюутнууд нэг бүлэг болж байхад эр зориг, хайр, хөдөлмөрч занг эрхэмлэж буй оюутнууд нэг бүлэг болж байна. Хүлээц, тэвчээрийг эрхэмлэдэг оюутнууд дээрх бүлгийн оюутнуудаас тусдаа бүлэг үүсгэсэн байна.

Хүснэгт 7: Хүний зан чанаруудыг үнэлсэн оюутны үнэлгээнд хийсэн фактор анализын үр дүн

		Факторууд				
		1	2	3	4	5
Бүлэг 1	Хувийн сахилга бат	.755				
	Идэвх зүтгэл	.730				
	Шударга хандлага	.651				
	Хариуцлагатай байдал	.568				
	Тууштай, цөхөршгүй	.456				
	Мэдлэг чадвар	.419				
Бүлэг 2	Өрөвч		.765			
	Өгөөмөр		.731			
	Даруу зан		.701			
	Талархах		.445			
Бүлэг 3	Олон нийтэч, элгэмсүү			.783		
	Хөгжилтэй зан			.737		
	Нөхөрсөг хандлага			.724		
Бүлэг 4	Эр зориг				.733	
	Хайр				.703	
	Хөдөлмөрч				.650	
Бүлэг 5	Хүлээц					.796
	Тэвчээр					.747

Оюутнуудын үнэлгээний найдвартай байдлын үзүүлэлт өндөр (Кронбах альфа – 0.92). Түүврийн тохироц чанарын үзүүлэлт сайн (КМО – 0.89)

Зан чанаруудыг үнэлсэн багш нарын үнэлгээнд хийсэн фактор шинжилгээний үр дүнгээр багш нарын 2 үндсэн бүлэг тодорхойлогджээ. Эхний бүлэгт сахилга бат, хичээл зүтгэл, тэсвэр тэвчээрийг эрхэмлэх байдал зонхилж байхад нөгөө бүлэг нь өрөвч нинжин сэтгэл, өгөөмөр зан, хайр халамж зэрэг сэтгэл хөдлөлийн шинжтэй харилцааны зан төлөвт түлхүү төвлөрчээ.


Хүснэгт 8: Хүний зан чанаруудыг үнэлсэн багш нарын үнэлгээнд хийсэн фактор анализын үр дүн

		Факторууд	
		1	2
Бүлэг 1	• Хариуцлагатай байдал	.846	
	• Идэвх зүтгэл	.827	
	• Тууштай, цөхөршгүй байх	.810	
	• Шударга хандлага	.804	
	• Нөхөрсөг хандлага	.743	
	• Хувийн сахилга бат	.741	
	• Нийтэч, элгэмсүү байдлыг	.734	
	• Мэдлэг чадвар	.701	
	• Хүлээцтэй байдал	.640	
	• Тэвчээртэй байдал	.592	
Бүлэг 2	• Өрөвч байдал		.844
	• Даруу зан		.834
	• Хөгжилтэй зан		.791
	• Талархах		.764
	• Өгөөмөр байдал		.755
	• Хайр		.749
	• Эр зоригтой байдал		.671
	• Олон нийтэч байдал		.561

Багш нарын зан чанарын үнэлгээнд хийсэн фактор анализын найдвартай байдлын үзүүлэлт өндөр (Кронбах альфа – 0.93), түүврийн тохироц чанар (КМО Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy – 0.87) байна


Их, дээд сургуулийн орчинд хэн хамгийн их ёс зүйгүй хандлага гаргадаг вэ гэсэн асуултад өгсөн багш, оюутны хариултад бага зэргийн ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, багш нарын 29,1 хувь захирал, удирдах албан тушаалтан ёс зүйгүй авирладаг гэж үзсэн нь хамгийн өндөр үзүүлэлт бол оюутнуудын 44,3 хувь нь оюутнуудыг ёс зүйгүй гэж үзжээ.

Зураг 13: Таны бодлоор их, дээд сургуулийн орчинд хэн хамгийн их ёс зүйгүй хандлага гаргадаг вэ?




Багш нар ёс зүйгүй гэж нийт багш нарын 20,9 хувь үзсэн бол оюутнуудын 11.6 хувь нь багшийг ёс зүйгүй гэж үзсэн. Оюутнуудын хувьд багшаас илүү оюутанд үйлчлэх албаны ба сургалтын албаны мэргэжилтэн, оюутны зөвлөлийн дарга гишүүдийг ёс зүйгүй гэж үнэлжээ.

Зураг 14: Өнөөгийн нийгэмд ямар хүн сайхан амьдрах боломжтой вэ? (багш, оюутны хариултаар)



Өнөөгийн нийгэмд ямар хүн сайхан амьдрах боломжтой вэ гэсэн асуултын хариултыг сонголтоор нь эрэмбэлэхэд нэн тэргүүнд хөдөлмөрч, боловсролтой, ёс зүйтэй хүн сайхан амьдарна гэж үзсэн хандлага тодорч байна. Гэхдээ оюутнууд багш нараас илүүтэй боловсролтой хүн сайхан амьдарна гэж үзэж буй бол багш нар ёс зүйтэй хүн сайхан амьдарна гэж үзсэн байдал оюутнуудаас илүү байна. Түүнчлэн оюутнуудын хувьд хөрөнгө мөнгөтэй хүн сайхан амьдарна гэж үзэх хандлага багш нарынхаас илүү байхад эрх мэдэлтэй хүн сайхан амьдарна гэж үзсэн байдал багш нарын дунд оюутнуудаас илүү байна.


Зураг 15: Уламжлалт ойлголтуудтай санал нийлж буй байдал (багш, оюутнаар)



Авлига, ёс зүйгүй үйлдлийг арилгахад түүнийг илрүүлэх, мэдээлэх, шүүмжлэх, буруутгах талаар оролцогч талуудын хандлага, үзэл бодол байр суурь чухал нөлөөтэй. Судалгаагаар авлига, шударга бус ёс зүйгүй үйлдлийг нуун дарагдуулах, тэвчихэд хүргэдэг уламжлалт, тогтсон ойлголтуудтай хэр санал нийлж буйг тодруулахад тодорхой хэмжээнд санал нийлэх хандлага ажиглагдсан. Урт хэл хүзүү орооно, сохрын газар сохор, доголлонгийн газар доголлон зэрэг хэлцтэй оюутнуудын бараг тал шахам хувь нь санал нийлж байхад багш нарын 30-40 хувь нь санал нийлж байна. Нийгэмд авлига, хээл хахууль, ёс зүйгүй үйлдэл газар авахад ийнхүү олон нийтийн дунд тогтсон ойлголт хандлага сөргөөр нөлөөлдөг. Авлига, шударга бус, ёс зүйгүй үйлдэлтэй эвлэрсэн, түүнийг тэвчсэн хандлага дээд боловсролын системд багш, оюутнуудын дунд тодорхой хэмжээнд илэрч байна гэж үзэж болох юм.

Багш нар ёс зүйн хувьд оюутнуудад үлгэрлэж чаддаг эсэх талаар оюутнуудаас асуухад 5 оюутны 1 нь тийм гэж хариулсан ба сургуулиудаар харахад ДХИС-ийн оюутнуудын үзүүлэлт хамгийн өндөр бол АШУҮИС-ийн оюутнуудын үзүүлэлт арай доогуур байна.

Зураг 16: Багш нар ёс зүйн хувьд оюутнуудад үлгэрлэж чаддаг эсэх талаар оюутны хариулт, сургуулиар



Сайн мэргэжилтэнд ёс зүй чухал эсэх талаар оюутны хандлагыг тодруулахад 92,2 хувь нь чухал гэж үзсэн ба ДХИС-ийн оюутнуудын үнэлгээ бусад сургуультай харьцуулахад бага зэрэг доогуур байна.

Хүснэгт 9: Мэргэжилтний ёс зүйн ач холбогдлын талаар оюутнуудын хариулт, сургуулиар


	Сургууль			Нийт
	АШУҮИС	МУБИС	ДХИС	
Сайн мэргэжилтэн заавал ёс зүйтэй байх ёстой гэдэгтэй санал нийлэх үү	95,8	93,7	87	92,2

БҮЛЭГ 3. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ЁС ЗҮЙН ЗӨРЧЛҮҮД


Дээд боловсролын орчин ёс зүйн асуудлуудтай нэлээд хэмжээгээр тулгардаг орчин болох нь харагдаж байна. Судалгаанд оролцсон оюутнуудын 30-40 гаруй хувь, харин багш нарын 24-34 хүртэлх хувь нь тухайн орчинд ёс зүйн зөрчил газар авсан үзэгдэл гэж хариулжээ.

Зураг 17: Их сургуулийн орчинд ёс зүйгүй байдал хэр газар авсан үзэгдэл вэ? Багш, оюутны хариулт, сургууль хувиар

Их сургуулийн орчинд ёс зүйгүй байдал хэр газар авсан үзэгдэл вэ?, оюутны хариулт, сургууль, хувиар




Таны бодлоор их сургуулийн орчинд ёс зүйгүй байдал хэр газар авсан үзэгдэл вэ?, багш нарын хариулт



Судалгааны тайлангийн эхний буюу арга зүйн бүлэг дэх дээд боловсролын орчин дахь ёс зүйн зөрчил, авлига, шударга бус үйлдлийн ангиллын дагуу багшийн ёс зүйгүй үйлдлүүдэд өгсөн багш болон оюутнуудын үнэлгээний үр дүнг авч үзэж болно. Тус бүр нарийвчилсан үйлдлүүдийн талаар судалгаанд үнэлгээ авсан бөгөөд тэдгээр үйлдлүүдийг ангилалд хамруулж, тус бүрийн үнэлгээний дунджийг

олж гаргасан болно. Ингэж үзэхэд 1) эрх мэдлээ урвуулан ашиглах, 2) сонирхлын зөрчилтэй байх, 3) үүргээ үл хэрэгжүүлэх, 4) үгсэх гэсэн төрлийн зан үйл, үйлдлүүд давамгайлж байна. Ерөнхийдөө багшийн ёс зүйгүй үйлдлийн талаар багш болон оюутнуудын хариултын давтамжид төсөөтэй хэлбэрийн дүрслэл бий болж байгаа нь дээрх хоёр бүлгийн хувьд төсөөтэй санал бодол буй нь харагдаж байна.

Зураг 18: Багшийн ёс зүйгүй үйлдлүүдийг дээд боловсролын орчин дахь ёс зүйн зөрчлийн ангиллын дагуу авч үзэх нь



Харин дээрх ангиллын дагуу оюутнуудын ёс зүйгүй үйлдлийг ангилж авч үзэх аваас дараах дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 10: Багшийн ёс зүйгүй үйлдлүүдийн нийтлэг хэлбэрүүд, багш болон оюутны үнэлгээний дунджаар эрэмбэлсэн нь

	Багшийн ёс зүйгүй үйлдлүүд	Багшийн үнэлгээ	Багшийн ёс зүйгүй үйлдлүүд	Оюутны үнэлгээ
1	Багш нар хичээлийн бус цагаар оюутнуудад зөвлөгөө өгдөггүй	3.047	Багш нар хичээлийн бус цагаар оюутнуудад зөвлөгөө өгдөггүй	2.92
2	Оюутанд сайн муу гэсэн хаяг шошго наах, түүгээрээ хандах	2.321	Өөрийн ном, сурах бичгийг оюутнуудад “шахах”	2.88
3	Оюутанд шударга бус үнэлгээ тавих	2.009	Оюутанд шударга бус үнэлгээ тавих	2.54
4	Оюутныг хэл амаар доромжлох	1.926	Оюутныг сурлагаар нь ялгаварлах	2.5
5	Багш хичээлээ орохгүй таслах	1.917	Танил оюутанд давуу тал олгох	2.46
6	Өөрийн ном, сурах бичгийг оюутнуудад “шахах”	1.852	Оюутанд сайн муу гэсэн хаяг шошго наах, түүгээрээ хандах	2.32

7	Танил оюутанд давуу тал олгох	1.806	Оюутныг хэл амаар доромжлох	2.17
8	Багш өөрийн үзэл бодлыг оюутанд тулгах	1.731	Багш өөрийн үзэл бодлыг оюутанд тулгах	2.13
9	Оюутныг сурлагаар нь ялгаварлах	1.561	Хувийн үнэлэмжээр оюутнуудыг ялгаварлаж хандах	2.06
10	Оюутныг төсөл, хөтөлбөрт үнэ хөлсгүй зарах	1.5	Оюутныг гадна үзэмж, хувцас зэргээр ялгаварлах	1.83
11	Хувийн үнэлэмжээр оюутнуудыг ялгаварлаж хандах	1.43	Багш хичээлээ орохгүй таслах	1.77


Багшийн ёс зүйгүй үйлдлүүдээс эхний 11 үйлдлийг эрэмбэлэн харвал багш болон оюутны үнэлгээнд төсөөтэй зүйлүүд, дээрх эрэмбэд ижил үйлдлүүд ч давтагдах хандлагатай байгааг харж болно. Тэдгээрийн заримаас сургуулиудаар харьцуулан харах боломжтой.

Хүснэгт 11: Багшийн ёс зүйгүй үйлдлийн нийтлэг хэлбэрүүд, сургуулиар

		Их сургуулиуд					
		ДХИС		АШУҮИС		МУБИС	
		Нийтлэг	Заримдаа	Нийтлэг	Заримдаа	Нийтлэг	Заримдаа
Нийтлэг зөрчлүүд	Оюутанд шударга бус үнэлгээ тавих	6.5%	34.7%	15.8%	44.2%	18.0%	36.8%
	Танил оюутанд давуу тал олгох	16.2%	23.8%	24.6%	29.9%	18.6%	26.9%
	Оюутныг хэл амаар доромжлох	7.2%	23.6%	11.3%	26.8%	7.8%	27.9%
	Дүн гаргахдаа оюутнаас шан харамж авах	3.9%	10.5%	3.2%	14.1%	4.7%	17.5%
	Өөрийн ном, сурах бичгийг оюутнуудад шахах	18.0%	26.4%	44.7%	26.5%	32.1%	30.1%
	Багш хичээл орохгүй таслах	1.8%	7.9%	4.2%	20.8%	2%	22.6%

Мөн арга зүйн бүлэгт дээд боловсролын орчин дахь ёс зүйн зөрчил, авлига, шударга бус үйлдлийн ангиллын дагуу оюутны ёс зүйгүй үйлдлүүдэд өгсөн багш болон оюутнуудын үнэлгээний үр дүнг авч үзэж болно. Дээр дурдсанчлан, зан үйлийн ангилал тус бүрд багтах дундаж үнэлгээ нь дараах зураглалыг бий болгож байна.

Зураг 19: Оюутны ёс зүйгүй үйлдлүүдийг дээд боловсролын орчин дахь ёс зүйн зөрчлийн ангиллын дагуу авч үзэх нь



Оюутны ёс зүйгүй үйлдлийн талаар мөн багш болон оюутны зүгээс өгсөн үнэлгээг ангилан үзвэл 1) оюутнууд үүргээ үл хэрэгжүүлэх, 2) хууран мэхлэх, 3) тэгш бус хандах, 4) саад учруулах гэсэн төрлийн зан үйл, үйлдлүүд зонхилсон байна.

Хүснэгт 12: Оюутны ёс зүйгүй үйлдлүүдийн нийтлэг хэлбэрүүд, багш болон оюутны үнэлгээний дунджаар эрэмбэлсэн нь

	Оюутны ёс зүйгүй үйлдлүүд	Багшийн үнэлгээ	Оюутны ёс зүйгүй үйлдлүүд	Оюутны үнэлгээ
1	Шалгалтын үед хуулах	2.935	Багийн ажилд харилцан адилгүй оролцоотой байж нэг ижил дүн авах	3.46
2	Хичээлээ таслах	2.701	Шалгалтын үед хуулах	3.24
3	Багийн ажилд харилцан адилгүй оролцоотой байж нэг ижил дүн авах	2.654	Хичээлээ таслах	2.87
4	Худал хэлж чөлөө авах	2.547	Хичээл дээр унтах	2.8
5	Хичээл дээр, холбогдолгүй өөр зүйл хийх	2.468	Семинар дээр үзэл бодлоо хамгаалахын тулд бусадтай хэрүүл үүсгэх	2.66
6	Хичээл дээр унтах	2.287	Худал хэлж чөлөө авах	2.66
7	Семинар дээр үзэл бодлоо хамгаалахын тулд бусадтай хэрүүл үүсгэх	2.113	Хичээл дээр, холбогдолгүй өөр зүйл хийх	2.62

8	Сургуулийн орчинд эд зүйлсээ алдах тохиолдол гардаг эсэх	2.028	Сургуулийн орчинд эд зүйлсээ алдах тохиолдол гардаг эсэх	2.26
9	Багшийг үл хүндэтгэх (багштай хэрэлдэх, доромжлох г.м)	1.673	Бусад оюутныг сурлагаар нь ялгаварлах	2.23
10	Оюутнууд нэгнээ дарамтлах, хүчирхийлэх	1.654	Бусдаас хуулуулахыг шаардах	2.2
11	Бусдыгаа үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах	1.604	Бусдыгаа үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах	2.15

Оюутны ёс зүйгүй үйлдлүүдийн нийтлэг хэлбэрүүд нь дээрх үр дүнтэй нийцэж байгаа бөгөөд тэдний зүгээс сурах үүргээ үл хэрэгжүүлэх, хууран мэхлэх, бие биенээ ялгаварлан гадуурхах, сурах, сургах үйл ажиллагаанд саад учруулах агуулга бүхий үйлдлүүд байгааг харж болно.

Хүснэгт 13: Оюутны ёс зүйгүй үйлдлийн нийтлэг хэлбэрүүд, сургуулиар

		Их сургуулиуд					
		ДХИС		АШУҮИС		МУБИС	
		Нийтлэг	Заримдаа	Нийтлэг	Заримдаа	Нийтлэг	Заримдаа
Нийтлэг зөрчлүүд	Худал хэлж чөлөө авах	8.7%	17.5%	27.4%	38.3%	38.8%	28.4%
	Хичээл дээр холбогдолгүй өөр зүйл хийх	13.1%	20.8%	23.4%	33.6%	28.8%	35.3%
	Хичээлээ таслах	10.9%	23.5%	30.1%	40.6%	37.8%	30.5%
	Шалгалтын үед хуулах	22.7%	40.4%	46.2%	37.2%	52.3%	31.7%
	Багийн ажилд харилцан адилгүй оролцоотой байж нэг ижил дүн авах	41.3%	27.2%	55.8%	27.9%	51.7%	33.0%
	Бусдаас хичээлээ хуулуулахыг шаардах	5.2%	19.6%	15.5%	24.3%	14.7%	26.4%
	Архи, согтууруулах ундаа хэрэглэх	2.2%	11.2%	11.7%	17.7%	11.7%	21.7%
	Семинар дээр үзэл бодлоо хамгаалахын тулд бусадтай хэрүүл үүсгэх	18.1%	36.8%	14.7%	42.9%	20.5%	42.3%

Хүснэгт 14: Оюутны ёс зүйгүй үйлдлийн нийтлэг хэлбэрүүд, сургуулиар

		Тийм	Үгүй
Дотоод хэргийн их сургууль	1-р курс	97.3%	2.7%
	2-р курс	84.7%	15.3%
	3-р курс	87.0%	13.0%
	4-р курс	90.0%	10.0%

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	1-р курс	92.0%	8.0%
	2-р курс	76.5%	23.5%
	3-р курс	73.5%	26.5%
	4-р курс	82.1%	17.9%
	5-р курс	68.8%	31.3%
	6-р курс	61.5%	38.5%
Монгол улсын боловсролын их сургууль	1-р курс	87.2%	12.8%
	2-р курс	79.7%	20.3%
	3-р курс	88.2%	11.8%
	4-р курс	78.0%	22.0%
Нийт	1-р курс	91.7%	8.3%
	2-р курс	80.3%	19.7%
	3-р курс	84.5%	15.5%
	4-р курс	83.9%	16.1%
	5-р курс	68.8%	31.3%
	6-р курс	61.5%	38.5%

Байгууллагын ажилтнуудын ёс зүйг дээшлүүлэх, ёс зүйтэй орчин төлөвшүүлэхэд дүрэм журмын боловсруулалт хэрэгжилтийн байдал чухал нөлөөтэй. Судалгааны хүрээнд их сургуулийн оролцогч талуудад зориулсан дүрэм журмын талаарх багш, оюутны ойлголт мэдлэгийг тодруулсан.

Хүснэгт 15: Их сургуулийн оролцогч талуудад зориулсан ёс зүйн дүрмийн талаарх мэдлэг, багш, оюутны хариулт (3-энэ талаар сайн мэднэ, 2- зарим зүйлийг мэднэ, 1-байдаг гэж мэдэх төдий, 0-энэ талаар мэдэхгүй байна)

	Багш		Оюутан	
	Дундаж	Стандарт хазайлт	Дундаж	Стандарт хазайлт
Багшийн ёс зүйн дүрэм	2.72	0.49	1.91	0.69
Оюутны ёс зүйн дүрэм	2.39	0.72	2.25	0.68
Сургалтын болон оюутанд үйлчлэх албаны ажилтны ёс зүйн дүрэм	2.08	0.90	1.54	0.83


Их сургуулийн оролцогч талуудад зориулсан ёс зүйн дүрмийн талаарх багш, оюутнуудын ойлголт мэдлэгийг 0-3 онооны хооронд үнэлүүлэхэд багш, оюутнуудын үнэлгээний дундаж үзүүлэлт ялгаатай байна. Тодруулбал багш нарын үнэлгээ 2.0-2.7 ийн хооронд байгаа бол оюутнууд өөрсдөд нь хамаатай ёс зүйн дүрмийн талаарх мэдлэгтээ өгсөн үнэлгээний дундаж үзүүлэлт харьцангуй сайн (2.25) хэдий ч багш ба сургалтын болон оюутанд үйлчлэх албаны ажилтнуудын ёс зүйн дүрмийн талаар төдийлөн сайн ойлголтгүй (1.91 ба 1.54) байна. Ерөнхийдөө оюутнууд оюутны ёс зүйн дүрмийн талаар, багш нар багш нарын ёс зүйн дүрмийн талаар илүүтэй мэдэж байна.

Хүснэгт 16: Авлига, шударга бус үйлдлийг мэдээлэх талаар багш нарын хандлага (сургуулиар)

		Сургууль			Нийт
		АШУУИС	МУБИС	ДХИС	
1.	Авлига, шударга бус үйлдлийн талаар мэдээлэх нь ёс зүйтэй үйлдэл мөн үү?	100	100	95.7	98.1
2.	Иргэд, олон нийт авлига, шударга бус үйлдлийн талаар мэдээлсэн хүнийг матаач, урвагч мэтээр үздэг гэдэгтэй та санал нийлэх үү?	27.3	27.6	32.6	29.6


Авлига шударга бус үйлдлийн талаар мэдээлэх нь ёс зүйтэй үйлдэл мөн гэдэгтэй багш нар бүрэн санал нийлж байгаа бөгөөд сургуулиудаар бага зэргийн ялгаатай буюу ДХИС-ийн багш нарын хувьд бусад сургуультай харьцуулах санал нийлэхгүй байгаа хэсэг байна. Харин авлига, шударга бус үйлдлийн талаар мэдээлсэн хүнийг буруутгах хандлага байдаг гэдэгтэй багш нарын 30 орчим хувь санал нийлж байна.

Зураг 20: Сургуулийнхаа шалгалт авах, дүн гаргах тогтолцоо шударга гэдэгтэй санал нийлж буй байдал, оюутны хариулт, сургуулиар




Их, дээд сургуулийн ёс зүйн түгээмэл зөрчлүүдийн нэг нь шалгалт авах, дүн гаргах тогтолцооны шударга бус байдал юм. Энэ талаар оюутнуудын санал бодлыг тодруулахад сургуулиар ялгаатай үр дүн гарчээ. Бүрэн санал нийлж буй оюутнуудын хувь ДХИС-ийн хувьд хамгийн өндөр (42.1) байна. Харин санал нийлэхгүй оюутнуудын хувь АШУУИС (42.9) ба МУБИС-ийн (42.9) хувьд олонх байна.

Зураг 21: Багшийн ёс зүйгүй үйлдэлд тооцож буй хариуцлага /багш, оюутны хариулт/




Багшийн ёс зүйгүй үйлдэлд хүлээлгэж буй хариуцлагын арга хэмжээний талаар 2 оюутан тутмын 1 нь мэдэхгүй гэж хариулсан ба цалин хасах, ёс зүйн дүрмээр хариуцлага тооцох, ажлаас чөлөөлөх арга хэмжээ авдаг байх гэж бодож буй хариултын хувь оюутнуудын дунд өндөр байна. Харин багш нарын хариултад цалин хасах, ажлаас чөлөөлөх, ёс зүйн дүрмээр хариуцлага тооцох гэсэн хариултауд өндөр хувьтай гарчээ.

Зураг 22: Оюутны ёс зүйгүй үйлдэлд хүлээлгэж буй хариуцлагын арга хэмжээ, багш, оюутны хариулт, хувиар




Оюутны ёс зүйгүй үйлдлийн талаар авч буй хариуцлагын арга хэмжээний талаар багш, оюутны саналыг харьцуулахад зэмлэн буруушаах, ёс зүйн дүрмээр хариуцлага тооцох, сургуулиас чөлөөлөх арга хэмжээ авдаг гэж багш оюутнуудын ихэнх нь үзсэн ба багш нарын хувьд зэмлэн буруушаах шийтгэлийг оногдуулах нь түгээмэл гэж үзсэн байхад оюутнууд сургуулиас чөлөөлөх арга хэмжээ түлхүү авдаг гэж бодож байна.

Зураг 23: Багш, оюутны ёс зүйгүй үйлдэлд хүлээлгэх хариуцлагын хэлбэрийн талаар оюутны хариулт, сургуулиар



Багш оюутны ёс зүйгүй үйлдэлд хүлээлгэх хариуцлагын хэлбэрийн талаар оюутнуудын хариултыг сургуулиудаар харьцуулж харвал Дотоод Хэргийн их сургуулийн оюутнуудын хариултад албан ёсны арга хэмжээ авдаг гэсэн хариулт зонхилж байна. Түүнчлэн Монгол улсын боловсролын их сургуулийн оюутнуудын 41.3 хувь мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ.


Зураг 24: Багш, оюутны ёс зүйгүй үйлдэлд хүлээлгэх хариуцлагын хэлбэр, багшийн хариулт, сургуулиар



Их, дээд сургуулийн орчинд багш, оюутны ёс зүйгүй үйлдэлд хүлээлгэх хариуцлагын хэлбэрийн талаар багш нарын хариултыг сургуулиар нь харьцуулж үзвэл АШУУИС-ийн багш нарын дунд албан ёсны арга хэмжээ давамгайлдаг гэсэн хариулт 80 орчим хувийг эзэлж буй бусад 2 сургуультай харьцуулахад өндөр

үзүүлэлт юм. ДХИС ба МУБИС-ийн багш нарын хувьд албан бус зэмлэл шийтгэл давамгайлдаг гэсэн хариулт бага зэрэг өндөр хувийг эзэлж байна.

Зураг 25: Их, дээд сургуулийн оролцогч талуудад ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн байдал, багш оюутны хариулт, хувиар



Их, дээд сургуулийн оролцогч талуудад ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн байдлын талаар багш, оюутны өгсөн хариултыг сургуулиар харахад ялгаатай үр дүн ажиглагдаж байна. Тухайлбал оюутнуудын энэ талаар мэдэхгүй ба хариуцлага хүлээсэн хүн байхгүй гэсэн хариулт АШУҮИС-ийн оюутнуудын бараг тал хувийг эзэлж байгаа бол ДХИС-д 30 орчим хувь харин МУБИС-д 80 орчим хувийг эзэлж байна. Ерөнхийдөө багш, оюутны хариултад ёс зүйн хариуцлага хүлээсэн багш, оюутны талаар мэднэ гэсэн хариулт бусад оролцогч талууд болох удирдлага ба мэргэжилтэнтэй харьцуулахад өндөр гарч байна.

БҮЛЭГ 5. ЁС ЗҮЙН ДҮРЭМД ХИЙСЭН АГУУЛГЫН ШИНЖИЛГЭЭ

Судалгаанд хамрагдсан их сургуулийн ёс зүйн дүрмийн агуулгыг харьцуулсан судалгааны загвараар баримтын шинжилгээний фремовок анализын аргыг ашиглан шинжиллээ. Эх хэрэглэгдэхүүнийг *ёс зүй, мэргэжлийн ёс зүй, багшийн ёс зүй, оюутны ёс зүй* гэсэн түлхүүр үгсээр шүүж бүрдүүлэв. Үүнд АШУҮИС-ийн ёс зүйн дүрэм, багшийн алтан дүрэм, АШУҮИС-ийн оюутны ёс зүйн дүрэм; МУБИС-ийн ёс зүйн дүрэм, МУБИС-ийн багшийн ажиллах журам, МУБИС-ийн оюутны журам; төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, ДХИС-ийн дүрэм; Их, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн ёс зүйн ерөнхий дүрэм багтсан болно.

Ерөнхий зорилго, их, дээд сургуулийн ёс зүйтэй холбоотой бүтээлд хийсэн тойм, нийт түлхүүр үгэнд түшиглэн, анализын явцад хоорондоо холбоотой ойлголт, санаануудыг багцлах *ёс зүйн үүрэг, ёс зүйн зөрчил, хариуцлага-шийтгэл* гэсэн үндсэн гурван категорийг дедуктив маягаар урьдчилан тодорхойлсон юм. Судалгаа эхлэхээс өмнө их, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн ёс зүйн ерөнхий дүрмийг сонгон авч, их сургуулиудын ёс зүйн дүрэм, журмыг өгөгдлийн сангийн бусад хэсэгтэй системтэй харьцуулах зорилгоор индуктив маягаар нээлттэй кодлон нийт 13 дэд сэдэв буюу шошго үүсгэв.

Үүний дараа аналитик фремовокоо үүсгэн, холбогдох агуулга, контекстийг аналитик фремовок руу хүснэгтлэн нэгтгэлээ. Нэгтгэсэн өгөгдлийг боловсруулж тайлбарлахдаа NVivo 11 Плас (NVivo 11 Plus) программыг ашиглалаа.

Их сургуулиудын ёс зүйн дүрэмд заасан биелүүлбэл зохих хэм хэмжээг бүхэлд нь ёс зүйн үүрэг гэсэн категорид бүлэглэж, харин ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнд тооцох заалтуудыг их, дээд сургуулийн орчин дахь ёс зүйн тухай бүлгийн 1 дүгээр хүснэгтэд тоочсон утгаар задалж кодлов.

Үр дүнг аваад үзвэл их сургуулийн ёс зүйн дүрэм, журамд үүргээ үл хэрэгжүүлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, сургалтын үйл ажиллагаанд саад учруулах, хуурч мэхлэхэд хамаарах үйлдлүүдийг ёс зүйн зөрчил хэмээн хамгийн ихээр томьёолсон байна. Харин лоббидох, үгсэх үйлдэлд хамаарах заалт хамгийн бага дурдагджээ. Эдгээр нь Монголын их, дээд сургуулийн орчинд түгээмэл болон ховор тохиолдож болзошгүй, ёс зүйгүй үйлдлийн давтамжийг илэрхийлж байж болно.

Хүснэгт 17: Үндсэн ба дэд сэдэв, эх сурвалж, дурдагдсан удаа

Зангилаа сэдэв	Эх сурвалж	Дурдагдсан
Ёс зүйн зөрчлүүд	7	123
Лоббидох	1	1
Саад учруулах	6	19
Сонирхлын зөрчил	2	6
Тал засах	3	7
Тэгш бус хандах	4	8
Үгсэх	1	2
Үүргээ үл хэрэгжүүлэх	6	25
Хахууль	2	5
Хувьдаа завших	5	10
Хуурах	4	16
Эрх мэдлээ урвуулах	6	24
Ёс зүйн үүргүүд	8	36
Хариуцлага, шийтгэл	7	7

Ёс зүйн үүрэг хийгээд хүлээлгэх хариуцлага, шийтгэлтэй холбоотой заалт нь дүрэм, журмын нийт агуулгын 58.2-73.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 18: Сэдвүүд дүрэм, журам тус бүрээр, хувиар

	АШУҮИС	ДХИС	Ерөнхий дүрэм	МУБИС
Лоббидох	1.12%	0%	0%	0%
Саад учруулах	5.17%	3.87%	4.88%	3.5%
Сонирхлын зөрчил	2.14%	0%	0%	0%
Тал засах	1.79%	1.73%	2.2%	0%
Тэгш бус хандах	1.28%	5.09%	7.68%	0.98%
Үгсэх	1.02%	0%	0%	0%
Үүргээ үл хэрэгжүүлэх	9.54%	3.67%	12.93%	3.01%
Хариуцлага, шийтгэл	28.88%	62.22%	23.78%	14.65%
Хахууль	1.38%	0%	0%	0%
Хувьдаа завших	2.06%	2.55%	2.2%	0.49%
Хуурах	7.45%	0%	4.63%	3.5%
Эрх мэдлээ урвуулах	5.6%	9.78%	7.2%	3.08%
Ёс зүйн үүргүүд	32.58%	11.1%	34.51%	70.78%

Харин ёс зүйн зөрчлийн тухайд тэгш бус хандахтай холбоотой заалтын 33.16 хувийг АШУҮИС, 26.32 хувийг ДХИС, 7.37 хувийг МУБИС, үлдсэн хувийг багшийн мэргэжлийн ёс зүйн ерөнхий дүрмийн агуулга эзэлж байв. Эрх мэдлээ урвуулах тухайд АШУҮИС, ДХИС, ерөнхий дүрэм, МУБИС-ийн ёс зүйн дүрэм нь 58.02%, 20.25%, 12.45%, 9.28% тус тус илэрхийлжээ. Үүргээ үл хэрэгжүүлэхэд хамаарах заалтын 71.71 хувийг АШУҮИС-ийн ёс зүйн дүрэм дангаар эзэлж байна.

Хүснэгт 19: Нийт дүрэм, журам дахь сэдвүүдийн хувь

	АШУҮИС	ДХИС	Ерөнхий дүрэм	МУБИС
Лоббидох	100%	0%	0%	0%
Саад учруулах	66.4%	9.9%	10.4%	13.0%
Сонирхлын зөрчил	100%	0%	0%	0%
Тал засах	71.5%	13.8%	14.6%	0%
Тэгш бус хандах	33.1%	26.3%	33.1%	7.3%
Үгсэх	100%	0%	0%	0%
Үүргээ үл хэрэгжүүлэх	71.7%	5.5%	16.2%	6.5%
Хариуцлага, шийтгэл	58.3%	25.1%	8.0%	8.5%
Хахууль	100%	0%	0%	0%
Хувьдаа завших	66.8%	16.5%	11.9%	4.6%
Хуурах	80.6%	0%	8.3%	11.0%
Эрх мэдлээ урвуулах	58.0%	20.2%	12.4%	9.2%
Ёс зүйн үүргүүд	53.3%	3.6%	9.4%	33.6%

Хариуцлага, шийтгэлийн хувьд анхааруулах, амаар болон бичгээр сануулга өгөх, донгодох, амлалт авахуулах, ёс зүйн сургалтад хамруулах, уучлал гуйхыг үүрэг болгох, олны өмнө буруушаах, учирсан хохирлыг нь төлүүлэх, зарим эрхийг хязгаарлах, тодорхой хугацаагаар суралцах хугацааг хойшлуулах, цол бууруулах, ээлжийн бус харуул, жижүүрийн үүрэг гүйцэтгүүлэх, хувийн хэрэгт тэмдэглэх, сургуулиас бүрэн мөсөн чөлөөлөх, хуулийн заалтад хамаарсан тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлэх, сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдөх, албан тушаалын зэрэглэлийг бууруулах, ажлаас халах хүртэл арга хэмжээ авах зэргээр тусгажээ.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

- Дээд боловсролын салбар дахь ёс зүйн асуудал нь бусад салбарын ёс зүйн асуудлаас анхаарал харьцангуй бага татдаг судалгааны талбар болохын хувьд академик болон бодлогын судалгааны эргэлтэд олон жил орхигдсон юм. Тиймээс энэ чиглэлийн тодорхой судалгаа хязгаарлагдмал байна.
- Их сургуулийн багш нарын дунд ёс зүйн эрхэмлэл маш чухалд тооцогдож байгаа бол оюутнуудын дунд ёс зүйн эрхэмлэл ерөнхийдөө чухалд тооцогдож байна. Багш нарын ёс зүйн эрхэмлэл оюутнуудынхаас өндөр байна.
- Оюутнуудын ёс зүйн үлгэр дуурайл авах хүмүүсийн эхэнд багш байгаа хэдий ч, багшаас суралцах ёстой гэсэн хандлага курс ахих тусам буурч байна. Мөн оюутнуудын курс ахих тусам их сургуулийн орчинд ёс зүйгүй байдал газар авсан гэж үзэх хандлага нэмэгдэж буй нь анхаарал татаж байна.
- Дээд боловсролын гол оролцогч талууд болох багш, оюутны хувьд боловсролын салбарын ёс зүй нь гэр бүл, ажил дээрх ёс зүйтэй нэгэн адил чухал ач холбогдолтойд тооцогдож байна.
- Багш, оюутнууд хариуцлагатай байдал, хөдөлмөрч зан, мэдлэг чадвар, шударга хандлага, хувийн сахилга бат, идэвх зүтгэлийг эрхэм чухал зан чанарт тооцож байна. Гэсэн хэдий ч багш, оюутны зан чанарыг эрхэмлэх байдал ба тухайн зан чанарыг бодит амьдралд хэрэгжүүлж буй байдал ихээхэн зөрүүтэй байна. Хэдийгээр багш, оюутнууд хүний ёс зүйд холбогдох эрхэм зан чанаруудыг чухалчлан үзэж байгаа хэдий ч тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэх тал дээр учир дутагдалтай байна.
- Нийгэмд авлига, хээл хахууль, ёс зүйгүй үйлдлийг өдөөж байдаг нийгмийн зарим тогтсон ойлголт, уламжлалт хандлагыг баримтлах байдал багш, оюутны дунд тодорхой хэмжээнд байна. Авлига, шударга бус үйлдлийн талаар мэдээлэх нь ёс зүйтэй үйлдэл гэдэгт багш нар санал нэгдсэн ч, авлига, шударга бус үйлдлийн талаар мэдээлсэн хүнийг буруушаах хандлага байдаг гэдгийг тэд хүлээн зөвшөөрч байна. Эндээс авлига шударга бус үйлдлийг мэдээлэх ёстой гэсэн ойлголттой хэдий ч үүнийг хэрэгжүүлэхийн тулд нийгмийн зүгээс буруушаах хандлагыг сөрөх шаардлагатай тулгардаг нь харагдаж байна.
- Их сургуулийн орчны ёс зүйн дүрэм журам, хариуцлагын талаар оюутнуудын мэдлэг, ойлголт хангалтгүй байна.
- Дээд боловсролын хүрээнд оролцогч талуудтай холбоотой үүсэж буй ёс зүйн зөрчлүүд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн байдал, авч буй арга хэмжээний талаар багш, оюутнуудын мэдлэг, ойлголт сул байна.
- Дээд боловсролын орчинд ёс зүйн зөрчил ихээхэн газар авсан зүйл гэдгийг судалгаанд оролцсон багш хийгээд оюутнууд хүлээн зөвшөөрч байна. Хамгийн багадаа дөрвөн багш тутмын нэг, гурван оюутан тутмын нэг нь үүнийг их тархсан үзэгдэл гэжээ.
- Багш нарын зүгээс үйлддэг ёс зүйгүй үйлдлүүдийг ангилан авч үзвэл 1) эрх мэдлээ урвуулан ашиглах, 2) сонирхлын зөрчилтэй байх, 3) үгсэх, 4) үүргээ үл хэрэгжүүлэх гэсэн төрлийн зан үйл, үйлдлүүд давамгайлж байна. Үүнийг нарийвчлан үзвэл, хичээлийн бус цагаар оюутанд зөвлөгөө өгөхөөс цааргалах, оюутанд шударга бус үнэлгээ тавих, оюутныг ялгаварлах, хэл амаар доромжлох, ном сурах бичгийг шахах, танил оюутанд давуу тал олгох, хичээл орохгүй байх, өөрийн үзэл бодлыг тулгах, оюутныг үнэ хөлсгүй

ажиллуулах зэргийг дурдаж болохоор байна.

- Оюутнуудын зүгээс үйлддэг ёс зүйгүй үйлдлүүдийг ангилан авч үзвэл 1) оюутнууд үүргээ үл хэрэгжүүлэх, 2) хууран мэхлэх, 3) тэгш бус хандах, 4) саад учруулах гэсэн төрлийн зан үйл, үйлдлүүд зонхилсон байна.
- Үүнийг нарийвчлан үзвэл, шалгалтын үед хуулах, хичээл таслах, худал хэлж чөлөө авах, бусдын хөдөлмөрийг ашиглан дүн авах, хичээлд холбогдолгүй зүйл хийх, хичээл дээр үзэл бодлоо соёлгүй илэрхийлэх, хичээл дээр унтах зэргийг дурдаж болох юм.
- Судалгаанд хамрагдсан их сургуулиудын ёс зүйн дүрэм, журамд үүргээ үл хэрэгжүүлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, сургалтын үйл ажиллагаанд саад учруулах, хуурч мэхлэхэд хамаарах үйлдлүүдийг ёс зүйн зөрчил хэмээн хамгийн ихээр томьёолж, харин лоббидох, үгсэх үйлдэлд хамаарах заалтыг хамгийн бага дурджээ.

Дээр дурдсан дүгнэлтүүдэд тулгуурлан дараах зөвлөмжүүдийг санал болгож байна.

Дээд боловсролын үндэсний бодлогын хүрээнд:

- Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд их сургуулийн ёс зүйн шинэчлэлийг хийх, их сургуулиуд ба багш нарт хамаарах нийтлэг ёс зүйн дүрэм журмыг шинэчлэх.
- Дээд боловсролын орчинд ёс зүйн дүрэм, журмын институтчилалыг хангах, үүний тулд түүнийг хангах үндэсний хэмжээний тусгай бүтэц, чиг үүргийг эргэн харах, оролцогч талуудын дунд нэгдмэл ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх шаардлагатай.
- Ирээдүйн иргэдийн үнэт зүйл, ёс зүйн төлөвшилд ихээхэн нөлөөтэй нийгмийн чухал институт болох их, дээд сургуулийн ёс зүйн асуудал, түүний нэр хүндийг тэтгэх шийдлийг илүү гүнзгий ойлгохын тулд дээд боловсрол дахь ёс зүйн асуудлыг үргэлжлүүлэн судлах, бодлогын хувьд дэмжих хэрэгтэй.

Их сургуулиудын түвшинд:

- Их сургуулийн оюутнуудыг ёс зүйн төлөвшил, эрхэмлэх үнэт зүйл, зан чанарын төлөвшилд анхаарах, үүнд чиглэсэн соён гэгээрэл нөлөөллийн хөтөлбөр, үйл ажиллагааг дотооддоо хэрэгжүүлэх.
- Их сургуулийн орчин дахь ёс зүйн асуудлын хамрах хүрээний талаар багш, оюутан, удирдлага, хөтөлбөрийн албаны ажилтан албан хаагчид зэрэг бүхий л оролцогч талуудын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх,
- Их сургуулиуд оролцогч талуудад холбогдох ёс зүйн асуудлыг зохих дүрэм журамд тусгах эсвэл ёс зүйн тусгайлсан дүрэм журам боловсруулах, хэвшүүлэх, дүрэм журамтай сургуулийн хувьд шинэчлэх сайжруулах, ёс зүйн түгээмэл зөрчлүүдийг тусгасан заалтуудыг нэмэх, баяжуулах
- Сургуулийн ёс зүйн дүрэм журмыг сургуулийн вебсайт, мэдээллийн цахим систем, сургуулийн үүдний танхим, анги зэрэгт нээлттэй, ил тод байршуулах
- Их сургуулиуд дотоодын ёс зүйн уур амьсгалаа тогтмол судалдаг, ёс зүйн түгээмэл зөрчлүүдийг нээн илрүүлдэг, түүгээр дамжуулан багш, оюутан зэрэг оролцогч талуудын ёс зүйн үйлдэл, зан байдлыг баримжаалдаг байх
- Их сургуулиуд оролцогч талуудын ёс зүйгүй үйлдлийн талаар мэдээлэх хүлээн авч, нягталж, үнэлж дүгнэн хариуцлага тооцдог дотоод механизмтай

- байх, чадавхийг бий болгоход анхаарах,
- Ёс зүйгүй шударга бус үйлдлийг үл тэвчих, түүнд шүүмжлэлтэй хандах уур амьсгал, соёлыг бүрдүүлэхэд анхаарах
 - Их сургуулиуд оролцогч талуудын ёс зүйгүй үйлдэлд хүлээлгэсэн хариуцлагын арга хэмжээний талаар мэдээлдэг байх
 - Их, дээд сургуулиуд болзошгүй ёс зүйн зөрчил, ёс зүйгүй үйлдлийг хэмжиж, үнэлж, бууруулж чадах хүлээн зөвшөөрөгдсөн арга, практикийг нэвтрүүлэх.
 - Оролцогч талуудын хүртэн хүлээж авч буй ёс зүйн давамгайлалч уур амьсгалыг тодорхой давтамжтай хэмжиж, тодорхойлдог болох, үүгээр дамжуулж ирээдүйд гарч болох ёс зүйгүй үйлдлийг урьдчилан таамаглах, сэргийлэх, үйл ажиллагаагаа ёс зүйн эерэг уур амьсгалыг дэмжихэд чиглүүлэх.

ЭШЛЭСЭН БҮТЭЭЛ

МУШУТИС. “Их, дээд сургууль, коллежийн багшийн ажлын хариуцлага, ёс зүйн асуудал.” Багшийн хөгжлийн төв. 2018 оны 6 сарын 17, <http://www.fdc.edu.mn/static/media/uploadfile/hariutslaga.pdf> (хандсан 2019 оны 11 сар)

МУШУТИС. “Боловсролын систем дахь авлига.” *Дээд боловсролын бодлогын өөрчлөлт*, 2017 оны 11 сар: 2-12.

Al-Omari, A. A. “The Perceived Organizational Ethical Climate in Hashemite University.” *Asia-Pacific Education Researcher* 22, 3 (2012): 273-279.

Arnaud, A. “Conceptualizing and Measuring Ethical Work Climate: Development and Validation of the Ethical Climate Index.” *Business and Society* 49, 2 (2010): 345-358.

CIHE & IBE. *Ethics Matter: Managing Ethical Issues in Higher Education*. London: The Council for Industry and Higher Education, 2005.

Clark, B.R. “The Wesleyan Story: The Importance of Moral Capital.” *Academic Transformation: Seventeen Institutions Under Pressure*, (Eds) D. Riesman, & V.A. Stadtman. New York: McGraw-Hill., 1973.

Couch, S, ба S Dodd. “Doing the Right Thing: Ethical Issues in Higher Education.” *Journal of Family and Consumer Sciences* 97, 3 (2005): 20-26.

Denisova-Schmidt, E. “Corruption, the Lack of Academic Integrity and Other Ethical Issues in Higher Education: What Can Be Done Within the Bologna Process?” *European Higher Education Area: The Impact of Past and Future Policies* (Eds) A Curaj, L Deca, & R Pricopie, 63-64. Cham: Springer, 2018.

European Centre for Higher Education. “Ethical and Moral Dimensions for Higher Education and Science in Europe.” *International Conference on Ethical and Moral Dimensions for Higher Education and Science in Europe*. Bucharest, 2004. 28.

Haase, M, E Raufflet, A Rudnicka, ба J Reichel. “Ethics Education.” *Encyclopedia of Corporate Social Responsibility*, (Eds) Idowu S.O, Capaldi N, Zu L, & Gupta A.D. Berlin: Springer, 2013.

Heyneman, S. “The Corruption of Ethics in Higher Education.” *International Higher Education* 62, 4 (2011): 8.

Keenan, J. F. *University Ethics: How Colleges can Build and Benefit from A Culture of Ethics*. London: Rowman & Littlefield., 2015.

Kelley, P. C, ба P. L Chang. “A Typology of University Ethical Lapses: Types, Levels of Seriousness, and Originating Location.” *The Journal of Higher Education* 78, 4 (2007): 402-429.

Kohlberg, L. *The Philosophy of Moral Development: Moral Stages and the Idea of Justice. (Essays on Moral Development)*. Vol. 1. New York: Harper & Row., 1981.

—. *The Psychology of Moral Development: The Nature and Validity of Moral Stages. (Essays on Moral Development)*. Vol. 2. New York: Harper & Row, 1984.

Kohler, J. “Prevention, Management, and Moderation: Ethical Frameworks of Governance.” *Higher Education in Europe* 29, 4 (2004): 481-489.

Lahi, A. *Corruption in Higher Education Appears to Be on the Rise Globally, Report Says*. 2013 October 1. <https://www.chronicle.com/article/Corruption-in-Higher-Education/142013>.

Philip, R. “Ethics in Higher Education: A Study of the Perceived Ethical Climate of Administrators and Faculty at a Higher.” *Education Doctoral*. Ralph C. Wilson, Jr. School of Education, 2017.

Robinson, G. M, ба J Moulton. *Ethical problems in higher education*. Lincoln: iUniverse, Inc, 2005.

Simha, A, ба J. B Cullen. "Ethical Climates and Their Effects on Organizational Outcomes: Implications from the Past and Prophecies for the Future." *Academy of Management Perspectives* 26, 4 (2011): 20-34.

Transparency International. *Global Corruption Report: Education*. New York: Routledge, 2013, 148.

Victor, B, ба J. B Cullen. "The Organizational Bases of Ethical Work Climates." *Administrative Science Quarterly* 33 (1988): 101-125.

Victor, B, ба J. B. Cullen. "A Theory and Measure of Ethical Climate in Organizations." *Research in Corporate Social Performance and Policy* 9 (1987): 51-57.

Wimbush, J. C, J. M Shepard, ба S Markham. "An Empirical Examination of the Relationship between Ethical Climate and Ethical Behavior from Multiple Levels of Analysis." *Journal of Business Ethics* 16, 16 (1997): 1705-1716.

ХАВСРАЛТ

Хүснэгт 20: Оюутнуудын өдөр тутмын амьдралд ёс зүйн зөрчил хэр их тохиолддог вэ?, хүйсээр

	Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Огт тохиолддоггүй	Нийт
Эмэгтэй	11.8%	28.9%	41.4%	16.9%	0.9%	100%
Эрэгтэй	11.5%	25.0%	42.1%	19.7%	1.6%	100%
Нийт	11.7%	27.6%	41.7%	17.9%	1.1%	100%

Хүснэгт 21: Оюутны өдөр тутмын амьдралд ёс зүйн зөрчил хэр их тохиолддог вэ, сургуулиар

	Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Огт тохиолддоггүй	Нийт
ДХИС	10.1%	25.4%	43.1%	19.6%	1.8%	100%
АШУУИС	16.9%	27.8%	38.3%	16.2%	0.8%	100%
МУБИС	9.0%	30.0%	42.0%	18.0%	1.0%	100%

Хүснэгт 22: Оюутнууд өдөр тутамдаа ёс зүйн зөрчилтэй таардаг эсэх, сургууль, курсээр

		Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Огт тохиолддоггүй	Нийт
ДХИС	1-р курс	5.4%	21.6%	45.9%	18.9%	8.1%	100%
	2-р курс	9.2%	29.9%	39.1%	20.7%	1.1%	100%
	3-р курс	13.0%	25.0%	43.5%	18.5%	0.0%	100%
	4-р курс	10.2%	22.0%	47.5%	18.6%	1.7%	100%
АШУУИС	1-р курс	12.0%	24.0%	40.0%	24.0%	0.0%	100%
	2-р курс	12.2%	26.8%	40.2%	19.5%	1.2%	100%
	3-р курс	12.2%	26.5%	51.0%	8.2%	2.0%	100%
	4-р курс	15.4%	30.8%	30.8%	23.1%	0.0%	100%
	5-р курс	31.3%	31.3%	21.9%	15.6%	0.0%	100%
	6-р курс	25.6%	28.2%	38.5%	7.7%	0.0%	100%
МУБИС	1-р курс	8.5%	40.4%	36.2%	14.9%	0.0%	100%
	2-р курс	5.9%	27.1%	45.8%	21.2%	0.0%	100%
	3-р курс	11.8%	25.9%	43.5%	15.3%	3.5%	100%
	4-р курс	12.0%	34.0%	36.0%	18.0%	0.0%	100%

Нийт	1-р курс	8.3%	30.3%	40.4%	18.3%	2.8%	100%
	2-р курс	8.7%	27.9%	42.2%	20.6%	0.7%	100%
	3-р курс	12.4%	25.7%	45.1%	15.0%	1.8%	100%
	4-р курс	12.2%	28.4%	39.2%	19.6%	0.7%	100%
	5-р курс	31.3%	31.3%	21.9%	15.6%	0.0%	100%
	6-р курс	25.6%	28.2%	38.5%	7.7%	0.0%	100%

Хүснэгт 23: Багш нар ёс зүйн хувьд оюутанд үлгэрлэж чаддаг уу? Оюутнуудын хариулт, сургууль, курсээр

		Тийм	Үгүй	Нийт
ДХИС	1-р курс	97.3%	2.7%	100%
	2-р курс	84.7%	15.3%	100%
	3-р курс	87.0%	13.0%	100%
	4-р курс	90.0%	10.0%	100%
АШУУИС	1-р курс	92.0%	8.0%	100%
	2-р курс	76.5%	23.5%	100%
	3-р курс	73.5%	26.5%	100%
	4-р курс	82.1%	17.9%	100%
	5-р курс	68.8%	31.3%	100%
	6-р курс	61.5%	38.5%	100%
МУБИС	1-р курс	87.2%	12.8%	100%
	2-р курс	79.7%	20.3%	100%
	3-р курс	88.2%	11.8%	100%
	4-р курс	78.0%	22.0%	100%

Хүснэгт 24: “Сайн мэргэжилтэн заавал ёс зүйтэй байх ёстой” гэдэгтэй санал нийлэх үү? Оюутнуудын хариулт сургууль, курсээр

		Бүрэн санал нийлнэ	Зарим талаар санал нийлнэ	Нийт
ДХИС	1-р курс	94.4%	5.6%	100%
	2-р курс	89.7%	10.3%	100%
	3- курс	85.9%	14.1%	100%
	4- курс	80.0%	20.0%	100%
АШУУИС	1- курс	96.0%	4.0%	100%
	2- курс	98.8%	1.2%	100%
	3- курс	98.0%	2.0%	100%
	4- курс	94.7%	5.3%	100%
	5- курс	90.6%	9.4%	100%
	6- курс	92.3%	7.7%	100%
МУБИС	1- курс	95.7%	4.3%	100%
	2- курс	95.8%	4.2%	100%
	3- курс	89.4%	10.6%	100%
	4- курс	94.0%	6.0%	100%

Нийт	1- курс	95.4%	4.6%	100%
	2- курс	94.8%	5.2%	100%
	3- курс	89.8%	10.2%	100%
	4- курс	88.5%	11.5%	100%
	5- курс	90.6%	9.4%	100%
	6- курс	92.3%	7.7%	100%

Хүснэгт 25: Ёс зүйн хичээл ордог эсэх, Оюутнуудын хариулт сургууль, курсээр

		Тийм	Үгүй	Мэдэхгүй	Нийт
Дотоод хэргийн их сургууль	1-р курс	83.8%	5.4%	10.8%	100%
	2-р курс	83.9%	10.3%	5.7%	100%
	3-р курс	92.4%	3.3%	4.3%	100%
	4-р курс	93.3%	3.3%	3.3%	100%
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	1-р курс	84.0%	4.0%	12.0%	100%
	2-р курс	79.3%	9.8%	11.0%	100%
	3-р курс	55.1%	28.6%	16.3%	100%
	4-р курс	76.9%	17.9%	5.1%	100%
	5-р курс	84.4%	15.6%	0.0%	100%
	6-р курс	97.4%	0.0%	2.6%	100%
Монгол улсын боловсролын их сургууль	1-р курс	44.7%	23.4%	31.9%	100%
	2-р курс	62.7%	16.1%	21.2%	100%
	3-р курс	59.5%	27.4%	13.1%	100%
	4-р курс	56.0%	18.0%	26.0%	100%
Нийт	1-р курс	67.0%	12.8%	20.2%	100%
	2-р курс	73.9%	12.5%	13.6%	100%
	3-р курс	72.0%	17.8%	10.2%	100%
	4-р курс	76.5%	12.1%	11.4%	100%
	5-р курс	84.4%	15.6%	0.0%	100%
	6-р курс	97.4%	0.0%	2.6%	100%

Хүснэгт 26: Шалгалт авах дүн гаргах тогтолцоо шударга гэдэгтэй санал нийлэх үү? Оюутнуудын хариулт сургууль, курсээр

		Бүрэн санал нийлнэ	Зарим талаар санал нийлнэ	Санал нийлэхгүй	Огт санал нийлэхгүй	Нийт
ДХИС	1-р курс	24.3%	64.9%	10.8%	0.0%	100%
	2-р курс	24.1%	69.0%	6.9%	0.0%	100%
	3-р курс	27.2%	56.5%	14.1%	2.2%	100%
	4-р курс	43.3%	56.7%	0.0%	0.0%	100%
АШУҮИС	1-р курс	20.0%	76.0%	4.0%	0.0%	100%
	2-р курс	21.0%	63.0%	11.1%	4.9%	100%
	3-р курс	20.4%	69.4%	10.2%	0.0%	100%
	4-р курс	28.2%	64.1%	7.7%	0.0%	100%
	5-р курс	15.6%	68.8%	12.5%	3.1%	100%
	6-р курс	12.8%	66.7%	17.9%	2.6%	100%

МУБИС	1-р курс	14.9%	53.2%	29.8%	2.1%	100%
	2-р курс	21.2%	67.8%	8.5%	2.5%	100%
	3-р курс	21.2%	62.4%	15.3%	1.2%	100%
	4-р курс	20.0%	70.0%	8.0%	2.0%	100%
Нийт	1-р курс	19.3%	62.4%	17.4%	0.9%	100%
	2-р курс	22.0%	66.8%	8.7%	2.4%	100%
	3-р курс	23.5%	61.5%	13.7%	1.3%	100%
	4-р курс	31.5%	63.1%	4.7%	0.7%	100%
	5-р курс	15.6%	68.8%	12.5%	3.1%	100%
	6-р курс	12.8%	66.7%	17.9%	2.6%	100%

Хүснэгт 27: Танай сургуулийн хүрээнд дотоод дүрэм журмууд ялгаварлалгүй, бүрэн хэрэгжиж чаддаг уу? Оюутнуудын хариулт сургууль, курсээр

		Тийм	Үгүй	Мэдэхгүй	Нийт
ДХИС	1-р курс	78.4%	5.4%	16.2%	100%
	2-р курс	73.6%	16.1%	10.3%	100%
	3-р курс	68.5%	16.3%	15.2%	100%
	4-р курс	58.3%	25.0%	16.7%	100%
АШУУИС	1-р курс	60.0%	4.0%	36.0%	100%
	2-р курс	36.6%	15.9%	47.6%	100%
	3-р курс	24.5%	32.7%	42.9%	100%
	4-р курс	30.8%	20.5%	48.7%	100%
	5-р курс	15.6%	34.4%	50.0%	100%
	6-р курс	10.3%	35.9%	53.8%	100%
МУБИС	1-р курс	44.7%	19.1%	36.2%	100%
	2-р курс	36.4%	21.2%	42.4%	100%
	3-р курс	35.3%	20.0%	44.7%	100%
	4-р курс	26.0%	24.0%	50.0%	100%

Хүснэгт 28: Багш нар оюутны ёс зүйн зөрчлийн талаар, дундаж үзүүлэлт, багшийн үнэлснээр, сургуулиар /1-5 оноогоор үнэлсэн, 1-огт үгүй, 5-маш их/

	ДХИС	АШУУИС	МУБИС
Оюутан шалгалтын үед хуулах	3.02	2.56	3.21
Оюутан семинар дээр үзэл бодлоо хамгаалахын тулд бусадтай хэрүүл үүсгэх	2.35	1.88	2.00
Оюутан багийн ажилд харилцан адилгүй оролцоотой байж нэг ижил дүн авах	2.70	2.63	2.62
Оюутан багшийг үл хүндэтгэх /багштай хэрэлдэх, доромжлох/	1.61	1.56	1.90
Оюутан нэг бие даалтыг олон хичээлд тооцуулах	1.54	1.34	1.76
Ахлах курсийн оюутнууд бага курсийн оюутнуудаа бие мах бодын хувьд хүчирхийлэх /зодох, цохих/	1.98	1.13	1.71
Ахлах курсийн оюутнууд бага курсийн оюутнуудаас эд зүйлс, мөнгө нэхэх, дээрэлхэх	1.52	1.13	1.67
Анги, тэнхим хооронд дайсагнах, зүй бусаар өрсөлдөх	1.43	1.23	1.50

Оюутан хичээлээ таслах	2.39	2.69	3.21
Оюутан худал хэлж хичээлийн чөлөө авах	2.33	2.56	2.89
Оюутан сургуулийн орчинд архи, согтууруулах ундаа хэрэглэх	1.39	1.17	1.55
Оюутнууд бусдыгаа үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах	1.67	1.48	1.62
Бусад оюутныг хөрөнгө чинээгээр нь ялгаварлах	1.35	1.42	1.48
Бусад оюутныг гадна үзэмж, өмссөн хувцас зэргээр ялгаварлах	1.39	1.52	1.55
Бусад оюутныг сурлагаар нь ялгаварлах	1.59	1.61	1.62
Бусад оюутныг үндэс угсаагаар нь ялгаварлах	1.37	1.32	1.43
Оюутнууд сургуулийн орчинд зодолдох	1.49	1.26	1.54
Сургуулийн орчинд гэсэн зүйлс эргэж олддог эсэх	2.33	3.28	2.10
Сургуулийн орчинд эд зүйлсээ хулгайд алдах тохиолдол гардаг эсэх	1.76	2.31	2.14
Оюутнууд сургуулийн орчинд цаг барьдаг эсэх	3.54	3.12	2.68
Оюутан хичээл дээр, холбогдолгүй өөр зүйл хийх	2.35	2.26	2.90
Оюутан хичээл дээр унтах	2.42	2.12	2.28

Хүснэгт 29: Оюутны ёс зүйн зөрчилд оюутнуудын өсгөн дундаж үнэлгээ, сургуулиар /1-5 оноогоор үнэлсэн, 1-огт үгүй, 5-маш их/

	ДХИС	АШУҮИС	МУБИС
Шалгалтын үед хуулах	2.80	3.44	3.52
Семинар дээр үзэл бодлоо хамгаалахын тулд бусадтай хэрүүл үүсгэх	2.64	2.56	2.77
Багийн ажилд харилцан адилгүй оролцоотой байж нэг ижил дүн авах	3.15	3.75	3.49
Багшийг үл хүндэтгэх /багштай хэрэлдэх, доромжлох г.м/	1.52	1.95	2.04
Номын санд чанга дуугаар ярих	2.06	2.31	2.80
Нэг бие даалтыг олон хичээлд тооцуулах	1.29	1.62	1.81
Ахлах курсийн оюутнууд бага курсийн оюутнуудаа бие махбодын хувьд хүчирхийлэх	1.71	1.28	1.75
Ахлах курсийн оюутнууд бага курсийн оюутнуудаас эд зүйлс, мөнгө нэхэх, дээрэлхэх	1.53	1.24	1.73
Анги, танхим хооронд дайсагнах, зүй бусаар өрсөлдөх	1.58	1.76	1.78
Багшид тал засах бэлэг сэлт өгөх	1.67	2.14	1.91
Багшид мөнгө өгч дүнгээ ахиулах	1.35	1.77	1.69
Хичээлээ таслах	2.17	3.04	3.36
Худал хэлж чөлөө авах	1.97	2.91	3.09
Архи, согтууруулах ундаа хэрэглэх	1.51	2.02	2.09
Бусдыг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах	1.87	2.30	2.25
Бусад оюутныг хөрөнгө чинээгээр нь ялгаварлах	1.59	2.03	2.04

Бусад оюутныг гадна үзэмж, өмссөн хувцас зэргээр ялгаварлах	1.62	2.18	2.19
Бусад оюутныг сурлагаар ялгаварлах	1.84	2.45	2.34
Бусад оюутныг үндэс угсаагаар нь ялгаварлах	1.57	1.75	1.79
Сургуулийн орчинд зодолдох	1.50	1.51	1.70
Бие биедээ хариу нэхэлгүй тусалдаг эсэх	3.31	3.29	3.36
Сургуулийн орчинд гэсэн зүйл эргэж олддог эсэх	2.88	3.24	2.44
Сургуулийн орчинд эд зүйлээ хулгайд алдах тохиолдол гардаг эсэх	1.86	2.53	2.38
Оюутнууд сургуулийн орчинд цаг барьдаг эсэх	3.96	3.18	3.00
Бусдаас хичээлээ хуулуулахыг шаардах	1.85	2.33	2.37
Хичээл дээр холбогдолгүй өөр зүйл хийх	2.21	2.72	2.91
Хичээл дээр унтах	2.43	2.89	3.02
Үзэл бодлоо илэрхийлсний төлөө анги хамт олондоо гадуурхагдах	1.88	2.23	2.16
Оөөрөө хүсээгүй ч асуудал гаргахгүйн тулд ангийн ажилд оролцох	2.73	2.98	2.82

Хүснэгт 30 : Зан чанарын ач холбогдол болон хэрэгжүүлдэг байдалдаа өгсөн багш нарын үнэлгээ. /1-10 хүртэлх оноогоор үнэлсэн 1- хамгийн бага 10- хамгийн сайн/

	Дотоод хэргийн их сургууль		Анагаахын шинжлэх ухааны их сургууль		Монгол улсын боловсролын их сургууль	
	Ач холбогдол	Хэрэгжүүлдэг байдал	Ач холбогдол	Хэрэгжүүлдэг байдал	Ач холбогдол	Хэрэгжүүлдэг байдал
Идэвх зүтгэл	9.09	7.95	8.73	8.00	8.62	7.27
Хувийн сахилга бат	9.26	7.95	9.06	8.09	8.41	7.00
Шударга хандлага	9.45	7.67	9.45	8.38	8.86	7.19
Өгөөмөр зан	7.47	7.05	7.55	7.00	6.73	5.71
Даруу зан	6.64	6.40	7.39	7.03	7.12	6.39
Өрөвч зан	6.43	6.50	7.39	6.75	6.88	5.35
Талархах	8.06	7.26	8.39	7.78	7.81	6.71
Хүлээц	8.43	7.43	8.58	7.63	7.46	7.19
Мэдлэг чадвар	9.30	8.33	9.52	9.00	7.67	6.65
Хөгжилтэй зан	6.89	6.44	7.21	6.69	6.38	5.40
Тэвчээр	8.78	7.93	8.45	7.81	7.88	7.00
Нийтэч	8.26	7.24	8.21	7.91	7.81	6.67
Нөхөрсөг хандлага	8.54	7.56	8.36	7.63	7.93	6.32
Тууштай, цөхөршгүй	9.02	7.61	8.76	7.88	8.25	6.94
Хариуцлагатай байдал	9.80	8.63	9.44	8.35	8.86	7.30
Хайр	7.63	7.08	8.09	7.26	6.83	5.21
Эр зориг	8.02	7.17	7.53	7.00	6.00	4.31
Олон нийтэч байдал	8.80	7.90	8.66	7.84	7.60	6.78

Хүснэгт 31: Багшийн ёс зүйн зөрчлүүдийн дундаж үзүүлэлт, оюутны үнэлснээр, сургуулиар /1-5 оноогоор үнэлсэн, 1-огт үгүй, 5-маш их/

	ДХИС	АШУУИС	МУБИС
Багш хичээл орохгүй таслах	1.55	1.83	1.91
Оюутанд шударга бус үнэлгээ тавих	2.28	2.70	2.63
Оюутныг хэл амаар доромжлох	2.05	2.27	2.16
Дүн гаргахдаа оюутнаас шан харамж авах	1.60	1.86	1.79
Танил оюутанд давуу тал олгох	2.34	2.64	2.42
Өөрийн ном, сурах бичгийг оюутнуудад шахах	2.41	3.27	2.91
Оюутныг үндэс, угсаагаар нь ялгаварлах	1.43	1.78	1.71
Оюутныг гадна үзэмж, хувцас зэргээр ялгаварлах	1.54	1.93	2.00
Оюутныг хөрөнгө чинээгээр нь ялгаварлах	1.55	1.86	1.80
Оюутныг сурлагаар нь ялгаварлах	2.23	2.73	2.52
Оюутанд хичээл номд холбогдолгүй зүйл зарах	1.59	1.45	1.57
Оюутнаас ар гэрийн ажилд туслалцаа авах	1.69	1.38	1.41
Багш өөрийн үзэл бодлыг оюутанд тулгах	1.95	2.31	2.11
Оюутныг төсөл, хөтөлбөрт үнэ хөлсгүй зарах	1.72	1.74	1.59
Оюутныг бие махбодын хувьд хүчирхийлэх /биед нь хүрэх, цохих/	1.58	1.29	1.31
Оюутанд бэлгийн дарамт үзүүлэх	1.22	1.24	1.13
Оюутнаас бэлэг сэлт авах	1.42	1.74	1.63
Багш өөрийн хүссэн үедээ хичээл орохоос татгалзах	1.28	2.04	1.52
Цонхолсон цагийн хичээлийг багш нөхөлгүй орхих	1.55	1.84	1.90
Баг бүрдүүлэхдээ "Сайн" гэж үзсэн оюутнаа "Муу" гэж үзсэн оюутантай хамт хуваарилах	2.33	2.44	2.19
Хувийн үнэлэмжээр оюутнуудыг ялгаварлаж хандах	1.92	2.15	2.09
Багш оюутантайгаа хувийн харилцаа тогтоох	1.51	1.55	1.57
Багш нар сургуулийн орчинд архи, согтууруулах ундаа хэрэглэх	1.37	1.44	1.58
Багш нар хичээлийн бус цагаар оюутнуудад хичээл тайлбарлах, зөвлөгөө өгөх зэргээр тусалдаг эсэх	3.07	2.55	3.16

Хүснэгт 32: Багшийн ёс зүйн зөрчлүүд, дундаж үзүүлэлт, багшийн үнэлснээр, сургуулиар /1-5 оноогоор үнэлсэн, 1-огт үгүй, 5-маш их/

	ДХИС	АШУУИС	МУБИС
Багш хичээлээ орохгүй таслах	1.93	1.75	2.06
Оюутанд шударга бус үнэлгээ тавих	2.06	1.93	2.00
Оюутныг хэл амаар доромжлох	2.13	1.69	1.86
Дүн гаргахдаа оюутнаас шан харамж авах	1.32	1.30	1.41
Танил оюутанд давуу тал олгох	1.91	1.78	1.65
Өөрийн ном, сурах бичгийг оюутнуудад шахах	1.97	1.81	1.69

Оюутныг үндэс, угсаагаар нь ялгаварлах	1.37	1.12	1.10
Оюутныг гадна үзэмж, хувцас зэргээр ялгаварлах	1.21	1.18	1.24
Оюутныг хөрөнгө чинээгээр нь ялгаварлах	1.17	1.21	1.24
Оюутнуудыг сурлагаар нь ялгаварлах	1.64	1.48	1.51
Оюутнуудад хичээл номд холбогдолгүй зүйл зарах	1.41	1.09	1.17
Оюутнуудаас ар гэрийн ажилд туслалцаа авах	1.71	1.03	1.31
Багш өөрийн үзэл бодлыг оюутанд тулгах	1.84	1.51	1.79
Оюутнуудыг төсөл, хөтөлбөрт үнэ хөлсгүй зарах	1.38	1.69	1.4
Оюутнуудыг бие махбодын хувьд хүчирхийлэх /биед нь хүрэх, түлхэх, цохих г.м/	1.32	1.03	1.37
Оюутнуудад бэлгийн дарамт үзүүлэх	1.06	1.03	1.17
Оюутнуудаас бэлэг сэлт авах	1.30	1.39	1.48
Багш өөрийн хүссэн үедээ хичээл орохоос татгалзах	1.06	1.43	1.31
Цонхолсон цагийн хичээлийг багш нөхөлгүй орхих	1.41	1.25	1.57
Баг бүрдүүлэхдээ “сайн” гэж үзсэн оюутнаа “муу” гэж үзсэн оюутантай хамт хуваарилах	2.43	2.03	2.46
Хувийн үнэлэмжээр оюутнуудыг ялгаварлаж хандах	1.45	1.28	1.55
Багш оюутантайгаа хувийн харилцаа тогтоох	1.20	1.03	1.42
Багш нар сургуулийн орчинд архи, согтууруулах ундаа хэрэглэх	1.32	1.25	1.69
Багш нар хичээлийн бус цагаар оюутнуудад хичээл тайлбарлах, зөвлөгөө өгөх зэргээр тусалдаг эсэх	3.26	2.68	3.10

